

ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CITES)-ИЙН ЛАВЛАХ



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

БОАЖЯ-ны Зэрлэг амьтан ба ургамлын
аймгийн ховордсон зүйлийг олон улсын
хэмжээнд худалдаалах тухай конвенцийн
Үндэсний удирдан зохицуулах зөвлөл



Монгол Улсад Гэмт хэргээс
урьдчилан сэргийлэх ажлыг
зохицуулах зөвлөл



Дэлхийн байгаль хамгаалах
сан (WWF)-ийн Монгол дахь
хөтөлбөрийн газар



Монгол Улсын
Их Сургууль



Монголын
шулуу судлалын
нийгэмлэг

Улаанбаатар хот
2018 он

ДАА 570
ННА 28
З-964

Редактор:

Б.Чимэддорж, С.Пүрэвсүрэн, Х.Тэрбиш

Бүлэг, сэдвийг эмхтгэсэн:

С.Гомбобаатар, Б.Одхүү, Ү.Төвшин (Шувуу)
Н.Жамъянхүү, Н.Гэрэл (I, II бүлэг)
С.Пүрэвсүрэн (Хөхтөн, хууль эрх зүй)
Д.Суран (Ургамал)
Х.Тэрбиш (Мөлхөгч, загас, шавж)

Тархалтын газрын зураг:

Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны өгөгдөлд тулгуурлан амьтан, ургамлын дэлхийн болон Монгол орны тархалтын зургийг С.Гомбобаатар, Д.Лхагвасүрэн, С.Нямбаяр нар гүйцэтгэв.

Зохиогчийн эрх:

© Байгаль орчин, аялал жуулчлалын яам
© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар

Гэрэл зураг:

Н.Батсайхан © (Хулан адуу, баданга хүдэр, балч гоорбис)
Н.Баяртогтох © (Аполлон)
А.Баясгалан © (Мазаалай баавгай)
С.Гомбобаатар © (Борцгор хотон, цагаагчин халбагат, дорнын өрөөтас, хар өрөөтас, ягаан, байгалийн нугас, цагаан толгойт ямаан сүүл, сохор элээ, үлэг харцага, морин харцага, шунгаагч харцага, тарлан сар, шилийн сар, талын сар, ойн сар, ооч ёл, бахим бүргэд, тарважи бүргэд, усны нөмрөг бүргэд, цагаансүүлт нөмрөгбүргэд, ухаа хажир, хималайн хажир, эгэл шонхор, шууман шонхор, хайргууна шонхор, амарын шонхор, зээрд шонхор, начин шонхор, алаг тогоруу, цагаан тогоруу, хархираа тогоруу, цэн тогоруу, хар тогоруу, өвөгт тогируу, хонин тоодог, реликт цахлай, цагаан уулж, эгэл шар шувуу, соотон гуйванга, хулгар гуйванга, хотны бүгээхэй, буслаг сүлиг, харсуун бэгбаатар, ердийн орволоо, хув ууль, угалзан ууль)
Ф.И.Еникеева © (Хүрэн баавгай)
Б.Мэндсайхан нар (2017) © (Шивэр хилэм, Амар мөрний хилэм)
Д.Өсөхжаргал © (Шилүүс мий)
С.Пүрэвсүрэн © (Тахь адуу)
Д.Суран © (Цэлийн аргамжинцэцэг, толбот саадганцэцэг, томцэцэгт саадганцэцэг, шар саадганцэцэг, булцуут түдэнхавх, хөхөө цүнхрэг, сэрхэн хөхөөцэцэг, гурвалсан шүрэнүндэс)
Э.Сэргэлэн © (Аргаль хонь, Монгол бөхөн)
Х.Тэрбиш © (Нөмрөг тас, цармын бүргэд, сохор элээ, идлэг шонхор, тэмээн сүүл могой)
С.Шар © (Ердийн орволого)
Askar Isabekov © (Намгийн хулд, шилийн шонхор, жороо тоодог)
Chaiyan Kasorndorkbia © (Загасч явлаг, алаг хулд)
Choi, C.Y © (Үүрсээ харцага)
Dick Forsman © (Турамтай шонхор)
Niranjan Sant © (Могойч загалай, уулын согсоот бүргэд, харсун бүргэд, бор бүргэд)
Potarov, E © (Цагаан шонхор)
Saxifraga-Jan Nijendijk © (Голын халуу)
Rishad Naoroji © (Хээрийн хулд, нугын хулд, хан бүргэд, дэлт ёлон)
Yongmin Moon © (Угалзан ууль)
WWF-Mongolia © (Цоохор ирвэс, саарал чоно, мануул мий)
Интернет эх сурвалж © (Шарнад цөөвөр, цоохондой мий)

Иш татах:

Чимэддорж, Б., Пүрэвсүрэн, С., Тэрбиш, Х., Гомбобаатар, С., Одхүү, Б., Төвшин, Ү., Жамъянхүү, Н., Гэрэл, Н., Суран, Д. (2018). *Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн лавлах*. БОАЖЯ, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн Ухааны салбар, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. Улаанбаатар хот, Монгол улс.

ISBN: 978-99978-938-1-9

ӨМНӨХ ҮГ	6
УДИРТГАЛ	7
ӨМНӨТГӨЛ	9
ТОВЧИЛСОН ҮГС	10

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CITES), ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ БАЙГУУЛЛАГА БОЛОН ХАВСРАЛТАД БҮРТГЭГДСЭН ЗҮЙЛҮҮДИЙН ТУХАЙ 11

1.1. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)	12
1.2. Конвенцийн Үндэсний удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагууд	25
1.3. Конвенцийн нэг, хоёрдугаар хавсралтад бүртгэгдсэн амьтан, ургамал	41
1.4. Конвенцийн нэг, хоёрдугаар хавсралтын тайлбар	80

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CITES)–ИЙН ХАВСРАЛТАД БҮРТГЭЛТЭЙ АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЭРХТЭН, ЗҮЙЛСИЙН ЭКСПОРТ, РЕЭКСПОРТ БОЛОН ИМПОРТЫН ТУХАЙ 87

2.1. Конвенцийн нэгдүгээр хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн экспорт	88
2.2. Конвенцийн хоёр, гуравдугаар хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн экспорт	90
2.3. Конвенцийн нэгдүгээр хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн реэкспорт	92
2.4. Конвенцийн хоёр, гуравдугаар хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн реэкспорт	94
2.5. Конвенцийн нэгдүгээр хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн импорт	96
2.6. Конвенцийн хоёр, гуравдугаар хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн импорт	98

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСААС ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CITES)–ИЙН НЭГ, ХОЁРДУГААР ХАВСРАЛТАД БҮРТГЭЛТЭЙ АМЬТАН, УРГАМАЛ 100

3.1. Хөхтөн	101
3.2. Шувуу	148
3.3. Мөлхөгч	294
3.4. Загас	297
3.5. Шавж	302
3.6. Ургамал	305

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CITES)-ИЙН ХОЛБОГДОЛТОЙ МОНГОЛ УЛСЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖУУД	323
Конвенцийн хэрэгжилтийг дэмжих Монгол Улсын бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн тухай.	324
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ	329
Амьтны тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2012).	330
Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль (2002)	336
Байгалийн ургамлын тухай хууль (1995) болон түүний хавсралт (Нэн ховор ургамлын жагсаалт)	343
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2012).	349
Гаалийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2008)	353
Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2017)	360
Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль (1995)	365
Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)	367
Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ (2015)	371
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ	375
Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт (Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалт)	376
Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт (Монгол улсын хилээр тарифын бус бусад хязгаарлалттай нэвтрүүлэх бүлэг барааны жагсаалт).	377
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ	379
Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолын хавсралт (Ховор ургамлын жагсаалт)	380
Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт (Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт)	385
Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт (Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам)	387
Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт (Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам)	390
Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт (Гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр агнуулах агнуурын амьтны олзворын жишиг үнэ, төлбөр, хураамжийн хэмжээ)	393

Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт (Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ)	395
Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт (Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ)	403
Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт (Ховор амьтны жагсаалт)	414
Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт (Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журам)	415
МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ	419
Байгаль орчны сайд, Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн хамтарсан 2008 оны 120/51 дүгээр тушаалын хавсралт (Амьтныг шинжлэх ухааны зориулалтаар барьж, тэмдэглэх журам)	420
Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-359 дүгээр тушаалын хавсралт (Амьтныг амьдаар нь болон амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах журам)	422
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/75 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт (Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолт олгох, хяналт тавих журам)	424
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/75 дугаар тушаалын 2 дугаар хавсралт (“Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолтын загвар)	426
Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн зөвшөөрлийн бичгийн загвар	427
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 09-р сарын 01-ны өдрийн А/27 тоот тушаалын 1 дүгээр хавсралт (Амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, зүйлийг гадаадад гаргах зөвшөөрөл) .	428
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 09-р сарын 01-ны өдрийн А/27 тоот тушаалын 2 дугаар хавсралт (Амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, зүйлийг гадаадаас оруулах зөвшөөрөл)	429
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 09-р сарын 01-ны өдрийн А/27 тоот тушаалын 6 дугаар хавсралт (Ан агнах тусгай зөвшөөрөл)	430
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 09-р сарын 01-ны өдрийн А/27 тоот тушаалын 7 дугаар хавсралт (Загас барих тусгай зөвшөөрөл)	430
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/75 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт (Ахуйн зориулалтаар ан амьтан агнах, загас барих эрхийн бичгийн загвар)	431
ТАЛАРХАЛ	432
АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛ	433
ХАВСРАЛТ	440

ӨМНӨХ ҮГ

Их хувь заяагаар та бидний эзэн нь болж төрсөн 1 сая 565 мянган ам дөрвөлжин километр нутаг, Төв Азийн тэгш өндөрлөгт, Хянганаас Алтай хүртэл дэлгэгдсэн, хөвч сарьдгаас их говь даван үргэлжилсэн уудам газар. Энэ улсыг Монгол гэдэг. Харамлах, хайрлах, хамгаалах ёстой эх оронд маань 138 зүйлийн хөхтөн, 487 зүйлийн шувуу, 22 зүйлийн мөлхөгч, 75 зүйлийн загас, 6 зүйлийн хоёр нутагтан бий. Харамсалтай нь, байгаль орчны глобаль өөрчлөлт болон хүний үйл ажиллагаанаас шалтгаалан зэрлэг амьтдын тоо толгой, тархац, нутгийн хүрээ хумигдан багасаж буй нь Монгол орныг ч тойрсонгүй. Дэлхийн дулаарал, хүний үйл ажиллагаанаас шалтгаалан Монгол орны 100 гаруй зүйлийн амьтан, ургамал устах аюулд тулаад байна.

Жишээ болгон өгүүлэхэд, манай дэлхий дээр соргог бөхөн, монгол бөхөн гэсэн хоёр салбар зүйлийн бөхөн бий. Монгол бөхөн Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны ангилал, шалгуураар олон улс болон бүс нутгийн хэмжээнд устаж болзошгүй хэмээн үнэлэгджээ. Монгол бөхөн 1920-иод онд Увс нуурын хотгорт, 60-аад онд Хяргас, Айраг нуурын хотгорт, мөн 60-аад оны дунд үеэс Дөргөн, Хар нуурын хавь, Завхан голын адагт устжээ. 1995 оны байдлаар тархац нутгийнхаа хориод хувьд, хоёрхон хэсэгт үлдсэн байна. 100 жилийн өмнө Каспийгаас Казахстан, Монгол хүртэл тархан амьдарч байсан бөхөнг эврээс нь болж хядсаар ийм цөөхөн болгожээ. Харин бөхөнгийн нөгөө зүйл болох соргог бөхөн Монгол Алтайн нуруунаас урагш Зүүн гарын говийн хэсэгт байснаа ховордсоор 1950-иад оноос үзэгдэхээ больж, устаж үгүй болжээ.

Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, экологийн асуудал нь хил хязгаараас үл хамааран хүн төрөлхтний нийтлэг бэрхшээл болоод байгаа учраас хаана амьдарч байгаагаас үл шалтгаалан бид хамтдаа энэхүү асуудлыг шийдэх ёстой.

Бүх шатны боловсролын байгууллага, биологи, экологи, байгаль хамгааллын чиглэлээр суралцагч оюутнууд, залуу судлаачид, байгаль хамгаалагчид төдийгүй хил, гааль, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтан, алба хаагчдад зориулсан гарын авлага, ном товхимол өнөөдөр дутмаг хэвээр байна.

Байгаль хамгааллын ажлыг үр дүнтэй болгодог гол хэрэгсэл бол мэдээлэл, сурталчилгаа юм. Иргэдэд зөв хандлага төлөвшүүлэхийн тулд тухайн амьтдын хүний хүрээлэн буй орчинд гүйцэтгэдэг үүрэг, ач холбогдлын талаарх оновчтой мэдээлэл өгч, бахархах, хайрлах, хамгаалах сэтгэлгээ бий болгох нь чухал байна. Хүн мэдэхгүй зүйлээ хайхралгүй өнгөрөөдөг, хайрладаггүй зүйлээ хамгаалахгүй. **МЭДЭХГҮЙ-ХАЙРЛАХГҮЙ-ХАМГААЛАХГҮЙ.** Чухам ийм учраас мэдлэг, мэдээлэл бол хамгийн сайн байгаль хамгааллын арга хэрэгсэл билээ.

Эх байгаль, элгэн нутаг, ховор амьтан, ургамал маань зөвхөн өнөөгийн бидний үеийнхний өмч биш. Өвөг дээдсээсээ өвлөж авсан эх орноо бид үр хойчдоо хүлээлгэн өгнө. Давтагдашгүй байгаль, нөхөгдөшгүй нөөц, мартагдашгүй түүх, үнэлэшгүй үнэ цэнэ, харьцуулшгүй унаган төрх бүхий газар нутгаа, ховор амьтдаа хамгаалахын ач холбогдлыг ойлгоход энэхүү товхимол бага ч болов хувь нэмэр болно гэдэгт итгэж байна.

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга



Л.НЯМГЭРЭЛ

УДИРТГАЛ

Хүн төрөлхтний байнга өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээ, техник, технологийн нэн хурдтай хөгжил дэвшил, бизнесийн орчны олон талт үйл ажиллагааны улмаас байгалийн нөөц баялгийн ашиглалтын цар хүрээ ямагт өргөсөн тэлж, эрчимжсээр иржээ. Ялангуяа амьтан, ургамлын аймагт хүний зүгээс үзүүлэх шууд ба шууд бус нөлөө зуунаас зуунд, жилээс жилд улам бүр өсөн нэмэгдсээр байна. Шууд нөлөө нь амьтан, ургамлыг байгалиас янз бүрийн аргаар олборлох, шинээр нутагшуулах, өсгөн үржүүлж нөөцийг нь нэмэгдүүлэх, эсвэл тоо толгойг нь багасгах, тархац нутгаас нь шахан зайлуулах, устгаж үгүй болох зэргээр илэрдэг бол шууд бус нөлөө нь амьтан, ургамлын амьдрах орчин, нөхцлийг өөрчлөх байдлаар илэрнэ. Хүний үйл ажиллагааны шууд, шууд бус нөлөө олон зүйл амьтан, ургамлын хувьд нэгэн зэрэг үйлчилж байдгийн зэрэгцээ тэдэнд үзүүлэх нөлөө, үр дагавар нь эерэг ба сөрөг талтай байна.

Хүмүүсийн зохисгүй, буруу үйлдлийн улмаас сүүлийн 500 жилийн хугацаанд 840 гаруй зүйлийн сээр нуруутан амьтад бүрэн устжээ. Эдгээрийн дотор 17 зүйл, дэд зүйлийн баавгай, 5 зүйлийн чоно, үнэг, 4 зүйлийн муур, 10 зүйлийн зэрлэг үхэр, хонь ямаа, гөрөөс, 5 зүйлийн зэрлэг адуу, тахь, илжиг, 3 зүйлийн буга болон олон зуун зүйлийн шувуу, хоёр нутагтан, мөлхөгч амьтад багтаж байна. Мөн асар олон зүйлийн ургамал бүрмөсөн устжээ. Цөөн зарим жишээ дурдахад, Маврикийн дронт буюу додо хэмээх нисдэггүй шувууны хамгийн сүүлчийн бодгаль 1691 онд Маритус аралд алагдаж, сүрэглэн нисэх үедээ хэсэг хугацаанд тэнгэрийг бүрхэн, нар халхалдаг байсан Хойд Америкийн бядан явагч тагтааг 1900 оноос хойш байгалийн нөхцөлд хэн ч хараагүй байна. Амьтны хүрээлэнд амьдарч байсан бядан явагч тагтааны Март нэртэй сүүлийн ганц бодгаль 1914 онд үхсэнээр энэ зүйл шувуу манай дэлхийгээс бүрмөсөн устжээ. Ахмад Витус Беренгийн удирдсан Камчаткийн 2-р экспедиц далайн үхэр хэмээх нэгэн зүйл сүүн тэжээлтэн амьтныг Командарын арлын эрэг орчмын далайгаас 1741 онд нээн илрүүлжээ. Энэ амьтны шинжлэх ухааны анхны бичиглэлийг тус экспедицийн эмч, байгаль шинжээч Георг Стиллер үйлдсэн тул түүний нэрээр Стиллерийн үхэр ч гэж нэрлэдэг. Бараг 8 м хүртэл урт биетэй, жин нь 4-5 тн хүрдэг энэ амьтны амтат

мах, өөх, арвин их сүүг нь ашиглахын тулд хайр найргүй хядсанаас 1768 онд бүрэн устсан юм.

Ийм харамсалтай баримт манай оронд ч цөөнгүй бий. Монгол орны Зүүнгарын говьд идээшин амьдарч байсан тахь хэмээх зэрлэг адуу 1960-аад оны дунд үе гэхэд байгальд бүрэн устжээ. Харин 100 гаруй жилийн өмнө Монгол нутгаас барьж, Европын амьтны хүрээлэнд өсгөн үржүүлсэн тахийн үр удмыг эх оронд нь сэргээн нутагшуулах төслийг 1992 оноос амжилттай хэрэгжүүлж байгаа нь ан амьтдыг устахаас авран хамгаалах үйлсийн сайн жишээний нэг мөн. Монголчууд бидний буруутай үйл ажиллагааны улмаас мазаалай баавгай, хавтгай тэмээ, хар сүүлт зээр, бөхөн, аргаль, янгир, тарвага зэрэг олон зүйлийн ан амьтдын тоо толгой эрс цөөрч, тархац нутаг нь хумигдаж байна.

Байгалийн амьтан, ургамал ховордох нэг үндсэн шалтгаан нь тэдгээрийн эд, эрхтэн, түүгээр хийсэн хүнс, эм, эд хэрэглэл, гоёл чимэглэлийн зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалж, ашиг олз олох зорилгоор агнаж, олборлодог олон зүйлийн амьтан, ургамлын нөөц багасаж, устах аюулд хүрээд байна. Ийм ч учраас “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц”-ийг 1973 оны 3-р сарын 3-нд байгуулан үзэглэсэн байна. “Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora” хэмээх Англи нэршлийн товчлол болох “CITES” буюу анх гарын үсэг зурсан хотын нэрээр “Вашингтоны конвенц” хэмээн дэлхий нийтэд түгэн мөрдөж буй энэ акт нь амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах үйл явцыг хянан зохицуулдаг олон улсын эрх зүйн үндсэн баримт бичиг юм.

Энэ конвенц 1975 оны 7-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон ба одоогоор дэлхийн 175 орон (талууд) уг конвенцид нэгдэн ороод байна.

Монгол улс уг конвенцид нэгдэн орох тухай хуулийг УИХ 1995 оны 5-р сарын 4-ний өдөр баталсан бөгөөд 1996 оны 4-р сарын 4-ний өдрөөс энэхүү конвенц (CITES)-ийн 133 дахь гишүүн орон болсон билээ.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай

конвенц (CITES)"-ийн үндсэн зорилго нь зэрлэг амьтан, ургамлын аль нэгэн зүйл олон улсын худалдаанд хэт их хэмжээгээр өртөж, устах аюулд орохоос хамгаалах явдал бөгөөд тухайн зүйлийг хамгаалахын зэрэгцээ олон улсын хяналт зохицуулалттайгаар худалдаалахад чиглэдэг.

Энэ конвенц бол импортлогч болон экспортлогчид байгалийн нөөц баялгийг ашиглахдаа олон улсын хамтын ажиллагааны түвшинд тэгш хамтран ажиллах үүрэг, хариуцлага хүлээн, дэлхийн улс орнуудад даган мөрдөж байгаа хууль эрх зүйн тогтолцоог уялдуулан зохицуулах механизм болж байдаг. Тус конвенц нь амьтан, ургамлын худалдааны талаарх мэдээ материалыг цуглуулж нэгтгэн, дүн шинжилгээ хийсний үр дүнд худалдаанд хяналт тавих хэрэгслийг бий болгох, мөн худалдаанд тавьдаг шалгууруудад үндэслэн зэрлэг амьтан, ургамлын зүйлийг ангилах арга хэрэгсэл болно.

Монгол улсаас энэ конвенцийн нэг, хоёрдугаар хавсралтад нийтдээ 14 зүйл хөхтөн, 72 зүйл шувуу, 8 зүйл ургамал, 2 зүйл загас, тус бүр 1 зүйл шавж, мөлхөгч багтсан байдаг. Үүнээс тус конвенцийн нэгдүгээр хавсралтад 5 зүйл хөхтөн, 14 зүйл шувуу, харин хоёрдугаар хавсралтад 9 зүйл хөхтөн, 58 зүйл шувуу, 1 зүйл мөлхөгч, 2 зүйл загас, 1 зүйл шавж, 8 зүйл ургамал тус тус бүртгэгдсэн байна.

Конвенцид нэгдсэн тал тус бүр Үндэсний Удирдан зохицуулах зөвлөл ба Шинжлэх ухааны зөвлөлийг байгуулж ажиллуулах нь энэхүү конвенцийн хэрэгжилтийг хангах үндсэн гол арга зам болно.

Конвенцийн 9 дүгээр зүйлийн 1.в болон Монгол Улсын "Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль"-ийн 4 дүгээр зүйл, "Амьтны тухай хууль"-ийн 36 дугаар зүйл, "Байгалийн ургамлын тухай хууль"-ийн 17 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг зохицуулах үүрэг бүхий Удирдан зохицуулах зөвлөл, Удирдан зохицуулах зөвлөлд зөвлөгөө, зааварчилгаа өгөх

үүрэг бүхий Шинжлэх ухааны зөвлөл ажиллаж байна.

Тус конвенцийн 8 дугаар зүйлийн 7-д зааснаар Талууд хавсралтад орсон зүйлүүд, тэдгээрийн гаралтай эд зүйлийг худалдах талаар бүртгэл (зүйлийн нэр, эдийн хэлбэр, тоо, хүлээн авч буй орон, зөвшөөрөл, сертификатын төрөл, тоо)-ийг нэгтгэсэн тайланг жил бүр, энэхүү конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль эрх зүй, захиргаа болон зохицуулах арга хэмжээний талаарх тайланг хоёр жилд нэг удаа Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлэх үүрэг хүлээсэн байдаг бөгөөд энэ конвенцийн хавсралтад орсон зүйлүүдийн худалдааны талаарх жил тутмын тайланг Нарийн бичгийн дарга нарын газарт тогтмол илгээж байна.

Монгол улс Талуудын хурлуудаас гарсан шийдвэрүүдийг дотоодын бодлого, төлөвлөлтөндөө тусгах ажлыг зохион байгуулж, Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт тус конвенцийн хэрэгжилтийн талаарх тайланг хүргүүлж, Нарийн бичгийн дарга нарын газар, конвенцийн гишүүн орны удирдан зохицуулах зөвлөлтэй байнгын холбоотой, конвенцийн үйл ажиллагаанд тогтмол идэвхтэй оролцож байна.

Байгаль орчны яам (хуучин нэрээр), Конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлөөс тус конвенцийн хавсралтад орсон олон улсын худалдаанд өртөж устах аюулд хүрсэн буюу экспортын зөвшөөрөлтэйгээр олон улсад худалдаалж болох зүйлүүдийн тухай мэдээллийг багтаасан анхны "Зэрлэг амьтан ба ургамалын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн лавлах" хэмээх номыг 2001 онд хэвлүүлж байсан билээ.

Энэ удаа тус номыг ховордож буй ургамал, амьтны зүйлүүдийг хамгаалах буянтай үйлсэд зүтгэж буй хил, гааль, цагдаа, улсын мэргэжлийн хяналт, байгаль орчны ажилтнууд болон сонирхсон хэн бүхэнд зориулан шинэчлэн хүргэж байна.

Ариун цагаан үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

*БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга бөгөөд
Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд
худалдаалах тухай конвенцийн Удирдан зохицуулах зөвлөлийн дарга*



ДОКТОР, ПРОФЕССОР Г. НЯМДАВАА

ӨМНӨТГӨЛ

Байгалийн амьтан, ургамал ховордох нэг үндсэн шалтгаан нь тэдгээрийн эд, эрхтэн, түүгээр хийсэн хүнс, эм, эд хэрэглэл, гоёл чимэглэлийн зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах, ашиг олох зорилгоор хомроглон агнах юмуу олборлож, улмаар хил давуулан наймаалах үйл ажиллагаа юм. Үүний улмаас олон зүйлийн амьтан, ургамлын нөөц багасаж, устах аюулд хүрсэн бодит жишээ олон бий.

Ийм ч учраас хүн төрөлхтний өмнө байгалийн баялгийг зүй зохистой, тогтвортой ашиглах, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд, зүйлийн олон улсын худалдаанд хяналт тавьж, зохицуулах шаардлага бий болж “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora)”-ийг 1973 оны 3-р сарын 3-нд байгуулан үзэглэсэн түүхтэй.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн Англи нэршлийн товчлол болох “CITES” нэрээр дэлхий нийтэд мөрдөж буй энэ акт нь амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах үйл явцыг хянан зохицуулдаг олон улсын эрх зүйн үндсэн баримт бичиг юм.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн лавлах” хэмээх энэхүү бүтээлд 2012 онд УИХ-аар батлагдсан Байгаль орчныг хамгаалах тухай багц хууль (7 хуулийн шинэчилсэн найруулга, 2 шинэ хууль, бусад 15 хуульд нэмэлт, өөрчлөлт орсон)-ийн өөрчлөлт болон шинэчлэгдэн гарсан тогтоол шийдвэр, дүрэм журмыг тусгах талаар онцгойлон анхаарсан бөгөөд экспорт, реэкспорт, импортын зөвшөөрөл олгогч талуудын үүрэг, оролцоо, дараалалд орсон өөрчлөлт, холбогдох хууль тогтоомж, шийдвэрүүдийг тусгалаа.

Мөн Монгол улсын хөхтний Улаан данс (2006), Монгол орны хоёрнутагтан, мөлхөгчдийн Улаан данс (2006), Монгол орны шувууны Улаан данс (2011), Монгол орны ургамлын Улаан данс (2011), Монгол улсын Улаан ном (2013; 2016) зэрэг сүүлд хэвлэгдсэн ном, бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, ажлуудаар тус номын

мэдээ баримт, агуулгыг баяжуулан сайжруулж, Монгол улсаас энэ конвенцийн нэг, хоёрдугаар хавсралтад бүртгэгдсэн ургамал, амьтны зүйлүүдийн мэдээллийг ойлгомжтой, хүртээмжтэй болгох талаар онцгойлон анхаарч ажиллалаа. Тодруулж хэлэхэд, Монгол улсаас энэ конвенцийн нэг, хоёрдугаар хавсралтад бүртгэгдсэн ургамал, амьтны зүйлүүдийн Шинжлэх ухааны нэр буюу Латин нэрийг энэ конвенцийн албан ёсны вэбсайт (<https://www.cites.org/>, <http://checklist.cites.org>) дээрх Латин нэрийг баримтлан бичсэн болно.

Энэхүү бүтээлийн нэгдүгээр бүлэгт “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн албан ёсны орчуулгыг бүрэн эхээр нь болон тус конвенцийн Үндэсний удирдан зохицуулах зөвлөл, байгууллагууд, конвенцийн нэг, хоёрдугаар хавсралтад орсон зүйлүүдийг тайлбарын хамт орууллаа.

Хоёрдугаар бүлэгт конвенц (CITES)-ийн хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд эрхтэн, зүйлсийн экспорт, реэкспорт, импортлох дарааллыг бүдүүвч зургаар харуулж, тайлбарлав.


Гуравдугаар бүлэгт Монгол Улсаас тус конвенцийн нэг, хоёрдугаар хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамлуудыг ангилалзүйн нэгжээр нь ялган авч, зүйл тус бүрийн нэршил, ховордлын зэрэглэл, таних шинж, дэлхийд болон Монгол оронд тархсан байдал, амьдрах орчин, амьдралын онцлог, тоо толгой, хомсдох шалтгаан, худалдаа, хамгаалсан байдал, экологи, эдийн засгийн үнэлгээ ба хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэргийг тодорхой орууллаа.

Дөрөвдүгээр бүлэгт энэ конвенцийн хэрэгжилтийг дэмжих Монгол улсын бодлогын баримт бичгүүдийн тухай дурдаж, бусад хууль тогтоомж, эрх зүйн үндсэн баримт бичгүүдээс холбогдох зүйл, заалтуудыг хэсэгчлэн авч оруулсан болно.

Тус номыг хил, гааль, цагдаа, улсын мэргэжлийн хяналт, байгаль орчны ажилтнуудаар зогсохгүй оюутан сонсогчид, сонирхсон хэн бүхэнд зориулан шинэчлэн хүргэж байна.

Энэхүү бүтээл нь дэлхий дахины өмнө Монголчууд бидний хүлээсэн үүргээ биелүүлэх их аяны нэгэн дөрөө болох болтугай!

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Байгаль хамгааллын асуудал хариуцсан захирал


Б.ЧИМЭДДОРЖ

ТОВЧИЛСОН ҮГС

АНУ – Америкийн Нэгдсэн Улс
АНЭУ – Арабын Нэгдсэн Эмират Улс
БНАСАУ – Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс
БНСУ – Бүгд Найрамдах Солонгос Улс
БНМАУ – Бүгд Найрамдах Монгол Ард Улс (хуучин нэрээр)
БНУ – Бүгд Найрамдах Улс
БОАЖЯ – Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ГЕГ – Гаалийн ерөнхий газар
ДБХХ (IUCN) – Дэлхийн байгаль хамгаалах холбоо
Конвенц (CITES) – Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц
НҮБ – Нэгдсэн Үндэсний Байгууллага
ОХУ – Оросын Холбооны Улс
Төв Африкийн БНУ – Төв Африкийн Бүгд Найрамдах Улс
УИХ – Улсын Их Хурал
ХБНГУ – Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХЕГ – Хил хамгаалах ерөнхий газар
ШУА – Шинжлэх Ухааны Академи
CMS – Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (Бонны конвенц)



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН АЙМГИЙН
ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД
ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CITES), ТҮҮНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ БАЙГУУЛЛАГА БОЛОН
ХАВСРАЛТАД БҮРТГЭГДСЭН ЗҮЙЛҮҮДИЙН ТУХАЙ

1.1

ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CITES)

УДИРТГАЛ

ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУД:

- Зэрлэг амьтан, ургамлын аймаг нь олон төрөл зүйл, үзэсгэлэнт сайхан болоод янз бүрийн хэлбэр төрхөөрөө энэ ертөнцийн байгалийн тогтолцооны орлуулшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тэдгээрийг хамгаалж өнөөгийн болоод хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээх ёстойг хүлээн зөвшөөрч;
 - Гоо зүй, шинжлэх ухаан, соёл, амралт, эдийн засгийн үүднээс зэрлэг амьтан, ургамлын аймгийн үнэ цэнэ улам бүр өсөн нэмэгдэж буйг ухамсарлан;
 - Ард түмэн, улс гүрнүүд нь зэрлэг амьтан, ургамлын аймгаа хамгийн сайн хамгаалагчид байх ёстойг хүлээн зөвшөөрч;
 - Түүнчлэн зэрлэг амьтан, ургамлын зарим зүйлийг олон улсын хэмжээнд хэтрүүлэн ашиглах явдлыг зохицуулахад олон улсын хамтын ажиллагаа нэн шаардлагатай байгааг мөн хүлээн зөвшөөрч;
 - Энэ зорилгын үүднээс зохих арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай байгаад Бат итгэж;
- Дараах зүйлийг харилцан тохиролцов:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ ТОДОРХОЙЛОЛТ

Утгын хувьд өөр агуулга шаардагдахгүй бол энэхүү Конвенцийн зорилгод;

- а “ЗҮЙЛ” гэж аливаа амьтан, ургамлын зүйл, салбар зүйл, мөн тэдгээрийн газар зүйн хувьд тусгаарлагдмал бүлийг хэлнэ.
- б “БИЕТ” гэж дараах байдлыг хэлнэ;
 - (i) амьд байгаа аливаа амьтан, ургамал, эсвэл тэдгээрийн цогцос, үлдэгдэл;
 - (ii) амьтны тухайд: нэг, хоёрдугаар хавсралт дахь зүйлүүдийн хувьд тэдгээрийн хялбархан танигдах аливаа эд хэсэг буюу амьтны гаралтай зүйлс, 3 дугаар хавсралт дахь зүйлүүдийн хувьд мөн хавсралтад тодорхойлсон хялбархан танигдах эд хэсэг буюу амьтны гаралтай зүйлс;
 - (iii) ургамлын тухайд: нэгдүгээр хавсралт дахь зүйлүүдийн хувьд тэдгээрийн хялбархан танигдах аливаа эд хэсэг буюу тэдгээрийн гаралтай зүйлс;
- в “ХУДАЛДАА” гэдэгт экспорт, импорт, реэкспорт, далай тэнгисээс олзворлон оруулж ирэх үйл ажиллагаа багтана.
- г “РЕЭКСПОРТ” гэж урьд нь импортоор оруулж ирсэн аливаа биетийг экспортлож гаргахыг хэлнэ.
- д “ДАЛАЙ, ТЭНГИСЭЭС ОЛБОРЛОН ОРУУЛАХ” гэж аль ч улс оронд харъяалагддаггүй далай, тэнгисийн орчноос аливаа зүйлийн төлөөлөх биетийг олзворлож, аль нэг улсад тээвэрлэн оруулахыг хэлнэ.

- е “ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙГУУЛЛАГА” гэж энэ Конвенцийн есдүгээр зүйлд заасны дагуу байгуулагдсан Үндэсний шинжлэх ухааны эрх бүхий байгууллагыг хэлнэ.
- ё “УДИРДАН ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГА” гэж

энэ Конвенцийн есдүгээр зүйлд заасны дагуу байгуулагдсан Үндэсний Удирдан зохицуулах байгууллагыг хэлнэ

- ж “ТАЛ” гэж энэхүү Конвенцийг хүчин төгөлдөр болохыг хүлээн зөвшөөрсөн улс, орныг хэлнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ ҮНДСЭН ЗАРЧМУУД

- 1 Нэгдүгээр хавсралтад устгах аюулд орсон, худалдаалах үйл ажиллагаанд өртөгдөж байгаа буюу цаашид өртөгдөж болох бүх зүйлүүд багтана. Эдгээр зүйлүүдийн төлөөлөх биетүүдийг худалдаалахыг зөвхөн онцгой нөхцөлд зөвшөөрөх ба худалдаалах үйл ажиллагааг тэдгээрийн оршин тогтнох байдалд аюул занал учруулахгүйгээр хатуу хяналт, зохицуулалтын дор явуулна.
- 2 Хоёрдугаар хавсралтад дараах зүйл багтана:
 - а Хэдийгээр эдүүгээ устгах аюул заналхийлээгүй боловч тэдгээрийн цаашид оршин тогтноход харшлахаар ашиглалт явуулахгүй байх үүднээс тэдгээрийн төлөөлөх биетийн худалдааг хатуу хяналт, зохицуулалтын дор явуулах шаардлагатай бүх зүйлүүд;

- б Энэ зүйлийн 2 дахь хэсгийн “а”-д заасан зарим зүйлийг төлөөлөх биетийн худалдааг үр нөлөөтэй хяналтын дор явуулахын тулд хууль тогтоомжоор зохицуулагдах бусад зүйлүүд.
- 3 Гуравдугаар хавсралтад аливаа Талд ашиглах явдал гаргуулахгүй байх, түүнийг хязгаарлах зорилгоор өөрийн үндэсний хуулийн үйлчлэх хүрээнд зохицуулах шаардлагатай хэмээн тодорхойлж, тэдгээрийг худалдаалах явдлыг хянахад бусад Талуудтай хамтран ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа бүх зүйлүүд багтана.
- 4 Энэхүү Конвенцийн заалтуудыг зөрчиж нэг, хоёр, гуравдугаар хавсралтад орсон Зүйлүүдийн төлөөлөх биетийг худалдаалах явдлыг Талууд зөвшөөрөх ёсгүй.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТАД ОРСОН ЗҮЙЛҮҮДИЙН ТӨЛӨӨЛӨХ БИЕТИЙГ ХУДАЛДААЛАХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ

- 1 Нэгдүгээр хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх биетийг худалдаалах үйл ажиллагааг явуулахдаа энэ зүйлийн холбогдох заалтуудыг мөрдлөг болгоно.
- 2 Нэгдүгээр хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх аливаа биетийг экспортлохдоо экспортын зөвшөөрлийг урьдчилан авч танилцуулсан байх шаардлагатай. Экспортын зөвшөөрлийг зөвхөн дараах нөхцөлийг хангасан тохиолдолд олгоно.
 - а экспортлосноор уг зүйлийн оршин тогтноход хор хохирол учрахгүй гэсэн дүгнэлтийг экспортлогч орны Шинжлэх ухааны байгууллага гаргасан байх;
 - б уг биетийг олж авахдаа тухайн орны амьтан, ургамлын аймгийг хамгаалах талаарх хууль тогтоомжийг зөрчөөгүй болохыг экспортлогч орны Удирдан зохицуулах байгууллага магадласан байх;
 - в гадаадад гаргах аливаа амьд биетийг гэмтээхгүй, эрүүл мэндэд нь хор хохирол

учруулахгүй, тэдэнтэй ширүүн догшин харьцахгүй байх болон тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэн зохицуулсныг экспортлогч орны Удирдан зохицуулах байгууллага магадласан байх;

- г тухайн биетийг оруулах импортын зөвшөөрөл олгосон эсэхийг экспортлогч орны Удирдан зохицуулах байгууллага магадласан байх;
- 3 Нэгдүгээр хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх аливаа биетийг импортлохдоо импорт буюу импортын зөвшөөрөл, эсвэл реэкспортын гэрчилгээг урьдчилан авч танилцуулсан байх шаардлагатай. Импортын зөвшөөрлийг зөвхөн дараах нөхцөлийг хангасан тохиолдолд олгоно:
 - а тухайн зүйл оршин тогтноход импортын зорилго харшлахгүй гэсэн дүгнэлтийг импортлогч орны Шинжлэх ухааны байгууллага гаргасан байх;
 - б аливаа амьд биетийг хүлээн авахаар

төлөвлөж байгаа Тал нь зохих ёсоор тоногдсон зориулалтын байртай, арчилж маллах бололцоотой эсэхийг импортлогч орны Шинжлэх ухааны байгууллага магадласан байх;

- В тухайн биетийг худалдаалах зорилгоор ашиглахгүй болохыг импортлогч орны Удирдан зохицуулах байгууллага тодруулсан байх.
- 4 Нэгдүгээр хавсралтад орсон зүйлүүдийг төлөөлөх аливаа биетийг реэкспортлох гаргахдаа реэкспорын гэрчилгээг урьдчилан авч танилцуулсан байх шаардлагатай. Реэкспорын гэрчилгээг зөвхөн дараах нөхцөлийг хангасан тохиолдолд олгоно:
 - а уг биетийг тухайн оронд импортлох оруулахдаа энэхүү Конвенцийг мөрдлөг болгосныг реэкспортлогч орны Удирдан зохицуулах байгууллага магадласан байх;
 - б аливаа амьд биетийг гэмтээхгүй, эрүүл мэндэд нь хор хохирол учруулахгүй, тэдэнтэй ширүүн догшин харьцахгүй байх болон тээвэрлэх нөхцлийг аль болохоор бүрдүүлэн зохицуулсныг реэкспортлогч орны Удирдан зохицуулах байгууллага тодруулсан байх.

В импортоор оруулах аливаа амьд биетэд импортын зөвшөөрөл олгох эсэхийг реэкспортлогч орны Удирдан зохицуулах байгууллага магадласан байх.

- 5 Нэгдүгээр хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх аливаа биетийг далай тэнгисээс олзворлон авч оруулахын тулд оруулагч орны Удирдан зохицуулах байгууллагаас урьдчилан гэрчилгээ авсан байх шаардлагатай. Гэрчилгээг зөвхөн дараах нөхцөлийг биелүүлсэн тохиолдолд олгоно:
 - а аливаа зүйлийг олзворлож оруулснаар тухайн зүйлийн цаашид оршин тогтноход хор хохирол учрахгүй гэсэн дүгнэлтийг оруулж буй орны Шинжлэх ухааны байгууллага гаргасан байх;
 - б уг амьд биетийг хүлээн авахаар төлөвлөж байгаа Тал нь шаардлагын дагуу тоногдсон зориулалтын байртай, арчилж маллах бололцоотой эсэхийг оруулагч орны Удирдан зохицуулах байгууллага магадласан байх.
 - в тухайн биетийг худалдаалах зорилгоор ашиглахгүй болохыг оруулж байгаа орны Удирдан зохицуулах байгууллага тодруулсан байх.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ ХОЁРДУГААР ХАВСРАЛТАД ОРСОН ЗҮЙЛҮҮДИЙН ТӨЛӨӨЛӨХ БИЕТҮҮДИЙГ ХУДАЛДААЛАХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ

- 1 Хоёрдугаар хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх аливаа биетүүдийг худалдаалах бүх ажиллагааг явуулахдаа энэ зүйлийг мөрдлөг болгоно.
- 2 Хоёрдугаар хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх аливаа биетийг экспортлохын тулд экспортын зөвшөөрлийг урьдчилан авч танилцуулсан байх шаардлагатай. Экспортын зөвшөөрлийг зөвхөн дараах нөхцөлийг хангасан тохиолдолд олгоно:
 - а Экспортод гаргаснаар тухайн зүйлийн оршин тогтноход хор хохирол учрахгүй гэсэн дүгнэлтийг экспортлогч орны Шинжлэх ухааны байгууллага гаргасан байх;
 - б уг биетийг олж авахдаа тухайн орны амьтан, ургамлын аймгийг хамгаалах талаарх хууль тогтоомжийг зөрчөөгүй болохыг экспортлогч орны Удирдан зохицуулах байгууллага магадласан байх;
 - в аливаа амьд биетийг гэмтээхгүй, эрүүл

мэндэд нь хор хохирол учруулахгүй, тэдэнтэй ширүүн догшин харьцахгүй байх болон тээвэрлэх нөхцлийг аль болохоор бүрдүүлэн зохицуулсныг экспортлогч орны Удирдан зохицуулах байгууллага магадласан байх.

- 3 Талуудын Шинжлэх ухааны байгууллагууд нь хоёрдугаар хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх биетүүдийг гаргахад зориулж, тухайн улсаас олгосон экспортын зөвшөөрөл болон нэгдүгээр хавсралтад оруулснаас илүү өндөр түвшинд экосистемдээ байр суурь эзэлж байдаг аливаа зүйлийн төлөөлөх биетүүдийг экспортлох явдлыг хязгаарлах шаардлагатай гэж үзвэл тухайн зүйлийн төлөөлөх биетүүдийг экспортлох зөвшөөрлийг хязгаарлах арга хэмжээ авахыг холбогдох Удирдан зохицуулах байгууллагад зөвлөнө.
- 4 Хоёрдугаар хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх аливаа биетийг импортлохдоо экспортлох зөвшөөрөл буюу эсвэл

реэспортын гэрчилгээ урьдчилан авч танилцуулахыг шаардаж болно.

- 5 Хоёрдугаар хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх аливаа биетийг реэспортлоход урьдчилан реэспортын гэрчилгээ авч танилцуулах шаардлагатай. Реэспортын гэрчилгээг зөвхөн дараах нөхцөлийг биелүүлсэн тохиолдолд олгоно:
 - а уг биетийг тухайн оронд импортлохдоо энэхүү Конвенцийг мөрдлөг болгож байгааг реэспортлогч орны Удирдан зохицуулах байгууллага магадласан байх.
 - б аливаа амьд биетийг гэмтээхгүй, эрүүл мэндэд нь хор хохирол учруулахгүй, тэдэнтэй ширүүн дориун харьцахгүй байх болон тээвэрлэх нөхцөлийг аль болохоор бүрдүүлэн зохицуулсныг реэспортлогч орны Удирдан зохицуулах байгууллага магадласан байх.
- 6 Хоёрдугаар хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх аливаа биетийг далай тэнгисээс олзворлон авч оруулахдаа уг биетийг оруулагч орны Удирдан зохицуулах байгууллагаас урьдчилан гэрчилгээ авах шаардлагатай.

Гэрчилгээг зөвхөн дараах нөхцөлийг хангасан тохиолдолд олгоно:

- а олзворлон авч нэвтрүүлснээр тухайн биетийн оршин тогтноход аюул занал учруулахгүй гэсэн дүгнэлтийг оруулагч орны Шинжлэх ухааны байгууллага гаргасан байх;
 - б аливаа амьд биетийг гэмтээхгүй, эрүүл мэндэд нь хор хохирол учруулахгүй, тэдэнтэй ширүүн догшин харьцахгүй байх болон тээвэрлэх нөхцөлийг аль болохоор бүрдүүлэн зохицуулсныг олборлон авч оруулж байгаа орны Удирдан зохицуулах байгууллага магадласан байх.
- 7 Энэ зүйлийн 6 дахь хэсэгт дурдсан гэрчилгээг Шинжлэх ухааны байгууллагын зөвлөмжийг үндэслэн нэг жилээс илүүгүй хугацаагаар олгож болох ба олгох хугацаа, тухайн хугацаанд оруулах биетүүдийн нийт тооны талаар үндэсний шинжлэх ухааны бусад байгууллагууд, шаардлагатай гэж үзвэл олон улсын шинжлэх ухааны байгууллагуудтай санал солилцсон байна.

ТАВДУГААР ЗҮЙЛ

ГУРАВДУГААР ХАВСРАЛТАД ОРСОН ЗҮЙЛҮҮДИЙН ТӨЛӨӨЛӨХ БИЕТҮҮДИЙГ ХУДАЛДААЛАХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ

- 1 Гуравдугаар хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх биетүүдийг худалдаалах бүх үйл ажиллагааг явуулахдаа энэ зүйлийг мөрдлөг болгоно.
- 2 Гуравдугаар хавсралтад тэрхүү зүйлийг оруулсан аливаа орноос уг хавсралтад орсон зүйлийн төлөөлөх аливаа биетийг экспортлохдоо урьдчилан экспортлох зөвшөөрөл авч танилцуулах шаардлагатай. Экспортлох зөвшөөрлийг зөвхөн дараах нөхцөлийг биелүүлсэн тохиолдолд олгоно:
 - а уг биетийг олж авахдаа тухайн орны амьтан, ургамлын аймгийг хамгаалах талаарх хууль тогтоомжийг зөрчөөгүй болохыг экспортлогч орны Удирдан зохицуулах байгууллага магадласан байх.
 - б аливаа амьд биетийг гэмтээхгүй, эрүүл мэндэд нь хор хохирол учруулахгүй, тэдэнтэй ширүүн догшин харьцахгүй байх

болон тээвэрлэх нөхцөлийг аль болохоор бүрдүүлэн зохицуулсныг экспортлогч орны Удирдан зохицуулах байгууллага магадласан байх.

- 3 Энэ зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад нөхцөлд гуравдугаар хавсралтад орсон зүйлийн төлөөлөх аливаа биетийг импортлоход түүний гарал үүслийн гэрчилгээг урьдчилан танилцуулах ба хэрэв уг биетийг гуравдугаар хавсралтад оруулсан орноос импортлож байгаа бол экспортлох зөвшөөрөл авч танилцуулах шаардлагатай.
- 4 Реэспортлох тохиолдолд тухайн биетийг тэр оронд боловсруулан реэспортоор гаргаж байгаа болохыг нотолж реэспортлогч орны Удирдан зохицуулах байгууллагаас олгосон гэрчилгээг импортлогч орон тухайн биетийн талаар энэхүү Конвенцийн заалтууд хэрэгжиж буйг батлах баримт болгон хүлээж авна.

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ ЗӨВШӨӨРӨЛ БА ГЭРЧИЛГЭЭ

- 1 Гурав, дөрөв, тавдугаар зүйлийн заалтуудын дагуу олгосон зөвшөөрөл ба гэрчилгээ нь энэ заалтуудтай тохирч байх ёстой.
- 2 Аливаа экспортын зөвшөөрөл нь дөрөвдүгээр хавсралт дахь албан загварт заасан мэдээ баримтыг өөртөө агуулах ба түүнийг олгосон өдрөөс хойш зургаан сарын хугацаанд ашиглаж болно.
- 3 Зөвшөөрөл гэрчилгээ бүрт энэ Конвенцийн нэр, олгосон Удирдан зохицуулах байгууллагын нэр, тамга, мөн байгууллагаас олгосон хяналтын дугаар байна.
- 4 Удирдан зохицуулах байгууллагаас олгосон бүх зөвшөөрөл буюу гэрчилгээн дээр хувь/хуулбар гэж тодорхой тэмдэглэсэн байх бөгөөд тэдгээрийг сунгаж баталгаажуулалгүйгээр жинхэнэ эх хувийн оронд ашиглаж болохгүй.
- 5 Аль нэг хэсэг биетийг тээвэрлэхэд жич зөвшөөрөл буюу гэрчилгээ авах шаардлагатай.
- 6 Аливаа биетийг импортлогч орны Удирдан зохицуулах байгууллага нь экспортын зөвшөөрөл, реэкспортын гэрчилгээ, мөн тухайн биетийг импортлохтой холбогдсон аливаа зөвшөөрлийг хүчингүй болгох, эсвэл хэвээр үлдээх эрх эдэлнэ.
- 7 Удирдан зохицуулах байгууллага аливаа биетийг тодорхойлох үйл ажиллагааг хялбар болгохын тулд түүний тохиромжтой, боломжтой газар нь тэмдэг тавьж болно. Энэ зорилгоор “ТЭМДЭГ” гэдэг нь аливаа биетийг тодорхойлон тогтоох зориулалттай, үл арилах дардас, тугалган лац байх бөгөөд аливаа хүмүүс түүнийг дуурайлган үйлдэхэд аль болох төвөгтэй байхаар хийсэн байна.

ДОЛДУГААР ЗҮЙЛ ХУДАЛДААНД ҮЛ ХАМААРАХ БОЛОН БУСАД ОНЦГОЙ ЗААЛТУУДЫН ТУХАЙ

- 1 Гурав, дөрөв, тавдугаар зүйлийн заалтуудыг тухайн биетүүдийг гаалийн хяналтад байгаа үед аль нэг Талын нутгаар тээвэрлэн өнгөрөх юмуу тухайн нутаг дэвсгэрт тээвэрлэхэд хэрэглэхгүй.
 - 2 Энэхүү Конвенцийн заалтуудыг тухайн биетэд хэрэглэхээс өмнө уг биетийг олж авсныг экспортлогч болон импортлогч орны Удирдан зохицуулах байгууллага магадласан тохиолдолд гурав, дөрөв ба тавдугаар зүйлийн заалтуудыг хэрэглэхгүй бөгөөд Удирдан зохицуулах байгууллага үүнийг нотолж гэрчилгээ олгоно.
 - 3 Гурав, дөрөв, тавдугаар зүйлийн заалтуудыг гэрийн мал, хувийн амьтан, ургамлын зүйлүүдэд хэрэглэхгүй. Эдгээр үл хамаарах тухай заалтыг дараах нөхцөлд хэрэглэхгүй:
 - а Нэгдүгээр хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх биетүүдийг эзэд нь байнга оршин суугаа орноос өөр газраас олж авсан бөгөөд уг биетийг оршин суудаг орондоо импортолж байгаа тохиолдолд;
 - б Хоёр дугаар хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх биетүүдийн хувьд:
 - тэдгээрийг эзэн нь байнга оршин суугаа орноос өөр аль нэг улсын зэрлэг амьтан, ургамлын аймгаас олж авсан бол;
 - зэрлэг амьтан, ургамлынхаа аймгаас
 - 4 Нэгдүгээр хавсралтад орсон амьтны зүйлүүдийн төлөөлөх биетийг худалдаалах зорилгоор хорионд өсгөн үржүүлж юмуу ургамлын зүйлүүдийн төлөөлөх биетийг тарьж ургуулж байгаа бол хоёрдугаар хавсралт дахь зүйлүүдийн биетүүдэд хамааруулж үзнэ.
 - 5 Хэрэв амьтны зүйлийг төлөөлөх ямар нэг биетийг хорионд өсгөн үржүүлсэн буюу ургамлын зүйлийн төлөөлөх биетийг тарьж ургуулсан, эсвэл амьтан, ургамлын эд хэсэг, тэдгээрийн гаралтай зүйлс болохыг экспортлогч орны Удирдан зохицуулах байгууллага магадлан тогтоосон тохиолдолд тухайн байгууллагаас олгох үнэмлэхийг гурав, дөрөв, тавдугаар зүйлийн заалтууд дахь зөвшөөрөл, гэрчилгээний оронд авна.
 - 6 Гурав, дөрөв, тавдугаар зүйлийн заалтууд нь тухайн орны Удирдан зохицуулах байгууллагад бүртгэлтэй эрдэмтэд буюу эрдэм шинжилгээний байгууллагуудын хооронд арилжааны бус зориулалтаар уг биетүүдийг олгосон орон, тэдгээрийг экспортлохын өмнө урьдчилан экспортын зөвшөөрөл олгохыг шаардаж байгаа бол.
- Энэхүү Конвенцийн заалтуудыг биетүүдийн хувьд хэрэглэхээс өмнө тэдгээрийг олж авсныг Удирдан зохицуулах байгууллага магадлаж тогтоосон тохиолдлыг үүнд хамааруулахгүй.

биетүүдийг түр хэрэглэх, бэлэглэх, дурсгах, солилцох, Удирдан зохицуулах байгууллагаас олгосон баталгаатай шошго бүхий биетүүдийг цуглуулга, музейд зориулан хадгалж, хатаасан, эсвэл ариутгасан биетүүд, амьд ургамал, тэдгээрийн эд хэсгийг шилжүүлэх зэрэгт хамаарахгүй.

- 7 Аль нэг улсын Удирдан зохицуулах байгууллага гурав, дөрөв, тавдугаар зүйлийн шаардлагаас татгалзаж, амьтны нүүдлийн хүрээлэн, цирк, амьтан, ургамлын үзэсгэлэн буюу бусад төрлийн явуулын үзүүлбэрийн хэсгийг зөвшөөрөл ба гэрчилгээгүйгээр тээвэрлэхийг

дараах нөхцөлийг хангасан тохиолдолд зөвшөөрч болно. Үүнд:

- а экспортлогч буюу импортлогч нь Удирдан зохицуулах байгууллагад тухайн биетүүдээ тодорхой бүртгүүлсэн байх;
- б тухайн биетүүд нь энэ зүйлийн 2, 5 дугаар заалтуудын аль нэгтэй тохирсон байх;
- в аливаа амьд амьтныг тээвэрлэх, маллахдаа гэмтээхгүй, эрүүл мэндэд нь хор хохирол учруулахгүй, тэдгээртэй ширүүн догшин харьцахгүй байх явдлыг дээд зэргээр эрхэмлэнэ гэдгийг Удирдан зохицуулах байгууллага магадласан байх.

НАЙМДУГААР ЗҮЙЛ ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУДААС АВАХ АРГА ХЭМЖЭЭ

- 1 Талууд энэхүү Конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэх болон энэ Конвенцийн заалтуудыг зөрчиж биетүүдийг худалдаалах явдлыг таслан зогсоох талаар холбогдох арга хэмжээг авна. Эдгээр арга хэмжээнд дараах асуудал хамаарна:

- а тухайн биетүүдийг худалдаалсан буюу эзэмшсэнийнх нь төлөө шийтгэл ногдуулах;
- б тухайн биетүүдийг хураан авах, эсвэл экспортолсон улсад нь эргүүлж өгөх зэрэг үйл ажиллагаа.

- 2 Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээнээс гадна тус Конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авсан арга хэмжээг зөрчиж худалдаалсан биетийг хураасны улмаас учирсан хохирлыг аливаа Тал дотооддоо нөхөн төлөх талаар ямар нэгэн механизм хэрэглэж болно.

- 3 Биетүүдийг худалдаалах үйл ажиллагаанд хяналт, шалгалт тавихдаа тэдгээрийг аль болохоор саатуулахгүйгээр нэвтрүүлэхэд Талууд бололцооныхоо хэрээр дэмжлэг үзүүлнэ. Дээрх нөхцөлийг хангах үүднээс аливаа Талууд нь биетүүдээ шалгуулж нэвтрүүлэх хилийн боомтоо сонгон авч болно. Үүний сацуу Талууд дамжуулан өнгөрүүлэх, зогсоолд байлгах, тээвэрлэх аль ч үед тухайн бүх амьд биетүүдэд зохих анхаарал тавьж, тэдгээрийг гэмтээхгүй, эрүүл мэндэд нь хор хохирол учруулахгүй, тэдэнтэй ширүүн догшин харьцахгүй байх нөхцөлийг аль болох хангах үүрэг хүлээнэ.

- 4 Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээний дагуу амьд биетийг хураан авч байгаа бол:

- а тухайн биетийг хураан авсан орны

Удирдан зохицуулах байгууллагын мэдэлд шилжүүлж маллуулах;

- б Удирдан зохицуулах байгууллага экспортлогч оронтой зөвлөсний дараа уг биетийг тухайн орны өөрийнх нь зардлаар буцаах, эсвэл Аврах төвд юмуу энэхүү Конвенцийн зорилгод нийцэх өөр аль нэг газар шилжүүлэх;

- в энэ зүйлийн 6-д заасны дагуу шийдвэр гаргахад тус дөхөм үзүүлэх ба түүний дотор аврах төв буюу өөр газрыг сонгохын тулд Удирдан зохицуулах байгууллага нь шинжлэх ухааны байгууллагаас зөвлөгөө авах, шаардлагатай гэж үзвэл Нарийн бичгийн дарга нарын газартай санал бодлоо солилцож болно.

- 5 Энэ зүйлийн 4 дэх хэсэгт дурдсан Аврах төв гэдэг нь амьд биетүүдийг, тухайлбал хураагдсан зүйлүүдийг харж хандаж байх үүргийг Удирдан зохицуулах байгууллагаас авсан байгууллага юм.

- 6 Талууд нэг, хоёр, гуравдугаар хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх биетүүдийг худалдаалж байгаа талаар бүртгэл хөтлөх бөгөөд тэр нь дараах мэдээ баримтыг өөртөө агуулна:

- а экспортлогч ба импортлогчийн нэр хаяг;
- б олгосон зөвшөөрөл, гэрчилгээний тоо, төрөл, уг худалдааг хийсэн улс орны нэр, нэг, хоёр, гуравдугаар хавсралтад орсон зүйлүүдийн нэрс хийгээд тэднийг төлөөлөх биетүүдийн тоо, төрөл, шаардлагатай бол биетийн хэмжээ, хүйс.

- 7 Талууд энэхүү Конвенцийг хэрэгжүүлж буй талаар дор дурдсан хугацаанд тайлан бэлтгэж Нарийн бичгийн дарга нарын газарт явуулна:

- а энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан мэдээллийн талаарх тайланг жил бүр;
- б энэхүү Конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль тогтоомж, захиргааны ба зохицуулах арга хэмжээний

талаарх тайланг хоёр жилд нэг удаа.

- 8 Хэрэв тухайн Талын хууль тогтоомжид харшлахгүй бол энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан мэдээллийг олон нийтийн хүртэл болгож болно.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ УДИРДАН ЗОХИЦУУЛАХ БА ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙГУУЛЛАГУУД

- 1 Талууд энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор дараах байгууллагыг байгуулна:
 - а Тухайн Талын нэрийн өмнөөс зөвшөөрөл, гэрчилгээ олгох эрх бүхий нэг буюу хэд хэдэн Удирдан зохицуулах байгууллага;
 - б нэг буюу хэд хэдэн Шинжлэх ухааны байгууллага.
- 2 Улс орнууд энэхүү Конвенцийг батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн эсвэл нэгдэн орсон тухай баримт бичгээ эх бичиг Хадгалагч улсын Засгийн газарт өгч бусад Талуудтай болон Нарийн бичгийн дарга нарын газартай харилцаж байх, Удирдан зохицуулах

байгууллагынхаа нэр, хаягийг мэдэгдэнэ.

- 3 Энэ зүйлийн заалтуудын дагуу томилолт, эрх олгохтой холбоотой аливаа өөрчлөлтийг Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан холбогдох Тал, бусад Талуудад мэдэгдэнэ.
- 4 Энэ зүйлийн 2 дахь хэсэгт нэрлэгдсэн Удирдан зохицуулах байгууллага нь Нарийн бичгийн дарга нарын газар, эсвэл бусад Талуудын Удирдан зохицуулах байгууллагаас шаардсан тохиолдолд өгсөн зөвшөөрөл, гэрчилгээнийхээ хуурамч бус болохыг нотолж тамга, тэмдэг болон бусад хэрэгслийн дардсыг хүргүүлнэ.

АРАВДУГААР ЗҮЙЛ КОНВЕНЦИД НЭГДЭН ОРООГҮЙ ОРНУУДАЙ ХУДАЛДАА ХИЙХ ТУХАЙ

Энэхүү Конвенцид нэгдэн ороогүй оронд экспортлох, реэкспортлох буюу тэндээс импортлох тохиолдолд тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон энэ Конвенцийн зөвшөөрөл, гэрчилгээний

шаардлагыг үндсэнд нь хангасан адил төстэй баримт бичгийг аливаа Тал албан ёсны зөвшөөрөл, гэрчилгээний нэгэн адил хүлээн авч болно.

АРВАННЭГДҮГЭЭР ЗҮЙЛ ТАЛУУДЫН БАГА ХУРАЛ

- 1 Энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 жилийн дотор хэлэлцэн тохирогч Талуудын Бага хурлын чуулганыг Нарийн бичгийн дарга нарын газраас зарлан хуралдуулна.
- 2 Хэрэв Бага хурал өөрөөр шийдвэрлээгүй бол Нарийн бичгийн дарга нарын газар цаашид ээлжит чуулганыг хамгийн цөөнөөр бодоход хоёр жилд нэг удаа, онц чуулганыг Талуудын гуравны нэгээс доошгүй нь бичгээр хүсэлт гаргасны үндсэн дээр хуралдуулж байна.
- 3 Талууд ээлжит болон онц чуулганы үеэр энэхүү Конвенцийн хэрэгжилтийн явцыг дараах чиглэлээр хэлэлцэж шийдвэрлэнэ:
 - а Нарийн бичгийн дарга нарын газар үүргээ биелүүлэх бололцоо бүрдүүлэхэд

шаардлагатай шийдвэр гаргах, санхүүгийн талаарх заалтуудыг батлах;

- б Арвантавдугаар зүйлийн дагуу нэг, хоёрдугаар хавсралтад оруулах өөрчлөлтийг хэлэлцэн батлах;
- в Нэг, хоёр, гуравдугаар хавсралтад оруулсан зүйлүүдийг нөхөн сэргээх, хамгаалах талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэх;
- г Нарийн бичгийн дарга нарын газар болон аль нэг Талын оруулсан илтгэлийг хүлээн авч хэлэлцэх;
- д Шаардлагатай үед энэхүү Конвенцийн үр нөлөөг дээшлүүлэх талаар зөвлөмж гаргах.
- 4 Ээлжит чуулганаар Талууд энэ зүйлийн 2 дахь

хэсэгт заасны дагуу хуралдуулах дараачийн ээлжит чуулганы хугацаа, газрыг товлону.

- 5 Аль нэг хуралдаанаар Талууд чуулганы дүрэм, дэгийг тодорхойлон баталж болно.
- 6 НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, Олон улсын цөмийн эрчим хүчний агентлаг, түүнчлэн энэхүү Конвенцид нэгдэн ороогүй аливаа орон Бага хурлын чуулганд ажиглагчаар оролцож болох бөгөөд асуудал хэлэлцэхэд зөвхөн оролцох эрхтэй, харин санал өгөх эрхгүй байна.
- 7 Амьтан, ургамлын аймгийг хамгаалах хийгээд энэ чиглэлийн менежментийн салбарт мэргэшсэн дараах байгууллагууд Бага хурлын

чуулганд ажиглагчаа илгээх хүсэлтээ Нарийн бичгийн дарга нарын газарт тавьж Талуудын гуравны хоёроос доошгүй нь зөвшөөрвөл ажиглагчаар оролцоно:

- а Олон улсын байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагууд, үндэсний засгийн газрын байгууллагууд;
- б Энэ зорилгоор тухайн улс орноос томилогдсон үндэсний засгийн газрын байгууллагууд.

Ажиглагчид чуулганд оролцоходоо асуудлыг хэлэлцэхэд оролцох эрх эдлэх ба санал өгөх эрхгүй байна.

АРВАНХОЁРДУГААР ЗҮЙЛ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН ГАЗАР

- 1 Энэхүү Конвенц хүчин төгөлдөр болмогц НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Гүйцэтгэх захирал Нарийн бичгийн дарга нарын газрыг зохион байгуулах үүрэг хүлээнэ.
Тэрээр өөрийн зохимжтой гэж үзсэн арга барилаар ажиллах бөгөөд түүнд амьтан, ургамлын аймгийг хамгаалах, энэ чиглэлийн менежментийн салбарт мэргэшсэн Засгийн газар хоорондын болон Засгийн газрын бус, Олон улсын үндэсний байгууллагууд тусална.
- 2 Нарийн бичгийн дарга нарын газрын үүрэгт дараах асуудал багтана.
 - а Хэлэлцэн тохирогч Талууд Бага хурлын чуулганыг зохион байгуулах, түүнд үйлчлэх;
 - б Энэхүү Конвенцийн арван тав, арван зургадугаар зүйлийн заалтуудын дагуу өөрт ноогдсон үүргийг гүйцэтгэх;
 - в Талуудын Бага хурлаас баталсан хөтөлбөрийн дагуу шинжлэх ухаан, техникийн судалгаа явуулах, энэхүү Конвенцийг хэрэгжүүлэхэд түүний дотор амьд биетүүдийг бэлтгэж тээвэрлэх стандарт, тэдгээр биетийг тодорхойлох

аргын талаар судалгаа, шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх;

- г Талуудаас ирүүлсэн тайланг судалж үзэх, энэхүү Конвенцийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт мэдээлэл авах тухай хүсэлтийг Талуудад тавих;
- д Энэхүү Конвенцийн зорилгыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа асуудалд Талуудын анхаарлыг хандуулах;
- е Нэг, хоёр, гуравдугаар хавсралт болон тэдгээрт орсон зүйлүүдийн төлөөлөх биетүүдийг тодорхойлон тогтоохтой холбогдсон мэдээллийг хэвлэж Талуудад тараах;
- ж Талуудын ажил төрөл, Конвенцийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаарх жилийн тайлан болон Талуудын Бага хурлын чуулганаас хүссэн бусад тайлан мэдээг бэлтгэж Талуудад тараах;
- з Энэхүү Конвенцийн зорилго, заалтуудыг хэрэгжүүлэх, түүний дотор шинжлэх ухаан, техникийн чанартай мэдээлэл солилцох талаар зөвлөмж гаргах;
- и Талуудаас түүнд хүлээлгэсэн бусад үүргийг гүйцэтгэх.

АРВАНГУРАВДУГААР ЗҮЙЛ ОЛОН УЛСЫН АРГА ХЭМЖЭЭ

- 1 Нэг, хоёрдугаар хавсралтад орсон аль нэг зүйл, түүнийг төлөөлөх биетүүдийг худалдаалсны уршгаар сөрөг нөлөөлөлд орсон юмуу, эсвэл энэхүү Конвенцийн заалтууд нь амьдралд үр дүнтэй хэрэгжихгүй байгаа тухай мэдээллийг Нарийн бичгийн дарга нарын газар авбал

тухайн мэдээллийг холбогдох Тал буюу Талуудын Удирдан зохицуулах байгууллагад илгээнэ.

- 2 Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан мэдээллийг аль нэг Тал хүлээн авбал өөрийн орны хууль тогтоомжийн хүрээнд тухайн мэдээлэл, түүнд

холбогдох мэдээ баримтыг Нарийн бичгийн дарга нарын газарт аль болохоор богино хугацаанд мэдээлэх, шаардлагатай гэж үзвэл засаж залруулах талаар саналаа тавина. Хэрэв тухайн Тал шалган тодруулах нь зүйтэй гэж үзвэл тусгай эрх олгосон нэг буюу хэд

хэдэн хүнийг томилон шалгуулж болно.

- 3 Тухайн Талаас өгсөн буюу энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан шалгалтын үр дүнд олсон мэдээллийг Талуудын дараагийн Бага хурлаар хэлэлцэж, шаардлагатай гэж үзвэл зөвлөмж гаргаж болно.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ ЭНЭХҮҮ КОНВЕНЦ, УЛС ОРНУУДЫН ДОТООДЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ОЛОН УЛСЫН БУСАД КОНВЕНЦИУДЫН УЯЛДАА

- 1 Энэхүү Конвенцийн заалтууд ямар ч нөхцөлд Талуудын дараах эрхийг хөндөхгүй:
 - а Нэг, хоёр, гуравдугаар хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх биетүүдийг худалдаалах, олзворлох, эзэмших болон тээвэрлэх нөхцөлийн талаар дотооддоо илүү хүчтэй арга хэмжээ авах, эсвэл тэдгээр үйлдлийг бүрэн хориглох талаар арга хэмжээ авах;
 - б Нэг, хоёр, гуравдугаар хавсралтад ороогүй зүйлүүдийг худалдаалах, олзворлох, эзэмших ба тээвэрлэхийг хязгаарласан буюу хориглосон арга хэмжээг дотоодод авч хэрэгжүүлэх.
- 2 Энэхүү Конвенцийн заалтууд нь ямар ч нөхцөлд эдүгээ үйлчилж байгаа юмуу цаашид аль ч Талын хувьд хүчин төгөлдөр болж болох бөгөөд биетүүдийг арилжаалах, олзворлон авах, эзэмших ба тээвэрлэхтэй холбогдсон бусад асуудлын талаарх аливаа гэрээ, Конвенц болон олон улсын хэлэлцээрээр Талуудын хүлээсэн үүрэг, дотооддоо авсан буюу авах арга хэмжээний заалтуудыг, тэдгээрийн дотор гааль, хүн амын эрүүл мэнд, мал эмнэлэг болон ургамлын хорио цээр тогтоох талаар авах аливаа арга хэмжээг хэрхэвч хөндөхгүй.
- 3 Энэхүү Конвенцийн заалтууд нь ямар ч нөхцөлд хамтын ажиллагаа тогтоож буй улс орны хооронд байгуулсан юмуу байгуулж болох аливаа гэрээ хэлэлцээрийн заалтууд, тэдгээрийн дагуу улс орны хүлээсэн үүрэг ба холбоо, гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон улс орны хооронд хийгдэж буй арилжаа наймаанд хамаарагдах түвшинд гаалийн ерөнхий гадаад хяналт шалгалт тогтоосон буюу түүнийг цаашид мөрдөх, эсвэл тухайн хэлэлцээрт нэгдэн орсон орнуудын хооронд хийгдэж байгаа гаалийн хяналт, шалгалтыг

өөрчлөх талаарх бүс нутгийн худалдааны хэлэлцээрийг хөндөхгүй.

- 4 Энэхүү Конвенцид нэгдэн орсон улс уг Конвенцийг хүчин төгөлдөр болох үед үйлчилж байгаа бөгөөд хоёрдугаар хавсралтад орсон далай тэнгисийн амьтан, ургамлыг хамгаалахтай холбогдсон заалт бүхий ямар нэг өөр гэрээ, Конвенц ба Олон улсын хэлэлцээрт урьд өмнө нь нэгдэн орсон улс орныг тэрхүү гэрээ, Конвенц болон Олон улсын хэлэлцээрийн заалтын дагуу ажиллах эрхийг өөрсдөд нь үлдээж, хоёрдугаар хавсралтад орсон зүйлүүдийн төлөөлөх биетүүдийг тухайн улсад бүртгэлтэй хөлөг онгоцоор олзворлон авч худалдаалах талаар энэ Конвенцийн заалтаар хүлээсэн үүргээс чөлөөлнө.
- 5 Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу олж авсан аливаа биетийг экспортлоход, гурав, дөрөв, тавдугаар зүйлийн заалтуудыг үл хэрэгсэн, тухайн биетийг олзворлон нэвтрүүлэгч орны Удирдан зохицуулах байгууллагаас өөр гэрээ, Конвенц болон Олон улсын хэлэлцээрийн заалтуудын дагуу олзворлолт хийснийг нотолсон гэрчилгээ туйлын шаардлагатай байна.
- 6 Энэхүү Конвенцид НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2750С (XXY) дугаар тогтоолын дагуу хуралддаг Далай, тэнгисийн хуулийн асуудлаарх НҮБ-ын Бага хурлаар далай, тэнгисийн хуулийг нарийвчлан боловсруулах, мөн эдүүгээ болон цаашид далай, тэнгисийн хуулийн асуудал болоод эрэг хавийн улс орон, зонхилогч улс гүрний харъяаллын шинж чанар, хил заагийн талаар аливаа орноос мэдүүлэх зарга, баримтлах хууль ёсны байр суурьт хор хохирол учруулах зүйл огт байхгүй болно.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ НЭГ, ХОЁРДУГААР ХАВСРАЛТАД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

1 Бага хурлын чуулганы үеэр нэг, хоёрдугаар хавсралтад оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийн талаар дараах заалтуудыг мөрдөнө:

а аль ч Тал дараачийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр нэг, хоёрдугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал тавьж болно. Санал болгож буй өөрчлөлтийнхөө бүрэн эх бичвэрийг чуулган эхлэхээс 150 хоногийн өмнө Нарийн бичгийн дарга нарын газарт ирүүлсэн байна. Нарийн бичгийн дарга нарын газар энэ зүйлийн 2 дахь хэсгийн б, в-д заасны дагуу тэрхүү нэмэлт өөрчлөлтийн талаар бусад Талуудтай болон сонирхож буй байгууллагуудтай зөвлөлдөж, хариуг чуулган эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө бүх Талуудад мэдэгдэнэ.

б нэмэлт, өөрчлөлтийг оруулахад байлцаж, оролцсон Талуудын гуравны хоёрын буюу олонхийн саналаар батална. Энэ утгаараа санал хураахад байлцаж оролцсон Талууд гэдэг нь санал хураахад байлцаж “ЗӨВШӨӨРСӨН” буюу “ТАТГАЛЗСАН” санал өгсөн талуудыг хэлнэ. Нэмэлт, өөрчлөлтийг батлахад шаардлагатай гуравны хоёрт түдгэлзсэн Талуудын тоог оруулахгүй.

в чуулганаар баталсан нэмэлт, өөрчлөлтүүд нь энэ зүйлийн 3 дахь хэсгийн дагуу нэмэлт тайлбар хийгчдээс бусад бүх Талын хувьд уг чуулган болсоноос хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2 Бага хурлын чуулгануудын хооронд нэг, хоёрдугаар хавсралтад оруулах нэмэлт, өөрчлөлтийн хувьд дараах заалтуудыг мөрдөнө:

а энэ зүйлээр тогтоосон захидал харилцааны горим, журмын дагуу аль ч Тал чуулгануудын хооронд хэлэлцүүлэхээр нэг, хоёрдугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал тавьж болно.

б далай, тэнгисийн зүйлсийн хувьд санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн бүрэн эх бичвэрийг Нарийн бичгийн дарга нарын газар хүлээн авмагц түүнийг Талуудад нэн даруй илгээнэ. Тэрээр эдгээр зүйлтэй холбоотой ямар нэгэн үүрэг хүлээсэн засгийн газар хоорондын байгууллагатай, тодруулбал тэдгээр байгууллагаас өгч болох эрдэм шинжилгээний мэдээ

баримтыг олж авах, түүнчлэн байгаль хамгаалах талаар авч буй аливаа арга хэмжээг зохицуулах зорилгоор үүднээс зөвлөлдөнө. Нарийн бичгийн дарга нарын газар тэдгээр байгууллагуудын илэрхийлсэн санал, өгсөн мэдээлэл, өөрийн дүгнэлт болон зөвлөмжийг Талуудад аль болохоор шуурхай мэдээлнэ.

в далай тэнгисийн бус зүйлсийн хувьд санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн бүрэн эх бичвэрийг Нарийн бичгийн дарга нарын газар хүлээн авмагц түүнийг Талуудад нэн даруй илгээж, дараа нь өөрийнхөө зөвлөмжийг аль болохоор яаралтай явуулна.

г энэ зүйлийн б, в-д заасны дагуу Нарийн бичгийн дарга нарын газар, Талуудад өөрийн зөвлөмжөө илгээсэн өдрөөс хойш 60 хоногийн дотор аливаа Тал санал болгосон тухайн нэмэлт, өөрчлөлтийн талаарх санал, холбогдох эрдэм шинжилгээний мэдээ баримт, мэдээллийг Нарийн бичгийн дарга нарын газарт ирүүлж болно.

д Нарийн бичгийн дарга нарын газар хүлээн авсан бүх хариултыг өөрийн зөвлөмжийн хамт Талуудад аль болохоор шуурхай илгээнэ.

е хэрэв Нарийн бичгийн дарга нарын газар энэхүү зүйлийн ж-д заасны дагуу Талуудад хариулт, зөвлөмж илгээсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор уг санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн талаар татгалзсан хариулт аваагүй бол тухайн нэмэлт, өөрчлөлт энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу нэмэлт тайлбар хийгчдээс бусад бүх Талуудын хувьд 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

ж хэрэв Нарийн бичгийн дарга нарын газар аль нэг Талаас татгалзсан хариу авбал энэ зүйлийн з, и, к заалтын дагуу санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн талаар шуудангаар санал хураана.

з Нарийн бичгийн дарга нарын газар тухайн Талаас татгалзсан хариулт авсан тухайгаа бүх Талуудад мэдэгдэнэ.

и Нарийн бичгийн дарга нарын газар энэ зүйлийн з-д заасны дагуу мэдэгдсэн өдрөөс хойш 60 хоногийн дотор наад зах нь Талуудын тэн хагасаас “ЗӨВШӨӨРСӨН”, “ТАТГАЛЗСАН” эсвэл “ТҮДГЭЛЗСЭН”

гэж санал болгосон нэмэлт, өөрчлөлтийг Бага хурлын дараачийн чуулганаар хэлэлцүүлэхээр шилжүүлнэ.

- К хэрэв Талуудын тэн хагасаас санал авбал уг нэмэлт, өөрчлөлтийг Талуудын “ЗӨВШӨӨРСӨН” буюу “ТАТГАЛЗСАН” гэж өгсөн саналын гуравны хоёрын олонхоор батална.
- Л Нарийн бичгийн дарга нарын газар санал хураалтын дүнг Талуудад мэдээлнэ.
- М хэрэв санал болгосон нэмэлт, өөрчлөлт батлагдвал энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу нэмэлт тайлбар хийгчээс

бусад бүх Талын хувьд түүнийг баталсан тухай Нарийн бичгийн дарга нарын газар мэдэгдсэн өдрөөс хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

- 3 Энэ зүйлийн 1 дэх хэсгийн в, 2 дахь хэсгийн м-д заасан 90 хоногийн хугацаанд аль ч Тал тухайн нэмэлт, өөрчлөлтийн тухай эх бичиг Хадгалагч Засгийн газарт бичгээр мэдэгдэх замаар нэмэлт тайлбар хийж болно. Нэмэлт тайлбарыг цуцлаагүй Талыг тухайн зүйлүүдийг худалдаалахтай холбогдсон асуудлын хувьд энэхүү Конвенцид нэгдэн орсон улс гэж тооцохгүй.

АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ ГУРАВДУГААР ХАВСРАЛТ БА ТҮҮНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

- 1 Аль ч Тал Нарийн бичгийн дарга нарын газарт хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу үндэсний хууль тогтоомжийн хүрээнд зохицуулах шаардлагатай гэж үзэж байгаа зүйлүүдийн жагсаалтыг хүссэн цагтаа гарган өгч болно. Гуравдугаар хавсралтад оруулахаар зүйлүүдийнхээ нэрсийг өгсөн Талуудын нэр, танилцуулсан зүйлүүдийн шинжлэх ухааны нэр томъёо болон нэгдүгээр зүйлийн б-гийн заалтын дагуу эдгээр зүйлүүдтэй холбогдох амьтан, ургамлын аливаа эд хэсэг, тэдний гаралтай зүйлийн нэрсийг уг хавсралтад оруулна.
- 2 Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гаргаж өгсөн жагсаалт бүрийг Нарийн бичгийн дарга нарын газар хүлээн авсныхаа дараа тэдгээрийг Талуудад аль болохоор шуурхай илгээнэ. Тухайн жагсаалтыг Талуудад илгээсэн өдрөөс хойш 90 хоногийн дараа тэрээр гуравдугаар хавсралтын бүрэлдэхүүн хэсэгт тооцож хүчин төгөлдөр болно. Жагсаалтыг илгээсний дараа аль ч Тал хүссэн цагтаа эх бичиг Хадгалагч Засгийн газарт бичгээр мэдэгдэх замаар аливаа зүйл буюу эд хэсэг, тэдгээрийн гаралтай зүйлсийн талаар нэмэлт тайлбар

хийж болох бөгөөд тухайн улс нэгэнт хийсэн нэмэлт тайлбараа цуцлаагүй тохиолдолд тэдгээр зүйл, холбогдох эд хэсэг буюу түүний гаралтай зүйлсийг худалдаалах талаар энэхүү Конвенцид нэгдэн орсон улс гэж тооцохгүй.

- 3 Гуравдугаар хавсралтад оруулахаар аливаа зүйлийг тодорхойлсон Тал дуртай цагтаа Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэх замаар түүнийг хавсралтаас хасуулж болох ба Нарийн бичгийн дарга нарын газар энэ тухай Талуудад мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэн өдрөөс хойш 90 хоногийн дараа хавсралтаас хассанд тооцогдоно.
- 4 Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу жагсаалт гарган өгсөн аль ч Тал Нарийн бичгийн дарга нарын газарт тухайн зүйлийг хамгаалах талаар өөрийн орны бүх хууль тогтоомжийн хуулбар, тэрчлэн шаардлагатай гэж үзсэн юмуу Нарийн бичгийн дарга нарын газраас шаардсан аливаа тайлбар зэргийг хамт хүргүүлнэ. Тухайн зүйл гуравдугаар хавсралтад байгаа үед холбогдох Тал үндэсний хууль тогтоомжид оруулсан аливаа засвар, шинээр батлагдсан хууль тогтоомжийн тайлбарыг өгч байна.

АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ КОНВЕНЦИД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 1 Нарийн бичгийн дарга нарын газар энэхүү Конвенцид оруулах нэмэлт, өөрчлөлтийг авч хэлэлцэн батлах зорилгоор наад зах нь Талуудын гуравны нэгийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн Талуудын Бага хурлын онц чуулганыг зарлан хуралдуулна. Конвенцид оруулах нэмэлт, өөрчлөлтийг санал хураахад байлцаж оролцсон Талуудын гуравны хоёрын олонхийн саналаар батална. Энэ утгаар “САНАЛ ХУРААХАД БАЙЛЦАЖ ОРОЛЦСОН ТАЛУУД” гэдэг нь тэнд байж “ЗӨВШӨӨРСӨН” буюу “ТАТГАЛЗСАН” санал өгсөн Талуудыг хэлнэ. Түдгэлзсэн Талуудыг нэмэлт, өөрчлөлтийг батлахад шаардлагатай гуравны хоёрын тоонд оруулахгүй.
- 2 Санал болгосон аливаа нэмэлт, өөрчлөлтийн бүрэн эх бичвэрийг Нарийн бичгийн дарга нарын газар чуулган эхлэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө Талуудад мэдээлж байна.
- 3 Уг нэмэлт, өөрчлөлт нь түүнийг хүлээн зөвшөөрсөн Талуудын хувьд, Талуудын гуравны хоёр нь хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгээ эх бичиг Хадгалагч Засгийн газарт хадгалуулахаар өгснөөс хойш 60 хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Дараа нь нэмэлт, өөрчлөлт бусад Талуудын хувьд хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш 60 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 1 Энэхүү Конвенцийн заалтуудыг тайлбарлах буюу хэрэглэхтэй холбогдон хоёр буюу хэд хэдэн Талуудын хооронд үүссэн маргааныг уг маргаанд оролцогч Талууд хэлэлцэн тохиролцох замаар шийдвэрлэнэ.
- 2 Хэрэв маргааныг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийдвэрлэж чадахгүй бол Талууд харилцан тохиролцох замаар маргаанаа Арбитрт, тодруулбал Гаага дахь Арбитрын байнгын шүүхэд мэдүүлж болох бөгөөд маргаан мэдүүлсэн Талууд Арбитрын шийдвэрт захирагдана.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ

Энэхүү Конвенц нь Вашингтон хотноо 1973 оны 4 дүгээр сарын 30-ыг хүртэл, дараа нь Берн хотод 1974 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэлх хугацаанд гарын үсэг зурахад нээлттэй байна.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ СОЁРХОН БАТЛАХ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ БА САЙШААН ДЭМЖИХ

Энэхүү Конвенцийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн тухай баримт бичгээ Гэрээ хадгалагч Засгийн газар болох Швейцарийн Холбооны Улсын Засгийн газарт хадгалуулахаар өгнө.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ НЭГДЭН ОРОХ

Энэхүү Конвенцид нэгдэн орох боломж байнга нээлттэй байна. Нэгдэн орсон тухай Баримт бичгүүдийг Гэрээ хадгалагч Засгийн газарт өгч хадгалуулна.

ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 1 Энэхүү Конвенц нь батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн буюу түүнд нэгдэн орсон тухай арав дахь баримт бичгийг эх бичиг Гэрээ хадгалагч Засгийн газарт хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.
- 2 Энэхүү Конвенц нь соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн буюу түүнд нэгдэн орсон тухай арав дахь баримт бичгийг

хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш түүнийг батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн буюу түүнд нэгдэн орсон орнуудын хувьд энэхүү Конвенц нь тухайн улс орон түүнийг батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн буюу түүнд нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ НЭМЭЛТ ТАЙЛБАР

- 1 Энэхүү Конвенцийн заалтуудын талаар ерөнхий нэмэлт тайлбар хийхийг зөвшөөрөхгүй. Тодорхой нэмэлт тайлбарыг энэ зүйл ба 15, 16 дугаар зүйлийн заалтуудын дагуу оруулж болно.
- 2 Аливаа улс орон соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн буюу түүнд нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөхдөө тодорхой нэмэлт тайлбарыг дараах байдлаар хийж болно:
 - a Нэг, хоёр, гуравдугаар хавсралтад орсон

- аливаа зүйлийн талаар;
- 6 Гуравдугаар хавсралтад орсон зүйлүүдтэй холбогдуулан заасан аливаа эд хэсэг буюу тэдгээрийн гаралтай зүйлийн талаар.
 - 3 Энэ зүйлийн заалтуудын дагуу хийсэн нэмэлт тайлбараа холбогдох Тал цуцлаагүй тохиолдолд тэрхүү нэмэлт тайлбарт заасан зүйлүүд, эд хэсэг буюу тэдгээрийн гаралтай зүйлсийг худалдаалахтай холбогдсон асуудлын хувьд энэхүү Конвенцид нэгдэн ороогүй улс хэмээн үзнэ.

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ КОНВЕНЦИОС ГАРАХ

Аливаа Тал хүссэн цагтаа эх бичиг Хадгалагч Засгийн газарт бичгээр мэдэгдэж энэхүү Конвенциос гарч болно. Эх бичиг Хадгалагч

Засгийн газар уг мэдээллийг хүлээн авснаас хойш 12 сарын дараа Конвенциос гарах асуудал хүчин төгөлдөр болно.

ХОРИН ТАВДУГААР ЗҮЙЛ ГЭРЭЭ ХАДГАЛАГЧ

- 1 Энэхүү Конвенцийн Англи, Испани, Орос, Франц, Хятад хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй байх бөгөөд тэдгээрийг Гэрээ хадгалагч Засгийн газарт өгч хадгалуулна. Гэрээ хадгалагч Засгийн газар нь энэхүү Конвенцид гарын үсэг зурсан болон нэгдэн орсон тухай баримт бичгээ өгсөн бүх улсад Конвенцийн баталгаажуулсан хувийг илгээнэ.
- 2 Гэрээ хадгалагч Засгийн газар нь гарын үсэг зурсан, соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн буюу түүнд нэгдэн орсон тухай баримт бичгээ өгсөн, Конвенц хүчин төгөлдөр болсон, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан, тайлбар тавьсан, түүнээс гарах тухай мэдэгдэл авсан, тухайн Конвенцид

гарын үсэг зурсан, нэгдэн орсон бүх орон болон Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлж байна.

- 3 Энэхүү Конвенц хүчин төгөлдөр болмогц Гэрээ хадгалагч Засгийн газар түүний баталгаат хувийг НҮБ-ын Дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу бүртгүүлж, нийтлүүлэхээр НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газарт илгээнэ.

Дээр дурдсаныг нотолж бүрэн эрх бүхий дор нэр дурдсан төлөөлөгчид энэхүү Конвенцид гарын үсэг зурав.

Вашингтон хотноо нэг мянга есөн зуун далан гурван оны гуравдугаар сарын гуравны өдөр гарын үсэг зурав.

1.2

КОНВЕНЦИЙН ҮНДЭСНИЙ УДИРДАН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ БАЙГУУЛЛАГУУД

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн есдүгээр зүйлд талууд энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор тухайн Талын нэрийн өмнөөс зөвшөөрөл, гэрчилгээ олгох эрх бүхий нэг буюу хэд хэдэн Удирдан зохицуулах байгууллага, мөн Шинжлэх ухааны байгууллагатай байхаар тусгасан байдаг.

Улс орнууд энэхүү Конвенцийг батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн эсвэл нэгдэн орсон тухай баримт бичгээ эх бичиг Хадгалагч улсын Засгийн газарт өгч бусад Талуудтай болон Нарийн бичгийн дарга нарын газартай харилцаж байх Удирдан зохицуулах байгууллагын нэр, хаягийг мэдэгдэх үүрэгтэй. Үүний дагуу томилолт, эрх олгохтой холбоотой аливаа өөрчлөлтийг Нарийн бичгийн дарга

нарын газраар дамжуулан холбогдох Тал, бусад Талуудад мэдэгдэж байдаг. Удирдан зохицуулах байгууллага нь Нарийн бичгийн дарга нарын газар юмуу өөр бусад Талуудын Удирдан зохицуулах байгууллагаас шаардсан тохиолдолд өгсөн зөвшөөрөл, гэрчилгээ хуурамч бус болохыг нотолж тамга, тэмдэг болон бусад хэрэгслийн дардасыг хүргүүлэх үүрэг хүлээдэг.

Тус конвенцид нэгдэн ороогүй орнуудтай худалдаа хийх тохиолдолд конвенцид нэгдэн ороогүй оронд экспортлох, реэкспортлох буюу тэндээс импортлоход тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон энэ конвенцийн зөвшөөрөл, гэрчилгээний шаардлагыг үндсэнд нь хангасан адил төстэй баримт бичгийг аливаа Тал албан ёсны зөвшөөрөл, гэрчилгээний нэгэн адил хүлээн авах ёстой байдаг.

Хүснэгт 1. Конвенцид нэгдэн орсон талууд

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
1.	Australia (Австрали)	Wildlife Protection Environment Australia	
2.	Austria (Австри)	Bundesministerium für Land- und Forstwirtschaft, Umwelt und Wasserwirtschaft (Federal Ministry of Agriculture and Forestry, Environment and Water Management) Division for Nature Conservation and Species Protection	
3.	Azerbaijan (Азербайжан)	1. State Committee on Ecology and Nature Utilization Control 2. Ministry of Agriculture and Food of the Russian Federation Fisheries Department	(Зөвхөн шонхортны багийн зүйлд зөвшөөрөл олгоно)
4.	Algeria (Алжир)	1. Ministère algérien de l'agriculture Direction générale des forêts Direction de la protection de la flore et de la faune	
5.	USA (АНУ)	US Fish and Wildlife Service Division of Management Authority	
6.	Antigua and Barbuda (Антигуа ба Барбуда)	1. Ministry of Planning, Implementation and Public Service Affairs	
7.	United Arab Emirates (Арабын Нэгдсэн Эмират)	1. Ministry of Agriculture and Fisheries ABU DHABI 2. Ministry of Agriculture and Fisheries, DUBAI	
8.	Argentina (Аргентин)	1. Ministerio de Relaciones, Comercio Internacional y Culto Direccion General de Asuntos Ambientales 2. Ministerio de Desarrollo Social y Medio Ambiente Secretaria de Desarrollo Sustentable y Politica Ambiental Direccion de Fauna y Flora Silvestre	
9.	Afghanistan (Афганистан)	Forests and Range Department Ministry of Agriculture and Land Reforms KABUL	
10.	Nepal (Балба)	1. The Director General, Department of National Parks and Wildlife Conservation 2. The Director General, Department of Plant resources	(Амьтны зүйлд зөвшөөрөл олгоно) (Ургамлын зүйлд зөвшөөрөл олгоно)
11.	Bangladesh (Бангладеш)	1. The Chief Conservator of Forests and/y/et The Conservator of Forests, Government of the People's Republic of Bangladesh 2. The Chief Controller Import and Export	
12.	Barbados (Барбадос)	Permanent Secretary (Environment Division) Ministry of Health and the Environment	
13.	Baham (Бахам)	Ministry of Agriculture and Fisheries	
14.	Belarusian (Беларус)	Ministry of Natural Resources and Environmental Protection of the Republic of Belarus	
15.	Belize (Белизе)	The Chief Forest Officer Forest Department Ministry of Natural Resources	

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
16.	Belgium (Бельги)	Ministere des classes moyennes et de l'agriculture Service de la qualite et protection des vegetaux	(Амьтны зүйлд зөвшөөрөл олгоно) (Ургамлын зүйлд зөвшөөрөл олгоно)
17.	Benin (Бенин)	Direction des forets et des ressources naturelles Ministere du developpement rural	
18.	Bulgarian (Болгар)	1. National Nature Protection Service Directorate Ministry of Environment and Water	
19.	Bolivia (Боливи)	1. Ministerio de Desarrollo Sostenible y Planificacion Direccion General de Biodiversidad	
20.	Botswana (Ботсван)	1. Department of Wildlife and National Parks 2. Ministry of Agriculture	(Амьтны зүйлд зөвшөөрөл олгоно) (Ургамлын зүйлд зөвшөөрөл олгоно)
21.	Brazil (Бразил)	Instituto Brasileiro do Meio Ambiente e dos Recursos Naturais Renovaveis - IBAMA Departamento de Vida Silvestre (DEVIS/DIREC) Instituto Brasileiro do Meio Ambiente e dos Recursos Naturais Renovaveis - IBAMA Departamento de Transformacao e Comercializacao - DECOM/DIREN	(Модноос бусад зүйлд зөвшөөрөл олгоно) (Модны зүйлд зөвшөөрөл олгоно)
22.	Brunei (Бруней)	The Director of Museums Jabatan Muzium-Muzium Brunei (Department of Museums) Kementerian Kebudayaan Belia dan Sukan (Ministry of Culture, Youth and Sports)	
23.	Burkina Faso (Буркина Фасо)	Direction de la faune et des chasses Ministere de l'environnement et du tourisme	
24.	Burundi (Бурунди)	Institut national pour l'environnement et la conservation de la nature	
25.	Vanuatu (Вануату)	Environment Unit	
26.	Venezuela (Венесуэл)	1. Ministro del Ambiente y de los Recursos Naturales Renovables Atn: Director General Ministerio del Ambiente y de los Recursos Naturales Renovabtes (MARNR) 2. El Director General Sectorial y el Director de Servicios Técnicos Presidente de la Fundacion Instituto Botànico de Venezuela Avenida Salvador Allende Director General Sectorial del Servicio Autonomo Forestal Venezolano	(Амьтны зүйлд зөвшөөрөл олгоно) (Модноос бусад ургамлын зүйлд зөвшөөрөл олгоно) (Модны зүйлд зөвшөөрөл олгоно)
27.	Vietnam (Вьетнам)	Forest Protection Department Ministry of Agriculture and Rural Development	
28.	Gabon (Габон)	Direction de la faune et de la chasse Direction generale des eaux et forets Ministère des eaux et forêts, des postes et telecommunications et de l'environnement	
29.	Guayana (Гайана)	The Wildlife Division Office of the President	

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
30.	Gambia (Гамби)	The Director, Department of Parks and Wildlife	
31.	Ghana (Гана)	1. Wildlife Division Forestry Commission 2. Forestry Services Division Forestry Commission	(Модны зүйлд зөвшөөрөл олгоно)
32.	Guatemala (Гватемала)	1. Secretario Ejecutivo Consejo Nacional de Areas Protegidas	
33.	Guinea (Гвиней)	1. Direction nationale des eaux et forets Ministere de l'agriculture et de l'elevage	
34.	Guinea-Bissau (Гвиней-Бисау)	1. Direccao dos Servicos Florestais e Caca Ministerio da Agricultura, Pescas e Recursos Naturais	
35.	Germany (Герман)	1. Bundesministerium für Umwelt, Naturschutz und Reaktorsicherheit (Ministry of Environment, Nature Conservation and Nuclear Safety) 2. Bundesamt für Naturschutz Abteilung Z.3 Management Authority to CITES 3. Baden-Württemberg 4. Freistaat Bayern 5. Berlin 6. Brandenburg Landesamt für Ernährung, Landwirtschaft und Flurneuordnung 7. Freie und Hansestadt Bremen Lebensmittelüberwachungs, Tierschutz-und Veterinardienst Bremen 8. Freie und Hansestadt Hamburg Universität Hamburg 9. Hessen Hessisches Landesamt für Regionalentwicklung und Landwirtschaft Pflanzenschutzdienst 10. Mecklenburg-Vorpommern Landespflanzenschutzamt Mecklenburg-Vorpommern 11. Niedersachsen a) Landwirtschaftskammer Hannover Pflanzenschutzamt b) Landwirtschaftskammer Weser-Ems Institut für Pflanzenbau und Pflanzenschutz 12. Nordrhein-Westfalen a) Pflanzenschutzamt der Landwirtschaftskammer Rheinland b) Institut für Pflanzenschutz, Saatgutuntersuchungen und Bienenkunde der Landwirtschaftskammer Westfalen-Lippe 13. Rheinland-Pfalz Landesanstalt für Pflanzenbau und Pflanzenschutz 14. Saarland Landwirtschaftskammer für das Saarland 15. Sachsen Sächsische Landesanstalt für Landwirtschaft 16. Sachsen-Anhalt Landespflanzenschutzamt Sachsen-Anhalt 17. Schleswig-Holstein a) Amt für Ländliche Räume Kiel b) Amt für Ländliche Räume Husum c) Amt für Ländliche Räume Lubeck 18. Thüringen Thüringen Landesanstalt für Landwirtschaft Jena	(Конвенц (CITES)-ийн зөвшөөрөл олгодоггүй) (Зохиомлоор үржүүлсэн ургамлаас бусад зүйлд зөвшөөрөл олгоно) (Эдгээр байгууллагууд нь (3-18) зохиомлоор үржүүлсэн ургамлын зүйлд зөвшөөрөл олгоно)

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
36.	Honduras (Гондурас)	1. Secretaria de Agricultura y Ganaderia Despacho Ministerial Boulevard Centroamerica 2. Administracion Forestal del Estado AFE/COHDEFOR Departamento de Areas Protegidas y Vida Silvestre	
37.	Greece (Грек)	1. Ministry of Agriculture, General Secretariat of Forest and Natural Environment, Dir of Aesthetic Forests, National Parks and Game Management 2. Ministry of Agriculture, Forestry Inspectorate for Macedonia 3. Ministry of Agriculture Forestry Dept of Kastoria	
38.	Grenada (Гренада)	1. Mr Allan Joseph, Chief Forestry Officer Ministry of Agriculture	
39.	Georgia (Гүрж)	Ministry of Environmental Protection and Natural Resources of Georgia	
40.	Denmark (Дани)	1. Miljo-og Energiministeriet (Ministry of the Environment and Energy) Skov-og Naturstyrelsen (The National Forest and Nature Agency) 2. Ministry of Food, Agriculture and Fisheries Danish Plant Directorate 3. Direktoratet for Miljo og Natur 4. Kalaallit Allakkeriviat 5. Narsaq Tourist Office 6. Post Greenland Upernavik 7. Kangerlussuaq Tourism A/S 8. Narsarsuaq Lufthavnsvaesen 9. Ammassallip Kummunia 10. Gronlands Lufthavnsvaesen, Pituffik 11. UltimaThule 12. Ittoqqortoormiit Politi 13. Danmarkskontoret	(Ургамлын зүйлд мөн зөвшөөрөл олгоно) (Эдгээр байгууллагууд нь (3-13) Гренландаас гаралтай амьтан болон бүтээгдэхүүнд экспортын зөвшөөрөл олгоно)
41.	Djibouti (Джибути)	Direction de l'elevage et des peches Ministere de l'agriculture et du developpement rural	
42.	Dominic (Доминик)	Forestry and Wildlife Division Ministry of Agriculture	
43.	Dominican Republic (Доминикан)	1. Cecilia Hernandez, Departamento de Vida Silvestre Secretaria de Estado de Agricultura	
44.	Egypt (Египет)	1. Ministry of Agriculture and Land Reclamation 2. The Director, Flora and Phytotaxonomy Researches Agricultural Research Centre	(Амьтны зүйлд зөвшөөрөл олгоно) (Ургамлын зүйлд зөвшөөрөл олгоно)
45.	Zaire (Заир)	1. Directeur de gestion des ressources naturelles renouvelables Ministere de l'environnement, conservation de la nature, peche et forets	
46.	Zambia (Замби)	The Director General Zambia Wildlife Authority	

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
47.	Zimbabwe (Зимбабве)	Department of National Parks and Wildlife Management 1. The Warden Marongora 2. The Warden Matetsi Safari Area 3. Provincial Warden Mashonaland West 4. Provincial Warden Matabeleland South 5. Provincial Warden Masvingo	(Эдгээр бүсийн зөвлөлүүд нь (1-5) мөн зөвшөөрөл олгоно)
48.	Israel (Израил)	Israel Nature and National Parks Protection Authority	
49.	Indonesia (Индонез)	Directorate General of Protection and Nature Conservation, Ministry of Forestry and Estate Crops	
50.	Iran (Иран)	1. Mr Farhad Dabiri, General Director of Legal Office and Parliamentary Affairs Department of the Environment 2. Mr Mohammad Reza Hosseini Managing Director Shilat Trading Corporation	(Зөвхөн шонхортны багийн зүйлд зөвшөөрөл олгоно)
51.	Iceland (Исланд)	1. Ministry of Foreign Affairs 2. Ministry of Fisheries 3. Ministry for the Environment	(Далайн амьтдын зөвшөөрөл олгоно) (Далайн амьтдаас бусад зүйлд зөвшөөрөл олгоно)
52.	Spain (Испани)	1. Ministerio de Economía y Hacienda Dirección General de Comercio Exterior Subdirección General de Inspección, Certificación y Asistencia Técnica del Comercio Exterior 2. Ministerio de Economía y Hacienda Departamento de Aduanas e Impuestos Especiales Centros de Inspección de Comercio Exterior (C.I.C.E.) 3. C.I.C.E. DE ALGECIRAS 4. C.I.C.E. DE ALICANTE 5. C.I.C.E. DE BARCELONA 6. C.I.C.E. DE BILBAO 7. C.I.C.E. DE LACORUÑA 8. C.I.C.E. DE LAS PALMAS 9. C.I.C.E. DE MADRID 10. C.I.C.E. DE MALAGA 11. C.I.C.E. DE PALMA DE MALLORCA 12. C.I.C.E. DE SEVILLA 13. C.I.C.E. DE STA. CRUZ DE TENERIFE 14. C.I.C.E. DE VALENCIA	(Эдгээр бүсийн салбар зөвлөлүүд (3-14) нь мөн зөвшөөрөл олгоно)
53.	Italy (Итали)	1. Ministero dell' Ambiente, Servizio Conservazione della Natura Divisione II 2. Ministero delle per le Politiche Agricole e Forestali Direzione Generale delle Risorse Forestali, Montane e Idriche Divisione II - Servizio CITES 3. Ministero del Commercio con l'Estero Direzione generale Import-Export Divisione IV	(Конвенц (CITES)-ийн зөвшөөрөл олгож конвенцийг хэрэгжүүлэх асуудлыг хариуцдаг) (II хавсралтад орсон зүйлийн бүтээгдэхүүний ре-экспортын зөвшөөрөл олгоно)

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
54.	Great Britain (Их Британи)	1. Department of the Environment, Transport and the Regions (DETR) Global Wildlife Division 2. States Committee for Horticulture ST MARTIN 3. Department of Agriculture and Fisheries Jersey 4. Department of Agriculture, Fisheries and Forestry 5. Department of Agriculture and Fisheries Bermuda	
55.	Иемен (Иемен)	The Environment Protection Council	
56.	Jordan (Йордан)	1. The Royal Society for the Conservation of Nature 2. Ministry of Agriculture Animal Health and Production Department	
57.	Kazakhstan (Казахстан)	Ministry of Natural Resources and Protection of Environment	
58.	Cambodia (Камбож)	1. H.E. Chhun Sareth Under-Secretary of State Ministry of Agriculture, Forestry and Fisheries	
59.	Cameroon (Камерун)	1. Ministère de l'environnement et des forêts Ministry of Environment and Forests	
60.	Canada (Канад)	The Administrator, Convention on International Trade in Endangered Species, Canadian Wildlife Service Department of the Environment Federal Management Authority Management Authority, Fisheries and Oceans Canada Management Authority, for Alberta, Environmental Conservation Service, Environment Canada, Canadian Wildlife Service Management Authority, British Columbia Management Authority, Manitoba Management Authority, New Brunswick Management Authority, Newfoundland and Labrador Management Authority, Northwest Territories Management Authority, Nova Scotia Management Authority, Nunavut Territory Management Authority, Ontario Management Authority, Prince Edward Island Organe de gestion, Quebec Management Authority, Saskatchewan Management Authority, Yukon Territory	(Загас болон далайн амьтны зүйлд зөвшөөрөл олгоно) (Эдгээр салбар зөвлөлүүд нь мөн экспортын зөвшөөрөл олгоно)
61.	Kenya (Кени)	1. Kenya Wildlife Service	
62.	Cyprus (Кипр)	1. Ministry of Agriculture, Natural Resources and Environment 2. Ministry of Commerce and Industry 3. Ministry of Interior	
63.	Colombia (Колумб)	1. Ministerio del Medio Ambiente Despacho Viceministro de Política y Regulacion (Fauna y Flora silvestres) Direccion General de Ecosistemas Grupo de Biodiversidad (Fauna y Flora silvestres)	
64.	Comoros (Коморос)	Monsieur Mohamed Youssouf Oumouri Direction générale de l'environnement Ministere de la production et de l'environnement	

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
65.	Congo (Конго)	Direction generale des eaux et forets Direction de la flore et de la faune Ministere de l'conomie forestiere	(Амьд биет, боловсруулсан зааны соёо, ургамлын зүйлийг экспортлоход зөвшөөрөл олгоно)
66.	Costa Rica (Коста Рика)	1. Autoridad Administrativa CITES Ministerio del Ambiente y Energia Sistema Nacional de Areas de Conservacion a) At. Biol. Juan Maria Rodriguez Ramirez Coordinador Autoridades Administrativas CITES Autoridad Administrativa - Fauna b) At. Ing. Sandra Arrieta Castro Autoridad Administrativa CITES - Flora	(Амьтны зүйлд зөвшөөрөл олгоно) (Ургамлын зүйлд зөвшөөрөл олгоно)
67.	Kot de Iwaur (Кот де Ивуар)	1. Direction de la protection de la nature Ministere de la construction et de l'environnement Directeur de la Protection de la nature	(Конвенц (CITES)-ийн зөвшөөрөл нь дараах гарын үсэгтэй байна.)
68.	Cuba (Куба)	Ministerio de Ciencia, Tecnologia y Media Ambiente Centre de Gestion e Inspeccion Ambiental	
69.	Latvia (Латви)	1. Ministry of Environmental Protection and Regional Development of Latvia	
70.	Либериа (Liberia)	1. Forestry Development Authority (FDA) 2. Bureau of Fisheries and Plant Quarantine Ministry of Agriculture	(Ургамал, загасны зүйлд зөвшөөрөл олгоно)
71.	Liechtenstein (Лихтенштейн)	Office veterinaire federal	
72.	Luxemburg (Люксембург)	1. Departement de la protection de la nature Ministere de l'environnement 2. Ministere de l'agriculture de la viticulture et des eaux et forêts Administration des services veterinaires 3. Ministere de l'agriculture, de la viticulture et des eaux et forêts Administration des services techniques de l'agriculture Service de la protection des vegetaux	(Амьтны зүйлд зөвшөөрөл олгоно) (Ургамлын зүйлд зөвшөөрөл олгоно)
73.	Mauritius (Мавритани)	None designated yet	(Одоогоор Удирдан зохицуулах зөвлөлөө томилоогүй)
74.	Mawriki (Маврики)	National Parks and Conservation Service Ministry of Agriculture and Natural Resources	
75.	Madagascar (Мадагаскар)	1. Direction de la gestion durable des ressources forestieres Ministère des eaux et forets	
76.	Macedon (Македон)	Ministry of Environment	
77.	Malawi (Малави)	The Director of National Parks and Wildlife Department of National Parks and Wildlife	

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
78.	Malaysia (Малайз)	1. Director General, Department of Wildlife and National Parks (Headquarters) 2. Director, Department of Wildlife and National Parks State of Penang 3. Director, Department of Wildlife and National Parks State of Johor 4. Head of Centre, Fish Health Management and Quarantine Centre Kuala Lumpur International Airport (KLIA) 5. Director, Crop Protection and Plant Quarantine Services Division Department of Agriculture, Ministry of Agriculture	(Загас, далайн амьтнаас бусад амьтны зүйлд экспорт, импортын зөвшөөрөл олгоно) (Загас, далайн амьтны зүйлд зөвшөөрөл олгоно) (Ургамлын зүйлд зөвшөөрөл олгоно)
79.	Mali (Мали)	Direction nationale de la conservation de la nature	
80.	Malta (Мальта)	Environment Protection Department	
81.	Morocco (Марокко)	1. Ministere charge des eaux et forets Division de la cynegetique, de la pisciculture et de la biodiversite RABAT/CHELLAH	
82.	Mexico (Мексик)	1. Instituto Nacional de Ecologia Direccion General de Vida Silvestre	
83.	Mozambique (Мозамбик)	Direccào Nacional de Florestas e Fauna Bravia Ministerio da Agricultura	
84.	Monaco (Монако)	1. Cooperation internationale pour l'environnement et le developpement Villa Girasole 2. Direction de l'environnement, de l'urbanisme et de la construction	
85.	Mongolia (Монгол)	Management Authority for CITES, Ministry of Nature Environment and Tourism	
86.	Myanmar (Мьянмар)	Director General, Forest Department Ministry of Forestry	
87.	Namibia (Намиби)	1. Ministry of Environment and Tourism Specialist Support Services	
88.	Niger (Нигер)	Direction de la faune, de la peche et de la pisciculture Ministere de l'hydraulique et de l'environnement	
89.	Nigeria (Нигери)	1. The Honourable Minister Federal Ministry of Environment 2. Federal Environmental Protection Agency CITES Enforcement Unit	

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
90.	Netherlands (Нидерланд)	<p>1. CITES-bureau LASER Zuidwest</p> <p>APOCYNACEAE ARAUCARIACEAE ASCLEPIADACEAE CACTACEAE</p> <p>CEPHALOTACEAE CYCADACEAE EUPHORBIACEAE</p> <p>LILIACEAE</p> <p>NEPENTHACEAE</p> <p>ORCHIDACEAE</p> <p>PRIMULACEAE SARRACENIACEAE</p>	<p>(Дараах зүйлүүдийн таримал ургамлын хувьд phytosanitary certificate нь экспортын зөвшөөрлийн оронд хэрэглэгдэнэ. Үүнд: <i>Pachypodium lameri</i> <i>Araucaria araucana</i> <i>Ceropegia woodii</i>)</p> <p>(II хавсралтад орсон бүх зүйл <i>Cephalotus ollicularis</i>, <i>Cycas revoluta</i>)</p> <p>(II хавсралтад орсон бүх шүүслэг зүйл)</p> <p>(II хавсралтад орсон Алое-ийн бүх зүйл II хавсралтад орсон <i>Nepenthes</i>-ийн бүх зүйл)</p> <p>(II хавсралтад орсон бүх зүйл)</p> <p>(<i>Cyclamen persicum</i> II хавсралтад орсон бүх зүйл)</p>
91.	Nicaragua (Никарагуа)	<p>1. Lcda. Sandra Tijerino Mejia Ministerio del Ambiente y Recursos Naturales (MARENA)</p> <p>2. Ministerio del Ambiente y Recursos Naturales (MARENA)</p>	
92.	Norway (Норвеги)	1. Direktoratet for naturforvaltning (Directorate for Nature Management)	
93.	Russia (ОХУ)	<p>Ministry of Natural Resources</p> <p>State Committee for Fisheries of the Russian Federation</p>	<p>(Беларус, Эстони, Гүрж, Казахстан, Латви, Литва, Украин, Узбекстанаас бусад хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудын Удирдан зохицуулах зөвлөлийг мөн орлоно.) (Шонхортны багийн зүйлийг хамаарна)</p>

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
94.	South Africa (Өмнөд Африк)	1. Department of Environmental Affairs and Tourism Subdirectorates: Biodiversity Utilization 2. The Chief Director of Nature and Environmental Conservation 3. The Chief Director 4. The Director of Nature and Environmental Conservation 5. The Chief Director 6. Northern Cape Nature Conservation Service 7. The Chief Director Sea Fisheries	(Энэ зөвлөл нь удирдан зохицуулах зөвлөл боловч зөвшөөрөл олгодоггүй) (Энэ зөвлөлүүд нь (2-6) зөвшөөрөл олгоно)
95.	South Korea (Өмнөд Солонгос)	1. Global Environment Division Ministry of Environment 2. Ecosystem Conservation Division Ministry of Environment 3. Korea Food and Drug Administration Pharmaceutical Safety Division 4. Chonju Regional Environmental Management Office 5. Kyung In - Regional Environmental Management Office 7. Nakdong River Environmental Management Office 8. Taegu Regional Environmental Management Office 9. Wonju Regional Environmental Management Office 10. Yongsan River Environmental Management Office	(Далай тэнгисээс олборлон оруулах биетэд зөвшөөрөл олгоно) (Хөхтөн, шувуу, хоёрнутагтан, загас, шавж болон ургамлын зүйлийг хариуцна) (Эмийн зориулалтаар ашигладаг зүйлийг хариуцна) (Бусад зүйлд зөвшөөрөл олгоно.)
96.	Pakistan (Пакистан)	National Council for Conservation of Wildlife (NCCW) Ministry of Environment, Local Government and Rural Development, Government of Pakistan	
97.	Panamá (Панам)	1. Nacional de Patrimonio Natural, Autoridad Nacional del Ambiente	
98.	Papua New Guinea (Папуа Шинэ Гвиней)	Office of Environment and Conservation	
99.	Paraguay (Парагвай)	1. Director, Direccion de Parques Nacionales y Vida Silvestre Sub-Secretaria de Recursos Naturales y Medio Ambiente Ministerio de Agricultura y Ganaderia 2. Ministro de Agricultura y Ganaderia	
100.	Peru (Перу)	1. Instituto Nacional de Recursos Naturales (INRENA)	
101.	Poland (Польш)	Ministry of the Environment, Department of Forestry, Nature Conservation and Landscape	
102.	Portugal (Португал)	1. Instituto da Conservação da Natureza Divisão de Aplicação das Convenções 2. Direcção Regional de Ambiente 3. Parque Natural da Madeira Secretaria Regional de Agricultura e Pescas	
103.	Rwanda (Руанда)	Office rwandais du tourisme et des parcs nationaux (ORTPN)	
104.	Romania (Румын)	Ministerul Apelor, Padurilor si Protectiej Mediului	

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
105.	Salvador (Сальвадор)	1.Direccion General de Sanidad Vegetat y Animal Ministerio de Agricultura y Ganaderia	
106.	Saudi Arabia (Саудын Араб)	The Secretary General, National Commission for Wildlife Conservation and Development (NCWCD)	
107.	Swaziland (Свазиленд)	1.The King's Office 2. Kingdom of Swaziland's	
108.	Seychelles Islands (Сейшеллийн арлууд)	1. Ministry of Environment and Transport Division of Environment Conservation Section	
109.	Senegal (Сенегал)	Direction des eaux, forets, chasses et de la conservation des sols	
110.	Saint Vincent and the Grenadines (Сент Винсент ба Гренадине)	Minestry of Agriculture, Industry and Labour	
111.	Saint Christopher and Nevis (Сент Кристофер ба Невис)	Minestry of Agriculture	
112.	Saint Lucia (Сент Люси)	1. Permanent Secretary, Ministry of Agriculture, Fisheries, Forestry and the Environment	
113.	Singapore (Сингапур)	1. Agri-food and Veterinary Authority (AVA) Ministry of National Development	
114.	Slovakia (Словак)	1. Ministry for the Environment of the Slovak Republic, Department of Nature and Landscape Protection, CITES Management Authority	
115.	Slovene (Словен)	1. Ministry of the Environment and Spatial Planning	
116.	Somalia (Сомали)	1. Wakaaladda Ugaarta iyo Degaanka Somaaliyeed (WUDS)	
117.	Sudan (Судан)	Wildlife Conservation Administration	
118.	Surinam (Суринам)	1. Hoofd Dienst Lands Bosbeheer (Head of Suriname Forest Service)	
119.	Sierra Leone (Сьерра Леоне)	1. Forestry Division, Department of Agriculture, Forestry and Marine Resources	
120.	Thailand (Тайланд)	1. CITES Office, Royal Forest Department 2. Plant Introduction and Conservation of Wild Flora Sub-Division Agricultural Regulatory Division, Department of Agriculture 3. Fisheries Resources Conservation Division Department of Fisheries	(Ургамлын зүйлд зөвшөөрөл олгоно) (Загас болон далайн амьтны зүйлд зөвшөөрөл олгоно)
121.	Tanzania (Танзани)	1. The Director of Wildlife, Wildlife Division Ministry of Natural Resources and Tourism 2. Officer-in-Charge, Trophy Hunting and CITES Office, Wildlife Division	

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
122.	Togo (Того)	1. Direction des parcs nationaux, des reserves de faune et de chasses Organe de gestion CITES du Togo Ministere de l'environnement et du tourisme	
123.	Central Africa Republic (Төв Африкийн БНУ)	Direction de la faune Ministere de l'environnement, des eaux, forets, chasses et peches	
124.	Trinidad and Tobago (Тринидад ба Тобаро)	1. Management Authority, Ms Nadra Nathai-Gyan Head of Wildlife Section, Forestry Division	
125.	Tunisia (Тунис)	Direction generale des forets, Ministere de l'agriculture	
126.	Turkey (Турк)	1. Ministry of Environment General Directorate of Environment Protection 2. Ministry of Forestry, General Directorate of National Parks, Hunting and Game-Wildlife Department of Game and Wildlife 3. Ministry of Agriculture and Rural Affairs General Directorate of Protection and Control 4. Orman Genel Mudurlugu Isletme ve Pazarlama Dairesi Baskanligi 5. Ministry of Agriculture and Rural Affairs General Directorate of Agricultural Production and Development	(Хөхтөн, шувуу, мөлхөгч амьтдын зүйлд зөвшөөрөл олгоно) (Усны амьтдын зүйлд зөвшөөрөл олгоно) (Модны зүйл, бүтээгдэхүүнд зөвшөөрөл олгоно) (Булцуут ургамлын зүйлд зөвшөөрөл олгоно)
127.	Uganda (Уганда)	1. Commissioner for Wildlife Ministry of Tourism, Wildlife and Industry	
128.	Uzbekistan (Узбекистан)	The State Inspection for Protection of Flora, Fauna and Reserves under the State Committee	
129.	Ukraine (Украин)	1. Ministry of Ecology and Natural Resources 2. State Department for Fishery of the Ministry of Agricultural Policy 3. Ministry of Natural Resources	(Хилимнээс бусад зүйлд) (Хилимний зүйлд зөвшөөрөл олгоно.)
130.	Hungary (Унгар)	1. Kornyezetvedelmi Miniszterium (Ministry for Environment)	
131.	Uruguay (Уругвай)	1. Ministerio de Ganaderia, Agricultura y Pesca Direccion General de Recursos Naturales Renovables	
132.	Fiji (Фижи)	The Permanent Secretary for Urban Development, Housing and Environment	
133.	Philippines (Филиппин)	1. Protected Areas and Wildlife Bureau Department of Environment and Natural Resources 2. Bureau of Fisheries and Aquatic Resources (BFAR)	(Усны болон далайн амьтны зүйлд зөвшөөрөл олгоно)
134.	Finland (Финлянд)	Ymparistoministerio (Ministry of the Environment), Alueidenkayton osasto (Land Use Department), Suomen Ymparistokeskus (Finnish Environment Institute), Luonto-ja maankayttoyksikko (Nature and Land Use Unit)	

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
135.	France (Франц)	1. Ministère de l'aménagement du territoire et de l'environnement, Direction de la nature et des paysages, Bureau des échanges internationaux d'espèces menacées	
136.	Croatia (Хорвати)	1. Ministarstvo zaštite okoliša i prostornog uređenja (Ministry of Environmental Protection and Physical Planning)	
137.	China (Хятад)	1. The Endangered Species Import and Export, Management Office of the People's Republic of China State Forestry Administration 2. Agriculture, Fisheries and Conservation Department Hong Kong Special Administrative Region 3. Research and Electronic Data Processing Department Economic Services Macao Special Administrative Region	
138.	Chad (Чад)	1. Direction de protection de la faune et des parcs nationaux Direction generale Ministere de l'environnement et de l'eau	
139.	Czech (Чех)	1. Ministerstvo životního prostředí (Ministry of the Environment) Odbor ochrany přírody – vykonávací orgán CITES (Nature Protection Department CITES Management Authority)	
140.	Chile (Чили)	1. Dirección de Medio Ambiente Ministerio de Relaciones Exteriores	
141.	Sweden (Швед)	1. Statens Jordbruksverk (Swedish Board of Agriculture)	
142.	Switzerland (Швейцар)	Office vétérinaire fédéral	
143.	New Zealand (Шинэ Зеланд)	1. Department of Conservation WELLINGTON 2. Department of Conservation AUCKLAND 3. Department of Conservation CHRISTCHURCH	
144.	Sri Lanka (Шри Ланка)	The Director, Department of Wildlife Conservation	
145.	Ecuador (Эквадор)	Instituto Ecuatoriano Forestal y de Áreas Naturales y Vida Silvestre (INEFAN) Av. Amazonas y Eloy Alfaro Ministerio de Agricultura y Ganadería	
146.	Equatorial Guinea (Экваторын Гвиней)	Dirección General de Protección y Guardería Forestal, Ministerio de Pesca y Forestal	
147.	India (Энэтхэг)	1. Additional Inspector General (Wildlife) Ministry of Environment and Forests Government of India 2. Inspector General of Forests Ministry of Environment and Forests Government of India 3. Deputy Director, Wildlife Preservation	
148.	Eritrea (Эритри)	Wildlife Conservation Division Ministry of Agriculture	
149.	Estonia (Эстони)	1. Ministry of the Environment	
150.	Ethiopia (Эфиопи)	1. Ethiopian Wildlife Conservation Organization	

№	Конвенцид нэгдэн орсон улс	Удирдан зохицуулах зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын нэр	Тайлбар
151.	Jamaica (Ямайка)	Natural Resources Conservation Authority	
в) арьсны болон савхин эдлэлийн худалдаа

Боловсруулаагүй зааныясных худалдааны улсын өмчид хамаарагдана. Крюгерийн Байгалийн цогцолборт газраас гарал үүсэлтэй зааны соёог бүхэлд нь хамрах бөгөөд квот нь тэгтэй тэнцүү болно. Бусад бүх биетийг нэгдүгээр хавсралтад орсон зүйлийг төлөөлөх биет гэж үзэх бөгөөд тэдгээрийн худалдааг нэгдүгээр хавсралтын заалтын дагуу зохицуулна.

°605 Хүлээн авах боломж бүхий тохиромжтой газарт амьд амьтныг олон улсын хэмжээнд худалдаалах бөгөөд ангийн олзворыг хүлээн зөвшөөрөхийг зөвхөн гол зорилгоо болгоно. Бусад бүх биетийг нэгдүгээр хавсралтад орсон зүйлийн төлөөлөх биет гэж үзэх бөгөөд тэдгээрийн худалдааг нэгдүгээр хавсралтын заалтын дагуу зохицуулна.

°606 Хоёрдугаар хавсралтад орсон популяциуд (+211 харах)-д хамаарах амьд *vicuna*-гийн хяргасан ноос болон Талуудын Бага хурлын IX хурал (1994 оны 11-р сар)-ын үеэр Перуд хуримтлагдаж үлдээд байсан 3249 кг ноос, мөн түүгээр хийсэн нэхмэл хувцас бусад бараа, түүний дотор дээд зэргийн гар урлалын бүтээгдэхүүнүүд болон сүлжмэл эдлэлийн олон улсын худалдааг хүлээн зөвшөөрсөн. Эдгээр бүтээгдэхүүн нь дотор талдаа тухайн зүйлийн тархан амьдардаг улс орнууд буюу *Convenio para la Conservacion y Manejo de la Vicuna* (Викунагийн менежмент болон хамгааллын хэлэлцээр)-т гарын үсэг зурсан орнуудын хооронд хэрэглэхээр тохиролцсон тэмдэгтэй байна. Мөн гарал үүслийн орон нь өөр өөр байхаас хамаарч *Vicuna* нэрийн ард тухайн гарал үүслийн орныг бичсэн тэмдгийг бүтээгдэхүүний захад хадсан байна. Бусад бүх биетийг нэгдүгээр хавсралтад орсон зүйлийг төлөөлөх биет гэж үзэх бөгөөд тэдгээрийн худалдааг нэгдүгээр хавсралтын заалтын дагуу зохицуулна.

°607 Чулуужмал биетүүд Конвенцийн заалтад хамаарахгүй.

°608 Дараах эрлийз, таримал ургамлаас зохиомлоор гаргаж авсан биетүүд энэхүү Конвенцийн заалтад хамаарахгүй. Үүнд: *Hatiora x graeseri*, *Schlumbergera x buckleyi*, *Schlumbergera russelliana x Schlumbergera truncate*, *Schlumbergera orssichiana x Schlumbergera truncate*, *Schlumbergera opuntioides x Schlumbergera truncate*, *Schlumbergera truncata* (таримал ургамал), *Gymnocalycium mihanovitchii* (таримал ургамал) хлорофиллийн дутагдалтай, ургамлын ишний холбоос: *Harrisia 'Jusbertii'*, *Hylocereus trigonus*, *Hylocereus undatus*, *Opuntia microdasys* (таримал ургамал)

°609 *Euphorbia trigona*-ийн таримлын зохиомлоор гарган авсан биет нь Конвенцийн заалтад хамаарахгүй.

°610 Туршилтын гуурсан дотор хатуу ба шингэн орчинд өсгөвөрлөж, бактергүй саванд шилжүүлэн зөөвөрлөсөн суулгац болон өсгөвөр нь Конвенцийн заалтад хамаарахгүй.

°611 *Cyclamen persicum*-ийн таримлын зохиомлоор гарган авсан биет нь конвенцийн заалтад хамаарахгүй. Гэвч энэ нь булцууг чөлөөтэй гаргана гэсэн үг биш юм.

°612 Гол төлөв худалдааны зорилгоор байгалиас цуглуулдаг биетүүд болох *Manis crassicaudata*, *M. javanica*, *M. pentadactyla*-ийн жилийн экспортын квотыг тэглэсэн болно.

°613 Гол төлөв худалдааны зорилгоор байгалиас цуглуулдаг биет болох *Geochelone sulcata*-ийн жилийн экспортын квотыг тэглэсэн болно.

12. Конвенцийн 1 дүгээр зүйлийн 6 дугаар хэсгийн 3 дугаар дэд хэсэгт заасны дагуу хоёрдугаар хавсралтад орсон зүйл болон зүйлээс дээших ангиллын нэгжийн нэрийн дараа тавьсан ардаа дугаартай тэмдэг (#) нь тухайн зүйл болон зүйлээс дээших ангиллын нэгжид хамаарах зүйлийг төлөөлөх биетийн эд хэсэг, тэдгээрийн гаралтай зүйлүүдийг дараах байдлаар тайлбарлана. Үүнд:

1 Бүх хэсгүүдийг тодорхойлох ба гарал үүсэл болон дараах бусад зүйлсийг хамруулна.

а) Үр, тагнай өвсийг дахин боловсруулах ба цэцгийн тоос

б) Шингэн ба хатуу орчинд өсгөвөрлөж,

- цэвэр саванд шилжүүлсэн өсгөвөр, суулгац
- в) Зохиомлоор үржүүлсэн ургамлыг тасдаж авсан
- # 2 Бүх хэсгүүдийг тодорхойлох ба гарал үүсэл болон дараах бусад зүйлсийг хамруулна.
- а) Үр, цэцгийн тоос
- б) Шингэн, хатуу орчинд өсгөвөрлөж, цэвэр саванд шилжүүлсэн өсгөвөр, суулгац
- в) Зохиомлоор үржүүлсэн ургамлыг тасдаж авсан
- г) Химийн гаралтай
- # 3 Үйлдвэрийн бүтээгдэхүүн болох нунтаг, үрэл, ханд, хийжүүлсэн бүтээгдэхүүн зэргийг оролцуулалгүй бүх үндэс, хэрчсэн үндэс, үндэсний хэсгүүдийг тэмдэглэнэ.
- # 4 Бүхий л гарал үүслийг тодорхойлох ба дараах бусад зүйлсийг хамруулна.
- а) Мексикээс гаралтай Мексик кактигаас бусад үр, цэцгийн тоос
- б) Шингэн ба хатуу орчинд өсгөвөрлөж, цэвэр саванд шилжүүлсэн өсгөвөр, суулгац
- в) Зохиомлоор үржүүлсэн ургамлыг тасдаж авсан
- г) Байгалийн ба зохиомол аргаар үржүүлсэн ургамлын жимс, түүний хэсэг, түүнээс гаралтай зүйлүүд
- д) *Opuntia* төрөл, *Opuntia*-ийн дэд төрлийн байгалийн ба зохиомол аргаар үржүүлж гаргасан ургамлын ишний тасархай, хэсэг, түүнээс гаралтай зүйлүүдээс бусад бүх хэсэг, түүнээс гаралтай зүйлүүдийг тэмдэглэнэ.
- # 5 Гуалин, зүсмэл, сарампай банзыг тэмдэглэнэ.
- # 6 Гуалин мод, хэрчсэн мод ба эвдэж ямар нэгэн юм хийгээгүй материалыг тэмдэглэнэ.
- # 7 Бүх хэсгүүдийг тодорхойлох ба гарал үүсэл болон дараах бусад зүйлсийг хамруулна. Үүнд:
- а) Үр, цэцгийн тоос
- б) Шингэн, хатуу орчинд өсгөвөрлөж, цэвэр саванд шилжүүлсэн өсгөвөр, суулгац
- в) Зохиомлоор үржүүлсэн ургамлыг тасдаж авсан
- г) Зохиомол ба Ванилла ургамлын төрлийг үржүүлсэн жимс, түүний хэсэг, түүнээс гаралтай зүйлүүд
- # 8 Бүх хэсгүүдийг тодорхойлох ба гарал үүсэл болон дараах бусад зүйлсийг хамруулна. Үүнд:
- а) Үр, цэцгийн тоос
- б) Шингэн, хатуу орчинд өсгөвөрлөж, цэвэр саванд шилжүүлсэн өсгөвөр, суулгац
- в) Зохиомлоор үржүүлсэн ургамлыг тасдаж авсан
- г) Эм үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд багтсан.
13. Нэгдүгээр хавсралтад ордог ургамлын төрлийн зүйлээс дээших ангиллын ба зүйлүүдийн эрлийзжүүлэг нь конвенцийн гуравдугаар хавсралтын дагуу шийдвэрлэгдэнэ. Конвенцийн нийтлэг зүйлд шингэн ба хатуу орчинд өсгөвөрлөж, цэвэр саванд шилжүүлсэн өсгөвөр, суулгац, тасласан цэцэг, цэцгийн тоос ба үр, мөн зохиомол үржүүлгийн гэрчилгээтэй, эсвэл нэг буюу түүнээс дээш зохиомлоор үржүүлсэн зүйлүүд нь конвенцийн нийтлэг зүйлд хамаарахгүй.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CITES)-ИЙН ХАВСРАЛТАД БҮРТГЭЛТЭЙ АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЭРХТЭН, ЗҮЙЛСИЙН ЭКСПОРТ, РЕЭКСПОРТ БОЛОН ИМПОРТЫН ТУХАЙ

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийг экспортлох дарааллыг Зураг 1-ээр харууллаа. Тус зураг дээрх дугаар, тэмдэглэгээг тайлбарлавал:

1-2. Импортлогч (аж ахуйн нэгж, байгууллага) нь конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад орсон амьтан, ургамлыг импортлох зөвшөөрлийг импортлогч орны конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлөөс гаргуулж, экспортлогч (аж ахуйн нэгж, байгууллага) руу хүргүүлнэ.

3-6. Экспортлогч нь конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад орсон амьтан, ургамлыг экспортод гаргахын тулд Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлд хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

Монгол Улсын Конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөл нь экспортын зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч дараах зүйлсийг магадлана. Үүнд:

- а. Тухайн биет нь конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад орсон эсэх;
- б. Экспорт нь шинжлэх ухааны судалгааны зорилготой бөгөөд арилжаа наймааны зорилгоор ашиглагдахгүй байх;
- в. Төлбөр хураамж төлөгдсөн эсэх;
- г. Импортын зөвшөөрлийг магадлах;
- д. Монгол улсын хууль тогтоомж зөрчөөгүй эсэхийг магадлах;
- е. Тээвэрлэх нөхцлийг бүрдүүлсэн, эрүүл ахуйн шаардлагыг хангасан эсэхийг магадлах;
- ё. Экспортлох зөвшөөрлийн бичиг олгоно.

Монгол Улсын Конвенц (CITES)-ийн Шинжлэх ухааны зөвлөл нь Удирдан зохицуулах зөвлөлд хандан дараах зөвлөгөөг өгнө. Үүнд:

- а. Экспорт нь тухайн зүйлийн оршин тогтноход аюул занал учруулахгүй гэсэн дүгнэлт гаргах;
- б. Уг амьтан, ургамлын зүйлийг экспортлох зөвшөөрлийг хязгаарлах шаардлагатай гэж үзвэл холбогдох зөвлөмжийг гаргана.

7.6. Мэргэжлийн хяналтын байгууллага нь Монгол Улсын “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль”-ийн 9, 11 дүгээр зүйл,

24.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан нөхцөлд хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн экспортын гэрчилгээг олгоно.

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”-ын 2.2-т “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 9, 11 дүгээр зүйл, 24.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан нөхцөлд хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн экспортын гэрчилгээг мэргэжлийн хяналтын байгууллага олгоно” хэмээн тодорхой тусгасан байдаг.

8.6. Худалдаа аж үйлдвэрийн танхим нь Монгол Улсын “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-д заасны дагуу экспортлогчид гарал үүслийн гэрчилгээ олгоно.


9-10. Монгол Улсын Гаалийн байгууллага нь конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад орсон амьтан, ургамал мөн болохыг тодорхойлсны дараа Монгол Улсын “Гаалийн тухай хууль”-ийн 24 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу гаалийн бүрдүүлэлт хийж, экспортлох зөвшөөрлийг экспортлогчид олгоно.

11. Экспортлогч нь уг барааг импортлогч руу хүргүүлнэ.

12. Монгол Улсын Гаалийн байгууллага нь Монгол Улсын хилээр гарсан эд зүйлсийн талаарх мэдээ, баримт бичиг, тайланг Монгол Улсын конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлд хүргүүлнэ.

Жич: УИХ-ын 1998 оны 5 дугаар тогтоол (Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай)-ын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтын 1-д “Мансууруулах бодис, тэдгээрийг хэрэглэх, үйлдвэрлэхэд зориулсан багаж хэрэгсэл, мансууруулах ургамал”-ыг улсын хилээр гаргах, оруулахыг хориглохоор заасан болно.

Зураг 1. Конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийг экспортолох дараалал



Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийг экспортлох дарааллыг Зураг 2-оор харууллаа. Тус зураг дээрх дугаар, тэмдэглэгээг тайлбарлавал:

1-3. Экспортлогч нь конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад орсон амьтан, ургамлыг экспортлохын тулд Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлд хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

Монгол Улсын Конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөл нь экспортын зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч дараах зүйлсийг магадлана. Үүнд:

- а. Тухайн биет нь конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад орсон эсэх;
- б. Төлбөр хураамж төлөгдсөн эсэх;
- в. Тээвэрлэлт эрүүл ахуйн нөхцлийг хангасан эсэх;
- г. Монгол улсын хууль тогтоомж зөрчөөгүй эсэхийг магадлах;
- д. Экспортлох зөвшөөрлийн бичиг олгоно.

Монгол Улсын Конвенц (CITES)-ийн Шинжлэх ухааны зөвлөл нь Удирдан зохицуулах зөвлөлд хандан дараах зөвлөгөөг өгнө. Үүнд:

- а. Уг амьтан, ургамлын зүйлийн оршин тогтноход аюул учруулах эсэх талаар дүгнэлт гаргаж өгөх;
- б. Тус амьтан, ургамлын зүйлийг экспортлох зөвшөөрлийг хязгаарлах шаардлагатай гэж үзвэл холбогдох зөвлөмж гаргана.

4.6. Мэргэжлийн хяналтын байгууллага нь Монгол Улсын “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль”-ийн 9, 11 дүгээр зүйл, 24.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан нөхцөлд хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн экспортын гэрчилгээг олгоно.

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”-ын 2.2-т “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 9, 11 дүгээр зүйл, 24.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан нөхцөлд хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн экспортын гэрчилгээг мэргэжлийн хяналтын байгууллага олгоно” хэмээн тодорхой тусгасан байдаг.

5.6. Худалдаа аж үйлдвэрийн танхим нь Монгол Улсын “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-д заасны дагуу экспортлогчид гарал үүслийн гэрчилгээ олгоно.


6-7. Монгол Улсын Гаалийн байгууллага нь конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад орсон амьтан, ургамал мөн болохыг тодорхойлсны дараа Монгол Улсын “Гаалийн тухай хууль”-ийн 24 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу гаалийн бүрдүүлэлт хийж, экспортлох зөвшөөрлийг экспортлогчид олгоно.

8. Экспортлогч нь уг барааг импортлогч руу хүргүүлнэ.

9. Монгол Улсын Гаалийн байгууллага нь Монгол Улсын хилээр гарсан эд зүйлсийн талаарх мэдээ, баримт бичиг, тайланг Монгол Улсын конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлд хүргүүлнэ.

Жич: УИХ-ын 1998 оны 5 дугаар тогтоол (Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай)-ын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтын 1-д “Мансууруулах бодис, тэдгээрийг хэрэглэх, үйлдвэрлэхэд зориулсан багаж хэрэгсэл, мансууруулах ургамал”-ыг гаалийн хилээр гаргах, оруулахыг хориглохоор заасан болно.

Зураг 2. Конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийг экспортолох дараалал



Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийг реэкспортлох дарааллыг Зураг 3-аар харууллаа. Тус зураг дээрх дугаар, тэмдэглэгээг тайлбарлавал:

1-3. Реэкспортлогч (аж ахуйн нэгж, байгууллага) нь конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад орсон амьтан, ургамлыг реэкспортлохын тулд Монгол Улсын конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлд хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

Монгол Улсын Конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөл нь реэкспортын гэрчилгээ хүссэн өргөдлийг хүлээн авч дараах зүйлсийг магадлана. Үүнд:

- а. Тухайн биет нь конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад орсон эсэх;
- б. Тус конвенцийн заалтуудыг мөрдлөг болгосон эсэх;
- в. Тээвэрлэлт, эрүүл ахуйн нөхцлийг хангасан эсэхийг тодруулах;
- г. Импортлоор оруулах амьд биетэд импортын зөвшөөрөл олгох эсэхийг магадлах;
- д. Реэкспортын гэрчилгээ олгоно.

4.6. Мэргэжлийн хяналтын байгууллага нь Монгол Улсын “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль”-ийн 9, 11 дүгээр зүйл, 24.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан нөхцөлд хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн экспортын гэрчилгээг олгоно.

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 173

дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”-ын 2.2-т “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 9, 11 дүгээр зүйл, 24.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан нөхцөлд хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн экспортын гэрчилгээг мэргэжлийн хяналтын байгууллага олгоно” хэмээн тодорхой тусгасан байдаг.


6-7. Монгол Улсын Гаалийн байгууллага нь конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад орсон амьтан, ургамал мөн болохыг тодорхойлсны дараа реэкспортлогчид гаалийн хилээр оруулах, гаргах зөвшөөрлийг олгоно.

8-9. Реэкспортлогч нь импортлогч оронд очих амьтан, ургамлыг Монгол Улсын хилээр оруулж гаргана.

10. Монгол Улсын Гаалийн байгууллага нь экспортын гэрчилгээ, бичиг баримтыг Монгол Улсын конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлд хүргүүлнэ.

Жич: УИХ-ын 998 оны 5 дугаар тогтоол (Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай)-ын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтын 1-д “Мансууруулах бодис, тэдгээрийг хэрэглэх, үйлдвэрлэхэд зориулсан багаж хэрэгсэл, мансууруулах ургамал”-ыг улсын хилээр гаргах, оруулахыг хориглохоор заасан болно.

Зураг 3. Конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийг реэкспортлох дараалал



Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийг реэкспортлох дарааллыг Зураг 4-өөр харууллаа. Тус зураг дээрх дугаар, тэмдэглэгээг тайлбарлавал:

1.6. Реэкспортлогч (аж ахуйн нэгж, байгууллага) нь конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад орсон амьтан, ургамлыг реэкспортлохын тулд Монгол Улсын конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлд хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

Монгол Улсын Конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөл нь реэкспортын гэрчилгээ хүссэн өргөдлийг хүлээн авч дараах зүйлсийг магадлана. Үүнд:

- Тухайн биет нь конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад орсон эсэх;
- Тус конвенцийн заалтуудыг мөрдлөг болгосон эсэх;
- Тээвэрлэлт, эрүүл ахуйн нөхцлийг хангасан эсэхийг тодруулах;
- Реэкспортын гэрчилгээ олгоно.

2.6. Мэргэжлийн хяналтын байгууллага нь Монгол Улсын “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль”-ийн 9, 11 дүгээр зүйл, 24.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан нөхцөлд хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн экспортын гэрчилгээг олгоно.

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан

“Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”-ын 2.2-т “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 9, 11 дүгээр зүйл, 24.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан нөхцөлд хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн экспортын гэрчилгээг мэргэжлийн хяналтын байгууллага олгоно” хэмээн тодорхой тусгасан байдаг.


4-5. Монгол Улсын Гаалийн байгууллага нь конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад орсон амьтан, ургамал мөн болохыг тодорхойлсны дараа реэкспортлогчид гаалийн хилээр оруулах, гаргах зөвшөөрлийг олгоно.

6-7. Реэкспортлогч нь импортлогч оронд очих амьтан, ургамлыг Монгол Улсын хилээр оруулж гаргана.

8. Монгол Улсын Гаалийн байгууллага нь экспортын гэрчилгээ, бичиг баримтыг Монгол Улсын конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлд хүргүүлнэ.

Жич: УИХ-ын 1998 оны 5 дугаар тогтоол (Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай)-ын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтын 1-д “Мансууруулах бодис, тэдгээрийг хэрэглэх, үйлдвэрлэхэд зориулсан багаж хэрэгсэл, мансууруулах ургамал”-ыг улсын хилээр гаргах, оруулахыг хориглохоор заасан болно.

Зураг 4. Конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийг реэкспортлох дараалал



Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийг импортлох дарааллыг Зураг 5-аар харууллаа. Тус зураг дээрх дугаар, тэмдэглэгээг тайлбарлавал:

1-3. Импортлогч (аж ахуйн нэгж, байгууллага) нь конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад орсон амьтан, ургамлыг импортлохын тулд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Монгол Улсын конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлд хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

Монгол Улсын Конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөл нь импортын зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч дараах зүйлсийг магадлана. Үүнд:

- а. Тухайн биет нь конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад орсон эсэх;
- б. Импорт нь шинжлэх ухааны судалгааны зорилготой бөгөөд арилжаа наймааны зорилгоор ашиглахгүй болохыг тодруулна.

Монгол Улсын Конвенц (CITES)-ийн Шинжлэх ухааны зөвлөл нь Удирдан зохицуулах зөвлөлд хандан дараах зөвлөгөө өгнө. Үүнд:

- а. Импорт нь тухайн зүйлийн оршин тогтноход аюул занал учруулахгүй гэсэн дүгнэлт гаргах;
- б. Амьд биетийн хувьд хүлээж авахад тохиромжтой нөхцөл, орчин бүрдүүлсэн байх.

4-6. Экспортлогч нь конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад орсон амьтан, ургамлыг экспортлох зөвшөөрлийг экспортлогч орны конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлд хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

7.6. Мэргэжлийн хяналтын байгууллага нь Монгол Улсын “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын

хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль”-ийн 23 дугаар зүйл болон Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”-ын 2.3 дахь “Мэргэжлийн хяналтын байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн хууль тогтоомжийн дагуу бүрдүүлсэн мэдээлэл, хүсэлтийг үндэслэн импортлох амьтан, ургамал, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл олгоно” гэсэн заалтын дагуу импортлогчид импортын мэдэгдэл олгоно.

8.6. Худалдаа аж үйлдвэрийн тахим нь Монгол Улсын “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5-д заасны дагуу экспортлогчид барааны тоо, чанар байдалд магадлагаа гаргаж өгнө.


11-12. Монгол Улсын Гаалийн байгууллага нь конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад орсон амьтан, ургамал мөн болохыг тодорхойлсны дараа Монгол Улсын “Гаалийн тухай хууль”-ийн 24 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу гаалийн бүрдүүлэлт хийж, импортлох зөвшөөрлийг импортлогчид олгоно.

12. Импортлогч нь уг барааг экспортлогчид хүргүүлнэ.

13. Монгол Улсын Гаалийн байгууллага нь импортын зөвшөөрлийн баримт бичгийг Монгол Улсын конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлд хүргүүлнэ.

Жич: УИХ-ын 1998 оны 5 дугаар тогтоол (Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай)-ын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтын 1-д “Мансууруулах бодис, тэдгээрийг хэрэглэх, үйлдвэрлэхэд зориулсан багаж хэрэгсэл, мансууруулах ургамал”-ыг улсын хилээр гаргах, оруулахыг хориглохоор заасан болно.

Зураг 5. Конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийг импортлох дараалал



Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийг импортлох дарааллыг Зураг 6-аар харууллаа. Тус зураг дээрх дугаар, тэмдэглэгээг тайлбарлавал:

1-3. Импортлогч (аж ахуйн нэгж, байгууллага) нь конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад орсон амьтан, ургамлыг импортлохын тулд Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлд хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

Монгол Улсын Конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөл нь импортын зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч дараах зүйлсийг магадлана. Үүнд:

- а. Тухайн биет нь конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад орсон эсэх;
- б. Импортлох зөвшөөрлийн бичиг олгоно.

4.б. Мэргэжлийн хяналтын байгууллага нь Монгол Улсын “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль”-ийн 23 дугаар зүйл болон Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”-ын 2.3 дахь “Мэргэжлийн хяналтын байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн хууль тогтоомжийн дагуу бүрдүүлсэн мэдээлэл, хүсэлтийг үндэслэн импортлох амьтан, ургамал,

бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл олгоно” гэсэн заалтын дагуу импортлогчид импортын мэдэгдэл олгоно.

5.б. Худалдаа аж үйлдвэрийн тахим нь Монгол Улсын “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5-д заасны дагуу экспортлогчид барааны тоо, чанар байдалд магадлагаа гаргаж өгнө.


7-8. Монгол Улсын Гаалийн байгууллага нь конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад орсон амьтан, ургамал мөн болохыг тодорхойлсны дараа Монгол Улсын “Гаалийн тухай хууль”-ийн 24 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу гаалийн бүрдүүлэлт хийж, импортлох зөвшөөрлийг импортлогчид олгоно.


9. Импортлогч нь уг барааг экспортлогчид хүргүүлнэ.

10. Монгол Улсын Гаалийн байгууллага нь импортын зөвшөөрлийн баримт бичгийг Монгол Улсын конвенц (CITES)-ийн Удирдан зохицуулах зөвлөлд хүргүүлнэ.

Жич: УИХ-ын 1998 оны 5 дугаар тогтоол (Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай)-ын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтын 1-д “Мансууруулах бодис, тэдгээрийг хэрэглэх, үйлдвэрлэхэд зориулсан багаж хэрэгсэл, мансууруулах ургамал”-ыг улсын хилээр гаргах, оруулахыг хориглохоор заасан болно.

Зураг 6. Конвенц (CITES)-ийн хоёр, гуравдугаар хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийг импортлох дараалал





ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСААС ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН
АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД
ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (СІТЕС)-ИЙН НЭГ,
ХОЁРДУГААР ХАВСРАЛТАД БҮРТГЭЛТЭЙ АМЬТАН, УРГАМАЛ

3.1

ХӨХТӨН АМЬТАД

СЭДВИЙН АГУУЛГА

МОНГОЛ УЛСААС КОНВЕНЦ (СІТЕС)-ИЙН НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТАД БҮРТГЭГДСЭН ХӨХТӨН АМЬТАД

1. Цоохор ирвэс (*Uncia uncia Schreber, 1775*)
2. Голын халиу (*Lutra lutra Linnaeus, 1758*)
3. Мазаалай баавгай (*Ursus arctos isabellinus Horsfield, 1826*)
4. Тахь адуу (*Equus ferus przewalskii Groves, 1986*)
5. Хулан адуу (*Equus hemionus Pallas, 1775*)

МОНГОЛ УЛСААС КОНВЕНЦ (СІТЕС)-ИЙН ХОЁРДУГААР ХАВСРАЛТАД БҮРТГЭГДСЭН ХӨХТӨН АМЬТАД

6. Шилүүс мий (*Lynx lynx Linnaeus, 1758*)
7. Цоохондой мий (*Felis silvestris Schreber, 1777*)
8. Мануул мий (*Felis manul Pallas, 1776*)
9. Саарал чоно (*Canis lupus Linnaeus, 1758*)
10. Шарнад цөөвөр (*Cuon alpinus Pallas, 1811*)
11. Хүрэн баавгай (*Ursus arctos Linnaeus, 1758*)
12. Аргаль хонь (*Ovis ammon Linnaeus, 1758*)
13. Монгол бөхөн (*Saiga borealis Tschersky, 1876*)
14. Баданга хүдэр (*Moschus moschiferus Linnaeus, 1758*)



ЦООХОР ИРВЭС

Uncia uncia Schreber, 1775

Баг: Махчтан (*Carnivora*)

Овог: Мийнхэн (*Felidae*)

НЭРШИЛ:

Англи: Snow Leopard

Орос: Снежный барс

Хятад: Хуе бао

Герман: Schneeleopard (Irbis)

Франц: Léopard des neiges

Казах: Барыс, ілбіс

ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Uncia irbis, *Uncia schneideri*, *Uncia uncioides* (Wilson and Reeder, 1993), *Panthera uncia* (Schreber, 1775) (<http://checklist.cites.org>), *Felis uncia* (Schreber, 1775), *Uncia uncia* (Schreber, 1775) (<http://www.iucnredlist.org>).

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Эмзэг” (<http://www.iucnredlist.org>), бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй” зүйл (Clark *et al.*, 2006) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Монгол орны хамгийн том биетэй, хүчирхэг мий. Биеийн урт 112-120 см, сэрвээний өндөр 60 см, сүүлний урт 92-105 см, чихний өндөр 6.6-

7.2 см. Биеийн жин 33-55 кг (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Мөнхцог, 2016). Бие сунагар урт, гинс (эмэгчин) гэндээс биеэр бага. Мөч богино, сарвууны алга өргөн, том, нуугдмал хумстай. Толгой жижиг, чих богино. Нүд том, хүүхэн хараа дугуй. Цайвар, шаргал дэвсгэр дээр 6-8 см дугуйвтар хар толбонуудтай эрэн цоохор зүстэй. Хэвэл толбогүй, цагаан цайвар өнгөтэй. Толгой, духны хэсэгт жижиг, шигүү хар толбонууд бий (Гептнер нар, 1972; Мөнхцог, 2016). Толгойн ясны кондиллобазаль урт 158-174 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо1/1; түрүү араа 3/2; агт араа 1/1=30 (Батсайхан нар, 2010).

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Цоохор ирвэс нь Төв Азийн Алтай, Соён, Памир, Тэнгэр, Төвдийн өндөрлөг, Гималайн уулсаар ОХУ, Казахстан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Киргизстан, Балба, Бутан, Монгол зэрэг дэлхийн 12 улс оронд тархсан байна.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Цоохор ирвэс Монгол Алтайн нуруу, Сийлхэмийн нуруу, Цамбагарав, Хөх Сэрх, Чигэстэй, Мөнххайрханы нуруу, Мянган Угалзат, Сутай хайрхан, Хасагт хайрханы нуруу, Хан Тайширын нуруу, Хар Азаргын нуруу, Гичгэний нуруу, Аж Богдын нуруу, Эдрэнгийн нуруу, Алтайн өвөр говийн Атас, Ингэс, Шар хулс, Сэгс Цагаан Богд, Цагаан шувуут, Хархираа, Түргэн, Алтан Хөхий, Хангайн нурууны Отгонтэнгэр, Хан Хөхийн нуруу, Говь-Алтайн нурууны Баянцагааны нуруу, Жинст, Их Богдын нуруу, Арц Богдын нуруу, Тост, Тосонбумбын нуруу, Эрдэнийн нуруу, Хүрэн Ханангийн нуруу, Нимэгт, Гилбэнт, Сэврэй, Зөөлөнгийн нуруу, Гурвансайханы нуруу, Ямаат уул хүртэл тархжээ. Хөвсгөлийн уулсаар гүйдлээр тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Цоохор ирвэс өндөр уул нуруудын ян сарьдаг, эгц цавчим хад цохио ихтэй, тачир ургамалтай орчинд амьдарна. Монгол орны говийн намхан уулсаас Монгол Алтайн нурууны 4000 метр өндөр уулсын бүсэд идээшин амьдрах ба Говь-Алтайн нурууны 700 метр өндөрт говийн баянбүрдэд гүйдлээр тааралдана (Мөнхцог, 2016). Мөн өндөр уулсын гүн хавцал, жалга, хад цохиот эгц хажуу зэрэг амьтан отох, гэтэж ойртох, довтлох боломжтой бартаат газраар илүүтэй байршиж, говь, цөлийн хад чулуут уулс, баянбүрд шүтэж амьдарна (Батсайхан нар, 2010).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Цоохор ирвэс гол төлөв бүрэнхий, шөнийн идэвхтэй. Энэ том муур тогтоосон эзэмшил нутагтаа ганц нэгээр амьдарна. Ирвэсний идэш тэжээлийн 40 гаруй хувийг янгир ямаа эзлэх бөгөөд тарвага, огдой, туулай, бор гөрөөс, хар сүүлт зээр, адуу, хонь, ямаа, цагаан ятуу, хахилаг, хойлог, шавжаар хооллоно. Заримдаа хулан, аргаль зэрэг тураг амьтдыг ч барьж иднэ.

Ирвэс хадны хонгил, ангалд үүрлэнэ. Ороо нийллэг хавар 1-3-р сард болж, хагас сар орчим

үргэлжилнэ. Хээл тээх хугацаа дунджаар 98-104 хоног. 5-6 сард хадны хөндий, агуйд 2-5, ихэвчлэн 3 гүем төрүүлж, 3 сар орчим хөхүүлнэ. Үржилд 3-4 настайдаа орно. Гүем бараг 2 нас хүртэл эхтэйгээ байна. Гинс жил өнжиж төллөнө. Байгальд 15-18 хүртэл жил насална. Сэм явдалтай, нуугдмал амьдралтай амьтан (Батсайхан нар, 2010; Мөнхцог, 2016).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Монгол оронд 1970-аад оны дундуур 700 гаруй, 1980-аад оны дундуур 2000 орчим цоохор ирвэс (Даш, 1979; Амарсанаа, 1985), 1990-ээд оны дундуур 10 аймгийн 107 сумын 160,000 км² нутаг дэвсгэрт 100 км² нутагт 0.8 бодгаль ногдох нягтшилтайгаар 1700 орчим ирвэс (Амарсанаа, 1994), үүнээс гадна зарим судлаачид 100 км² нутагт 1.1 бодгаль ногдох нягтшилтайгаар 1000 орчим ирвэс (Schaller *et al.*, 1994), 2000 онд 103,000 км² нутаг дэвсгэрт 100 км² нутагт 1-1.5 бодгаль ногдох нягтшилтайгаар 800-1500 ирвэс байна (McCarthy, 2000) хэмээн тус тус үзсэн байдаг.

Хөх Сэрх, Модонт, Охант, Баатархайрхан ууланд цоохор ирвэс хамуурч үхсэн тохиолдол бий. Нялх гүем үерт урсах, махчин амьтдад бариулах зэргээр үрэгдэнэ. Эзэнгүй бэлчих гэрийн малд халдана. Түүний идэш тэжээл бологч туруутан амьтад нь цөөрч, гэрийн малын тоо толгой өсөж, байршил нутагт нь түрж орсноос цоохор ирвэс малаар хооллох нь ихэссэн (McCarthy, 2000; Мөнхцог, 2006) байна.

ХУДАЛДАА

Конвенц (CITES)-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10 жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Монгол улс зөвхөн судалгаа шинжилгээний зориулалтаар цоохор ирвэсний 560 гаруй сорьц дээжийг АНУ, Япон руу экспортолжээ. Монгол улсын хэмжээнд бүртгэгдсэн (2011-2014 он) Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн гэмт хэргийн мэдээгээр, 2014 онд цоохор ирвэстэй холбоотой нэг гэмт хэрэг тэмдэглэгдсэн (Мягмарсүрэн нар, 2014) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол улс 1972 оноос агнахыг хуулиар хориглож (БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975) ирсэн бөгөөд Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (2016)-нд оруулсан. Цоохор ирвэсний тархац нутгийн 18% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна. Тухайлбал, түүний үндсэн тархац нутаг болох Монгол Алтай, Говь Алтай, Хангайн нурууд, Алтайн өвөр говь, Хөвсгөлийн уулсыг хамарсан 19 улсын тусгай хамгаалалттай газар нутагт энэ зүйлийг хамгаалсан (Мөнхцог, 2016) байна.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), мөн “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай олон улсын конвенц (CMS)”-ийн нэгдүгээр хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус оржээ.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Цоохор ирвэс (*Uncia uncia*)-ний эр нь 11200.0 мян.төг, эм нь 13000.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд цоохор ирвэс нь 2240.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ГОЛЫН ХАЛИУ

Lutra lutra Linnaeus, 1758

Баг: Махчтан (*Carnivora*)

Овог: Суусрынхан (*Mustelidae*)

НЭРШИЛ:

Англи: Common Otter, Eurasian Otter, European Otter, European River Otter

Орос: Выдра, Речная выдра

Хятад: Shui ta

Герман: Eurasischer Fischotter

Франц: Loutre commune, Loutre d'Europe

Казах: Қәмшат



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Lutra indica, *Lutra kutab*, *Lutra splendida* (Wilson and Reeder, 1993), *Lutra aurobrunnea*, *Lutra vulgaris*, *Lutra whitleyi* (CITES-ийн лавлах, 2001), *Viverra lutra* (Linnaeus, 1758) (<http://checklist.cites.org>).



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Ховордож болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Мэдээлэл дутмаг” зүйл (Clark *et al.*, 2006) хэмээн үнэлсэн.



ТАНИХ ШИНЖ

Бие урт, цээжин тал руугаа шувтан, мөч богино. Толгой жижиг, уртавтар, тавшгар. Хөлийн хуруунууд сэлэхэд зохицсон арьсан холбоостой. Сүүл урт, угаараа бахим, үзүүр рүүгээ шувтан,

үсээр жигд хучигдсан. Биеийн нуруун тал хар хүрэн, хэвлий бор шаргалдуу, өөхий цайвар (Батсайхан нар, 2010). Сор үс тачирхан, ноолуур өтгөн, нягт. Хамрын сүвний хооронд үсгүй, халцгай. Чихний сүвийг хаадаг арьсан хавхлагатай. Эр нь эмэгчнээс яльгүй том (Дуламцэрэн, 1970; Соколов нар, 1980). Халиуны биеийн урт 60-95 см, сүүл 25-55 см, жин 5,5-10 кг (Tsagaan, 1977; Батсайхан нар, 2010). Толгойн ясны нүүрний хэсэг богино. Гавлын хайрцаг яс намхан бөгөөд өргөн. Кондилобазаль урт 103-126 мм. Шанааны өргөн 61-82 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3, соёо 1/1, бага араа 4/3, их араа 1/2=36 (Батсайхан нар, 2010).



ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Голын халиуны түүхэн тархац нутагт Евразийн ихэнх нутаг дэвсгэр хамрагддаг (Nowak, 1991) бөгөөд Азид Афганистан, Балба, Бангладеш, Бирм, Бутан, БНАСАУ, БНСУ, Лаос, Хятад, Вьетнам, Израиль, Индонез, Иордан, Ирак,



Иран, Камбож, Малайз, Монгол, ОХУ, Пакистан, Сингапур, Сири, Тайланд, Турк, Шри-Ланк, Энэтхэг, Японд, Африкийн Алжир, Тунист, Европтын Австри, Албани, Англи, Бельги, Болгар, Герман, Грек, Дани, Ирланд, Испани, Итали, Лихтенштейн, Люксембург, Нидерланд, Норвег, ОХУ, Польш, Португал, Румын, Турк, Унгар, Финлянд, Франц, Чех, Словак, Швед, Швейцари, Югослав (CITES-ийн лавлах, 2001) зэрэг 70 гаруй улс оронд тархсан (<http://checklist.cites.org>) байна.

голын сав (Цэнджав, 2005), Хангайн нурууны хойд хэсгийн Тэс, Хөвсгөлийн уулсын Эг, Хуримт голуудын сав, Монгол Алтайн нурууны Даян нуурын сав газар (Шар, Самьяа, 2007), Онон голд (Батсайхан нар, 2008) тархсан тухай сүүлийн үеийн судлаачдын мэдээ байдаг.

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монголын умард хэсгийн Хөвсгөл, Хангай, Хэнтийн нуруу (Mallon, 1985), Монгол Алтайн баруун хойд хэсгийн ой тайгат уулсын голууд, зүүн хязгаарын Их Хянганы уулс, Халх голын сав газраар голын халиу өргөн тархаж байсан боловч устаж, 1920-оод оноос Онон, Минж, Завхан, Тэс, Тамир, Чулуут, Шишгэд, Дэлгэр мөрөн, Эг, Халх голын савд ховорхон үзэгдэх болсон (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Tsagaan, 1975; 1977; Соколов нар, 1980).

Голын халиуг XIX, XX зууны турш эрчимтэй агнасны улмаас түүний тоо толгой эрс буурч, Хөвсгөлийн хойд хэсэг, Шишгэдэд Тэнгис голын бэлчирээс улсын хил хүртэлх зэлүүд зах хязгаар нутаг (Samjaa нар, 1998), Баруун Хэнтийн Ерөө



АМЬДРАХ ОРЧИН

Халх, Нөмрөг голын шигүү бургас, монос, зэгсэн, шугуйт зэлүүд ширэнгэ, тохойд байрладаг. Шишгэдэд уулсын тайгын гүн хавцал, өтгөн шигүү ой дундуур урссан өвөл харзалдаг, ширүүн урсгалтай, боргиотой хэсэгт тааралдана. Орогнодог нүхний амсар голын эрэгт, усны түвшнээс доод талд, харин хэвтэр ноохой нүхнийхээ мухарт эргээс 4 м хүртэл зайд газар доор 2 м хүртэл гүнд байна. Ноохойноосоо

дээш цооног малтаж хүн үл нэвтрэх, үзэхүйяа бэрх, өтгөн ширэнгэ дотор, эсвэл бутан доогуур салхивч, өрх гаргана (Tsagaan, 1975). Загас элбэгтэй, өвөлдөө ёроол хүртлээ хөлддөггүй гүн цүнхээлтэй, өвөл харзалдаг гол, цэнгэг устай нуурт амьдарна. Халиуны амьдралд голын эргийн шинж чухал үүрэгтэй. Эргийн өндөр, өтгөн шигүү ургамлан нөмрөг, ус руу түрж орсон модны үндэс, унасан мод халиуны амьдрах орчны сайн чанарыг илтгэх үзүүлэлт болно (Батсайхан нар, 2010).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Голын халиу нь суусрын овгийн амьтдаас усанд сэлж, шумбахад гаргуун сайн зохицсон, хагас усны амьдралтай амьтан юм. Голчлон загасаар хооллох (Батсайхан нар, 2010) бөгөөд заримдаа жижиг мэрэгч, шувуу, усны амьтдыг иднэ (Банников, 1954). Шөнийн болон бүрэнхийн идэвхтэй. Шинэ нутаг олохын тулд хуурай газраар нэг усан сангаас нөгөө усан санд шилжинэ. Голдуу ганц нэгээрээ амьдарна. Голын эргийн дагуу зурвас газрыг эзэмшин амьдрах ба тогтмол орогнох байргүй. Хээл тээх хугацаа 60 хоног орчим боловч далд үетэйгээ нэг жил хүртэл үргэлжлэх нь бий. Эвий 5-6 сард ихэвчлэн 2-3 боор гаргана. Байгальд 20 хүртэл насална (Батсайхан нар, 2010). Шишгэдэд 3-р сарын дундаас отолж эхэлнэ (Tsagaan, 1975). Халх голд нутгийнхан 5 боортой эвүү үзсэн тохиолдол бий (Tsagaan, 1977). Усан доторх болон эргийн хад чулуу, унанги модон дээр нарлаж, салхилж хэвтэнэ. Өвөл заримдаа татмын шугуй, тохойг хэсэж, уул давж ой туулан хэдэн арван километр хол гүйдэг (Банников, 1954; Намнандорж, 1976).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

1970-аад оны сүүлчээр Монголд 20 гаруйхан байв (Tsagaan, 1977). 1995 оны судалгаагаар Халх гол, Дархадын хотгорт нийтдээ 100 орчим толгой халиу байгааг тогтоосон (Samjaa нар, 1998) байна. Дээр үеэс хайр гамгүй агнаснаас хүн байнга нутагладаг том голуудын татамд устаж, зэлүүд нутагт нэн цөөн үлджээ (Банников, 1954; Намнандорж, 1976). Өвөл хоол тэжээл хайх, нар салхинд гарах, үржлийн хосоо олж, хөөцөлдөх зэргээр уснаас гарч цас мөсөн дээгүүр хэсэх үед золбин нохой, чоно, нохой зээх, бүргэд барьж хороохын зэрэгцээ хүмүүс агнах тохиолдол бий. Нүхний амсрыг мөс таглан хөлдөх, өрхөөр үер орж, эрэг нурж, үүр байр усанд автах зэргээс бүлээрээ сүйрэх нь цөөнгүй (Шийрэвдамба нар, 2016).

Халиуны арьсыг дотооддоо хэрэглэхээс гадна, олон улсын хэмжээнд худалдаалдаг учраас хууль бусаар ихээхэн агнана. Өнөөгийн уул уурхайн хөгжилтэй холбоотойгоор энэ зүйлийн амьдардаг усан сангууд ихээр бохирдож, амьдралд нь сөргөөр нөлөөлж байна (Clark et al., 2006) хэмээн үздэг.

ХУДАЛДАА

CITES-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10 жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Монгол улс экспортолж, импортлосон тухай болон хууль бусаар агнасан, худалдаалсан тухай тодорхой мэдээлэл байхгүй байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол улс 1930 оноос агнахыг хуулиар хориглож (БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975) ирсэн бөгөөд Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (2016)-нд оруулсан Голын халиуны тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ. Тухайлбал, Халх гол дахь үндсэн тархац нутгийг Нөмрөгийн дархан газарт хамруулаад байна.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралтад бүртгэлтэй (<http://checklist.cites.org>) амьтан.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Голын халиу (*Lutra lutra*)-ны эр нь 2400.0 мян.төг, эм нь 2700.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд голын халиу нь 480.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



МАЗААЛАЙ БААВГАЙ

Ursus arctos isabellinus Horsfield, 1826

Баг: Махчтан (*Carnivora*)

Овог: Баавгайнхан (*Ursidae*)

НЭРШИЛ:

Англи: Gobi Bear

Орос: Гобийский медведь, Медведь пищуход

Хятад: Ge bi Xiong

Герман: Gobibär

Франц: Ours de Gobi

Казах: Ғобы аю



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Монгол улсын Шинжлэх ухааны хүрээлэнгийн 1943 оны судалгаагаар албан ёсоор тусгай хэлбэр (Банников, 1954), мөн Соколов нар (1992) *Ursus gobiensis* гэсэн бие даасан зүйл гэж тодорхойлсон боловч энэ нь судалгааны хязгаарлагдмал бага материал дээр морфологийн шалгуураар гаргасан дүгнэлт тул асуудалтай хэвээр гэж үзжээ (Schaller *et al.*, 1993; McCarthy, 1999). Энэ салбар зүйлийг *Ursus arctos pruinosus* (Blyth, 1854) гэж дахин тодорхойлсон боловч хожим нь энэ салбар зүйлийн газарзүйн тархалтад Монгол орон багтаагүй, хронологийн судалгааны үр дүн ялгаатай гарсан зэргээс буруу тодорхойлогдсон нь тогтоогдсон. Соколов, Орлов нар (1980) энэ салбар зүйлийг *Ursus arctos isabellinus* гэж үзсэн. Сүүлийн үеийн генетик судалгаагаар Монгол орны мазаалайг *Ursus arctos isabellinus* (Horsfield, 1826) салбар зүйлийн нэг хэлбэр гэж үзсэн бөгөөд *Ursus arctos gobiensis* салбар зүйл нь уг салбар зүйлийг дагалдах синоним байх боломжтой (Clark *et al.*, 2006). Мазаалайн ангилал зүйн асуудлыг цаашид ДНХ-ийн нарийвчилсан судалгаагаар тогтоох шаардлагатай.



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор, үлдвэр зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд “Устаж байгаа” зүйл (Clark *et al.*, 2006) хэмээн үнэлсэн.



ТАНИХ ШИНЖ

Мазаалайн биеийн ерөнхий галбир төрх хүрэн баавгайтай адил боловч түүнээс жижиг биетэй. Цагаан Богд уулын шармаахайн биеийн урт 168 см, сэрвээний өндөр 92 см, жин 90 кг байв (Болд, 1967). Шар хулсны нурууны Хөшөөтийн булгаас хавар амьдаар барьсан шармаахайн биеийн урт 167 см, сэрвээний өндөр 79 см, биеийн жин 138 кг байлаа (Batsaikhan *et al.*, 2004). Мазаалайн бие лагс, хөл бахим, тавхай нүцгэн сайртай, 5 хуруутай. Сүүл ахар, үснээс бараг цухуйж харагдахгүй. Чих харьцангуй жижиг, үзүүр нь дугираг. Хүзүү богино, бахим. Зүс ухаа бор, цайвар хүрэн, бараан хүрэн, дааны урд, хүзүүний уг орчим цайвар толботой. Үс урт өтгөн. Зуны зүс жигд хүрэн бор, өвөл, хавар хар хүрэн сор үстэй, цайвар шаргал ноолууртай. Зүс


нас хүйснээс хамааран өөрчлөгдөнө. Хумс цайвар өнгөтэй, шулуундуу, мохоо, бүдүүн богинохон. Хөнгөн шалмаг хөдөлгөөнтэй. Ерөнхийдөө биеийн урт 147-168 см, сэрвээний өндөр 92 орчим см, сүүлний урт 6.2 см, чихний урт 10 см, биеийн жин 52-100 кг хүрнэ. Толгойн ясны кондилобазаль урт: 258-306 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; түрүү араа 4/4; агт араа 2/3 = нийт 42 (Дуламцэрэн, 1970; Соколов нар, 1992; Батсайхан нар, 2010).

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Азид Монгол, Хятадад тархсан (CITES-ийн лавлах, 2001) бөгөөд бие даасан салбар зүйл мөн гэдэг нь тогтоогдвол Монгол орны эндемик зүйл болно (Clark *et al.*, 2006).

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

1930-аад онд Алтайн өвөр говийн баруунаа Аж Богдын зүүн үзүүр, зүүнээ Тост, Нэмэгт уул, хойшоо Эж хайрхан, Захуй, Зармангийн баянбүрд, Эдрэнгийн нуруу, өмнөө улсын хил хүртэлх нутагт тархаж байв (Банников, 1954; Болд, 1967; Дуламцэрэн, 1970). Харин өдгөө зүүнээ Цагаан Богд, баруунаа Баруун Тооройн нуруу, хойш Зараа, Буурын хар уулын хооронд буюу тархацынхаа тэн хагасаас бага нутагт Сэгс Цагаан Богд, Шар хулсны нуруу, Төмөртэйн хөх нуруу, Атас Ингэс уулын хавиар байршиж байна (Дуламцэрэн, 1970; Жирнов нар, 1985). Шар хулс, Цагаан тохой, Цагаан бургас, Өлзий бэлгих, Хөшөөт зэрэг булаг шандын ойролцоох хад бартаат намхан уулсаар гүйдэлтэй. Зүүнээ Тост уул, баруунаа Майхан булаг, Хар хайрхан, хойшоо Эдрэнгийн нуруу хүртэл тохиолдлоор үзэгдэнэ (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Намнандорж, 1976; Жирнов нар, 1985). Мазаалайн тархац нутаг 1960-аад оныхоос 5 дахин хумигдаж, 18,000 ам дөрвөлжин нутаг дэвсгэрт байршиж байна (Мижиддорж, 2006).



АМЬДРАХ ОРЧИН

Монгол орны Алтайн өвөр говийн хэт гандуу элдэв сөөг, чулуут цөлийн бэсрэг уулсын бэл, хөндий, нам аараг, толгод, уудам хотос, хоолой, сайр, садарга даган бэлчээрлэнэ. Задгай булаг, шанд, тойром шүтнэ (Батсайхан нар, 2010).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Хоногийн турш идэвхтэй. Бамбарууштай эвшээс бусад нь ганц нэгээр амьдарна (Батсайхан нар, 2010). Намар орой 10-р сараас 11-р сард ичэж, хавар 3-р сараас 5-р сард ичээнээс гарна. Хадны агуй, хонгил, хулсан ширэнгэ, сухайн төгөл доогуур нүх, хэвтэр засан ичээлнэ. Зун задгай усны ойролцоо нутаглана (Тулгат, 1993; Батсайхан нар, 2010). Ороо нийллэг 5-р сараас 8-р сарын эцэс хүртэл үргэлжилнэ (Батсайхан нар, 2010). Эвш хавар эрт 2-3-р сард ичээндээ ихэвчлэн нэг, заримдаа ихэр бамбарууш төрүүлнэ (Болд, 1967; Дуламцэрэн, 1970). Хээлээ 180-220 орчим хоног тээнэ. Мазаалай 5 нас хүрч үржилд орох ба нэг эсвэл 2-3 жил өнжиж төллөнө. Хойд мөч дээрээ босоо зогсож ойр орчноо харуулдана. Элдэв идэштэй (Батсайхан нар, 2010). Зун зээргэнэ, хармагийн жимс, хавар, намар бажууны үндэс, зэгс, зээргэнэ, махирс, сухай, хялгана, хөмүүл зэрэг ургамлаар хооллоно. Амьтны зүйлээс тураг амьтдын сэг, туулай, шижүүхэй, чичүүл зэрэг мэрэгчид, шувуу, гүрвэл, шавжаар хооллоно (Дуламцэрэн, 1970; Соколов нар, 1980). Мазаалайн идэш тэжээлд 33 зүйл ургамал, 18 зүйл амьтны гаралтай хоол тэжээл улирлын онцлогоос хамаарч харилцан адилгүй оролцдог (Мижиддорж, 2006) байна.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

1960-аад онд 15-20 толгой, далаад оны дундуур 20 гаруй, 1980 оны эхээр 25-30, наяд оны сүүлчээр 50-60, 1990 оны эхээр 30 гаруй толгой байжээ (Болд, 1967; Даш, 1979; Batsaikhan *et al.*, 2004). Автомат камер болон генотипийн судалгаагаар 22-31 толгой байгааг тогтоосон (Амгалан нар, 2006; Одбаяр нар, 2011) байна. Орчны өөрчлөлт, халдварт өвчин зэрэг биотик хүчин зүйлүүдэд эмзэг бөгөөд мазаалайн хувьд жижиг популяцид тохиолддог олон сөрөг нөлөө (инбридинг, үржлийн эрчим бага байх гэх мэт) илэрдэг. Түүний тархац нутгийн хэмжээнд популяцийн тусгаарлалт, генетик солилцооны талаар бага судлагдсан (McCarthy, 1999).

1992 оноос хойш Говийн Их дархан газарт хийсэн мониторинг судалгаагаар туснутагт жил дараалсан ган гачиг болж, жилийн хур тундасны хэмжээ 100 мм-ээс 50 мм хүртэл буурсан (Мижиддорж, 2006) байна. Эрстэс уур амьсгалтай хэт хуурай бүс нутагт амьдарч буй мазаалайн хувьд жил дараалсан ган, хуурайшилт, ус, тэжээлийн байнгын гачаалалтай байдал нь түүнийг үхэж хорогдуулах, тоо толгой, үржил төлжилтийг нь хязгаарлах хүчин зүйл болно (Болд, 1967; Базардорж, 1972; Намнандорж, 1976; Тулгат, 1993). Ус, тэжээл хүрэлцээгүйгээс нутаг, тэжээлээ булаалдах, нэгнийгээ барих тохиолдол бий (Тулгат, 1993).

Аялагчид тохиолдлоор хөнөөх, нялх аламцаг барих зэргээр хороодог (Намнандорж, 1976; Тулгат, 1993). Түүнчлэн хоргодож үүрлэх, ичээлэх орчны хулс, бутан шугуй ширэнгийг хадах, хүн, мал суурьших зэргээр түүний хэвийн амьдралыг өөрчилж, үргээж дайжуулна (Намнандорж, 1976). Мазаалай баавгайн тархац нутгийн хүрээнд алт зэрэг ашигт малтмалыг хууль бусаар хайх, олборлох зөрчил нэмэгдэх хандлагатай байна (Амгалан нар, 2006). Мазаалай баавгай нь устах аюулд орсон амьтан (Шийрэвдамба нар, 2016) юм.

ХУДАЛДАА

CITES-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10 жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Монгол улс 2010 онд зөвхөн судалгаа шинжилгээний зориулалтаар мазаалай баавгайны 843 үс, сорьц дээжийг Канад руу экспортложээ. Одоогоор энэ зүйл амьтныг хууль бусаар агнасан, худалдаалсан тухай тодорхой мэдээлэл байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол улс 1953 оноос мазаалай баавгайг агнахыг хуулиар хориглож (БНМАУ-ын ан агнуурын хууль,


1975) ирсэн бөгөөд Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (1987; 1997; 2013; 2016)-нд оруулсан. Мазаалай баавгайн үндсэн байршил нутгийг Говийн Их Дархан цаазат газарт хамруулсан байна.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). 2013 оноос БОАЖЯ тусгай ажлын хэсэг байгуулж, мазаалайн биологи, экологи, хамгааллын талаарх судалгааны ажлыг өргөжүүлэх, амьдрах орчныг хамгаалж, нөхөн сэргээх, биотехникийн арга хэмжээг тогтмолжуулах зэрэг цогцолбор арга хэмжээг авч хэрэгжүүлж байна (Шийрэвдамба нар, 2016).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр мазаалай баавгайны эр нь 19000.0 мян.төг, эм нь 22000.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнах, барих тохиолдолд мазаалай баавгай нь 3600.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ТАХЬ АДУУ

Equus ferus przewalskii Groves, 1986

Баг: Туурайтан (*Perissodactyla*)

Овог: Адууныхан (*Equidae*)

НЭРШИЛ:

Англи: Mongolian Wild horse, Przewalski's Wild horse

Орос: Лошадь Пржевальского

Хятад: Ye Ma

Герман: Przewalskipferd, Wildpferd

Франц: Cheval de Przewalski

Казах: Пржевальский жылқысы



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Тахь адуу нь гэрийн адуу (*Equus caballus* Boddaert, 1785)-тай өвөг нэг бөгөөд хоорондоо үржилд орж үр төл гаргах чадвартай боловч генетикийн хувьд нэлээд ялгаатай, түүнчлэн тэдний хромсомын тоо нь өөр тул тахь адууг бие даасан зүйл гэж үзэх ёстой (Ryder, 1994; Oakenfull нар, 2000) гэжээ. *Equus caballus przewalskii* (Linnaeus, 1758), *Equus ferus przewalskii* (Boddaert, 1785) (<http://checklist.cites.org>).



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд “Устаж байгаа” зүйл (Clark et al., 2006) хэмээн үнэлсэн.



ТАНИХ ШИНЖ

Тахь адуу хул зүстэй, улирал болон бодгалийн хувийн онцлогоос хамаарч ухаа хонгор, цайвар хул, бор хул зүстэй ч тохиолдоно. Хэвлий, цавь, суга, гуяны зураа орчим цайвар зүстэй. Мундаанаас зоо нуруу дагуу сүүлний цацаг хялгас хүртэл бор тууш хүрэн судалтай. Дэл босоо, ахар, хар өнгөтэй. Сүүлийн угаас төгсгөл хүртэл хар бараан урт хялгастай. Толгой данхар. Мөч чацархаг, бахим, өвдөгнөөс доош хар, олонх бодгаль өвдөгний дотор талд хар хөндлөн судалтай. Тахийн дээд эрүү завсрын ясны нийлэх хэсэгт байрлах товгор үл мэдэг буюу байхгүй. Биеийн урт 220-280 см, мундаа орчим чац нь 115-146 см, хялгастай сүүлний урт 92-111 см, чихний урт 14-18 см, биеийн жин 275-325 кг хүрнэ. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 0-1/0-1; түрүү араа 3/3; агт араа 3/3; 36-40 (Гептнер нар, 1961; Батсайхан нар, 2010; Шийрэвдамба нар, 2016).



ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Эрт цагт тахь адуу нь Евразийн ихэнх нутагт тархан амьдарч байсныг Франц, Испани дахь хадны сүг зургууд гэрчилдэг. Дэлхийн хэмжээнд тахь адууг хуучин тархац нутагт нь сэргээн нутагшуулах хөтөлбөр явагдаж байна. Одоогоор Украин, Казахстан, Хятад, Монгол зэрэг улс оронд сэргээн нутагшуулж байна. Энэ зүйл түүхэн тархац нутагтаа зэрлэгээр амьдарч байгаа цорын ганц нутаг бол Монгол орон юм. Иймээс Монголын эндемик зүйл гэж үздэг бөгөөд өнгөрсөн зууны эхний хагас хүртэл зэрлэгээр энэ газар нутагт амьдарч байсан билээ (Clark *et al.*, 2006).

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

XIX зууны сүүлийн хагаст Зүүнгарын говьд Тэнгэр уулын ар хормой, бэлээс хойш Монгол Алтайн нурууны өвөр бэл, зүүн зүгт Аж Богд, баруун зүгт Манас, Өрөнгө гол хүртэлх нутагт тархаж байжээ (Банников, 1954; Жирнов нар, 2005).

XX зууны хорь гучаад онд Зүүн гарын Тахийн шар нуруу, Хөх өндөр, Хавтаг, Байтаг уулс, Гүн тамга, Хонин ус, Тахийн усны говь, Биж, Бодонч, Үенч, Булган голуудын адгаар сүрэг сүргээрээ бэлчиж байв (Банников, 1954; Эрэгдэндагва, 1959; Намнандорж, 1976). Гучаас тавиад онд тахь адууны үндсэн байршил нутаг улсын хилийн зурвас бүсэд орсноор гэрийн мал, хүний нөлөөлөл багассан боловч тавиад оноос Байтаг Богд уул, Тахийн шар нурууны хоорондох улсын хил орчмын 20-30 км өргөн зурваст өвөл, хавар малчид нүүдэллэн нутаглах болсноор тахь адуу ховордож, цөөн үзэгдэх болсон (Шагдарсүрэн, 1962; Довчин, 1969). Тавь, жараад онд хилийн цэргийн анги, нутгийн малчид задгай ус, бэлчээрийг эзэгнэж, үлдсэн тахийг шахан зайлуулжээ. Жараад онд ганц нэгээр үзэгдэж байгаад, далаад оноос хойш Монгол улсад устсан (Довчин, 1970; Хотолхүү нар, 1972) бөгөөд хамгийн сүүлд тахь адуу 1969 онд Зүүнгарын говийн Тахийн шар нуруу орчимд харагдсан (Paklina *et al.*, 1989) хэмээн тэмдэглэжээ.

Монгол улсын Засгийн газар тахийг сэргээн нутагшуулах ажлыг 1992 оноос эхлэн холбогдох байгууллага, гадаадын иргэдтэй хамтран зохион байгуулсны үр дүнд Хустайн Байгалийн цогцолборт газар, Говийн Их Дархан цаазат газрын Б хэсгийн Бижийн гол, Хонин усны говь, Тахийн ус, Гүн тамга, Завхан аймгийн Дөрвөлжин сумын Хомын тал зэрэг газарт нутагшин үржиж байна (Шийрэвдамба нар, 2016).



АМЬДРАХ ОРЧИН

Тахийн уугуул нутаг нь Монголын Зүүнгарын цөл, цөлөрхөг хээрийн өдлөг хялгана-хөмүүл, баглуур-бударганат бэсрэг уулсын бэл, хөндий, нам аараг, толгод, уудам хотос, хоолой, сайр садарга юм. Задгай булаг, шанд, тойром шүтэж байршина. Харин Хустайн нуруунд нутагшуулж байгаа тахийн сүрэг элдэв үетэн, алаг өвст уулын хээр, ойт хээрт бэлчээрлэдэг (Батсайхан нар, 2010).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Ороо нийллэг 5-р сараас 7-р сарын эцэс хүртэл үргэлжилнэ. Гүү 5-р сарын дунд үеэс 7-р сарын эх хүртэл төллөж, нэг унага төрүүлнэ. Хээлээ 327-357 орчим хоног тээнэ. Байдас 3-4 настай, харин үрээ 5 нас хүрч үржилд орно (Батсайхан нар, 2010; Шийрэвдамба нар, 2016). Зун өглөө, орой, шөнийн цагаар, сэрүүн улиралд бараг өдрийн турш бэлчээрлэнэ. Азарган сүрэг жилийн турш тогтвортой, үрээ ганц нэгээр эсвэл сүрэглэнэ. Азарга соёолон наснаас эхлэн 9-15 нас хүртэл гүү хураана. Тэжээвэр тахь 20-31 хүртэл насалдаг (Батсайхан нар, 2010) байна.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

1898-1904 онд Монголын говиос тахийн 88 унага барьж, тэдгээрээс 53 нь Украин, Герман улсын амьтан үржүүлгийн газар, амьтны хүрээлэнгүүдэд эсэн мэнд хүрч, өсч үржсээр өдгөө 30 шахам орны 130 гаруй амьтны хүрээлэн, нөөц газруудад

2000 орчим толгойд хүрчээ. Монгол орны гурван газарт нийтдээ 400 гаруй бодгаль тахь байгаагаас Хустайн нуруу, Бижийн голын тахь жилийн турш байгальд сул чөлөөтэй идээшин дасаж байна (Шийрэвдамба нар, 2016).

1940-1950-иад онд БНМАУ-ын хилийн ойролцоо байсан хасгийн босуул зэвсэгт хүмүүс тахийг хайр гамгүй хядан хүнсэнд хэрэглэж, 1944-1945 оны их зуданд түүний тоо толгой ихээхэн хорогдож, 1898-1903 онд Европод гаргахаар нялх унагыг олон тоогоор барьсан зэрэг нь тахийн сүргийн бүтэц, тоо толгойд сөргөөр нөлөөлж устахад хүргэжээ. Ус, бэлчээрээр хулан, хар сүүлт, хааяа аргаль, янгиртай давхцана. Чононд унага, даага ихэвчлэн идүүлнэ. Их цастай хүйтэн өвөл бөөнөөрөө өлдөж турж үхдэг (Шагдарсүрэн, 1962; Соколов нар, 1978).

Гэрийн адуутай эрлийзжих, малтай бэлчээр, усаар өрсөлдөх нь ховордох шалтгаан болж магадгүй. Маш жижиг популяцийг хэд хэдэн үе удмаар үржүүлж байгаа тохиолдолд генийн олон янз байдлын хомсдолд орох аюул бий. Сэргээн нутагшуулахад амьтны хүрээлэнгээс тахь тээж ирсэн *Babesia equi*, *B.caballi* болон боом (*Streptococcus equi*)-оор өвчлөх зэргээр халдварт өвчинд нэрвэгдэх нь мөн ховордлын гол шалтгаан болж байна (Roberts нар, 2005).

ХУДАЛДАА

Дэлхийн олон орон дахь тахь адууны үржүүлмэл бодгаль 1200 гаруй толгой болжээ. Монгол улс 1992 оноос Голланд, Герман, ОХУ, Швейцарь, Австрали улсын амьтны хүрээлэнгээс тахь адуу авчээ. Амьтны хүрээлэнгүүд үржүүлмэл тахь адууны удмуудыг солилцдог (CITES-ийн лавлах, 2001; Шийрэвдамба нар, 2016). CITES-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10 жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Монгол улс судалгаа шинжилгээний зориулалтаар тахь адууны цөөн тооны гавлын яс, үс (20), сорьц дээж (96)-ийг экспортолсон байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол улс 1930 оноос эхлэн агнахыг хуулиар хориглож (БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975), улмаар Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд, Монгол улсын Улаан ном (2016), “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд

худалдаалах тухай конвенц (CITES)"-ийн нэгдүгээр хавсралтад (<http://checklist.cites.org>) тус тус оруулсан байна

Монгол улс 1992 оноос тахийг уугуул нутагт нь сэргээн нутагшуулах ажлыг гадаад улс орнууд, хувь хүн, байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. 1992 онд Хустайн нуруунд 15 тахь, Говь-Алтай аймгийн Бижийн голд 5 тахь гадаадаас зөөвөрлөж тавьснаар тахийг сэргээн нутагшуулах ажил эхэлсэн. 2004 онд Завхан аймгийн Хомын талд 12 тахь авчирснаар тахь сэргээн нутагшуулах 3 дахь төсөл эхлэв. 1992 онд Голланд, Украин улсаас 20, 1993 онд Украинаас 6, 1994 онд Голландаас 10, 1995 онд Швейцар, Австрали улсаас 13, 1996 онд Швейцар, Голландаас 21 тахийг Монголд зөөвлөрлөн тавьж амжилттай сэргээн нутагшуулж байна (Шийрэмдамба нар, 2016). Тахь адууны тархац нутаг бүхэлдээ улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг.



ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Тахь адуу (*Equus przewalski*)-ны эр нь 11000.0 мян.төг, эм нь 13000.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд тахь адууны эр нь 2200.0 мян.төг, эм нь 2600.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ХУЛАН АДУУ (ХУЛАН)

Equus hemionus Pallas, 1775

Баг: Туурайтан (*Perissodactyla*)

Овог: Адууныхан (*Equidae*)

НЭРШИЛ:

Англи: Asiatic Wild Ass, Khulan, Dziggetai, Mongolian Wild Ass

Орос: Кулан

Хятад: Ye lu

Герман: Kulan (Asiatischer Wildesel, Asiatischer esel)

Франц: Hémione sauvage de Mongolie

Казах: Құлан



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Equus bedfordi, *Equus castaneus*, *Equus finschi*, *Equus luteus* (Wilson and Reeder, 1993), *Equus hemionus hemionus* (Pallas, 1775), *Equus onager* (Boddaert, 1785), *Equus hemionus khur* (Lesson, 1827), *Equus hemionus kiang* (Pallas, 1775) (<http://checklist.cites.org>).



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Эмзэг”, бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй” зүйл (Clark *et al.*, 2006) хэмээн үнэлсэн.



ТАНИХ ШИНЖ

Ерөнхий зүс хул. Зун улаавтар, өвөл цайвар хул. Мундаанаас сүүлний уг хүртэл зоо нуруу дагуу нарийхан хүрэн бор судалтай. Дэл, сүүлний хялгас

бараан (Шийрэвдамба нар, 2016). Дэл босоо, ахар, хар өнгөтэй. Толгой данхар, урт чихтэй, мөч чацархаг. Биеийн урт 200-260 см, мундаа орчим чац нь 110-140 см, чихний урт 17.5-26.5 см, биеийн жин 200-300 кг хүрнэ (Соколов нар, 1980; Батсайхан нар, 2010). Хуланг толгойн ясаар нь тахь, гэрийн адуунаас хялбар ялгах гол шинж бол түүний дээд эрүү завсарын ясны нийлэх хэсэгт байрлах товгор юм. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 0-1/0-1; түрүү араа 3/3; агт араа 3/3=36-40 (Батсайхан нар, 2010).



ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Азид хулан адууны хэд хэдэн зүйлхэн өөр хоорондоо алслагдан тархсан байна. Тухайлбал, Монгол, Хятадад монгол хулан адуу (*Equus hemionus hemionus*), Энэтхэг, Иран, Пакистанд энэтхэг хулан адуу (*Equus hemionus khur*), Хятад, Энэтхэг, Непаль, Пакистанд төвд хулан адуу (*Equus hemionus kiang*) тус тус тархсан (<http://checklist.cites.org>) байна. Хулан адуу Ойрхи



Дорнодод Арабын хойг, Бага Ази болон Баруун хойд Энэтхэг хүртэл тархаж байсан боловч эдүгээ тэдгээр нутгуудад устаж, одоо Израиль, Саудын Араб, Иран, Казахстан, Туркменистан, Узбекистан зэрэг улс орнуудад сэргээн нутагшуулж байна (Feh *et al.*, 2002).


МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хулан адуу Монгол орны баруун өмнөд ба баруун хойд хэсгээс хамгийн зүүн хойд нутаг болох Монгол, Орос, Хятадын хил хүртэлх говь цөл, тал хээрийн бүсээр өргөн тархаж байсан (Feh *et al.*, 2002) боловч түүний тархац нутаг, тоо толгой буурах үйл явц үргэлжилсээр байжээ (Банников, 1981).

Өнгөрсөн зууны дунд үе хүртэл Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Өмнөговь, Дорноговь, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, одоогийн Дундговь, Сүхбаатар аймгийн ихэнх цөлөрхөг хээр, зүүн тийшээ Буйр нуур хүртэл тархаж байв (Банников, 1954; Намнандорж, 1964). Дорнодын тал, Дорноговийн зүүн хэсэгт 1900-аад оноос өмнө, Их нууруудын хотгор, Нууруудын хөндийд 1930-аад он хүртэлх хугацаанд устаж, харин Зүүнгарын

говь, Алтайн өвөр говь, Өмнөговь, Дорноговийн баруун хэсэг, Дундговийн өмнөд хэсэгт үлдсэн байлаа (Соколов нар, 1980; Мөнхсайхан нар, 1986; Дуламцэрэн нар, 1989).

Одоо Монгол орны өмнөд хэсгийн говиудаар тодруулбал, Алтайн өвөр говь, Умард говь, Алашань говь, Зүүнгарын говь (Reading *et al.*, 2001; ШУА-ийн Биологийн хүрээлэн, 2010), Дорнод говийн Их нартын чулууны хойд хэсгээр идээшин байршиж байна (Reading *et al.*, 2006). Сүүлийн 20-25 жилийн хугацаанд хулан адуу төмөр зам гаталж хуучин тархац нутгаасаа хойш болон зүүн тийш шилжиж Сайншанд хүртэл тэлэн тархаж байна (Clark *et al.*, 2006).



АМЬДРАХ ОРЧИН

Монгол орны цөл, цөлөрхөг хээрийн нам уулс, аараг толгод, тэдгээрийн завсрын уудам хөндий, хоолой, хотос, толгодын шил, бэлийн үетэн, шарилж, баглуур, бударгана, заг, харганат элсэрхэг, хайрган болон дагжуур чулуурхаг газар нутаглана (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов нар, 1980). Задгай булаг, шанд, тойром шүтэн идээшлэх боловч задгай усгүй нутагт сайранд татаал гаргаж ундаална (Батсайхан нар, 2010). Өвөл өвс сайтай, бартаа нөмөртэй, ундлах цастай бэлчээрт байршина. Сүүлийн 200 жилд хуурай хээрээс цөл рүү шилжин байршжээ (Соколов нар, 1978).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Ороо нийллэг 7-р сараас 8-р сарын эцэс хүртэл үргэлжилнэ. Гүү 5-р сарын дунд үеэс 7-р сарын эх хүртэл төллөж, нэг унага төрүүлнэ. Хээлээ 330-342 орчим хоног тээнэ (Банников, 1954; 1975; Намнандорж, 1964; Батсайхан нар, 2010). Байдас 3-4 настай, харин үрээ 4-5 нас хүрч үржилд орно (Соколов нар, 1980; Батсайхан нар, 2010).

Зун өглөө, орой, шөнийн цагаар, сэрүүн улиралд бараг өдрийн турш бэлчээрлэнэ. Үржлийн улиралд азарганы сүрэг бусдаас тусгаар байх боловч ус бэлчээр хомс үед эсвэл сэрүүн улиралд олон хулангийн сүрэг нэгдэж, хэдэн зуун бодгальтай том сүрэг бүрэлдэнэ. Азарга байх идэвхтэй нас нь 5-10, байгалийн нөхцөлд 14 насалдаг (Батсайхан нар, 2010) байна.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Монгол оронд 1970-аад оны дундуур хулан адууны тоо толгой 15,000 орчим байсан бөгөөд үүнээс Алтайн өвөр говиор 8,000 орчим хулан тоологдож (Банников, 1975) байжээ. Түүнээс хойш Зүүнгарын говьд 1500 толгой, Алтайн өвөр говийн баруун өмнөд буюу Говийн дархан газрын "А" хэсэгт 500 толгой хулан байсан (Соколов нар, 1980; Мөнхсайхан нар, 1986) тухай тэмдэглэн үлдээжээ.

ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн судалгаагаар (2003; 2010) Монгол орны хэмжээнд 2000 оны эхээр 19,000 орчим хулан адуу тоологдож, үүний 70 орчим хувь нь Дорноговь аймагт, 20 хувь нь Өмнөговь аймагт, 12 хувь нь Зүүнгарын говьд, үлдсэн 1 хувь нь Говь-Алтай, Баянхонгор аймгийн нутагт тохиолдож байжээ. Хулан адууны тоо

толгой 2003 оны байдлаар 1997 оныхоос 60 хувь, 2009 байдлаар 2003 оныхоос 29 хувиар тус тус буурсан тухай дурдсан байна.

Дорнодын тал, Дорноговь, Их нууруудын хотгор, Нууруудын хөндийн нутаг дэвсгэрт гол горхи, булаг шанд зэрэг задгай усыг хүн мал эзэгнэж, хулан адууг хяналт зохицуулалтгүй агнаж, үргээж дүрвээсний улмаас устсан (Банников, 1954; Цэвэгмэд, 1970; Соколов нар, 1978; Жирнов нар, 2005) хэмээн үздэг. Өнөөгийн байдлаар Дорноговь, Өмнөговь, Алтайн өвөр говийн хулан адууны багахан байршил нутагт малын тоо толгой жилээс жилд өсөж, үүний улмаас хулан адуу идэш тэжээл, бэлчээр нутаг, ус ундаар хомсдон шахагдаж (ШУА-ийн Биологийн хүрээлэн, 2010; Жирнов нар, 2005), хууль бус агнуурт ихээхэн өртөх болов (Банников, 1954; Цэвэгмэд, 1970; Stubbe *et al.*, 2005). Мөн хулангийн байрших зарим нутгуудад (баянбүрд, задгай усны ойролцоох) уул уурхай, дэд бүтцийн хөгжил эрчимжиж, хүн амын суурьшил нэмэгдэж байна. Эдгээр болон бусад шалтгааны улмаас хулангийн амьдрах орчин доройтон хомсдох болсон байна. Цаашид уул уурхайн хөгжил, авто зам, дэд бүтцийн шинэ төсөл, үйл ажиллагаа нь хулан адуунд аюул учруулах боломжтой (Clark *et al.*, 2006).

Байгаль дээр хулангийн унага, даагыг чоно барьж хороох, цаг агаарын нөхцлөөс шалтгаалсан ган зуднаар, ялангуяа цас ихтэй өвөл түүний тоо толгой ихээхэн хорогддог (Шийрэвдамба нар, 2016) байна.

ХУДАЛДАА

CITES-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10 жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Монгол улс судалгаа шинжилгээний зориулалтаар хулан адууны 200-аад гавлын яс, 260 гаруй үс, сорьц дээжийг экспортолжээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн (2011-2014 он) Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн гэмт хэргийн мэдээгээр, хулан адууны талаарх гэмт хэрэг, зөрчил нийтдээ 36 удаа тэмдэглэгдсэн (Мягмарсүрэн нар, 2014) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол улс 1953 оноос агнахыг хуулиар хориглож (БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975) ирсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан байна.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int>) тус тус бүртгэлтэй. Хулан адууны тархац нутгийн 29% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байгаа бөгөөд түүний үндсэн тархац нутгийг Говийн Их болон Бага Дархан цаазат газруудад хамруулан хамгаалж байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан

амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хулан адуу (*Equus hemionus*)-ны эр нь 9700.0 мян.төг, эм нь 11000.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд хулан адууны эр нь 1940.0 мян.төг, эм нь 2200.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ШИЛҮҮС МИЙ (ШИЛҮҮС)

Lynx lynx Linnaeus, 1758

Баг: Махчтан (*Carnivora*)

Овог: Мийнхэн (*Felidae*)

НЭРШИЛ:

Англи: Eurasian Lynx

Герман: Luchs

Орос: Рысь

Франц: Lynx, Lynx d'Eurasie

Хятад: She li

Казах: Сілеусін



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Lynx isabellina, *Lynx kozlovi*, *Lynx vulgaris* (Wilson and Reeder, 1993), *Lynx lynx*, *Lynx canadensis*, *Lynx pardellus*, *Lynx pardinus* (CITES-ийн лавлах, 2001), *Felis lynx* (Linnaeus, 1758) (<http://checklist.cites.org>).



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд “Ховордож болзошгүй” зүйл (Clark *et al.*, 2006) хэмээн үнэлсэн.



ТАНИХ ШИНЖ

Монгол оронд тархсан мийн овгийнхноос биеийн хэмжээгээр ирвэсний дараа орно. Мөч харьцангуй урт зэгзгэр, тавхай том. Биеийн урт

73-106 см, сүүлний урт 10-24 см, чихний урт 7.5-9.9 см. Биеийн жин 9-21 кг (Дуламцэрэн, 1970; Батсайхан нар, 2010). 8-р сарын сүүлээр эр ногуул 7.5 кг орчим жинтэй болно (Дуламцэрэн, 1995). Эмэгчин биеэр арай бага. Бусад зүйл шилүүснээс харьцангуй том биетэй. Зүс саарал, ухаагаас шаравтар толботой. Чихний үзүүрт 4-7 см урт шовх хар цацаг үстэй. Сүүл богино, үзүүр нь хар. Шанаанаас унжсан «хууз» маягийн урт үстэй. Толгойн ясны конднлобазаль урт 108-150 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3, соёо 1/1, бага араа 2/2, их араа 1/1=28 (Батсайхан нар, 2010).



ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Шилүүс мий Азийн Афганистан, Балба, Бутан, БНХАУ, БНСУ, Ирак, Иран, Казахстан, Монгол, ОХУ, Пакистан, Сири, Турк, Туркменистан, Энэтхэгт, Европийн Австри, Албани, Герман, Грек, Испани, Норвег, ОХУ, Польш, Португал, Румын, Финлянд, Чех, Словак, Швейцарь, Швед, Югославт, Умард




Америكت АНУ, Канад (CITES-ийн лавлах, 2001) зэрэг 40 гаруй улс оронд тархсан (<http://checklist.cites.org>) байна.

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол орны шилүүс мий Норвеги, Швейцариас Төвдийн өндөрлөг хүртэлх өргөн уудам нутагт тархсан Евразийн шилүүсний зүйлд хамаарах (Дуламцэрэн, 1970) боловч хязгаарлагдмал тархацтай. XIX зууны сүүлээр Алтайн өвөр говь, Атас уул орчимд шилүүс харсан (Ладыгин, 1900) байдаг. Монгол оронд өргөн тархсан боловч тархалт нь жигд бус. Хөвсгөлийн тайгын бүсэд, ялангуяа Дархад, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул сумдын ойт бүсэд илүү элбэг тохиолдоно (Дуламцэрэн, 1970).

Өмнөговь, Алтайн өвөр говийн хад чулуутай нүцгэн, намхан уулс, толгодоор байршиж, тэдгээрийн хоорондох хөндий гатлан гөрөөлөх (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; 1995) бөгөөд Тостын нуруунаас Атас хүртэлх бүх уулсаар шилүүс ердийн тархацтай байв (Банников, 1954). Говийн Их Дархан цаазат газрын А хэсэг, түүний хил залгаа нутагт 1981-1987 онд говийн шилүүсний

бие, мөр үзсэн, агнасан, амьтан барьж идсэн сэг зэм олдсон 44 цэг тэмдэглэж, Алтайн өмнөх говьд шилүүс ихэнх уулс, аараг толгод, бэлийн сайр садарга, бут сөөгт тал, уулсын хоорондох хотгор хоолой говьд тааралдаж байсан (Дуламцэрэн, 1995) тухай тэмдэглэжээ.



АМЬДРАХ ОРЧИН

Шилүүс мий умард Монголд тайга, холимог ой, ойт хээр, хээрийн хад чулуут бэсрэг уулс, өндөр уулархаг нутаг, говь цөлийн хадат уулсаар тохиолдоно (Батсайхан нар, 2010). Говийн баянбүрд, задгай ус, булаг шандын хавьд бараг байнга нутаглаж, зулзагална (Дуламцэрэн, 1995).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Шилүүс мий гол төлөв бүрэнхий шөнийн идэвхтэй. Ганц нэгээр амьдарна. Шилүүс туулай, чандага, бор гөрөөс, хүдэр, хар сүүлтий, янгирын ишиг, аргалийн хурга, тарвага, огдой, жижиг мэрэгчид, ятуу, хөтүү, хахилаг мэтийн дунд зэргийн биетэй шувуудаар хооллоно (Батсайхан нар, 2010). Говийн шилүүс голдуу 2-3-аар нийлж ан хийх бөгөөд туршлагатай хашир нь эхэлж довтолно. Хар сүүлтий, бөхөн, аргаль хонь, янгир ямаа, туулай, хахилаг, ногтруугаар хооллож, тэдгээрийн байршлыг дагаж нутаглана. Хар сүүлтийн усанд ирэх жим дээр отож, эсвэл идээшилж байхад нь сайр, бут, бартаа даган мярааж ойртоод гэнэт үсрэн дайрч барина. Гэрийн ямааг олонтаа барих, нялх ботго, муур, тугал идсэн тохиолдол бүртгэгддэг. Говийн шилүүс 7-р сарын хорьд орчмоос үүрнээс холдож ногоулаа дагуулан бүл сүргээр явж, ан авд сургаж эхэлнэ (Дуламцэрэн, 1970; 1995).

Ороо нийллэг хавар 3-р сараас 4-р сард болно. Хээл тээх хугацаа дунджаар 69 хоног. Эм шилүүс 2-3 ногоул төрүүлнэ. Хоёр настай бэлэг боловсорно. Тэдний үүр модны үндэс орчмын хөндий, унанги модны доор, хад чулууны анга, завсар байрлана. Байгальд 17-24 жил хүртэл насалдаг (Дуламцэрэн, 1970; 1995; Батсайхан нар, 2010) байна.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Олон улсын хэмжээнд шилүүсний арьсыг худалдаалдаг тул хараа хяналтгүй, хууль бусаар агнасаар байна. Монгол оронд 1958-1960 онд хамгийн их буюу жилд 350 шилүүс агнаж байжээ (Stubbe, 1965). Мөн шилүүсний гол идэш бологч янгир ямаа (*Capra sibirica*), монгол тарвага (*Marmota sibirica*) цөөрч, гэрийн нохойн дайралтад өртөж, түүний тархац нутгийн зарим хэсэгт байгалийн баялгийн олборлолт явагдаж, ялангуяа ой модыг хавтгайруулан огтолсны улмаас орчны хомсдол, доройтолд орох боломжтой байна (Clark et al., 2006).

Нутгийн иргэд хавх, буугаар шилүүсийг олонтаа агнадаг. Ялангуяа гэрийн мал, ямаа идсэн бол мөр хөөж заавал агнахыг хичээнэ. Монгол Алтайн нурууны өвөр бэл Баянбулаг хавийн 600 км² талбайд 10-р сар хүртэл 9 шилүүс агнаж байжээ. Гантай жил зээр, гөрөөс, ногтруу алс нүүдэллэж, туулай ховордоход идэш эрж, арзгар хад чулуу,

хайргат говиор тэнэсэн шилүүсний тавхайн ул хагарч урагдан, цус алдаж, үхэж хорогддог тохиолдол бий (Дуламцэрэн, 1995). Устаж болзошгүй зүйл юм.

ХУДАЛДАА

CITES-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10 жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Монгол улс 2007, 2010 онд судалгаа шинжилгээний зориулалтаар шилүүс мийн гавлын яс, арьс зэрэг эд эрхтнийг АНУ, Япон руу экспортолжээ. Монгол улсын хэмжээнд бүртгэгдсэн (2011-2014 он) Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн гэмт хэргийн мэдээгээр, шилүүс мийн талаар нийтдээ 8 гэмт хэрэг тэмдэглэгдсэн (Мягмарсүрэн нар, 2014) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад Говийн шилүүс (*Lynx lynx isabellina*)-ийг оруулж, Монгол улсын Улаан ном (2016)-нд бүртгэсэн. Шилүүс мийн тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна. Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэгдсэн (<http://checklist.cites.org>) байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Шилүүс мийн (*Lynx lynx*) эр нь 2300.0 мян.төг, эм нь 2600.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд шилүүс мий нь 460.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ЦООХОНДОЙ МИЙ (ЦООХОНДОЙ)

Felis silvestris Schreber, 1777

Баг: Махчтан (*Carnivora*)

Овог: Мийнхэн (*Felidae*)

НЭРШИЛ:

Англи: Wild Cat

Орос: Пустынная кошка

Хятад: Ye Mao (Саоууан Ван Мао)

Герман: Wildkatze (Lybische Wildkatze)

Франц: Chat sauvage

Казах: Сарбалақ, шағыл мысығы



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Felis ferus, *Felis kozlovi*, *Felis libyca* (Wilson and Reeder, 1993), Евроази, Африкийн популяциудын ангилал зүй, мөн *Felis libyca* болон *Felis silvestris* зүйлүүдийн ангилал зүй, удам төрлийн холбоо тодорхойгүй хэвээр байна (Clark *et al.*, 2006). *Felis libyca* (Forster, 1780), *Felis ornata* (Gray, 1830) (<http://checklist.cites.org>).



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Мэдээлэл дутмаг” зүйл (Clark *et al.*, 2006) хэмээн үнэлсэн.



ТАНИХ ШИНЖ

Цоохондой мий бие галбир, хэмжээгээр мануултай тун төсөөтэй зэрлэг муур. Нүүрний үс богино. Мөч

намхан, бахим. Биеийн урт 40-70 см, сүүлний урт 24-35 см, чихний өндөр 4-6 см. Биеийн жин 2.5-4.0 кг (Гептнер нар, 1972; Батсайхан нар, 2010). Зоо нурууны дагуу өргөн бараан хүрвэтэр, боровтор судалтай. Биеийн хажуугийн цайвар бор, хөхөвтөр саарал дэвсгэр өнгөн дээр хөндлөн эгнэсэн бараан, бор, хүрвэтэр толбонуудтай. Хэвэл, мөчдийн дотор тал цайвар. Сүүлний үзүүр хар, түүнээс дээш 4-5 гархи маягийн хар бараан хөндлөн судалтай. Чихний үзүүрт 3 см шахам урт, бийр шиг цацаг үс бий (Гептнер нар, 1972; Банников, 1954; Дуламцэрэн, 1970). Толгойн ясны кондилобазаль урт 82-93 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; түрүү араа 3/2, агт араа 1/1=30 (Батсайхан нар, 2010).




ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Цоохондой мий бүх Европ, Төв Ази, Африкаар тархсан (Nowak, 1991). Тухайлбал, Азийн Афганистан, Хятад, Ирак, Иран, Изриаль, Иордан, Кувейт, Ливан, Монгол, ОХУ, Оман, Пакистан,



Саудын Араб, Сири, Йемен, Энэтхэгт, Африкийн Хойд хэсгийн Сахарын цөл, Баруун өмнө хэсгийн зарим халуун орны ойт нутгаас бусад ихэнх нутагт, Европийн Албани, Австри, Бельги, Болгар, Герман, Грек, Унгар, Итали, Чех, Словак, Франц, Люксембург, Польш, Португаль, Румын, Испани, ОХУ, Югослав (CITES-ийн лавлах, 2001) зэрэг 90 гаруй улс оронд тархсан (<http://checklist.cites.org>) байна.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол Алтайн нурууны Шаргын говь, Умард говь, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Өмнөговь зэрэг цөл, цөлөрхөг тал хээрийг хамарсан өргөн уудам нутагт алаг цоог тархсан (Банников, 1954). Мөн Их Нууруудын хотгор, Нууруудын хөндий, Дорнод говь, Алашань говиор тархсан (Дуламцэрэн нар, 1989) байна. Монгол орны цөл, цөлөрхөг хээрийн бүс нь цоохондой мийн дэлхийн тархацын зүүн хойд хил болно. Хааяагүй ховор тохиолдоно.

АМЬДРАХ ОРЧИН

Хармаг, заг, сухай бүхий элсэн довцог, баянбүрд, булаг шанд, шал тойрмын захын заг, сухай, харгана, дэрс бүхий довцог элс, манхан, хадархаг дов толгод, уулын бэлийн сайрт амьдарна (Дуламцэрэн, 1970). Түүнчлэн цөлийн баянбүрд, сухайн сондуулт бөөрөг, загт хотос, хад чулуут бэсрэг уулс, аараг толгод, сөөгт чулуут цөл, хайлааст сайр зэрэг говь, цөлийн гандуу нутагт тохиолдоно (Батсайхан нар, 2010).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Цоохондой мий гол төлөв бүрэнхий, шөнийн идэвхтэй. Ганц нэгээр тохиолддог, нуугдмал амьдралтай. Үнэгний хуучин нүх, хад чулууны хонгил, ангал, жижиг агуй, тоорой, хайлаасны хонгилд үүрлэнэ. Ороо нийллэг хавар 1-р сараас 2-р сард болно. Хээл тээх хугацаа дунджаар 60-62 хоног. Эм цоохондой 3-6 зулзага төрүүлнэ. Хоёр настай бэлэг боловсорно. Цоохондой чичүүл, алагдаахай, шишүүхэй, зусаг зэрэг жижиг хөхтөн амьтны зэрэгцээ гүрвэл, хахилаг шувуу, элдэв шавжаар хооллоно (Батсайхан нар, 2010). Захуйн говьд цоохондой мийн өвлийн идэш тэжээлийн 92 хүртэл хувийг ногтруу (*Syrrhaptes paradoxus*), тагтаа (*Columbia livia*), согсоот болжмор (*Galerida cristata*), шоорон алаг болжмор (*Eremophilla alpestris*), оронгийн боршувуу (*Passer domesticus*), хээрийн боршувуу (*Passer montanus*) зэрэг шувуу, шар чичүүл бүрдүүлж байжээ (Дуламцэрэн, 1970; Мөнхцог нар, 2002).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Монгол оронд бага судлагдсан. Шар үнэг, хярс үнэг, шилүүс мий зэрэг амьтдад тавьсан хавханд орж агнуулна (Дуламцэрэн нар, 1995). Зөвхөн Захуйн говьд 1995-1997 онд 4-5 цоохондой анчдын хавханд орж үхсэн (Мижиддорж, 1997) байна. Захуй, Зарман, Эхийн гол зэрэг хүн ам суурьшсан баянбүрдүүдийн орчмоор гэрийн мууртай эрлийзжих болсон нь удмын санг алдагдуулж болзошгүй (Мөнхцог нар, 2002). Цөл, хээрт идэш тэжээл ховор үед саарал чоно, бүргэд, хааяа нохойд бариулна. Нутгийн хүмүүс тохиолдлоор агнана.

ХУДАЛДАА

Монгол улсын хэмжээнд тодорхой мэдээлэл

байхгүй. CITES-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10 жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Олон улсын хэмжээнд цоохондой мийн арьс, яс, эд эрхтэнг болон амьдаар нь худалдаалсан тухай мэдээлэл нэлээд байдаг.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол улс 1996 оноос агнахыг хуулиар хориглож, Монгол улсын Улаан ном (2016)-нд оруулсан. Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). Цоохондой мийн тархац нутгийн 19% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байгаа бөгөөд түүний тархац нутгийн нэлээд хэсгийг Говийн Их болон Бага Дархан цаазат газруудад хамруулан хамгаалсан байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Цоохондой мийн эр нь 850.0 мян.төг, эм нь 950.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд цоохондой мий нь 170.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



МАНУУЛ МИЙ (МАНУУЛ)

Felis manul Pallas, 1776

Баг: Махчтан (*Carnivora*)

Овог: Мийнхэн (*Felidae*)

НЭРШИЛ:

Англи: Pallas's Cat

Герман: Manul (Pallaskatze)

Орос: Манул

Франц: Chat de Pallas

Хятад: Tu Sun

Казах: Сабаншы



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Otocolobus ferrugineus, *Otocolobus mongolicus*, *Otocolobus nigripetctus*, *Otocolobus satuni* (Wilson and Reeder, 1993), *Otocolobus manul* (Pallas, 1776) (<http://checklist.cites.org>).



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд "Ховордож болзошгүй" зүйл (Clark *et al.*, 2006) хэмээн үнэлсэн.



ТАНИХ ШИНЖ

Биеийн төрх, хэмжээний хувьд гэрийн мууртай ойролцоо, жижиг биетэй зэрлэг муур. Мөч богино, бахим. Биеийн урт 50-72 см, сүүлний урт 21-31

см, чихний өндөр 4-5 см. Биеийн жин 2.2-5.0 кг хүрнэ. Зун бараавтар хөх-шаргал, өвөл цайвар хөх-шаргал зүстэй. Өтгөн урт, зөөлөн үстэй, үсны үзүүр мөнгөлөг цагаан тул буурал харагдана. Дух цайвар хөх, жижиг хар толбуудтай. Эрүү, цээж, хэвлий цагаан. Сүүл богино, хар бараан гархи маягийн хөндлөн судалтай, үзүүр нь хар. Нуруундаа хөндлөн хар судлуудтай (Мөнхцог нар, 2005а). Толгойн ясны кондилобазаль урт 72-87 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; түрүү араа 2/2, агт араа 1/1=28 (Батсайхан нар, 2010).



ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Мануул мий ОХУ, Армэн, Иран, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Киргизстан, Монгол зэрэг улс орнуудад тархсан байна.



ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол орны тайгын бүсээс бусад нутагт тархсан бөгөөд таг, цөлийн бүсээр ховор тааралдана (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов нар, 1980).



АМЬДРАХ ОРЧИН

Мануул мий ойт хээр, бүх хэв шинжийн хээр, хад чулуут бэсрэг уулс, өндөр уулархаг нутаг, говь, цөлийн хадат уулсыг шүтэн амьдарна. Хуурай, гандуу, задгай нутагт байршилтай (Батсайхан нар, 2010).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Мануул мий өвлийн улиралд үүрийн бүрэнхийгээс бага үд хүртэл, дулааны улиралд шөнийн хоёроос арван цаг, орой зургаагаас арван цаг хүртэл хамгийн их идэвхтэй байх бөгөөд өдрийн цагаар ч тохиолдоно (Мөнхцог нар, 2005б). Ганц нэгээр тохиолддог, нуугдмал амьдралтай. Монгол орны хээрийн бүсийн мануул мийн идэш тэжээлийн 81.3%-ийг жижиг хөхтөн амьтад, 3.7%-ийг жижиг шувууд, 7.2%-ийг ургамал бүрдүүлнэ. Түүний өвлийн идэш тэжээлд дагуур огдой (65.5%) зонхилж, цайвар үлийч (15.4%), хул чичүүл (11.5%) оролцоно. Харин дулааны улиралд дагуур огдой (39.1%), хул чичүүл (9.2%), цайвар үлийч (4.8%), хадны барагчин (4.5%) зэргээр хооллохоос гадна, шавж (17.4%) иднэ (Мөнхцог нар, 2005в). Тарваганы эзэнгүй орхисон нүх, хад чулууны хонгил, ангал, жижиг агуй зэрэгт үүрлэнэ.

Гуужилт 3-р сарын сүүлчээр эхэлж, 6-р сарын эхээр дуусна. Ороо хөөцөлдөөн 2-р сарын сүүлээр болж 3-р сарын эхээр нийллэгэнд орно. Мигүү (эм мануул) хээлээ 60 гаруй хоног тээх бөгөөд 2–6

ногоолой төрүүлнэ (Пүрэвсүрэн нар, 2013а). Хоёр настай бэлэг боловсорно. Байгальд 10 хүртэл жил насална (Батсайхан нар, 2010).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Баянхонгор, Архангай, Завхан, Говь–Алтай аймгийн нутагт мануул мий элбэг ба дунджаар 1000 га эдэлбэр нутагт 1–2, Дархадын хотгорт дээд хэмжээ нь 1000 га эдэлбэр нутагт 4-6, хамгийн бага хэмжээ нь 0.4–1.2 толгой ногдож байхад Дорнод Монголын талд 1000 га–д 0.8–1, Алтайн цаадах говь, Зүүнгарын говь, Өмнийн говиудад ховор тохиолддог бөгөөд Төв, Дундговь, Сүхбаатар аймгийн тал хээрийн сумдад 2000–3000 га-д 1-2 бодгаль ногдоно (Сүхбат, Шагдарсүрэн, 1990). 2000, 2001 онд Төв аймгийн 10 км² нутаг дэвсгэрт дунджаар 0.6 мануул ногдох нягтшилтай байв (Пүрэвсүрэн нар, 2013б).

Олон улсын хэмжээнд арьсыг нь худалдаалдаг тул хяналтгүй агнуурын улмаас тус зүйлийн тоо толгой буурсаар байна. Монгол улсын 1927-1980 оны хоорондох мануул мийн арьс бэлтгэлийн мэдээнээс үзвэл, 1928 онд 8400 ширхэг, 1958-1966 онд жил бүр 5300-8432 ширхэг буюу хамгийн олон арьс бэлтгэж байсан бол 1933-1953 онд жил бүр 450-1000 ширхэг буюу хамгийн цөөхөн арьс бэлтгэж байжээ. 1969 онд 6000 гаруй арьс бэлтгэж, түүнээс хойш мануулын арьс бэлтгэл тогтмол багассан байгаа нь түүний тоо толгой цөөрсөнтэй холбоотой байж болох юм (Пүрэвсүрэн нар, 2013б).

Гэрийн нохой, бүргэд, махчин шувууд түүний гол дайсан амьтад юм. Монгол орны хээрийн бүсээр түгээмэл тархсан шар үнэг, хярс үнэг нь мануул мийн идэш тэжээл болоод орон байрны гол өрсөлдөгчид болно. Уур амьсгалын хүчин зүйлсээс нэлэнхүй, зузаан цасан бүрхүүл нь богино мөчтэй, удаан хөдөлгөөнтэй мануул мийг турааж доройтуулахаас гадна, түүний нуугдаж биеэ хамгаалах боломжийг хязгаарлаж, махчин шувуудын довтолгоонд ихээр өртөх нөхцлийг бий болгож мануул мийн амьдралд хүчтэй сөрөг нөлөө үзүүлдэг (Пүрэвсүрэн нар, 2013в). Дорнод

Монгол болон Монгол Дагуурын хээрт 2001, 2002, 2003 онд үлийн цагаан оготны (*Lasiopodomys brandti*) тоо толгойг зохицуулахад хэрэглэсэн Бромадиолоне химийн хорт бодисонд дам өртөж хорогдох нь бий (Н. Батсайхан, аман мэдээ).

ХУДАЛДАА

CITES-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10 жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Монгол улс судалгаа шинжилгээний зориулалтаар мануул мийн 200 гаруй сорьц дээжийг АНУ, Япон руу экспортолжээ. ХХЕГ болон ГЕГ-аас авсан хууль бусаар хил нэвтрүүлэхийг завдсан амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийн судалгаагаар (2002-2014 он), мануул мийн 11 арьс, эд эрхтэн хураагдсан (Мягмарсүрэн нар, 2014) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). Мануул мийн тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Мануул мийн эр нь 440.0 мян.төг, эм нь 500.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд мануул мий нь 88.0 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



СААРАЛ ЧОНО (ЧОНО)

Canis lupus Linnaeus, 1758

Баг: Махчтан (*Carnivora*)

Овог: Чонынхон (*Canidae*)

НЭРШИЛ:

Англи: Grey Wolf

Орос: Волк, Серый волк

Хятад: Lang, Lobo comun

Герман: Wolf, Schwarzer wolf

Франц: Loup, Loup gris

Казах: Қасқыр

ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Canis rufus (Audubon & Bachman, 1851), *Canis niger* (Bartram, 1791), *Canis lycaon* (Schreber, 1775), *Canis familiaris* (Linnaeus, 1758), *Canis himalayensis* (Aggarwal, Kivisild, Ramadevi & Singh, 2007), *Canis indica* (Aggarwal, Kivisild, Ramadevi & Singh, 2007), *Canis lupus dingo* (Linnaeus, 1758) (<http://checklist.cites.org>).

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Ховордож болзошгүй” зүйл (Clark *et al.*, 2006) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Толгой зантгар, хоншоор өргөн мохоодуу. Чих соотон, үзүүр нь шовх. Хөлний уланд 5 саарин товхтой. Урьд хөлийн дунд хоёр хурууны саарин товх нийлээгүй тусдаа. Нүд шар. Сүүл сагсардуу

богино, борвиноосоо доош өнгөрөхгүй. Хумс бараан. Хялгасан үс урт, ширүүн. Ноолуур бүдүүвтэр өтгөн бүдэг цайвар өнгөтэй (CITES-ийн лавлах, 2001). Монгол орны саарал чоно үл мэдэг шаргал туяа бүхий цайвар-саарал зүстэй. Нурууны голыг дагасан хар бараавтар сор үстэй. Бадриун зэгзгэр мөчтэй. Биеийн урт 105-160 см, сэрвээний өндөр 80-100 см, сүүлний урт 35-50 см, биеийн жин 20-80 кг. Бие гүйцсэн чонын толгойн ясны ерөнхий урт нь 32-50 см, шүд нь нилээд том, хүчирхэг ялангуяа соёо сайн хөгжсөн. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; бага араа 2/3; их араа 2/3=42 (Батсайхан нар, 2010).

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Саарал чоно Ази тивд Афганистан, Балба, Бангладеш, БНСУ, БНАСАУ, Хятад, Казахстан, Кувейт, Ливан, Йемен, Монгол, Оман, ОХУ, Пакистан, Саудын Араб, Сири, Туркменистанд, Европт тивд Албани, Болгар, Грек, Гренланд, Испани, Итали, Норвег, ОХУ, Польш, Португаль,



Румын, Турк, Унгар, Финлянд, Чех, Словак, Швед, Югославд, Умард Америкт АНУ, Аляск, Канад, Мексикт тус тус тархсан (CITES-ийн лавлах, 2001) байна.

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол орны бүх нутагт хааяагүй тархсан боловч халиун буга (*Cervus elaphus*), бор гөрөөс (*Capreolus pygargus*) нутагладаг Хэнтий, Хөвсгөлийн зэлүүд ой тайга, цагаан зээр (*Procapra gutturosa*) элбэгтэй Дорнод тал хээр, аргаль хонь (*Ovis ammon*), янгир ямаа (*Capra sibirica*)-ны бэлчээр бүхий уулархаг нутагт илүү элбэг тархсан (Шагдарсүрэн, 1966; Дуламцэрэн, 1970). Хүн ам нягт суурьшсан газрын орчим тохиолдоггүй.



АМЬДРАХ ОРЧИН

Саарал чоно туурайтан, малын бэлчээрийг дагаж улирлаар байршлаа сэлгэнэ. Гэвч ихэвчлэн хүний нөлөөнөөс зайдуу бартаа хоргодоц сайтай хад асга бүхий өндөр уул, гүн ой тайгад байршин амьдарна. Ялангуяа бэлтрэглэх үедээ хүнээс алс зайдуу, усанд ойр, харууцтай газрыг сонгодог онцлогтой (Батсайхан нар, 2010).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Ороо нийллэг өвөл ид хүйтнээр эхэлж, орооны үед нэг гичий чоныг хэд хэдэн азарган чоно дагана. Гичий чоно хээлээ 62-65 хоног тээгээд 5, 6-р сард тусгайлан зассан нүх буюу хадны хонгил, агуйд дунджаар 6-8 бэлтрэг төрүүлнэ. Бэлтрэг 9-13 хоногийн дараа нүдээ нээнэ. Гичий чоно 4-6 долоо хоног хөхүүл байх бөгөөд үүний дараа бэлтрэгээ бор хоолонд дасгаж эхэлнэ. Гэрийн мал, зэрлэг туурайтан, мэрэгчид, туулайтан, жижиг шувууд тэдгээрийн өндөг, ангаахай, дэгдээхэй, амьтны сэг зэм, ургамлын үр жимс зэргээр хооллоно. Ихэвчлэн үүрийн харанхуйгаар гөрөөлнө. Саарал чоно байгалийн нөхцөлд 15-16 хүртэл жил насална (Батсайхан нар, 2010).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Саарал чонын арьсыг худалдаалах, эд эрхтэнг (хэл, хэвлийн эрхтэн, шагай, шүд зэрэг) ардын уламжлалт эмнэлэгт ашиглах зорилгоор ихээхэн агнадаг бөгөөд мөн спорт агнуураар агнаж байгаа нь түүний тоо толгойг ховордуулах гол шалтгаан болно. Мөн гэрийн мал руу байнга довтолж идшээ болгодог учраас малын дайсан гэж үздэг. Монголын 949 анчдаас авсан судалгаагаар 40 гаруй хувь (321) нь чоно агнадаг (Wingard, Zahler, 2006) гэжээ. Хамгийн ихээр 1933 онд 18,000 ширхэг чоно агнаж, 1942-1960 онд бэлтгэсэн чонын арьсны тоо жилд дунджаар 5,827 ширхэг болж байжээ (Stubbe, 1965). Энэ байдал харьцангуй тогтвортойгоор үргэлжилж 2003 онд Монголын зах зээлд 4,900 чонын арьс зарагдсан байна. Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн 2004 оны судалгаагаар 20,000-30,000 чоно агнаснаас үзвэл, хараа хяналтгүй агналт нэн өндөр түвшинд хүрчээ (Wingard, Zahler, 2006). Хамуу, шүдний парвовирус, нүд сохрох, галзуу зэрэг өвчинд өртөмтгий (Mech, Boitani, 2004).

ХУДАЛДАА

CITES-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10 жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Монгол улс олзворын ангийн зориулалтаар 100 гаруй саарал чоныг агнуулж, түүний арьс, гавлын яс зэрэг эд эрхтнийг гадаадад гаргажээ. Харин 2009 онд хоёр саарал чоныг амьдаар нь экспортолсон байна. ХХЕГ болон ГЕГ-аас авсан хууль бусаар хил нэвтрүүлэхийг завдсан амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийн судалгаагаар (2002-2014 он), саарал чонын 929 арьс, соёо, ходоод, хэл зэрэг

эд эрхтэн, түүгээр зогсохгүй бүхлээр нь хөлдөөсөн байдалтайгаар хураасан байна (Мягмарсүрэн нар, 2014).

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэлтэй (<http://checklist.cites.org>). Манай оронд түгээмэл тархсан зүйл. 2007-2009 онд тал хээрийн бүс буюу зүүн бүсийн аймаг, сумдын зарим нутагт агнахыг хориглосон. Саарал чонын тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр саарал чоно (*Canis lupus*)-ны эр нь 510.0 мян.төг, эм нь 600.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр ахуйн болон соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд саарал чоно нь 102.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ШАРНАД ЦӨӨВӨР (ЦӨӨВӨР ЧОНО)

Cuon alpinus Pallas, 1811

Баг: Махчтан (*Carnivora*)

Овог: Чонынхон (*Canidae*)

НЭРШИЛ:

Англи: Asiatic Wild Dog (Red Wild Dog)

Орос: Красный волк

Хятад: Chai lang

Герман: Rothund (Asiatischer Wildhund)

Франц: Dhole, Chien sauvage d'Asie, Cuon d'Asie

Казах: Қызыл қасқыр



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Cuon clamitans, *Cuon grayiformes*, *Cuon rutilans* (Wilson and Reeder (1993)).



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Устаж болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Устсан” зүйл (Clark *et al.*, 2006) хэмээн үнэлсэн.



ТАНИХ ШИНЖ

Зүс тод улаан зээрд. Хэвэл, суга, цавь, чихний дотор тал цайвар. Шарнад цөөврийн сүүл саарал чоныхоос урт сагсар, үнэгнийхээс арай богино, жигд улаан буурал. Завж, багалзуурын үс урт. Биеийн урт 110 см, сүүлний урт 50 см орчим. Саарал чононоос жижиг, үнэгнээс том биетэй.



ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Шарнад цөөвөр Бангладеш, Бутан, Камбож, Хятад, БНСУ, БНАСАУ, Энэтхэг, Индонез, Казахстан, Киргизстан, Лаос, Малайз, Монгол, Мьянмар, Непаль, Пакистан, ОХУ, Шриланк, Тажикстан, Узбекистан, Вьетнамд тус тус тархсан (<http://checklist.cites.org>) байна.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ


Шарнад цөөврийн дэлхийн тархацын хойд захад Монгол орон хамаарна. Өнгөрсөн зуунд Хэнтий, Хөвсгөл орчмын уулс, Хангайн нуруу, Монгол Алтай, Алтайн өвөр говь, Өмнөговийн уулсаар ховор биш тохиолддог байжээ (Банников, 1954; Дуламцэрэн, 1972). 1930 онд Өмнөговийн Ноён, Сэврээ, Нэмэгт ууланд агнасан, дөчөөд онд Цагаан богд, Эдрэнгийн нуруу, Суман хаданд үзсэн мэдээ бий (Дуламцэрэн, 1992). 1950 онд Монгол Алтайн нуруунд устаж, Хөвсгөл орчимд



ГУРАВДУГААР БҮЛЭГ

үгүй болж, Өмнөговь, Алтайн өвөр говь, Говь-Алтайн зарим уулсаар ховорхон үзэгдэх болжээ (Банников, 1954; Цэвэгмэд, 1963). 1967 онд Сэгс Цагаан Богд ууланд хэд хэдэн удаа үзэгдэж, 1968 онд Өмнөговийн Алтан ууланд хавханд орсныг тухайн үед нутгийнхан мэдээлж байв (Дуламцэрэн, 1972). 1969 онд Өмнөговийн Зөөлөн ууланд шарнад цөөвөр хавханд орсон тохиолдол бол Монголын говьд байсны хамгийн сүүлчийн бодит баримт болой (Дуламцэрэн, 1972; 1992). 1991 оны өвөл Тува, Монголын хил орчимд шарнад цөөврийг харсан хоёр тохиолдол бий. 1988 онд Монгол улсын хил залгаа Тес-Хемийн районд 4 шарнад цөөвөр хоёр хонь барьж, Цагаан толгойн заставын офицер Гаврилов шарнад цөөвөр харсан тухай баримтууд бүртгэгдсэн (Савельев, Шурыгин, 1997) байдаг. Мөн 1995-1996 онд Байгалийн чанадын өмнөд бүс нутгаас 4 шарнад цөөврийн арьс бэлтгэсэн мэдээ бий (Пузанский, 1997). Мөн Хөвсгөл аймгийн Улаан уул сумын иргэн н. Батмөнх улаан, улбар шар зүсмийн чоно Бүсийн голын савд 2000-2005 онуудад хэд хэдэн удаа харжээ (Батмөнхийн аман мэдээ). Дээрх баримтуудаас үндэслэн Алтайн өвөр говьд Аж Богдын нуруунаас Тост уул хүртэл, ялангуяа, Цагаан Богд орчим, Өмнөговь, Хөвсгөлийн

уулсаар тохиолдож магадгүй (Дуламцэрэн, 1972; 1992) хэмээн үздэг.



АМЬДРАХ ОРЧИН

Аргаль хонь, янгир ямаа, туулай элбэгтэй говийн хад, цохиот уулс, бор гөрөөс, баданга хүдэр, халиун буга нутагладаг Хөвсгөлийн тайгын ян сарьдагаар амьдардаг байжээ (Гептнер нар, 1967).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Шарнад цөөвөр бөөн, сүргээр явж, идэш бологч амьтнаа хоморголон барьж иднэ (Гептнер нар, 1967). Гөрөөсний сэг зэм дээр ирнэ. Өнгөрсөн

зуунд малд байнга довтолдог байсныг нутгийнхан ярьдаг (Дуламцэрэн, 1992). Өмнөговийн Ноён ууланд агуйд үүрлэж, хоёр бэлтрэг гаргасныг нутгийн анчин олсон мэдээ бий (Банников, 1954). 1-р сараас 2-р сард отолж, 4-р сард бэлтрэглэж байсан тухай баримт байдаг (Гептнер нар, 1967).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Шарнад цөөврийн тоо толгойн талаар тодорхой мэдээ баримт байхгүй байна. Нутгийн иргэд шарнад цөөврөөс малаа хамгаалахын тулд агнаж, түүний идэш бологч амьтад ховордон цөөрч, саарал чоно, цоохор ирвэс элбэгшсэнээр шарнад цөөврийг идэш тэжээл, амьдрах орчны хувьд шахан зайлуулсан байх магадлалтай. Дэлхийн хэмжээнд ховордсон, устаж байгаа зүйл.

ХУДАЛДАА

Монгол улсын хэмжээнд тодорхой мэдээлэл байхгүй. CITES-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10 жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Олон улсын хэмжээнд шарнад цөөврийн 43 бодгалийг амьдаар нь худалдаалсан тухай мэдээлэл байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол улс 1973 оноос агнахыг хуулиар хориглож (БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975), улмаар Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд, Монгол улсын болон Олон улсын Улаан номонд тус тус оруулсан (Шийрэвдамба нар, 2016). Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). Шарнад цөөврийн урьд тархаж байсан нэлээд нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ХҮРЭН БААВГАЙ

Ursus arctos Linnaeus, 1758

Баг: Махчтан (*Carnivora*)

Овог: Баавгайнхан (*Ursidae*)

НЭРШИЛ:

Англи: Brown Bear

Орос: Бурый медведь, Обыкновенный медведь

Хятад: Zong Xiong

Герман: Braunbär

Франц: Ours brun

Казах: Қоңыр аю



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Ursus baikalensis, *Ursus collaris*, *Ursus dalli* (Wilson and Reeder, 1993).



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Мэдээлэл дутмаг” зүйл (Clark *et al.*, 2006) хэмээн үнэлсэн.



ТАНИХ ШИНЖ

Бие үлэмж, лагс. Мөч бахим, тавхай үстэй, таван хуруу нь хүчирхэг бор хумстай. Толгой данхар, хоншоор богино. Хүзүү богино, бүдүүн. Чихний дэлбэ богино, дугираг. Хумс том, махир, хурц, сүүл ахар, үснээс бараг үл нухуйна. Зүс бараан хүрэн, цайвар хүрэн, хар хүрэн, бор хул ч тохиолдоно.

Зарим баавгай цагаан цээжтэй байх нь бий. Биеийн урт 180-240 см, сэрвээний өндөр 90-150 см, хойд тавхайн урт 13-30 см, сүүлний урт 6-21 см, биеийн жин 150-300 кг хүрнэ. Толгойн ясны кондилобазаль урт: 258-378 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1: бага араа 4/4; их араа 2/3 =42 (Банников, 1954; Батсайхан нар, 2010).



ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Хүрэн баавгай Канад, АНУ, Испани, Франц, Норвеги, Итали, Австри, Чех, Словен, Хорват, Швед, Польш, Босни Герцеговин, Серб, Монтенегро, Словак, Албани, Финланд, Грек, Румын, Македон, Латви, Эстони, Украин, Болгар, Беларусь, Турк, ОХУ, Сири, Ирак, Гүрж, Иран, Азербайжан, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Киргизстан, Монгол, БНАСАУ, Япон зэрэг улс орнуудад тархсан (CITES-ийн лавлах, 2001; Clark *et al.*, 2006) байна.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хүрэн баавгайн 4 тусгаар популяци Монгол оронд тархсан байх бөгөөд Хөвсгөл, Хэнтийн нурууны зүүн бие, Монгол Дагуурын хээрийн Улз, Онон гол, Монгол Алтайн нурууны баруун хойд хэсэг, Их Хянганы салбар уулс зэрэг тайга, ойт уулсаар амьдардаг (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980). Хүрэн баавгай өөрсдийн үндсэн тархац нутгаас 130-200 км хол зайтай Дорнод Монголын уулын хээр, голын хөндийд хааяа нэг тохиолддог (Банников, 1954) байна.



АМЬДРАХ ОРЧИН

Хүрэн баавгайн үндсэн амьдрах орчин нь унанги мод, намаг балчиг, ойн цоорхой бүхий аглаг

бөглүү, шигүү ой юм. Хавар, зуны улиралд өндөр өвс, буттай, задгай ус, ойн цоорхой бүхий голын хөндий, уулархаг газарт байршина. Монгол Алтайд жижиг бут сөөгөн шугуйтай хадархаг газарт тохиолдоно (Банников, 1954). Хөвч тайга, хуш-шинэсэн ой, холимог ойд идээшин амьдрах бөгөөд ичээгээ бүдүүн унанги, дархины хонгил, эсвэл хадны уужим хүнгэд сонгож, хуурай хагд өвс, хөвд, мөчир зулж дэвсэн засдаг (Батсайхан нар, 2010).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Хоногийн турш идэвхтэй. Бамбарууштай эвшээс бусад нь ганц нэгээр амьдарна. Ороо нийллэг 6-р сараас 7-р сард болно. Эвш хээлээ 180-220 орчим хоног тээж, 1 ичээндээ голдуу ихэр, хааяа 4 хүртэл бамбарууш төрүүлнэ. Бамбарууш төрөх үедээ 350-500 гр жинтэй, нүдээ нээгээгүй, нүцгэн байдаг. Нэг эсвэл 2-3 жил өнжиж төллөнө. Хүрэн баавгай 5 нас хүрч үржилд орно. Намар орой 10-р сарын сүүлч 11-р сард ичээнд орж, хавар 3-р сараас 5-р сард ичээнээс гарна. Байгалийн нөхцөлд 20-30 жил, тэжээвэр нөхцөлд 40 хүртэл насална. Хойд мөч дээрээ босоо зогсож ойр орчноо харуулдана (Батсайхан нар, 2010).

Байгаль, цаг уур, тухайн орчны амьтан, ургамлын аймгийн онцлогоос хамааран баавгайн идэш тэжээлийн бүрэлдэхүүн олон янз байна. Идэш тэжээл хомс хаврын эхэн үед улиангарын үр, модны нахиа, ургамлын үндэс, хуучин самар, шоргоолж зэргээр, харин зуны эхэн үеэр тэд голчлон жимс жимсгэнэ, ногоон ургамал, шавж, загас, заримдаа сэг зэмээр хооллоно. Идэш тэжээл дутагдалтай үед хандгай, зэрлэг гахай, бор гөрөөс, халиун буга, баданга хүдэр барина. Зуны сүүл, намрын эхэн үед гол төлөв ургамлаар хооллох бөгөөд янз бүрийн үр жимс, самар, ургамлын үндэс иднэ. Монгол Алтайд хүрэн баавгай огдой, тарвага бусад мэрэгчдээр хооллоно (Банников, 1954; Болд, 1967).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

CITES-ийн мэдээнд дурдсанаар (CITES-ийн лавлах, 2001), Канадад 25000, Аляскт 12000, АНУ-д 700-1000, Японд 3000-4000, Туркт 1000, ОХУ-д 70000, Болгарт 520, Чехэд 300, Финляндад 400, Францад 20, Италид 85-115, Норвегт 50, Польшид 30, Испанид 70, Шведэд 400-600, Югославт 700 бодгаль баавгай байгальд амьдарч байгаа бөгөөд Умард Америкт 117 бодгалийг гаршуулан өсгөж, Европын зарим орны амьтны хүрээлэнгүүдэд цөөнгүй тооны бодгалийг үржүүлж байгаа ажээ.

ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн судалгаагаар (1986), Монгол орны 50,000 км² нутаг дэвсгэрт ойролцоогоор 500 орчим бодгаль хүрэн баавгай бий гэж тооцоолжээ. Монголын ихэнх ойт бүс нутгийг хамарсан их хуурайшилт, гантай байсан 1988 оны үед Төв, Хэнтий, Сэлэнгэ аймгийн нутагт өлсгөлөн хорхойтсон баавгайтай учирсан 103 тохиолдол бүртгэгдэж, хот сууринд орж ирсэн хоёр тохиолдлын нэг нь нийслэл Улаанбаатар хот болж, хорхойтсон 47 бодгаль баавгайг орон нутгийн хүмүүс агнасан бөгөөд бүгд маш туранхай, зарим нь дотор өөхгүй байсан (Дуламцэрэн, Ганбат, 2000) ажээ.

Хүний сөрөг нөлөөллөөс улбаатай амьдрах орчны өөрчлөлт нь хүрэн баавгайг ховордуулах гол шалтгаан болж байна. Олон улсын хэмжээнд ардын уламжлалт эмнэлэгт баавгайн ихэнх эд эрхтнийг хэрэглэж байгаагийн улмаас түүнийг хараа хяналтгүй, хууль бусаар агнадаг. Сүүлийн жилүүдэд Монгол оронд баавгайн доньд, сарвууг худалдаалж ашиг олох зорилгоор хараа хяналтгүй, хууль бусаар голдуу агнах болсон (Wingard, Zahler,

2006) байна. Цаатнууд баавгайн мах, арьсыг ашиглах зорилгоор агнадаг, устаж болзошгүй зүйл (Шийрэвдамба нар, 2016) юм.

ХУДАЛДАА

CITES-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10 жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Монгол улс судалгаа шинжилгээний зориулалтаар хүрэн баавгайны 2000 гаруй үс, сорьц дээжийг АНУ, Канад руу экспортолжээ. ХХЕГ болон ГЕГ-аас авсан хууль бусаар хил нэвтрүүлэхийг завдсан амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийн судалгаагаар (2002-2014 он), хүрэн баавгайны 624 савар, доньд зэрэг эд эрхтэн хураасан (Мягмарсүрэн нар, 2014) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалт болон Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). Хүрэн баавгайн тархац нутгийн 21% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хүрэн баавгай (*Ursus arctos*)-ны эр нь 6500.0 мян.төг, эм нь 7500.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд хүрэн баавгай нь 1300.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



АРГАЛЬ ХОНЬ (АРГАЛЬ)

Ovis ammon Linnaeus, 1758

Баг: Туруутан (*Artiodactyla*)

Овог: Тугалмайтныхан (*Bovidae*)

НЭРШИЛ:

Англи: Argali Sheep, Asian Wild Sheep

Орос: Горный баран

Хятад: Pan Yang

Герман: Argali (Reisenwildschaf)

Франц: Argali

Казах: Арқар



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Ovis altaica, *Ovis argali*, *Ovis blythi* (Wilson and Reeder, 1993), *Ovis jubata* (Peters, 1876), *Ovis arabica* (Sopin&Harrison, 1986) (<http://checklist.cites.org>). Алтайн аргаль хонь (*Ovis ammon ammon*), Говийн аргаль хонь (*Ovis ammon darwini*) гэсэн хоёр салбар зүйл бий гэж өмнө нь үздэг байв. Гэвч сүүлийн үеийн аргаль хонины генетикийн судалгаагаар Монгол орны бүх аргаль хонь нэг салбар зүйлд хамаарна (Tserenbataa, 2003; Tserenbataa *et al.*, 2004) гэж үзжээ.



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Эмзэг”, бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй” зүйл (Clark *et al.*, 2006) хэмээн үнэлсэн.



ТАНИХ ШИНЖ

Их биеийн зүс хүрэн бор, хүрэвтэр. Хэвэл цайвар.

Зуны зүс хүрэвтэр бор, цайвар. Харин өвлийн зүс цайвар. Хүнд лагс биетэй, хөл харьцангуй урт. Биеийн урт 140-150 см, сэрвээний өндөр 120-125 см. Угалз хомь хоёулаа эвэртэй (Батсайхан нар, 2010; Шийрэвдамба нар, 2016). Угалзын эвэр мушгарсан хэлбэртэй бөгөөд урт нь 58-150 см, хааяа 170 см хүрнэ. Түүний эврийн угийн бүдүүн 40-44 см. Хомийн эвэр жижиг, 25-35 см урт, мушгиа багатай. Угалз 40-200 кг, хомь 27-66 кг жинтэй. Толгойн ясны суурийн (кондилобазаль) урт 230-390 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 0/1; бага араа 3/3; их араа 3/3=32 (Батсайхан нар, 2010).



ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Аргаль хонь (*Ovis ammon*) нь ОХУ, Казахстан, Узбекистан, Афганистан, Киргизстан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Балба, Монгол, Бутан, Непальд тархсан (<http://checklist.cites.org>) байна.

Хятад, Монгол, ОХУ-д тархсан Алтайн аргаль хонь (*Ovis ammon ammon*) нь аргаль хонины бүх




ГУРАВДУГААР БҮЛЭГ

зүйл дотроос хамгийн том бие, эвэртэй бол Хятад, Монголын говиор тохиолддог говийн аргаль хонь (*Ovis ammon darwini*) түүнээс бие, эврийн хэмжээгээр жижиг (CITES-ийн лавлах, 2001). Түүнчлэн Нангиад (Schansi) аргаль хонь (*Ovis ammon jubata*) Хятадад, Төвдийн аргаль хонь (*Ovis ammon hodgsonii Blyth, 1841*) Бутан, Энэтхэг, Хятад, Непальд, Харуул аргаль хонь (*Ovis ammon nigrimontana Severtzov, 1873*) Казакстанд тус тус тархсан (<http://checklist.cites.org>) байна.

Орлов, 1980) байна. Мөн Төв халхын тал хээрийн зарим намхан уулс, Хан Хөхийн нуруу, Хангайн нуруу, түүний өмнөд бэлийн уулс, Хөвсгөлийн Хорьдолын нурууны Нарийн бэлтэс, Арсайн голын эхээр хэсэгхэн газар тасархай популяци бий (Дуламцэрэн, 1970; Адъяа, Төмөрсүх, 2001; Amgalanbaatar et al., 2002). Хэнтийн нурууны баруун, өмнө захын зарим уулсад түр хугацаагаар нүүдэллэн үзэгдэнэ (Дуламцэрэн, 1970; Жирнов нар, 2005).

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Аргаль хонь нь Монгол орны зүүн хэсгийн уулс, тал хээрээс бусад нутаг дэвсгэрт тэгш өндөрлөг, хадан цохио, дов толгод, намхан уулсаар тархаж байсан боловч сүүлийн хэдэн арван жилд түүний тархцац нутаг нэлээд тасархайтсан байна (Амгаланбаатар нар, 2002). Одоогоор говийн бүсийн умард хэсгээс, хээр, ойт хээр, уулын тайгын өмнөд хэсэг хүртэлх Монгол Алтай, Говь Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говийн уулс, Алашань говь, Дорнод говийн бэсрэг уулсаар тархсан (Банников, 1954; Соколов,



АМЬДРАХ ОРЧИН

Монгол орны умардаас өмнөд хязгаар хүртэл уулын тайга, уулын ойт хээр, хээр, цөлийн бүс, бүслүүрт тархсан (Банников, 1954; Дуламцэрэн, 1970) байна. Өндөр нам уулс, аараг толгод, довцог, манхан элс зэрэг бартаа сархиа, нугачаа бүхий ой модгүй газар идээшилнэ. Алтайн нуруунд 3500 метр хүртэл, Өмнөговь, Алтайн өвөр говьд 1100 метрээс дээш, Хөвсгөлд 1250-2500 метр өндөрт нутаглана (Дуламцэрэн, 1970; Базардорж нар, 1984; Жирнов нар, 2005). Алтай, Хангайн уулсад зун мөнх цасны зах хүртэл нүүдэллэн тагийн нуга, царам, ар хажуугаар бэлчиж, өвөл уулын дундаас доош бэл энгэр газарт байршина. Хээр цөлийн бэсрэг уулс, аараг толгодод цас, задгай ус, өвс ногоо дагаж улирлаар хол ойр нүүдэллэж бэлчээрээ сэлгэдэг. Монгол орны уулархаг нутгийн хад асгат налуу, тагийн бүсийн дэвсгэрт байршин амьдарна (Батсайхан нар, 2010).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Сүрэглэн амьдарна. Намар, өвөлд олноороо сүрэглэнэ. Зун өглөө болон оройд, өвөлд өдөржин идээшлэнэ. Элдэв зүйлийн өвслөг ургамал, үет ургамал голдуу иднэ. Өвөлд сөөглөг ургамлын мөчир иднэ. Ус болон бэлчээрийн нөөцөөс хамааран улирлаар бэлчээрээ сэлгэж байрлана. Байгалийн нөхцөлд 10-18 жил насална (Батсайхан нар, 2010).

Ороо нийллэгт 9-11-р сард орж, 4-5-р сард хургална. Хээл тээх хугацаа 150 орчим хоног. Жилд 1 удаа төллөх ба ихэвчлэн 1, хааяа ихэрлэнэ. Үржилд 3-4 насандаа оролцоно (Дуламцэрэн, 1970; Соколов, 1980; Базардорж нар, 1984; Батсайхан нар, 2010).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Монгол орны байгаль, цаг уурын онцлогоос шалтгаалан аргаль хонины тоо толгой ихээхэн хэлбэлзэнэ. Монгол Алтайн нуруу, Говь-Алтайн зарим нутагт элбэг, Хангайн нуруу, түүний зах бэлийн уулсаар ховор, Өмнөговийн уулсад ховордуу, Дундговь, Дорноговийн намхан уулсаар ховор тохиолдоно (Базардорж нар, 1984). Монгол оронд 1975 онд 50,000 орчим толгой аргаль хонь тоологдож байсан бол 1985 онд 60,000 толгой болж өссөн байдаг бөгөөд харин 1994 онд 20,000 орчим толгой аргаль тоологдож, түүний популяцийн хэмжээ ихээхэн буурч (Reading *et al.*, 1997), түүнчлэн 2001 онд 13,000-15,000 толгой

болж үргэлжлэн буурсан (Амгаланбаатар нар, 2002) байна. Үүнээс үзэхэд, өнгөрсөн 26 жилд аргаль хонины популяцийн хэмжээ 72 хувиар буурсан байна (Zahler *et al.*, 2004).

ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн 2009 оны уулын туруутны судалгаагаар, Монгол улсын хэмжээнд 50,215.4 км² нутаг дэвсгэрт аргаль хонь тархсан болохыг тогтоож, нийтдээ 18,100 толгой байна хэмээн үнэлсэн байдаг. Мөн сүүлийн 10 орчим жилд Хөвсгөл, Сүхбаатар аймагт аргаль хонины тоо толгой харьцангуй тогтмол, харин тархац нутгийн хэмжээ 9.7-8.9 дахин нэмэгдсэнээс Говьсүмбэр аймагт тархац нутгийн хэмжээ 3.2 дахин, Төв аймагт 2.3 дахин, Баянхонгор, Дорноговь, Баян-Өлгий, Увс аймгуудад 1.2-1.9 дахин нэмэгдсэн, Хэнтий, Ховд, Өмнөговь, Өвөрхангай, Дундговь аймагт аргаль хонины тархац нутгийн хэмжээ 1.1-2.3 дахин багассан болохыг тогтоожээ.

Монгол оронд дээр үеэс эхлэн өнөөг хүртэл аргаль хонийг агнаж ирсэн уламжлалтай бөгөөд түүний тоо толгой ховордсоор байна (Банников, 1954; Намнандорж, 1976). Говь цөл, хээрт задгай ус, бэлчээр бүхий байршил нутагт мал бэлчээрлэсэнээс дайжин зайлж байна. Аргалийн байршил нутаг малын бэлчээртэй давхцаж хавчигдан шахагдах үзэгдэл түгээмэл. Түүний гол дайсан чоно болно. Бүргэд нялх хургыг барина. Хааяа ирвэс, шилүүс хорооно (Базардорж нар, 1984; Амарсанаа, 1985; Жирнов нар, 2005). Цастай хүйтэн өвөл хөгширсэн угалз, төл олноор хорогдоно. Цөл, хээрт цангаж үхэх тохиолдол бий (Базардорж нар, 1984).

Хууль бус агнуур, эврийн төлөөх гадаадын анчдын тогтвортой бус, судалгаанд үндэслээгүй агнуур аргалийн тоо толгойн ховордлын гол шалтгаан болж байна (Amgаланbaatar *et al.*, 2002). Мөн угалзыг тусгай зориулалтаар агнах тоо хэмжээ өссөөр байна (Zahler *et al.*, 2004).

Сүүлийн жилүүдэд аргалийн тархац нутагт уул уурхайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрс ихэссэнээс түүнийг амьдрах орчны хомсдолд оруулж байна (Wingard, 2005). Дэлхийн хэмжээнд ховордсон устаж болзошгүй зүйл юм.

ХУДАЛДАА

CITES-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10 жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Монгол улс олзворын ангийн зориулалтаар 510 гаруй

аргаль хонь агнуулж, судалгаа шинжилгээний зориулалтаар түүний арьс, үс, сорьц дээж 280 гаруйг гадаад руу гаргасан байна. Үүнээс гадна, улсын хэмжээнд бүртгэгдсэн (2011-2014 он) Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн гэмт хэргийн мэдээгээр, аргаль хоньтой холбоотой гэмт хэрэг нийтдээ 13 удаа тэмдэглэгдсэн (Мягмарсүрэн нар, 2014) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол улс 1953 оноос агнахыг хуулиар хориглож (БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975) ирсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн II (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int>) тус тус бүртгэлтэй. Аргаль хонины тархац нутгийн

14% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Аргаль хонь (*Ovis ammon*)-ны эр нь 11000.0 мян.төг, эм нь 13000.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд аргаль хонины эр нь 2200.0 мян.төг, эм нь 2600.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



МОНГОЛ БӨХӨН (БӨХӨН)

Saiga borealis Tschersky, 1876

Баг: Туруутан (*Artiodactyla*)

Овог: Тугалмайтныхан (*Bovidae*)

НЭРШИЛ:

Англи: Mongolian saiga, Mongolian Saiga Antelope

Орос: Монгольский сайгак

Хятад: Meng gu ling yang

Герман: Steppenantilopen

Франц: Saiga

Казах: Монгол бөкен, жезкиик

ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Saiga colus, *Saiga mongolica*, *Saiga saiga*, *Saiga scythica* (Wilson and Reeder, 1993). Монгол орны Сопрог бөхөн (*Saiga tatarica tatarica* Linnaeus, 1766) нь сүүлийн 40 жилд бүс нутгийн хэмжээнд устсан (Дулмаа, Шагдарсүрэн, 1973; Lkhagvasuren *et al.*, 2001) гэж үздэг.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор, унаган зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй” зүйл (Clark *et al.*, 2006) хэмээн үнэлсэн.

Бөхөн нутагшдаг бүх орны Засгийн газар, шинжлэх ухааны байгууллага, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөгч оролцсон Олон улсын хурал Улаанбаатар хотноо 2010 онд болж, Монгол бөхөнг тусгаар бие даасан зүйл (*Saiga borealis*) болохыг хүлээн зөвшөөрч

талуудын гэрээг шинэчлэн найруулсан (Бөхөн хамгаалах Олон улсын хурлын эмхэтгэл, 2010).

ТАНИХ ШИНЖ

Бие нь бөгтөр хэлбэртэй. Толгой том, монхор хамартай, хамрын сүв том. Хэржин 28-38 см урт, олон төвгөр үетэй, цайвар шаргал өнгөтэй, хос шорон эвэртэй. Хэрэгчин эвэргүй. Зуны зүс элсэн-саарал, ууцан дээрээ хүрэвтэр өнгийн толботой. Өвлийн зүс боровтор-саарал, нялх янзага бор хүрэн зүстэй. Биеийн урт 110-140 см, сэрвээний өндөр 63-80 см, сүүлний урт 8-13 см, чихний өндөр 7-11 см, биеийн жин 23-40 кг. Хэржний толгойн ясны кондилобазаль урт 223-250 мм, хэрэгчнийх 205-229 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 0/1; бага араа 3/2; их араа 3/3=30 (Батсайхан нар, 2010).

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Зөвхөн Монгол болон ОХУ-д тархсан (<http://checklist.cites.org>) байна.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Өнгөрсөн зуунд Увс нуурын хотгороос Улаан нуур хүртэлх Их нууруудын хотгор, Нууруудын хөндийн цөлөрхөг хээрт тархан амьдарч байв (Банников, 1954; Намнандорж, 1976; Жирнов нар, 2005). Их нууруудын хотгорын Хүйсийн говь, Хүрэн талын орчмоор тааралдана (Дуламцэрэн, Амгалан, 2003). Одоо Монгол орны баруун хэсэгт түүхэн тархац нутгийнхаа хориод хувьтай тэнцэх хэмжээний нутагт дэвсгэрт тусгаарлагдсан хоёр жижиг популяци болж үлдээд байна. Түүний нэг нь Шаргын говийн өмнө, баруун, хойд хэсгээр, эргэн тойрны уулсын бэлээс говь, хөндий, хотосыг хамарсан 2,000 км² нутаг дэвсгэр бөгөөд энд Монгол бөхөнгийн нийт популяцийн 90 хувь идээшин амьдарч байна. Шаргын популяциас хойш 200 км зайд Хар-Ус нуурын өмнөд хэсэгт Манхан элс, Монгол Алтайн уулсын бэлийн 200 км² нутаг дэвсгэрт цөөнөө тоогоор үлдсэн, устах аюулд орсон зүйл (Намнандорж, 1976; Дуламцэрэн, Амгалан, 1995) юм. Өнөөгийн байдлаар Монгол бөхөн Шаргын говьд 3,325 км², Хүйсийн говьд 6,700 км², Таван хайрхан, Чандманий талын 1,173

км² нутаг дэвсгэрт тархан амьдарч байна (Амгалан нар, 2008).



АМЬДРАХ ОРЧИН

Монгол Алтайн нурууны 1100-2200 метр өндөр уулсын бэл, хормой, хөндийн баглуур, таана, монгол өвст, шаваг бүхий дагжуур хайрган хөрст, бартаагүй, хэвгий, ээрэм дэнж талд нутаглана (Банников, 1954; Намнандорж, 1976; Дуламцэрэн нар, 1993). Хүйтэн, цастай өвөл, эсвэл гантай зун нөмөр, бэлчээр дагаж уулсын ам хөндий, толгод доор бэлчинэ (Амгалан нар, 2008). Бутлаг ургамал бүхий говийн уулсын шил, хоолой, цөлөрхөг

хээрийн бүсэд байршин амьдарна (Батсайхан нар, 2010).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Сүрэглэж амьдарна. Зуны улиралд өглөө эрт, оройн цагаар идээшлэх бөгөөд өвөлд өдрийн турш идээшлэнэ (Батсайхан нар, 2010). Таана, хөмүүл, баглуур, говийн хялгана, шаваг, шарилж зэрэг 30 гаруй зүйлийн өвслөг ургамал иднэ. Шүүслэг, нялх ургамалтай үед ус бараг уухгүй. Өвс, ус дагаж бэлчээрээ ойр зуурхан сэлгэнэ. Алс нүүдэллэх нь ховор. Шаргын говьд өвөл 50 хүртэл толгойгоор сүрэглэж, зун сүрэг задарч, цөөн тоогоор сүрэглэж байв. Хүзүүгээ урагш сунган, толгойгоо гудайлган бөхийж, цагт 60-70 км хүртэл хурдан хатирдаг (Дуламцэрэн нар, 1993).

Ороо нийллэгт 1-р сард орж, хээлээ 150 орчим хоног тээнэ. 6-р сарын дундуур төллөнө. Нийт төллөж буй хэрэгчний 16% орчим нь ихэрлэнэ. Хэрэгчин голдуу 7 сартайдаа, хэржин 19 сартайдаа үржилд орж эхэлнэ (Дуламцэрэн нар, 1989).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Байгаль, хүний хүчин зүйлийн нөлөөгөөр бөхөнгийн тоо толгой жилээс жилд ихээхэн хэлбэлзэнэ. 1993 оны байдлаар, Шаргын популяци 1,400 орчим, Манханы популяци 70 гаруй толгой байв (Дуламцэрэн нар, 1993). Шаргын говийн 1000 га-д 5.9 толгой ногдох 1,980 орчим, Хүйсийн говьд 1000 га-д 1.6 толгой ногдох 1,100 орчим, Чандманий талд 1000 га-д 0.8 толгой ногдох 160 орчим, нийт 3,240 толгой Монгол бөхөн байна (Амгалан нар, 2008). 2010-2012 онд ШУА-ийн Биологийн хүрээлэн, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын хамтарсан судалгаагаар, Монголд орны хэмжээнд нийтдээ 8,000 толгой Монгол бөхөн байгааг тогтоожээ.

Дээр үеэс бөхөнгийн эврийг Дорно дахины уламжлалт эмнэлэгт, махыг нутгийнхан хүнсэндээ хэрэглэж, хайр гамгүй агнаснаас түүний тархац нутаг хумигдаж, тоо толгой нь эрс цөөрсөн (Банников, 1954; Намнандорж, 1976; Жирнов нар, 2005) байна. 1990-ээд оноос эхлэн бөхөнгийн эврийг гадаадад гаргах болсноор хууль бус агналт ихэссэн. Идээшин дассан гол байршил нутаг, ус бэлчээрийг хүн, мал эзлэн шахаж байна. Их цастай хүйтэн өвөл, хавар бөхөн бөөнөөрөө осгож, өлбөрч үхдэг (Дуламцэрэн нар, 1993; Жирнов нар, 2005). Ихээхэн гууртдагаас таргалах, байгалийн бэрхшээл даах чадвар доройтож хомсдоход нөлөөлдөг (Дуламцэрэн нар, 1989). Байгаль дээрх

гол дайсан нь бүргэд болно (Дуламцэрэн, 1992). Устах аюулд орсон, унаган зүйл.

ХУДАЛДАА

CITES-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10 жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Монгол улс судалгаа шинжилгээний зориулалтаар Монгол бөхөнгийн 100 гаруй арьс, үсний дээжийг АНУ руу экспортолжээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн (2011-2014 он) Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн гэмт хэргийн мэдээгээр, Монгол бөхөнгийн талаарх гэмт хэрэг нийтдээ 22 удаа тэмдэглэгдсэн (Мягмарсүрэн нар, 2014) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол улс 1930 оноос агнахыг хуулиар хориглож (БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975) ирсэн бөгөөд Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан. Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн II (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int>) тус тус бүртгэлтэй. Монгол бөхөнгийн тархац нутгийн 24% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байгаа бөгөөд 1993 оноос Шарга, Манханыг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамруулсан байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Монгол бөхөнгийн эр нь 2000.0 мян.төг, эм нь 2200.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд Монгол бөхөнгийн эр нь 400.0 мян.төг, эм нь 440.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



БАДАНГА ХҮДЭР (ХҮДЭР)

Moschus moschiferus Linnaeus, 1758

Баг: Туруутан (*Artiodactyla*)

Овог: Бугынхан (*Cervidae (Moschidae)*)

НЭРШИЛ:

Англи: Siberian Musk Deer (Musk Deer)

Орос: Кабарга

Хятад: Yuan She

Герман: Moschustier (Sibirischer Moschushirsch)

Франц: Chevrotin porte-musc

Казах: Құдыр

ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Moschus moschiferus moschiferus. Хүдрийн бүлгийн ангилал нь бүрэн гүйцэд шийдэгдээгүй хэвээр байна. Энэ зүйлийг голдуу Cervidae овогт багтаадаг (Цэнджав, 2002).

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Эмзэг”, бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй” зүйл (Clark *et al.*, 2006) хэмээн үнэлжээ.

ТАНИХ ШИНЖ

Хажуу, зоо хондлойгоороо бүдэг шаравтар толбо бүхий хүрэн бор, бараан хүрэн зүстэй. Хэвэл, мөчдийн дотор тал цайвар (Банников, 1954; Дуламцэрэн, 1989). Эрүүний доороос өөхий дагасан хос цайвар судалтай. Хэвлий цайвар бор,

сааралдуу. Бие жижиг. Хойд хөл урдахаасаа урт учир хондлойгоороо өндөр, харайх нь туулайтай төстэй (Батсайхан нар, 2010). Гирээ, гирэгчин эвэргүй. Гирээний дээд уруул дороосоо илүү гарч эрүүнээс доош сөрдийсэн, 7 см хүртэл урт сэлэм хэлбэртэй, хурц, тод цагаан соёотой. Гирэгчний соёо жижиг (Дуламцэрэн, 1989). Мөч 4 хуруутай. Хажуугийн хоёр хуруу нь зогсож байх үед газарт хүрнэ. Биеийн урт 85-100 см, сүүлний урт 4-6 см, сэрвээний өндөр 55-69 см, хондлой орчмоор 67-80 см, биеийн жин 10-17 кг. Гавлын хэсэг илүү хүчирхэг, харин хоншоорын хэсэг богино. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 1/1; бага араа 3/3; их араа 3/3=34 (Батсайхан нар, 2010).

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Баданга хүдэр ОХУ, Казахстан, Афганистан, Пакистан, Хятад, Энэтхэг, Киргизстан, Балба, Монгол, Бутан, Мьянмар, Вьетнам, БНСУ, БНАСАУ зэрэг улс оронд тархсан (Цэнджав, 2002) байна.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол Алтайн нурууны хойд хэсгийн ойт нутаг (Тогтохбаяр нар, 2000), Хөвсгөл, Хэнтийн тайгын ойт хэсгээр, Хангайн уулсын зарим нутаг (Дуламцэрэн нар, 1989), Хан Хөхийн нурууны баруун хойт хөвчөөр тархсан (Дуламцэрэн нар, 1989; Цэнджав, 2002). Монгол орны хэмжээнд Хөвсгөлийн уулс болон Хангайн нуруу баданга хүдэр тархан байршихад тохиромжтой нөхцөл ихтэй болохыг нэр дурдсан нутгуудад энэхүү зүйлийн нийт нөөцийн 83 хувь байгаа дүн нотолдог (Банников, 1954; Соколов нар, 1982; Дуламцэрэн, 1989) байна.



АМЬДРАХ ОРЧИН

Жинхэнэ уулын тайгын амьтан. Уулсын ар хажууд 1700-2300 метр өндөрт хуш, хуш-шинэс, шинэсэн ой, хөвдөн дэвсгэртэй, унанги модтой балар өтгөн ой, уулын арын сүүдэр, оройн хад асгатай газарт илүү байршиж амьдарна. Хад асгатай, бартаа ихтэй газар авирч дүүлэхдээ сайн (Банников, 1954; Соколов нар, 1982; Дуламцэрэн, 1989; Батсайхан нар, 2010). Ой доторх хад цохио, асганд тааралдах бөгөөд харин задгай газар үзэгдэхгүй. Байршлаа улирлаар бага өөрчилж, тодорхой хэсэгхэн газар байнга нутаглана (Дуламцэрэн, 1989).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Өвслөг ургамал, хаг, хөвд, шилмүүсээр хооллоно. Ороо нийллэгт 12-р сарын дундаас орж, дараа зуны 6-р сарын сүүлч, 7-р сарын эхний хагаст голдуу ихэр шовшоорой гаргана. Сүрэглэхгүй. Голдуу ганцаараа эзэмшил газартаа тогтвортой амьдарна (Батсайхан нар, 2010). 7-р сараас 8-р сард гуужина. Шовшоорой 2 сар гаруй хөхүүл байна. Аюул тохиолдох, айж сандрахдаа исгэрэх, уйлах мэт дуугарна (Соколов нар, 1982; Дуламцэрэн, 1989).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Хэт их агналтын улмаас ХХ зууны хорь гучаад онд баданга хүдэр тархацынхаа ихэнх хэсэгт нэлээд цөөрчээ (Соколов нар, 1982; Дуламцэрэн, 1989). 1970-аад онд Монгол орны хэмжээнд 60-80 мянган хүдэртэй байсан бөгөөд үүнээс 44 мянгыг нь Хангай, Хэнтийн нуруунд бүртгэжээ (Дуламцэрэн, 1989). Элбэг газраа Хэнтийн нуруунд 1000 га-д 21-35 бодгаль, Хангайн нуруунд 6-8 бодгаль тус тус бүртгэгдэж байв (Соколов нар, 1982; Дуламцэрэн, 1989). Үүнээс хойш, баданга хүдрийн популяцийн хэмжээ багассаар 1990-2000 онд 1 км² нутагт 1.2-0.2 бодгаль ногдох нягтшилтай болтлоо буурсан (Цэнджав, Бүжинханд, 2000; Цэнджав, 2002) байна. БОАЖЯ, Дэлхийн банк, Голландын Засгийн газрын хамтарсан “NEMO-II” төслийн дэмжлэгээр ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн 2010 онд гүйцэтгэсэн “Монгол орны ойн туруутан амьтдын популяцийн үнэлгээ”-ний ажлын тайланд 34,796 км² нутагт 1000 га-д 1,9 бодгаль ногдох нягтшилтайгаар 6,525 толгой баданга хүдэр байна хэмээн тогтоожээ.

Сүүлийн жилүүдэд гирээний заарыг авахын тулд хараа хяналтгүй, хууль бусаар ихээхэн агнаж байгаа нь түүний толгой ховордох гол шалтгаан болж байна. 1990-2001 онд хууль бусаар болон тусгай зориулалтаар 25,000 толгой бие гүйцсэн гирээг агнасан (Homes, 2004) мэдээ байдаг. Хүдрийн заарыг авахын тулд нас, хүйс ялгалгүй дөрвөөс таван хүдэр агнадаг байна (Green, 1987). Өнөө үед сүрчигийг синтетик эдээр хийх нь илүү нийтлэг болсон бөгөөд үйлдвэрийн аргаар заараар сүрчиг хийх нь буурч байгаа боловч ардын эмнэлэгт амьсгал, зүрх судасны өвчинг анагаахад ашигладаг тул өндөр үнэтэй хэвээр байна. Мөн хүдрийн тархац нутаг, амьдрах орчны хуваагдал, тасархайталт нь түүний толгойн ховордлын шалтгааны нэг болж байна (Цэнджав, Бүжинханд, 2000).

Баданга хүдрийг чоно, шилүүс, нохой зээх, баавгай барьж иднэ (Дуламцэрэн, 1989). Дэлхийн хэмжээнд ховордсон, устах аюулд орсон зүйл юм.

ХУДАЛДАА

CITES-ийн мэдээллийн сангийн сүүлийн 10

жилийн мэдээгээр (<https://trade.cites.org>), Монгол улс баданга хүдрийн хоёр эд эрхтнийг Япон руу экспортолжээ. Монгол улсын хэмжээнд бүртгэгдсэн (2011-2014 он) Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн гэмт хэргийн мэдээгээр, баданга хүдэртэй холбоотой нийтдээ 5 гэмт хэрэг тэмдэглэсэн (Мягмарсүрэн нар, 2014) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол улс 1953 оноос агнахыг хуулиар хориглож (БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975) ирсэн бөгөөд Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан. Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>) байдаг.

Баданга хүдрийн тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна. Тухайлбал, Хангайн нуруу, Тарвагатай, Хан Хэнтий, Богдхан уул, Горхи-Тэрэлж зэрэг улсын тусгай хамгаалалттай газар нутагт энэ зүйлийг хамгаалж байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Баданга хүдэр (*Moschus moschiferus*)-ийн эр нь 3000.0 мян.төг, эм нь 3500.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд баданга хүдрийн эр нь 600.0 мян.төг, эм нь 700.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

СЭДВИЙН АГУУЛГА

МОНГОЛ УЛСААС КОНВЕНЦ (СІТЕС)-ИЙН НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТАД БҮРТГЭГДСЭН ШУВУУД

1. Борцгор хотон (*Pelecanus crispus*)
2. Дорнын өрөвтас (*Ciconia boyciana*)
3. Хан бүргэд (*Aquila heliaca*)
4. Цагаансүүлт нөмрөгбүргэд (*Haliaeetus albicilla*)
5. Усны нөмрөг бүргэд (*Haliaeetus leucorhynchus*)
6. Цагаан шонхор (*Falco rusticolus*)
7. Эгэл шонхор (*Falco peregrines*)
8. Шилийн шонхор (*Falco peregrinoides*)
9. Алаг тогоруу (*Grus japonensis*)
10. Цагаан тогоруу (*Grus leucogeranus*)
11. Цэн тогоруу (*Grus vipio*)
12. Хар тогоруу (*Grus monacha*)
13. Жороо тоодог (Жороо тоодгой) (*Chlamydotis macqueenii*)
14. Реликт цахлай (*Larus relictus*)

МОНГОЛ УЛСААС КОНВЕНЦ (СІТЕС)-ИЙН ХОЁРДУГААР ХАВСРАЛТАД БҮРТГЭГДСЭН ШУВУУД

15. Халбаган хошуут (Цагаагчин халбагат) (*Platylea leucorodia*)
16. Хар өрөвтас (*Ciconia nigra*)
17. Ягаан нэл (*Phoenicopterus roseus*)
18. Байгалийн нугас (*Anas Formosa*)
19. Цагаантолгойт ямаансүүл (*Oxyura leucoscephala*)
20. Загасч явлаг (*Pandion haliaetus*)
21. Балч гоорбис (*Pernis apivorus*)
22. Согсоот гоорбис (*Pernis ptilorhynchus*)
23. Сохор элээ (*Milvus migrans*)
24. Саарал хулд (*Circus cyaneus*)
25. Хээрийн хулд (*Circus macrourus*)
26. Нугын хулд (*Circus pygargus*)
27. Алаг хулд (*Circus melanoleucus*)
28. Намгын хулд (*Circus aeruginosus*)
29. Дорнын хулд (*Circus spilonotus*)
30. Үлэг харцага (*Accipiter gentilis*)
31. Морин харцага (*Accipiter nisus*)
32. Үүрсээ харцага (*Accipiter badius*)
33. Шунгаач харцага (*Accipiter gularis*)
34. Тарлан сар (*Buteo lagopus*)
35. Шилийн сар (*Buteo hemilasius*)
36. Талын сар (*Buteo rufinus*)
37. Ойн сар (*Buteo buteo*)
38. Саржуу харцгай (*Butastur indicus*)
39. Могойч загалай (*Circaetus gallicus*)
40. Уулын согсоот бүргэд (*Spizaetus nipalensis*)
41. Бахим бүргэд (*Hieraaetus pennatus*)
42. Харсун бүргэд (*Hieraaetus fasciatus*)
43. Тарважи бүргэд (*Aquila nipalensis*)
44. Бор бүргэд (*Aquila clanga*)
45. Цармын бүргэд (*Aquila chrysaetos*)
46. Ооч ёл (*Gypaetus barbatus*)
47. Дэлт ёлон (*Neophron percnopterus*)
48. Нөмрөг тас (*Aegypius monachus*)
49. Ухаа хажир (*Gyps fulvus*)
50. Хималайн хажир (*Gyps himalayensis*)
51. Идлэг шонхор (*Falco cherrug*)
52. Шууман шонхор (*Falco subbuteo*)
53. Хайргууна шонхор (*Falco columbarius*)
54. Турамтай шонхор (*Falco vespertinus*)
55. Амарын шонхор (*Falco amurensis*)
56. Зээрд шонхор (*Falco naumanni*)
57. Начин шонхор (*Falco tinnunculus*)
58. Хархираа тогоруу (*Grus grus*)
59. Өвөгт тогоруу (Өвөгт тогируу) (*Anthropoides virgo*)
60. Хонин тоодог (*Otis tarda*)
61. Цагаан уульж (*Nyctea scandiaca*)
62. Эгэл шаршувуу (*Bubo bubo*)
63. Соотон гуйванга (*Asio otus*)
64. Хулгар гуйванга (*Asio flammeus*)
65. Ердийн орволго (*Otus scops*)
66. Ойн орволго (*Otus sunia*)
67. Савагт ариан (*Aegolius funereus*)
68. Хотны бүгээхэй (*Athene noctua*)
69. Буслаг сүлиг (*Glaucidium passerinum*)
70. Харсуун бэгбаатар (*Serhiya ulula*)
71. Хув ууль (Хув бэгбаатар) (*Strix uralensis*)
72. Угалзан ууль (*Strix nebulosa*)

Шувууны Монгол орон дахь тархацийн зураг дээрх өнгөний ялгарлын тайлбар

- Нүүдлийн дайрч өнгөрдөг
- Үрждэг нутаг
- Өвлийн улиралд нэвтрэн ирж байршдаг нутаг
- Жилийн дөрвөн улирлын турш байршдаг
- Бодгалиудын зарим нь нүүж, зарим хэсэг нь үлддэг зүйлүүд



БОРЦГОР ХОТОН

Pelecanus crispus Bruch, 1832

Баг: Хотон (*Pelecaniformes*)

Овог: Хотон (*Pelecanidae*)

НЭРШИЛ:

Англи: Dalmation Pelican

Орос: Кудрявый пеликан

Хятад: Juanyu Tihu

Герман: Krauskopfpelikan

Франц: Pélican frisé

Казах: Бұйра бірқазан

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Эмзэг”, бүс нутгийн хэмжээнд “Устаж байгаа” зүйл (Gombobaatar *et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ


Манай орны томоохон биетэй шувуудын нэг бөгөөд биеийн урт 160-180 см, далавчны дэлгэмэл 310-345 см, жин 11-15 кг хүрнэ.

Эр, эм шувуу ижил зүстэй. Бие гүйцсэн шувууны ерөнхий зүс цагаан. Хошуу урт, хүчирхэг, түүний урт 37-45 см. Үзүүрээрээ доош үл ялиг махир, бор шаргал, доод хэсэгтээ шараас улбар шар өнгийн арьсан ууттай байдгаараа өвөрмөц. Цээж,

хэвлий цагаан. Дагзны өд буржгар бараавтар саарал. Далавчны нэгдүгээр зэргийн дэвүүр өд хар, хоёрдугаар зэргийн дэвүүрүүд сааралдуу бөгөөд үзүүр нь хар. Залуу хотонгийн хөл, хошуу бараан саарал, биеийн дээд хэсэгтээ бор хүрэн толбуудтай.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Баруун Сахар, Испани, Алжир, Норвег, Итали, Чех, Польш, Хорват, Босни, Словак, Монтенегро, Албани, Грек, Румын, Македони, Латви, Украин, Болгар, Египет, Турк, Молдов, ОХУ, Кипр, Израиль, Ливан, Сири, Ирак, Гүрж, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Эмират, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Хятад, Монгол, Хонконг, Тайвань, БНСУ, Японд тархсан. Унгар, Австри, Германд устсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хар-Ус нуур, Шувуун Цуглаан нуур (1976 онд 40 хос, 1992 онд 23 бодгаль), Айраг нуур (1995 оны 6-р сард 19 бие гүйцсэн бодгаль, 5 үүр, 1998 оны 6-р сард 23 бие гүйцсэн бодгаль 2-3 үүр, 9-р сард 5 бие гүйцсэн бодгаль, 2 ангаахай, 1999 онд 31 бодгаль), Хар, Дөргөн нуурт үржиж байсан. 1999 онд тус нуурын Бөмбөгөр арал дээрээс 1999 онд нисгэл ангаахай олсноос хойш 2006 онд тус газраас 4 ангаахай (үхсэн байсан) олох хүртэл үржлийн тухай баримт дахин тэмдэглэгдээгүй. Хяргас (1976 онд 10 бодгаль, 1995 онд 2 бодгаль), Эрээн, Тайгам нуур (Их Нууруудын хотгор), Увс нуур (1985 онд 1 бодгаль), Чоно Харайх гол, Хар нуурын цутгал (1995 онд 1 бодгаль), Ховд гол, Хар-Ус нуурын цутгал (1995 онд 2 бодгаль), Хар-Ус нуур, Шувуун Цагаан нуур (1956 оны зун 300 гаруй, 1972 онд 207, 1981 онд 13 бодгаль), Завхан аймгийн Баян нуур (1995 онд 1 бодгаль), Ойгон нуур (1976 онд 13 бодгаль), Завхан гол, Архангай аймгийн Өгий нуур, Баянхонгор аймгийн Бөөнцагаан, Холбоож (1979 онд 50 бодгаль), Орог нуур (1977 онд 3 бодгаль), Таацын цагаан нуур (1977 онд 6 бодгаль), Өвөрхангай аймгийн Сангийн далай нуур (2007 онд 1 бодгаль), Хэрлэн голын хөндийд (Багануур дүүрэгт 2008 онд 1 бодгаль) нүүдлийн үеэр, эсвэл үржлийн бус бодгалиуд зусах байдлаар бүртгэгдсэн (Gombobaatar *et al.*, 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Зэгс, арал бүхий загас элбэгтэй амгалан тайван байдлыг бүрдүүлсэн дээр дурдсан томоохон нууруудыг шүтэн амьдарна. Нүүдлийн үедээ тал хээрийн нууранд тохиолдож болно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд үржлийн нутагтаа 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд ирнэ. Үржил 5-р сарын сүүлчээс 6-р сарын эхэнд эхэлж, 8-р сар хүртэл үргэлжилнэ. Үүрээ загас бүхий нуурын алслагдмал, хүн хүрэхэд хэцүү хэсэгт, эсвэл тураг гогойн колоны захад гол төлөв засдаг бөгөөд цөөн буюу ганц нэгхэн хосууд нийлж жижиг колониор үүрлэдэг. Зэгс, өвс, мөчир, чулуу зэргийг овоолон 40-100 см өндөр үүр засна. Ийнхүү барьсан хөвдөг үүр нь ангаахай томорч, жин нэмэгдэх тусам усанд автаж болзошгүй. Эм бодгаль 2-4, ховор тохиолдолд 5-6 өндөг гаргана. Өндөгнөөс ангаахай 30-32 хоногийн дараа гарах ба 2 дахь долоо хоногоос эхлэн усанд сэлэх чадвартай болж, 70 хоногтойгоос нисэж эхэлнэ. Эцэг, эх шувууд ангаахайг дунд зэргийн хэмжээтэй загасаар хооллоно. 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд өвөлжих нутагруугаа нүүж эхлэнэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 11,400-13,400 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) гэж үнэлсэн.

Энэ зүйл шувууны Монгол оронд өмнө үрждэг байсан нутгуудад малын тооны хэт өсөлт, аялал жуулчлалын бааз, уул уурхай, усан цахилгаан станц, моторт завин аялал зэрэг хүний хүчин зүйл тэдгээрийн тайван байдлыг алдагдуулна. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үржих орчны нөхцөл доройтсон. Хошууг нь авах зорилгоор хууль бусаар агнаж буй нь энэ зүйлийн тоо цөөрөхөд нөлөөлдөг. Дээрх хүчин зүйлийн улмаас Хар-Ус, Айраг нууранд сүүлийн жилүүдэд үржлийн бус бодгалиуд л тэмдэглэгдэх боллоо (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Хотонгийн толгой бүхий хошууг уяачид хурдан морины хусуур болгон ашигладаг. Ингэхдээ түүнийг мөнгөлөх, алтдах зэргээр чимсэн байх нь бий. 2017 онд Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын алба хаагчид Монгол улсын хилээр хууль бусаар 23 ширхэг хотонгийн хошууг нэвтрүүлэн

бусдад худалдаалахыг завдсан үйдлийг илрүүлэн шалгаж байна. Хятадад махыг нь эмийн чанартайд тооцдог ба түүний өд, арьсаар эд зүйлс хийдэг (Del Noyo, 1992). Европын орнуудад хотонгийн хошууг хутганы хуй, тамхины сав болгон олон зууны турш ашиглаж ирсэн түүхтэй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол улс 1953 оноос агнахыг хуулиар хориглож ирсэн бөгөөд Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016), Азийн Улаан ном (2001)-нд тус тус оруулсан.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус оржээ.

Борцгор хотонгийн Монгол орон дахь тархац нутгийн 13.2% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна. Тухайлбал, Хар-

Ус нуур, Хяргас нуур, Увс нуурын ай сав газрууд зэрэг болно (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Борцгор хотон (*Pelecanus crispus*) нь 6,570.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 1,314.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ДОРНЫН ӨРӨВТАС

Ciconia boyciana Swinhoe, 1873

Баг: Өрөвтас (*Ciconiiformes*)

Овог: Өрөвтас (*Ciconiidae*)

НЭРШИЛ:

Англи: Oriental Stork

Орос: Дальневосточный аист

Хятад: Dongfang Baiguan

Герман: Schwarzschnabelstorch

Франц: Cigogne orientale

Казах: Қиыршығыс дегелегі

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Устаж болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Үнэлэх боломжгүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Эр нь эмээс ялимгүй том. Биеийн урт 950-1,100 мм, далавчны урт 620-670 мм, хошууны урт 200-260 мм хүрнэ. Эр, эм ижил зүстэй. Бие гүйцсэн шувуу цагаан зүстэй ба далавчны дэвүүр, мөрний урд өд, хошуу хар. Хөл улаан. Залуу шувуу бие гүйцсэнтэйгээ төсөөтэй боловч бор шаргал толбо судал илэрнэ.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

ОХУ, Энэтхэг, Хятад, Монгол, Бангладеш, Мянмар, Хонконг, Тайвань, Филиппин, БНАСАУ, БНСУ, Япон зэрэг улс оронд тархжээ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хавар, намрын нүүдлийн үедээ Монгол орны зүүн хэсгээр тухайлбал, Улз голын хөндий (Дорнод Монгол), Халх гол, Их Хянганаар дайран өнгөрдөг, үржлийн бус зүйл. Хустайн Байгалийн цогцолборт газарт бүртгэгдсэн гэх эргэлзээтэй мэдээ бий (Gombobaatar *et al.*, 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Өндөр ургамал, зэгс бүхий нуур ба голын хөндийд нүүдлийн үедээ тохиолдоно. Усны шавж, царцаа болон хоёр нутагтнаар хооллоно (Gombobaatar *et al.*, 2011).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны зүүн хэсгээр зөвхөн хавар, намрын нүүдлийн үедээ ховор тохиолдоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 1,000-2,499 бие гүйцсэн бодгаль бөгөөд тэдгээрийн тоо толгой буурсаар байна (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Энэ зүйлийн тоо толгой буурах гол шалтгаан нь нүүдлийн мал аж ахуй, уул уурхайн шууд ба дам нөлөөнөөс үүссэн амьдрах орчны доройтол, загасны тор, орчны бохирдол, дэлхийн дулаарал зэрэг голчлон хүний нөлөө болж байна

(Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай орны хувьд гадаад худалдааны мэдээ баримт байхгүй байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://www.cms.int/en/species>) болон Азийн Улаан ном (2001)-нд орсон.

Дорнын өрөвтасын Монгол орон дахь тархац нутгийн 22.4% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Дорнын өрөвтас (*Ciconia boyciana*) нь 380.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 76.0 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ХАН БҮРГЭД

Aquila heliaca Savigny, 1809

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)



НЭРШИЛ:

Англи: Eastern Imperial Eagle

Орос: Могильник

Хятад: Baijian Diao

Герман: Kaiseradler

Франц: Aigle impérial

Казах: Қарақұс

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 720-840 мм. Далавчны урт эрд 540-610 мм, эмд 580-665 мм, биеийн жин 2,450-4,530 г хүрнэ.

Эр нь эмээс биеэр жижиг ба зүс ижил. Бие гүйцсэн шувуу цармын бүргэдтэй төсөөтэй ч дагзны ар хэсэг цайвар шаргал, дал мөрний бүх өд цагаан. Дэвүүр өд хөндлөн судалтай. Нүдний хүрээ, хошууны зэтэр шар. Хошуу, хумс хар. Залуу шувууны ерөнхий зүс цайвардуу бор хонгор, биеийн доод хэсэг улбар бор шаргал судалтай. Мөрний цагаан илрээгүй.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Марокко, Франц, Герман, Итали, Дани, Камерон, Ливийн Жамахири, Швед, Чех, Словени, Польш, Хорват, Босни, Унгар, Словак, Серби, Монтенегро, Грек, Румын, Македони, Финланд, Литва, Судан, Украин, Болгар, Беларусь, Египет, Турк, Молдов, ОХУ, Танзани, Кипр, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Энэтхэг, Киргиз, Хятад, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапур, Хонконг, Тайвань, БНАСАУ, БНСУ, Япон улсад тархсан. Макао болон Палестинд бүртгэгдсэн гэх боловч эргэлзээтэй. Австралид утсан, тохиолдлоор таарах боломжтой.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хэнтий, Хөвсгөлийн тойрог, ялангуяа Орхон, Сэлэнгэ мөрний сав, Дорнодын тал хээр болон Булган голын сав газраар тархсан. Нүүдлийн үедээ ой, хуурай хээрт тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Тайга, ойт хээр, голын хөндийн шилмүүст ба холимог ойд амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг, дайрч өнгөрдөг зүйл. Үржлийн болон нүүдлийн шувууд манай оронд цаг агаарын нөхцөлөөс хамааран 4-р сүүлчээс 5-р сарын эхэн үед ирдэг. Үржлийн хосууд тайга, голын хөндий, ойт хээрийн шилмүүст ба холимог ойн өндөр модонд хуурай өвс, мөчирөөр үүр засна. Бор, саарал толбо бүхий 2-3 ширхэг цайвар өндөг гаргаж, 43 хоногийн турш эм шувуу голчлон дарна. Ангаахай 60 хоногийн дараагаас нисэж эхэлнэ.

Урт сүүлт зурам, дагуур зурам, дагуур огдой болон жижиг, дунд хэмжээний шувуудаар хооллоно. Нүүдлийн үедээ ойт хээрээс цөлөрхөг хээр хүртэлх задгай газарт ганц нэгээр тохиолдоно. Намрын нүүдэл 9-р сарын эхээс 10-р сарын сүүлч хүртэл үргэлжилнэ. Манай оронд цөөн тоогоор өвөлждөг байх боломжтой (Gombobaatar *et al.*, 2011).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 2011 онд 5,200-16,800 бие гүйцсэн бодгальтай байсан бол өдгөө 2,500-9,999 болж буурсан байна (BirdLife International, 2017).

Энэ зүйлийн тоо толгой хомсдох гол шалтгаан нь уул уурхай, ойн зүй бус ашиглалт, түймэр зэргээс шалтгаалсан амьдрах орчны доройтол, мөн идэш тэжээлийн хомсдол болно (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны тухай мэдээ баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int>) тус тус бүртгэлтэй.

Хан бүргэдийн Монгол орон дахь тархац нутгийн 11.6% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хан бүргэд (*Aquila heliaca*) нь 513.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 102.6 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ЦАГААНСҮҮТ НӨМРӨГБҮРГЭД

Haliaeetus albicilla Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: White-tailed Eagle


Орос: Орлан-белохвост

Хятад: Baiwei Haidiao

Герман: Seeadler

Франц: Pygargue à queue blanche

Казах: Аққұйрықты субүркіт



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Ховордож болзошгүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 700-1,000 мм. Эрийн далавчны урт 575-660 мм, эмд 635-705 мм. Биеийн жин 3,000-6,500 г хүрнэ.

Эр нь эмээс биеэр жижиг, өнгө зүсээр ижил. Бие гүйцсэн шувууны ерөнхий зүс бор хүрэн, толгой, хэвлий цайвар хүрэн, хүзүү сааралдуу, сүүл цагаан. Нүдний цагираг цагаан шар. Хошуу шаравтар, зэтэр, савар шар, хумс хар. Залуу шувууны ерөнхий зүс бараан, сүүл бор саарал, жигд бус цагаан зураасуудтай. Хэвлий цайвар тууш толботой. Хошуу хар саарал. Сүүлний өд 4-5 наснаас цагаан болно.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

АНУ, Гренланд, Исланд, Ирланд, Их Британи, Франц, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Тунис, Дани, Австри, Свалбард Ян Майен, Швед, Чех, Словени, Польш, Мальта, Хорват, Босни, Унгар, Словак, Серб, Монтенегро, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет,


Турк, Молдов, ОХУ, Кипр, Саудын Араб, Ливан, Ирак, Гүрж, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Энэтхэг, Хятад, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Тайланд, Тайвань, БНАСАУ, БНСУ, Японд тархсан. Алжир, Сири, Португалид бүс нутгийн хэмжээнд устсан. Португалид тохиолдлын байдлаар таарна.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Буянт, Ховд гол, Ачит нуур, Үүрэг нуур (Монгол-Алтайн тойрог), Увс нуур, Тэсийн голын адаг Торхилог гол (Увс нуурын хойд хөндий), Чоно Харайх гол, Хар-Ус, Дөргөн, Хяргас, Айраг нуур, Тамир, Хануй, дээд Орхон гол, Сангийн далай, Өгий нуур (Хангайн тойрог), Хан Хөхийн муж, Тэрхийн цагаан, Тэлмэн нуур, Идэр, Чулуут гол (Тарвагатай-Булнайн нуруу), Эг-Үүрийн бэлчир,

Тэшиг, Булган (Хөвсгөлийн тойрог), доод Орхон, Сэлэнгэ, Эг, Хархираа, Ерөө гол (Орхон-Сэлэнгийн сав), Минж, Онон, Балж голын хөндий, Туул, Тэрэлж, Хүдэр, Булнайн гол (Хэнтийн тойрог), Хэрлэн-Улз голын сав, Халх, Нөмрөг, Буйр нуурын савд үрждэг. Нүүдлийн үедээ нуурын хөндий, Булган гол, Дундад Халхын хээрт тохиолдоно. Улаанбаатар хотын ойролцоо өвөлждөг (Gombobaatar *et al.*, 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Ой, ойт хээрийн цэнгэг устай нуур, голын ойролцоох навчит болон шилмүүст мод, хадан цохио бүхий орчныг шүтэн амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн үрждэг зүйл бөгөөд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд ирнэ. Үржлийн хосууд цэнгэг устай нуур, голын ойролцоох ойт хээрийн хөгшин өндөр модны гол иш дээр, эсвэл өндөр уулын цавчим хад, хясаа дээр модны иш, мөчир ашиглан том үүр засаж, цагаан өнгийн 1-3 өндөг гаргана. Өндгийг гол төлөв эм шувуу дарах ба 35-45 хоногийн дараа ангаахай гарна. Агнуурт эр шувуу голлох үүрэгтэй ба загас болон зэрлэг, ногоохон, халбага, зээрд, шовтгор алаг зэрэг нугасыг барьж үүрэндээ авчирна. Намрын нүүдэл идэш тэжээлийн олдоц, цаг уурын нөхцөлөөс шалтгаалан 8-р сарын сүүлчээс 10-р сарын эхэнд явагдах ба энэ үеэр хосоороо болон ганц нэгээрээ армаг тармаг модтой задгай хээр, бургасан шугуй, шилмүүст мод бүхий нуур, голын хөндий, хадтай уулаар тохиолдоно. Бие гүйцсэн болон залуу шувууд хөлдөлгүй үлдсэн задгай ус, харзанд өвөлжих нугаснаас хамааран цөөн тоогоор өвөлждөг.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 2011 онд 20,000-39,600 бие гүйцсэн бодгальтай байсан бол өдгөө 20,000-49,999 болж нэмэгдсэн (BirdLife International, 2017) байна.

Малын тооны өсөлт, уул уурхайн шууд ба дам нөлөөллөөс үүссэн ус намгархаг орчны доройтол, бохирдол, мөн Өгий болон бусад загастай нууран дахь хууль бус загасчлал нь энэ зүйл шувууны идэш тэжээлийн нөөцийг бууруулах тул тэдний амьдралд сөргөөр нөлөөлдөг. Мөн загасчдын хаясан тор, түймэр зэргээс шалтгаалж тоо толгой буурна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай оронд худалдааны баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int>) тус тус бүртгэлтэй.

Цагаансүүлт нөмрөгбүргэдийн Монгол орон дахь тархац нутгийн 8.7% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Цагаансүүлт нөмрөгбүргэд (*Haliaeetus albicilla*) нь 1,052.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 210.4 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



УСНЫ НӨМРӨГБҮРГЭД

Haliaeetus leucoryphus Pallas, 1771

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Pallas's Fish Eagle (Pallas's Sea-Eagle)

Орос: Орлан-долгохвост

Хятад: Yudai Haidiao

Герман: Bindenseeadler

Франц: Rygargue de Pallas

Казах: Ақиық субүркіт

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй” зүйл (Gombobaatar *et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Далавчны урт эрд 525-585 мм, эмд 555-634 мм. Биеийн жин 2,100-3,200 г хүрнэ.

Эр нь эмээс биеэр жижиг, өнгө зүсээр ижил. Бие гүйцсэн шувууны ерөнхий зүс бор хүрэн, толгой, хоолой хүзүү цайвардуу хул шар, сүүл цагаан ба үзүүр өргөн хар судалтай. Хэвлий бор хүрэн ба судалгүй. Нүд цайвар бор. Хошуу хар бор. Хөл ягаавар цагаан шаргал, хумс хар. Залуу шувуу бие гүйцсэнээс эрс өөр бараан хүрэн зүстэй, нуруу, сүүлний дээд бүрхүүл өд цайвар хүрэн. Далавч бор алаг харагдана.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Нидерланд, Норвег, Финланд, Украин, ОХУ, Израиль, Саудын Араб, Ирак, Иран, Казахстан, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мьянмар, Тайланд, Камбожид тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хөвсгөл нуур (үржлийн тухай тэмдэглэгдсэн, ялангуяа Хороо, Ходон, Бэрх, Алагцар, Жаргалант голын тохойд үржих боломжтой), Увс, Зост, Айраг, Ачит, Хар, Хар-Ус, Дөргөн нуур, Буянт, Чоно Харайх, Ховд, Булган, Завхан, Тамирын гол, мөн Өгий, Бөөнцагаан нуур, Өвөрхангайн Хужирт, Орхон, Туул голын хөндий, Монгол Дагуур, Нөмрөгийн тусай хамгаалалттай газар нутагт тэмдэглэгдсэн. Нүүдлийн үедээ дээрх газруудаас гадна Говь-Алтайн тойрог, Дундад Халхын хээр, Нууруудын хөндийгөөр тохиолдоно. Өгий нуурын хойд эрэгт 1-2 бие гүйцсэн, 2-3 залуу шувуу сүүлийн 10 жил байнга бүртгэгдэж байна (Gombobaatar *et al.*, 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Загасаар баялаг цэнгэг устай нуур, голын ойролцоох навчит болон шилмүүст ой, өндөр хадан цохиотой орчин шүтэж байршина.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг ховор зүйл бөгөөд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд нүүдэллэн ирж, 5-р сарын дундаас үржих боловч үржлийн талаарх мэдээ, баримт хомс. Томоохон гол, нуурын ойролцоох хад, мод дээр модны хуурай иш, мөчир, зэгсээр үүр засаж, цагаан өнгийн 2-4 өндөг гаргана. Эцэг, эх шувууд өндгийг 35-40 орчим хоног дарж ангаахай болгох ба ангаахай 70 орчим хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Залуу шувуу 8-р сарын дунд үе хүртэл эцэг, эх шувуудын хамт байна. Тэд цэнгэг уст нуур, дөлгөөн урсгалт голоос загас барьж хооллоно. Нүүдлийн үедээ нуур ба голын эрэг, мод, модон шонгийн оройд сууж түр амарна. Нүүдлийн болон үржлийн шувууд өвөлжих нутгийг 8-р сарын сүүлчээс 9-р сарын дундуур зорино.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяци 2011 онд 2,500-9,999 бие гүйцсэн бодгаль байсан (BirdLife International 2011) бол 2017 онд 1,000-2,500 болж огцом буурсан

(BirdLife International, 2017) байна. Манай орны хувьд тоо толгойн үнэлгээ хийгдээгүй.

Мал, уул уурхай, аялал жуулчлал, хүн амын төвлөрлийн шууд ба дам нөлөөнөөс үүссэн ус намгархаг орчны доройтол, бохирдол, мөн Өгий болон бусад загастай нууран дахь хэт загасчлал нь энэ зүйл шувууны тоо толгой цөөрөхөд нөлөөлнө. Мөн загасчдын хаясан тор, түймэр зэрэг аюулаас шалтгаалж түүний тоо толгой буурах эрсдэлтэй (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай орны хувьд худалдааны тухай баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), мөн “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

Усны нөмрөгбүргэдийн Монгол орон дахь тархац нутгийн 8.5% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Усны нөмрөгбүргэд (*Haliaeetus leucoryphus*) нь 525.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 105.0 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ЦАГААН ШОНХОР

Falco rusticolus Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Шонхор (*Falconidae*)

НЭРШИЛ:

Англи: Gyr Falcon

Орос: Кречет

Хятад: Mao Sun

Герман: Gerfalke

Франц: Faucon gerfaut

Казах: Ак сүңқар

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Мэдээлэл дутмаг” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.


ТАНИХ ШИНЖ

Биеийн урт эрд 512-540 мм, эмд 510-627 мм. Эрийн далавчны урт 360-382 мм, эмийнх 390-418 мм. Биеийн жин 2,100 г хүрнэ.

Өнгө зүсний 3 (цагаан, хөх саарал, бараан) хувьсалтай. Цагаан хэлбэр нь танан цагаан зүстэй бөгөөд биеийн доод, дээд хэсэг хар, бараан хүрэн жижиг толбо ихтэй. Хөх саарал болон бараан хэлбэр нь идлэг шонхортой тун ижил ч биеийн хэмжээгээр том, хүчирхэг харагдахаас гадна, сахал өд шингэн сийрэг байдаг онцлогтой. Хошууны зэтэр, хөл шар. Залуу шувууд идлэг шонхорын залуу шувуутай тун адилхан ч биеэр том, нуруу хөхвөр туяатай байдгаараа ялгарна.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Канад, АНУ, Мексик, Бразил, Сэнт Пьер ба Микелон, Гренланд, Исланд, Ирланд, Португали, Испани, Их Британи, Франц, Бельги, Нидерланд, Норвег, Герман, Швейцарь, Дани, Австри, Свалбард Ян Майен, Швед, Чех, Польш, Финланд, Латви, Украин, Эстони, ОХУ, Казахстан, Пакистан, Хятад, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол Алтай, Хангай, Хэнтийн тойргийн уул, уулын хээр, голын хөндийд зөвхөн өвлийн улиралд орж ирнэ.



АМЬДРАХ ОРЧИН

Уулын болон ойт хээр, голын өргөн хөндийн хад, цохиотой задгай орчинд байршижтай. Үлийн цагаан, чичүүл зэрэг мэрэгчдийн колонийг дагаж өвөлжинө.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд өвөл орж ирдэг, маш ховор тохиолдох шувуу. Тэд 11-р сарын сүүлчээс ирж 2-р сар хүртэл байршина. Маш цөөн удаа бүртгэгдсэн, баримт байхгүй тул эргэлзээтэй. Өвөлжиж буй зарим эм идлэг шонхорууд цагаан шонхортой маш төсөөтэй харагддаг тул андуурах нь их. Зөвхөн шувуу, хөхтөн амьтдаар хооллоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяци 2011 онд 110,000 бие гүйцсэн бодгальтай байсан (Birdlife International, 2011) бол 2017 онд 20,000-49,999 болж буурсан (BirdLife International, 2017) байна.

Үлийн цагаан оготны тоо толгойг зохицуулах зорилгоор цацсан хоронд хордох, өндөр хүчдэлд цохиулах, утас мөргөж эндэх эрсдэл бий (Gombobaatar et al., 2011).

ХУДАЛДАА

Хувийн болон худалдааны зорилгоор нийт 17 бодгалийг АНЭУ, Саудын Араб улсууд руу 2003, 2008 онд гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), мөн “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

Цагаан шонхорын Монгол орон дахь тархац нутгийн 20.3% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar et al., 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Цагаан шонхор (*Falco rusticolus*) нь 322.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 64.4 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ЭГЭЛ ШОНХОР

Falco peregrinus Tunstall, 1771

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Шонхор (*Falconidae*)

НЭРШИЛ:

Англи: Peregrine Falcon

Орос: Сапсан

Хятад: You Sun

Герман: Wanderfalke

Франц: Faucon pélerin

Казах: Лашын



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Мэдээлэл дутмаг” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 340-580 мм. Далавчны урт 265-390 мм. Биеийн жин эрийн хувьд 330-1,000 г, эмд 700-1,500 г хүрнэ.

Биеийн хэмжээ, галбираар идлэг болон шилийн шонхортой төстэй. Нурууны бараан хөх зүс, цээж бараан хөндлөн судал, толботой, мөн нүднээс доош сунасан тод сахал хэлбэрт тод хар өд нь бусад шонхороос ялгарах шинж болно. Залуу шувуу нь түгээмэл тохиолдох идлэг шонхорын залуу шувуутай ижил ч цээжний тууш судал нарийн, тод хар сахал мэт судал, мөн дэвүүр болон залуур өдний нарийн жигд хөндлөн судал зэргээрээ ялгарна.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Канад, АНУ, Мексик, Гватемал, Сальвадор, Белиз, Гондурас, Никарагуа, Коста-Рика, Куба, Панам, Кайманы арлууд, Перу, Эквадор, Ямайка, Колумб, Чили, Гайти, Багам, Бразил, Аргентин, Венесуэль, Турк ба Кайгосын арлууд, Доминикан,

Араб, Боливи, Нидерланд, Их Британи, Парагвай, Ангила, Сент-Киттс Невис, Монтсерат, Гренада, Антигуа Барбуда, Гваделуп, Гринидад Тобаго, Гайана, Уругвай, Барбадос, Суринам, Бермуд, Гренланд, Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби, Марокко, Сьерра-Леоне, Мали, Либер, Ирланд, Португали, Испани, Алжир, Франц, Гана, Того, Нигер, Бенин, Андорра, Бельги, Нигери, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Габон, Лихтенштейн, Ливийн Жамахири, Экваторын Гвиней, Австри, Конго, Швед, Ангол, Намиби, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Төв Африк, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Ботсвана, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Замби, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Зимбабве, Турк, Молдов, Лесото, ОХУ, Руанда, Танзани, Уганда, Мозамбик, Швейцарь, Кипр, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Коморос, Мадагаскар, Майотте, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапур, Бруней, Австрали, Макао, Хонконг, Тайвань, Филиппин, БНАСАУ, БНСУ, Япон, Палау, Папуа Шинэ Гвиней, Гуам, Шинэ Каледони, Вануату, Фижи, Самоа улсад тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Энэ зүйл нь Их Нууруудын хотгор, Хангай, Хөвсгөл, Хэнтийн тойрог, Хэрлэн-Улз голын сав, Зүүнгарын хотгор, Говь-Алтай, Алтайн Өвөр говиор дамжин нүүдэллэдэг. Хөвсгөл болон Ховдод үрждэг байж болзошгүй (Gombobaatar *et al.*, 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Уулархаг бүс нутаг болон хад, цохио бүхий гол, нуурын хөндийгөөр байршижтай. Нүүдлийн үедээ ой, тал хээр, говь цөлд ч тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Монгол орны хувьд нүүдлийн, зусдаг зүйл бөгөөд маш цөөн тоогоор үрждэг байж болзошгүй. Тэд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд нүүдэллэн ирдэг. Хүүрзгэнэ, тагтаа, усны болон эргийн шувуу, дуучшувуу зэрэг дундаж хэмжээтэй шувуудаар голчлон хооллоно. Зарим үед оготно, хулгана, туулай зэрэг жижиг хөхтөн амьтнаар хооллоно. Ихэвчлэн хавцал хадны ирмэгт үүрлэж, улаан хүрэн толбо бүхий цавар өнгийн 1-5 (гол төлөв 3-4) өндөг гаргаж, 42-46 хоног дарна. Идэш тэжээлийн олдоц, цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэн үед нүүдэллэнэ. Манай оронд өвөлжиж буй тохиолдол бүртгэгдсэн (Gombobaatar *et al.*, 2011).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 100,000-499,999 бие гүйцсэн бодгаль бөгөөд тэдгээрийн тоо толгой тогтвортой байна (BirdLife International, 2017).

Уул уурхайн олборлолт, түймэр, Арабын шонхорчдын тавьсан урхитай тагтаа, үлийн цагаан оготны тоо толгойг цөөрүүлэх зорилгоор ашигласан хор, өндөр хүчдэл зэрэг хүчин зүйлс энэ зүйлийн тоо толгой цөөрөх шалтгаан болно (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Худалдааны зорилгоор нийт 19 бодгалийг 1998, 2001, 2003 онд ОХУ, Итали, Саудын Араб улс руу гаргасан. Хувийн болон худалдааны зорилгоор 2001, 2003 онд 10 бодгалийг импортлосон (CITES-ийн тайлан, 2017) тухай баримт бий.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Эгэл шонхорын Монгол орон дахь тархац нутгийн 8.6% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Эгэл шонхор (*Falco peregrinus*) нь 62.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 12.2 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ



ШИЛИЙН ШОНХОР

Falco peregrinoides Temminck, 1829

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Шонхор (*Falconidae*)

НЭРШИЛ:

Англи: Barbary Falcon

Орос: Рыжеголовый сокол

Хятад: Beifei Sun (Ni Yonsun)

Герман: Wüstenfalke

Франц: Faucon de Barbarie

Казах: Жиренбас сүңқар

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Үнэлэх боломжгүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт эрийн хувьд 354-365 мм, эмд 409.6-435 мм. Эрийн далавчны урт 274-302 мм, эмийнх 312-388 мм. Биеийн жин эрийн хувьд 350 г, эмд 765 г хүрнэ.

Эгэл шонхортой төсөөтэй ч магнай, зулай, шил улбар бор шарга зэргээрээ ялгарна. Нуруу хөхөлбөр саарал. Хэвлий улбардуу шаргал. Залуу шувууны бие жижиг, улбар тууш тод судалтай. Хошууны зэтэр, хөл шар.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Сенегал, Марокко, Мали, Португали, Испани,

Алжир, Буркина Фасо, Нигер, Итали, Тунис, Камерон, Ливийн Жамахири, Мальта, Грек, Судан, Египет, Турк, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Сомали, Джибути, Йемен, Иран, Казахстан, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Балбад тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Их Богд, Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогт-Овоо сум, Баян-Овоо, Дорноговь аймгийн Зүүнбаян сум, Увс аймгийн Завхан сумын Айраг нуур, Булган аймгийн Ингэт толгой, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Ховд голын хөндийд тэмдэглэгдсэн.



АМЬДРАХ ОРЧИН

Цөлөрхөг хээр, говь цөлийн өндөр хадан цохио бүхий орчинд байршина.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн дайрч өнгөрдөг, зусдаг, ховор тохиолдох зүйл. Хавар, намрын нүүдлийн үедээ Монгол орны олон ялгаатай бүсүүдэд бүртгэгдсэн ба өндөр уул, цөлөрхөг хээр болон цөлийн уулсаар үрждэг байх магадлалтай. Гэвч энэ талаар ямар нэг баримт байхгүй. Гол төлөв шувуугаар хооллох ба олзоо ихэвчлэн хурдтай нисэх зуураа барьдаг.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээг 2011 онд 5,000 бие гүйцсэн бодгальтай (Birdlife International, 2011) гэж тогтоожээ.

Уул уурхай, Арабын шонхорчдын тавьсан урхитай тагтаа, өндөр хүчдэл, үлийн цагаан оготны тоо толгойг зохицуулах зорилгоор хэрэглэсэн

хор зэрэг нь түүний тоо толгойг цөөрүүлэх гол шалтгаан болно (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай оронд энэ зүйлийн худалдааны талаарх мэдээ баримт хомс. Арабын орнууд руу идлэг шонхортой андууран гаргасан байх магадлал өндөр байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

Шилийн шонхорын Монгол орон дахь тархац нутгийн 47.7% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Шилийн шонхор (*Falco peregrinoides*) нь 66.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 13.2 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



АЛАГ ТОГОРУУ

Grus japonensis Muller, 1776

Баг: Тогоруу (*Gruiformes*)

Овог: Тогоруу (*Gruidae*)

НЭРШИЛ:

Англи: Japanese Crane (Red-Crowned Crane)

Орос: Уссурийский (Японский) журавль

Хятад: Danding He

Герман: Mandschurenkranich

Франц: Grue du Japon

Казах: Жапон тырна

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Устаж болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Үнэлэх боломжгүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 1,400 мм. Далавчны урт эрд 560-670 мм, эмд 557-635 мм. Биеийн жин 6,000-9,000 г хүрнэ.

Эр ба эмийн өнгө зүс ижил. Бие гүйцсэн шувууны эрүү, хоолой, хүзүү, 2,3-р зэргийн дэвүүр өд хар, дагз, шил, болон биеийн бусад өд цагаан байдгаас алаг харагдана. Дух, зулай улаан арьстай. Хошууны уг цайвар ногоон. Хөл хар. Залуу шувууны толгой, хүзүү бор шаргал. Их биеийн өд цагаан боловч далавчны бүрхүүл өдний эмжээр бор шаргал.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

ОХУ, Хятад, Монгол, Япон, БНАСАУ, БНСУ-д тархсан. Тайваньд тохиолдлын байдлаар бүртгэгдсэн.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Халх гол (Дорнод аймгийн Сүмбэр сум), Хэрлэн гол (Дорнод аймгийн Хөлөнбуйр сум), Улз гол (Дорнод аймгийн Дашбалбар сум), Биндэр нуурт цөөн тоогоор бүртгэгдсэн. 1920-иод оны үед үржлийн талаарх баримт бүртгэгдэж байсан боловч одоо Монгол орны зүүн хязгаараар зөвхөн үржлийн бус бодгалиуд маш ховор тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Дорнод Монголын зэгс, шагшуурга бүхий ус намгархаг орчинд амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн дайрч өнгөрдөг зүйл бөгөөд маш цөөн тоогоор үржлийн бус бодгалиуд зусдаг. Зусах болон дайран өнгөрөх шувууд Монгол орны зүүн хэсэгт 5-р сарын сүүлчээс 6-р сарын эхэнд нүүдэллэн ирж, 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд буцна. Ургамлын үр, нахиа, үндэс болон царцаа, цох, сээр нуруугүйтэн, мэлхий, бах зэргээр хооллоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 1,830 бодгальтай бөгөөд тэдгээрийн тоо толгой буурсаар байна. Малын тооны өсөлт, хадлан, түймэр зэрэг хүний

буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж түүний амьдрах орчин доройтож байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Худалдааны тухай мэдээ, баримт бага.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралт (<http://www.cms.int/en/species>) болон Азийн Улаан ном (2001)-нд орсон.

Алаг тогорууны Монгол орон дахь тархац нутгийн 10.5% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Алаг тогоруу (*Grus japonensis*) нь 733.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 146.6 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ЦАГААН ТОГОРУУ

Grus leucogeranus Pallas, 1773

Баг: Тогоруу (*Gruiformes*)

Овог: Тогоруу (*Gruidae*)

НЭРШИЛ:

Англи: Siberian Crane

Орос: Стерх

Хятад: Bai He

Герман: Schneekranich

Франц: Grue de Sibérie

Казах: Ақ тырна

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд “Устаж байгаа” зүйл (Gombobaatar *et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 1,350 мм. Далавчны урт эрд 599-643 мм, эмд 584-605 мм. Биеийн жин 4,900-8,620 г хүрнэ. Эр нь эмээсээ арай том. Бие гүйцсэн шувууны бие дун цагаан, далавчны үзүүр хар. Нүүр, дух, магнай нүцгэн улаан. Хошуу, хөл улаавар ягаан. Залуу шувууны толгой, биеийн ерөнхий өнгө цагаан боловч бор хүрэн толботой.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

ОХУ, Иран, Азербайджан, Казахстан, БНСУ, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Энэтхэг, Хятад, Монгол, Хонконг, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Өгий (Архангай аймаг), Хайчийн Цагаан, Дөрөө, Булан Шавар, Тарь нуур, Улз (Дорнод аймаг), Туул, Бөхөг, Бөөрөлжүүт гол (Төв аймаг), Буурын гол (Сэлэнгэ аймаг), Булангийн нуур (Хэнтий аймаг), Тэлмэн нуур (Завхан аймаг), Шарга нуурт (Булган аймаг) цөөн тоогоор тэмдэглэгдсэн.



АМЬДРАХ ОРЧИН

Зэгс, шагшуурга, өндөр өвс бүхий ус намгархаг газарт амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн дайрч өнгөрдөг, цөөн тоогоор зусдаг ховор тохиолдох зүйл юм. Зусах болон дайран нисэх шувууд 5-р сарын дундаас сүүлч үед нүүдэллэн ирж, 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд буцна. Ургамлын үр, нахиа, навч, үндэс болон царцаа, цох зэрэг сээр нуруугүйтэн мэлхий, бах зэрэг амьтдаар хооллоно (Gombobaatar et al., 2011).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 3,500-4,000 бие гүйцсэн бодгаль бөгөөд тэдгээрийн тоо толгой буурсаар байна. Малын тооны өсөлт, хадлан, уул уурхай, түймэр, аялал жуулчлал зэрэг хүний үйл ажиллагаанаас голчлон шалтгаалж түүний амьдрах орчин доройтож байна (Gombobaatar et al., 2011).

ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны мэдээ байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016), Азийн Улаан ном (2001)-нд тус тус оржээ.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн байна.

Цагаан тогорууны Монгол орон дахь тархац нутгийн 8.1% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан (Gombobaatar et al., 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Цагаан тогоруу (*Grus leucogeranus*) нь 771.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 154.2 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ЦЭН ТОГОРУУ

Grus vipio Linnaeus, 1758

Баг: Тогоруу (*Gruiformes*)

Овог: Тогоруу (*Gruidae*)

НЭРШИЛ:

Англи: White-naped Crane

Орос: Даурский журавль

Хятад: Baizhen He

Герман: Weissnackenkranich

Франц: Grue à cou blanc

Казах: Қызылсирақ тырна, Даур тырнасы

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 1270 мм. Далавчны урт эрд 510-600 мм, эмд 521-560 мм. Биеийн жин 4,750-6,500 г хүрнэ.

Бие гүйцсэн шувууны биеийн ерөнхий зүс хөхвөр бараан саарал. Сүүл, шил хүзүүний ар хэсэг цагаан. Дух, хацар улаан нүцгэн арьстай бөгөөд сийрэг үс маягийн нарийхан өдтэй. Хошуу шар ногоон. Хөл ягаавар улаан. Залуу шувууны зүс бие гүйцсэн шувуутай бараг адил ч биеийн бүрхүүл өд бор шаргал толбо, өнгөр ихтэй.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

ОХУ, Казахстан, Хятад, Монгол, Тайвань, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Энэ зүйл нь манай орны зүүн хойд, зүүн, төвийн хэсэгт тархсан бөгөөд өндөр өвс, зэгс бүхий задгай нуур, голын хөндийн зэгсэн дунд үржинэ.



АМЬДРАХ ОРЧИН

Нүүдлийн болон зусах үедээ зэгс, өндөр өвс бүхий нуур, голын хөндий болон тариан талбай, хуурай хээрт тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын дундаас манай орны зүүн, зүүн хойд хэсгийн нуур, голын хөндийн өндөр ургамал, зэгс бүхий чийглэг нуга, зэгс бүхий арал дээр нүүдэллэн ирж, шигүү өвс, зэгсэн дунд хуурай өвс, зэгсээр үүр засна. Хүрэн толбо бүхий шаргал ногоон өнгийн 1-2 өндөг гаргана. Өндгийг 30 орчим хоног дарна. Дэгдээхэй 70-75 хоногийн дараагаас нисэж эхэлнэ. 3-4 дэх жилдээ бэлэг боловсорно. Үржлийн улиралд царцаа, голио, усны сээрнууруугүйтэн, хорхой, мэлхий, бах, ургамлын үр, үндэс, нугын ургамлаар хооллоно. Дэгдээхэй том болсон үедээ зэгс, өндөр өвс орчмын хуурай газарт хооллоно. Монголын зүүн хэсгийн бодгалиуд Хятадын Поянг нуурт, ОХУ-ын дагуурын хээрээс нүүдэллэсэн шувууд Хятад, Солонгос, Японд өвөлждөг.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 3,700-4,500 бодгальтай бөгөөд тэдгээрийн тоо толгой буурсаар байна (BirdLife International, 2017). Манай орны хувьд тоо толгойн үнэлгээ хийгдээгүй ч Онон, Улз, Балж, Хэрлэн голын савд 800 бодгаль үржиж, зусдаг бөгөөд дэлхийн популяцийн 40 орчим хувь нь манай оронд амьдарч байна.

Малын тооны хэт өсөлт, чийглэг нугаас хадлан бэлтгэх, уул уурхай, аялал жуулчлалын бааз

байгуулах, аялал жуулчлал, машины хөдөлгөөн олширох, амьдрах орчин бохирдох зэрэг хүний буруутай үйл ажиллагаанаас голчлон шалтгаалж цэнгэг уст нуур, усан сангийн зэгс сүйтгэгдэж, ойр орчмын газар хуурайшиж, шувуудын амгалан тайван байдал алдагдаж байгаа нь энэ зүйлийн тоо толгой буурах гол шалтгаан болж байна. Өндөг, дэгдээхэй малын хөлд гишгэгдэх, нохой, бүргэд, үнэг, хярс зэрэг махчдад бариулах зэргээс шалтгаалан түүний тоо толгой цөөрч байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

ЗХУ-ын амьтны хүрээлэн рүү 4 бодгалийг 1981 онд гаргаж (CITES-ийн тайлан, 2017) байжээ.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол улсын Улаан ном (2013; 2016), Азийн Улаан ном (2001)-нд тус тус орсон.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн байна.

Цэн тогорууны Монгол орон дахь тархац нутгийн 9.9% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Цэн тогоруу (*Grus vipio*) нь 680.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 136.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ХАР ТОГОРУУ

Grus monacha Temminck, 1835

Баг: Тогоруу (*Gruiformes*)

Овог: Тогоруу (*Gruidae*)

НЭРШИЛ:

Англи: Hooded Crane

Орос: Чёрный журавль

Хятад: Baitou He

Герман: Mönchskranich

Франц: Grue moine

Казах: Қара тырна

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 910-1000 мм. Далавчны урт эрд 479-525 мм, эмд 453-560 мм. Биеийн жин 3,110-4,870 г хүрнэ.

Бие гүйцсэн шувууны биеийн ерөнхий зүс хар саарал. Шанаа, дагз, хоолой, хүзүүний дээд хэсэг цагаан, дух, зулай нүцгэн улаан арьстай. Дэвүүр болон залуур өд хар. Хошуу ногоовор шаргал. Хөл хар. Залуу шувуу бие гүйцсэнтэйгээ төсөөтэй

ч биеийн ерөнхий өнгө хар саарал бөгөөд бор шаргал толбо, өнгөр ихтэй.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

ОХУ, Казахстан, Энэтхэг, Хятад, Монгол, Тайвань, БНАСАУ, БНСУ, Японд тархжээ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Завхан, Урд тамир гол, Өгий нуур (Архангай аймаг), Хутаг өндөр сум (Булган аймаг), Онгийн гол, Арвайхээр хот (Өвөрхангай аймаг), Хэрлэн гол, Сүмбэрийн цагаан нуур, Ташгайн Таван нуур, Дөрөө нуур, Галуут нуур, Хайчийн цагаан нуур, Тарь нуур, Монгол Дагуур, Угтам, Дөч, Улз голын хөндий, тариалангийн талбай (Дорнод аймаг), Баянжаргалан сум (Төв аймаг), Орхон, Тамир гол (Сэлэнгэ аймаг), Цагаан сум, Ар Хонгор нуур (Хэнтий аймаг), Орог нуур (Баянхонгор аймаг), Шарга нуур (Булган аймаг), Хороо голд (Хөвсгөл аймаг) бүртгэсэн.



АМЬДРАХ ОРЧИН

Нүүдлийн болон зусах үедээ зэгс, өндөр усны ургамал бүхий нуур, голын хөндий болон тариан талбайд тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Үржлийн бус бодгалиуд манай оронд зусах, эсвэл нүүдлийн үедээ дайрч өнгөрөх байдлаар тохиолдоно. Эдгээр шувуу цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан 4-р сарын дундаас 5-р сарын дунд үед нүүдэллэн ирж, 9-р сарын сүүлчээс 10-р сарын эхэн үед буцдаг. 3-4 наснаас үржилд орж эхэлнэ. Улз ба Хурх голын хөндийн тариан талбайд 1990 онд 700, 1991 онд 2,079, 1992 онд 107, 1994 онд 1,891, 1994 онд 1,000 орчим бодгаль бүртгэгдэж байсан. Энэ зүйл тогоруу ургамлын үр, жимс, үндэс, шавж, мэлхийгээр хооллоно. Харин өвлийн цагт нийт популяцийн 80 хувь нь Японы Изуми (Izumi)-д өвөлжинө.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 2011 онд 2,500-9,999 бие гүйцсэн бодгаль байсан бол өдгөө 6,000-15,000 болжээ (BirdLife International, 2017). Харин манай орны хувьд тоо толгой буурч Улз,

Хурх голын савд ердөө 30-100 бодгаль бүртгэгдэх болсон.

Гэрийн мал, хадлан, уул уурхай, түймэр, аялал жуулчлал, уур амьсгалын өөрчлөлт, орчны бохирдол зэрэг хүний буруутай үйл ажиллагаанаас голчлон шалтгаалж цэнгэг уст нуур, усан сангийн зэгс сүйтгэгдэж, ойр орчмын газар хуурайшиж, шувуудын амгалан тайван байдал алдагдаж байгаа нь энэ зүйлийн тоо толгой буурах гол шалтгаан болж байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай оронд худалдааны талаарх баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол улсын Улаан ном (2013; 2016), Азийн Улаан ном (2001)-нд тус тус орсон.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн байна.

Хар тогорууны Монгол орон дахь тархац нутгийн 10.2% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хар тогоруу (*Grus monacha*) нь 610.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 122.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ЖОРОО ТООДОГ (ЖОРОО ТООДГОЙ)

Chlamydotis macqueenii Gray, 1832

Баг: Торопуу (*Gruiformes*)

Овог: Тоодог (*Otididae*)

НЭРШИЛ:

Англи: Huobara Bustard

Орос: Дрофа-красотка (Джек)

Хятад: Boban Bao

Герман: Steppenkragentrappe

Франц: Outarde de MacQueen

Казах: Джек, Жеж дуадақ

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 550-650 мм. Далавчны урт эрд 354-430 мм, эмд 325-385 мм. Биеийн жин эрийн хувьд 2,400 г бол эмийнх 1,700 г хүрнэ.

Бие гүйцсэн шувууны биеийн дээд хэсэг бор шаргал, хэвлий цайвар. Толгойдоо залаа хэлбэрийн урт өдтэй. Орооны үед эрэгчний энэ өд илүү урт болно. Чихний араас хүзүүний хоёр талыг дагасан урт хар судалтай. Нисэх үед далавчны дээрх том цагаан толбо тод харагдана. Залуурын захын таван өд цагаан, ирмэгээс дотогш хөндлөн хар судалтай. Залуу шувуу эхний намар эм шувуутай бараг адил. Хошуу бор саарал, үзүүртээ хар. Хөл бор ногоон.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Мавритани, Марокко, Португали, Испани (Канарын Арал.), Алжир, Их Британи, Франц, Бельги, Нидерланд, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Ливийн Жамахири, Швед, Чех, Словени, Польш, Мальта, Словак, Грек, Румын, Финланд, Латви, Судан, Украин, Египет, ОХУ, Кипр, Израиль, Саудын Араб, Палестин, Йордан, Ливан, Сири, Ирак, Йемен, Армэн, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Хятад, Балба, Монгол, Бутанд тархсан. Туркэд устсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Дундсайхан уул (Өмнөговь аймаг), Их Богд (Баянхонгор аймаг), Бяруухайн булагт (Борзонгийн говь) үрждэг. Нүүдлийн үедээ Цагаан Богд, Шар дэрсний ус, Хяргас, Дөргөн болон Бөөнцагаан нуур, Тайшир-Сэрх, Бөхмөрөн гол, Ачит нуур, Ховд гол (Ховд хотын орчимд), Ботгон гол, Цэцэг нуур, Шаргын говь, Тэхийн ус, Цагаан Бургас, Баянзаг, Гурвансайхан, Арц Богд, Умдайн гол, Зээрэгтийн хөндий, Улаан нуур, Булган, Ноён, Манлай болон Хатанбулаг сум, Баянтооройн Сангийн далай (Өмнөговь аймаг), Ар хөдөө, Тарын голын нарийн ус, Дарви уул, Цагаан дуулгат булаг, Бөхмөрөн сум (Увс аймаг), Эрдэнэбүрэн сум (Ховд аймаг), Лүн сум (Төв аймаг), Биндэр нуурт (Хэнтий аймаг) тэмдэглэгдсэн.



АМЬДРАХ ОРЧИН

Говь цөлийн бут, сөөглөг ургамал бүхий дагжуур, хайргархаг хөрстэй орчин амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд нүүдэллэн ирнэ. Хайргархаг хөрстэй цөлөөр нутаглах ба ойр орчимдоо армаг тармаг бут, сөөгөөр хүрээлэгдсэн хайргыг бага зэрэг хонхойлон үүр засаж, 6-р сарын эхээр улаан хүрэн, саарал толбо бүхий ногоовор бор өнгийн 3-6 өндөр гаргана. Эм шувуу өндөгнүүдийг 21-26 хоног дарах ба дэгдээхэй өндөгнөөс гарснаас хойш 35 дахь хоногоос эхлэн бие даан амьдарна. Царцаа, голио, цох болон ургамлын үр, навч, нахиагаар хооллоно. Идэш тэжээлийн олдоц, цаг агаарын нөхцөлөөс хамааран 8-р сарын сүүлчээс 10-р сарын эхэнд өвөлжих нутагруугаа нүүдэллэнэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 13,000-33,000 бие гүйцсэн бодгаль бөгөөд тэдгээрийн тоо толгой буурсаар байна (BirdLife International, 2017). Монгол орны популяци 200-300 буюу түүнээс бага (Болд, Цэвээнмядаг, 2001). Галбын говьд 6-р сард

хамгийн их буюу 0.22 бодгаль/км² нягтшилтай, 4-р сард хамгийн бага буюу 0.03 бодгаль/км² нягтшилтай (Нямбаяр нар, 2010) байжээ.

Энэ зүйлийн үржлийн болон хооллох нутагт малын нөлөө их бөгөөд уул уурхай, дэд бүтэц, заган ойн ашиглалт зэрэг нь түүний үржлийн амжилтанд шууд болон дам байдлаар нөлөөлснөөр тэдгээрийн тоо толгойг цөөрөх аюулд хүргэж байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны талаар тодорхой баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн байна.

Жороо тоодгийн Монгол орон дахь тархац нутгийн 27.7% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Жороо тоодог (*Chlamydotis macqueenii*) нь 210.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 42.0 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



РЕЛИКТ ЦАХЛАЙ

Larus relictus Loennberg, 1931

Баг: Хиазтан (*Charadriiformes*)

Овог: Цахлай (*Laridae*)

НЭРШИЛ:

Англи: Relict Gull

Орос: Реликтовая чайка

Хятад: Yi Ou

Герман: Reliktmöwe

Франц: Mouette relique

Казах: Қарамойнақ шағала

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Эмзэг”, бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй” зүйл (Gombobaatar *et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 390-450 мм. Биеийн жин эрийн хувьд 470-575 г, эм 420-488 г хүрнэ.

Хүрэн толгойт цахлайтай ижил ч, хошуу бахим, толгой хар хүрэн, нүд тойрсон өргөн цагаан цагирган хүрээтэй байдгаараа ялгагдана. Нэгдүгээр зэргийн дэвүүрийн үзүүр далавчаа нугалж суух үед харьцангуй том цагаан толбо илт ялгагдана. Хошуу болон хөл улаан. Залуу шувууны хошуу, хөл хар, харьцангуй бахим

биетэй, далавчны төгсгөл орчимд бараан саарал том толботой.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Болгар, Орос, Казахстан, Солонгос, Киргиз, Хятад, Монгол, Вьетнам, Хонконг, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол орны олон газарт бүртгэгдсэн боловч Увс, Лаг, Ихэс нуурт (Говь-Алтайн Дарви сум) цөөн тоогоор үрждэг. Таацын цагаан болон Орог нуур (Нууруудын хөндий), Хөх, Тарь, Тоорой нуурт үрждэг байсан. Ихэс, Бөөнцагаан, Бүс, Галуут болон Хайчийн цагаан нуурт үрждэг байж болзошгүй. Нүүдлийн үедээ дээрх нууруудаас гадна, Хяргас, Айраг, Хар-Ус, Хар, Дөргөн, Адгийн Цагаан, Сангийн далай, Өгий, Тэрхийн Цагаан, Хур, Талын Таваг, Сүмийн Цагаан, Дөрөө, Ангирт, Шорвог, Цайдам, Хорын Цагаан, Чух, Буйр, Баян нуур, Булган голд тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Гүехэн устай цэнгэг болон давстай нуурын арал, ус руу түрж орсон хошуу дээр колониор үүрлэнэ.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны нүүдлийн өндөглөдөг зүйл. Тэд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд нүүдэллэн ирж, 5-7-р сард колониор үрждэг. Хуурай өвс, зэгсээр газар дээр үүр засаж, бараан, улаан хүрэн толбо бүхий цайвар ногоон өнгийн гол төлөв 3, ховор тохиолдолд 4-5 өндөг гаргана. Хосууд өндгөө ээлжлэн 24-26 хоног дарж дэгдээхэй болгоно. Дэгдээхэй ба бие гүйцсэн шувууд усны сээр нуруугүйтэн болон жижиг загасаар хооллоно. Дэгдээхэй сар хагасын дараа нисэх чадвартай болох ба үржлийн улирлын дараагаас залуу болон бие гүйцсэн шувууд 3-60 тоотой сүрэг үүсгэн, идэвхтэй хооллодог. Намрын нүүдэл 8-р сарын сүүлчээс 9-р сарын дунд үе хүртэл явагдана.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээг 10,000-19,999 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн. Манай оронд хамгийн ихдээ 300-400 бие гүйцсэн бодгаль байх боломжтой бөгөөд түүний тоо толгой буурч байна.

Тархалт нутгийн хүрээнд нүүдлийн мал аж ахуй, уул уурхай, уур амьсгалын дулаарал, Чоно Харайх ба Завхан голд баригдсан усан цахилгаан станцын шууд ба дам нөлөөнөөс улбаатай амьдрах орчны доройтол, тэжээлийн хомсдол, хууль бус загас агнуур зэрэг нь түүний тоо толгойг цөөрүүлэх шалтгаан болж байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор нийт 4 дээжийг 2008 онд АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) баримт бий.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016), Азийн Улаан ном (2001)-нд тус тус оруулсан.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн нэгдүгээр хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэгдүгээр хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус оржээ.

Реликт цахлайн Монгол орон дахь тархац нутгийн 13.1% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Реликт цахлай (*Larus relictus*) нь 171.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 34.2 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ХАЛБАГАН ХОШУУТ (ЦАГААН ХАЛБАГАНТ)

Platalea leucorodia Linnaeus, 1758

Баг: ӨРӨВТАС (*Ciconiiformes*)

Овог: Билүүс (*Threskiornithidae*)



НЭРШИЛ:

Англи: Eurasian Spoonbill (Spoonbill, White/European/Common Spoonbill)

Орос: Колпица (Обыкновенная колпица)

Хятад: Bai Pilu

Герман: Löffler

Франц: Spatule blanche

Казах: Жалбағай

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Эр, эмийн биеийн хэмжээ ижил. Биеийн урт 86 см, далавчны дэлгэмэл 115-120 см, тарс 120-160 мм, хошууны урт 180-223 мм хүрнэ. Биеийн жин 1,700 г.

Эр, эм ижил зүстэй. Бие гүйцсэн бодгалийн зүс танан цагаан ба үржлийн зүстэй шувууны хоолой орчим, толгойн өрөвлөг шаргал. Хошууны үзүүр өргөссөн халбага хэлбэрийн хавтгай, хар. Хөл хар. Тэдний нэгдүгээр зэргийн дэвүүрийн үзүүр, түүний гадаад өрөвлөг хар. Залуу шувуу толгой дээрээ өрөвлөггүй, хошуу бор байдгаараа бие гүйцсэн бодгалиас ялгагдана.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Бразил, Гринидад Тобаго, Исланд, Кабо-Верде, Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби, Марокко, Мали, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Фароз Арлууд, Бахрейн, Буркина Фасо, Франц, Нигер, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Ливийн Жамахири, Конго, Швед, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Босни, Унгар, Словак, Монтенегро, Серб, Албани, Грек, Румын, Македони, Финлянд, Латви, Судан, Украин, Болгар, Египет, Турк, Молдов, ОХУ, Уганда, Кипр, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб,


Йордан, Ливан, Сири, Ирак, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайжан, Казахстан, Кувейт, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Мальдив, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Мянмар, Тайланд, Хонконг, Тайвань, БНСУ, Японд тархсан. Австри улсад устсан байж болзошгүй.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙШИЛ НУТАГ

Увс нуур, Тэс, Торхилог гол (Увс нуурын хотгор), Баян нуур (Алтан элс), Хар-Ус, Хар нуурт (Их Нууруудын хотгор) үрждэг. Орог нуурт үрждэг байв. Нүүдлийн үедээ Ховд гол, Толбо, Ачит, Үүрэг нуур (Монгол-Алтай), Увс нуур, Тэс, Торхилог гол (Увсын нуурын хотгор), Хар-Ус, Хар, Дөргөн, Хяргас, Айраг нуур, Ховд голын зэгстэй тохой (Их Нууруудын хөндий), Завхан, Тамир, Орхон гол, Сангийн Далай, Өгий нуур (Хангайн тойрог), Тэрхийн Цагаан, Сангийн Далай нуур

(Тарвагатай-Булнайн нуруу), Хөвсгөл нуур, Эгийн гол (Хөвсгөл тойрог), Орхон, Сэлэнгэ гол (Орхон-Сэлэнгийн сав), Онон, Балж, Хэрлэн, Туул гол (Хэнтий тойрог), Бөөнцагаан, Таацын Цагаан нуур (Нууруудын хөндий), Халх голын сав, Буйр нуураар тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Зэгс шагшуургатай томоохон нуурын арал, голын цутгал, салаа зэрэг харьцангуй бөглүү газарт үүрлэнэ. Хооллохдоо гүехэн устай, шавж ихтэй усыг сонгоно. Нүүдлийн үедээ тал хээрийн элдэв усан сангийн орчим таарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд үржлийн болон зусах нутагтаа ирж, 5-р сарын эхээр зэгс шагшуургатай томоохон нуурын арал, голын цутгал, салаа зэрэг зэгс, бургас бүхий бөглүү газарт зэгсний иш, өвс, мөчрөөр үүр засна. Улаан хүрэн толбо бүхий цагаан өнгийн гол төлөв 4-5 өндөг гаргаж, 24-25 хоног дарж ангаахай болгоно. Цох, соно, ялаа, царцаа болон усны шавж, авгалдай, зөөлөн биетэн, хавч хэлбэртэн, чийгийн улаан хорхой, хануур хорхой, мэлхий, шанаган хорхой, 10-15 см хүртэлх хэмжээтэй жижиг загас болон замаг, усны ургамлаар хооллоно. Үржлийн бус 4-9 бодгаль зусах үедээ гол төлөв нуур, голын эргийн гүехэн устай хэсэгт тохиолдоно. Нүүдлийн үедээ ганц нэгээр, хосоор, эсвэл 6-200 бодгаль бүхий сүргээр том нуур, заримдаа томоохон голын хөндийгөөр таарна. Намрын нүүдэл идэш тэжээлийн олдоц, цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхээр үргэлжилнэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээг 2011 онд 66,000-140,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2011) гэж үнэлжээ. Манай орны популяцийн талаар үнэлгээ хийгдээгүй ба нийт 600-700 орчим үржлийн хос Увс нуурын хотгорт үрждэг (Болд, Цэвээнмядаг, 2001) гэсэн баримт бий.

Малын тооны хэт өсөлт, уул уурхай, усан цахилгаан станцтай холбоотой гол, нуурын экосистемийн тэнцвэр алдагдах, усны бохирдол, хуурайшилт, ширгэлт зэрэг амьдрах орчны доройтол, өвөрмөц хэлбэртэй хошууг авах, чихмэл хийх зорилгоор хууль бусаар агнах, мөн Хөвсгөл, Өгий зэрэг нуурын усанд хаясан загасны торонд орж эндэх зэрэг хүний шууд нөлөөллөөс шалтгаалан энэ зүйлийн тоо толгой буурч байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай орны хувьд гадаад худалдааны мэдээ баримт байхгүй байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), мөн “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус оржээ.

Халбаган хошуутын Монгол орон дахь тархац нутгийн 9.6% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байгаа бөгөөд түүний үржлийн болон зусч байршдаг Увс нуур, Хар-Ус, Хар, Хяргас, Тэрхийн цагаан нуур зэргийг улсын тусгай хамгаалалтад авч, Өгий, Орог, Бөөнцагаан зэрэг нууруудыг “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д оруулаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Цагаан халбагант (*Platelea leucorodia*) нь 110.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 22.0 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ХАР ӨРӨВТАС

Ciconia nigra Linnaeus 1758

Баг: ӨРӨВТАС (*Ciconiiformes*)

Овог: Өрөвтас (*Ciconiidae*)



НЭРШИЛ:

Англи: Black Stork

Орос: Чёрный аист

Хятад: Hei Guan

Герман: Schwarzstorch

Франц: Cigogne noire

Казах: Кара дегелек

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ


Эр нь эмээс биеэр арай том. Биеийн урт 950-1,000 мм. Далавчны урт 520-585 мм, хошуу 180-195 мм, тарс 185-195 мм. Биеийн жин 3,000 г хүрнэ.

Эр ба эм бодгаль ижил зүстэй. Бие гүйцсэн шувууны хэвлий цагаан. Нуруу, хүзүү, толгой, гүеэ, далавч, сүүл металлын ногоон туяатай хар. Хошуу, нүдийг тойрсон нүцгэн арьс, хөл улаан. Залуу бодгаль бие гүйцсэнтэй төсөөтэй ч бүдэг зүстэй төдийгүй хошуу, хөл цайвардуу ногоон байдгаараа ялгаатай.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Кипр, Сенегал, Мавритани, Гвиней, Марокко, Португали, Испани, Алжир, Гибралтар, Франц, Того, Бельги, Нигери, Нидерланд, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Хятад, Тунис, Дани, Ливийн Жамахири, Австри, Швед, Ангол, Намиби, Чех, Словени, Польш, Мальта, Хорват, Төв Африк, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Ботсвана, Грек, Румын, Македони, Латви, Литва, Судан, Замби, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Зимбабве, Турк, Молдов, Лесото, ОХУ, Танзани,


Уганда, Мозамбик, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бутан, Мьянмар, Тайланд, Лаос, Вьетнам, Хонконг, Тайвань, БНАСАУ, БНСУ, Японд тархсан. Гамби, Мали, Ирланд, Их Британи, Буркина Фасо, Гана, Бенин, Нигер, Норвег, Камерон, Лихтенштейн, Конго, Чад, Финланд, Руанда, Сомали, Кувейт, Оман, Эмиратад тохиолдлын байдлаар үзэгдэнэ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Буянт, Булган, Ховд гол, Хотон, Дунд, Ачит, Үүрэг нуур (Монгол-Алтай), Увс нуур, Тэс ба Торхилог голын адаг (Увс нуурын хотгор), Хар-Ус нуурын Улаан уул, Хар Ямаат уул, Хар, Дөргөн, Хяргас,

Айраг нуур, Ховд голын адаг (Их Нууруудын хотгор), Завхан, Хүнгүй гол, Их Богд (Говь-Алтай), Идэр, Чулуут, Тамир, Орхон гол, Сангийн Далай, Өгий нуур (Хангайн тойрог), Тэрхийн Цагаан, Сангийн Далай, Тэлмэн, Хар нуурын сав (Тарвагатай-Булнайн нуруу), Хөвсгөл нуур, Эгийн гол (Хөвсгөл тойрог), Шишгид гол, Доод Нуур (Дархадын Хотгор), Орхон, Сэлэнгэ, Эг, Хараа, Ерөө гол (Орхон-Сэлэнгийн сав), Туул, Онон, Балж, Хэрлэн Гол (Хэнтий тойрог), Улз, Дөч гол (Хэрлэн-Улз голын сав), Халх, Дэгээ, Нөмрөг, Азарга гол (Буйр нуур-Халх гол-Хянган), Байдраг, Галуут нууранд үржинэ. Нүүдлийн үедээ ойт хээр, хээр болон говийн баянбүрдээр тааралдана (Gombobaatar *et al.*, 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Загас, усны амьтан элбэгтэй гол, нуур, ус намгархаг газар, тэдгээрийн хөндийн хад цохио, сийрэг ойд амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын дундаас 5-р сарын сүүлчээр нүүдэллэн ирдэг. Энэ үедээ гол төлөв 3-10 тоогоор сүрэглэнэ. Ойт хээр, нуур, голын хөндийд загас, хоёрнутагтан, усны сээр нуруугүйтэн ихтэй задгай усны орчимд мод, эсвэл хадан дээр үүрлэнэ. Үүрээ модны иш, мөчир, зэгс зэргээр барьж олон жил ашигладаг тул хэмжээ нь томордог. Голдуу 5-р сарын эхээр 3-5, ховор тохиолдолд 2, эсвэл 6 ширхэг цагаан өндөг гаргаж, 30-35 хоног дарж ангаахай болгоно. Жижиг мэрэгч, шувууны ангаахай, мэлхий, бах, жижиг ба дунд зэрэг хэмжээтэй загас, усны сээр нуруугүйтнээр хооллоно. Ангаахай өндөгнөөс гарснаас хойш 63-71 хоногийн дараа нисэх чадвартай болно. Үржлийн бус бодгалиуд загас, бусад идэш тэжээлээр баялаг томоохон нуур, гол, усан сангийн орчимд зусна. 9-р сарын эхээс 10-р сарын эхэнд нүүдэллэх ба энэ үедээ ойт хээрээс говь цөл хүртэл гол, нуур, ус намагт хөндий, түүний орчимд байршина (Gombobaatar *et al.*, 2011).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээг 2006 онд 24,000-44,000 бие гүйцсэн бодгаль (Birdlife International, 2006) хэмээн үнэлсэн. Түүнээс хойш тоо толгойн үнэлгээ хийгдээгүй. Манай оронд 1,000-1,500 бодгаль бий (Болд, Цэвээнмядаг, 2001) гэж үздэг.

Малын тооны хэт өсөлт, уул уурхай, гол, нуурын экосистемийн бохирдол, хуурайшилт, усан цахилгаан станцтай холбоотой амьдрах орчны доройтол болон өвөл, зуны загасчлал зэрэг хүний олон талт шууд нөлөөнөөс шалтгаалан энэ зүйлийн тоо толгой буурч байна.

ХУДАЛДАА

Одоогоор манай орны хувьд гадаад худалдааны мэдээ баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>) болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Хар өрөвтасын Монгол орон дахь тархац нутгийн 9.6% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хар өрөвтас (*Ciconia nigra*) нь 204.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 40.8 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ЯГААН НАЛ (НАЛ ДЭГЛИЙ)

Phoenicopterus roseus Pallas, 1811

Баг: Налтан (*Phoenicopteriformes*)

Овог: Налынхан (*Phoenicopteridae*)

НЭРШИЛ:

Англи: Greater Flamingo

Герман: Roseflamingo

Орос: Розовый фламинго

Франц: Flamant rose

Хятад: Da Hongguan

Казах: Қоқиқаз

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Үнэлэх боломжгүй” зүйл (Gombobaatar *et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн өндөр 110-150 см, далавчны дэлгэмэл 135-170 см, далавч 680-720 мм, тарс 260-370 мм, хошуу 115-135 мм. Биеийн жин 2,000-4,000 г хүрнэ. Өндөр хөлтэй, хүзүү урт, хошуу өвөрмөцөөр тахийн унжсан.


Их бие цагаан ч усан ягаан эсвэл сарнайн ягаан туяа бүхий өнгөртэй. Ягаан зүс хүзүү, зулай, нуруу, сүүл хэсэгт тодорно. Дэвүүрийн 1 ба 2-р зэргийн өд хар. Хөгшин бодгаль бусдаас тод ягаан харагдах

ба идэш тэжээлийн онцлогоос шалтгаалж ерөнхий зүс нь цайвардуу эсвэл ягаавтар харагдана. Хошуу бүхэлдээ тод ягаан ба үзүүр нь хар. Хөл тод ягаан. Залуу шувуудын зүс цайвар ч хүзүү, нуруу болон далавчны дээд хэсэг бор хүрэн, бор саарал ба хошуу эврэн саарал. Хөл бор саарал.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Канад, АНУ, Мексик, Белиз, Куба, Кайманы арлууд, Эквадор, Ямайка, Колумб, Гайти, Багам, Бразил, Венесуэль, Турк, Доминикан, Аруба, Нидерландын Антилез, Пуэрто Рико, Виржиний арлууд, Сент-Киттс Невис, Гваделуп, Гринидад Тобаго, Гайана, Сент Люсиа, Суринам, Францын Гайана, Бермуд, Кабо-Верде, Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби, Гвиней, Марокко, Сьерра-Леоне, Португали, Испани, Алжир, Гибралтар, Франц, Нигер, Бельги, Норвег, Герман,

Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Сан-Томе Принсипи, Ливийн Жамахири, Экваторын Гвиней, Австри, Конго, Швед, Ангол, Намиби, Чех, Словени, Польш, Мальта, Хорват, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Ботсвана, Грек, Румын, Финланд, Латви, Судан, Замби, Болгар, Египет, Турк, Лесото, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Швейцарь, Кипр, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Сомали, Джибути, Йемен, Коморос, Мадагаскар, Зимбабве, Армен, Иран, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Сейшел, Узбекистан, Мавритан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Мальдив, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Камбожид тархсан. Антигуа Барбуда, Туркменистанд утсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хар-Ус нуурт цөөн бодгаль 1947 онд, мөн Дархадын Хотгорын Шишгид голд 3 бодгаль тэмдэглэгдэж байсан (Gombobaatar *et al.*, 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Цэнгэг болон давсархаг устай нуур, цөөрмийн эрэг орчмын гүехэн устай хэсгээр байршилттай.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд тохиолдлын байдлаар оржирдэг зүйл. Монгол орны баруун, хойд хэсгийн томоохон нуурын эрэгт тэмдэглэгдсэн (Gombobaatar *et al.*, 2011). Нуурын ёроолоос артем, зөөлөн биетэн, усны шавж, өт, авгалдай, жижиг загас, замаг, цахиурт замаг зэргийг өвөрмөц хавтгай том хушуугаараа шүүж хооллоно. Үржлийн бус үедээ 100 буюу түүнээс олон тоогоор сүрэглэдэг (Del Hoyo *et al.*, 1992).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээг 550,000 - 680,000 бие гүйцсэн бодгаль (Wetlands International, 2015) хэмээн үнэлсэн.

Хүний нөлөөнөөс улбаатай ус намгархаг газрын бохирдол, доройтол, хууль бус агнуураас шалтгаалж энэ зүйлийн тоо толгой буурч байна.

ХУДАЛДАА

Одоогоор манай орны хувьд гадаад худалдааны мэдээ баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>) болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Ягаан нал (*Phoenicopterus roseus*) нь 84.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 16.8 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



БАЙГАЛИЙН НУГАС

Anas formasa Georgi, 1775

Бар: Галуу (*Anseriformes*)
Овог: Нугас (*Anatidae*)

НЭРШИЛ:

Англи: Baikal teal

Орос: Чирок-клоктун

Хятад: Hualian Ya

Герман: Gluckente

Франц: Sarcelle élégante

Казах: Қырылдақ шүрегей

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Харьцангуй жижиг нугас. Биеийн урт 39-43 см, жин 500-600 г. Бие гүйцсэн эрийн толгойд тал сар мэт тод ногоон, хацрын цайвар шарга толбыг нүднээс доош буусан хар судал дундуур нь хуваана. Цээж улбар, биеийн хажуу, сүвээ, хэвлий-саарал, нуруу-бор хүрэн, сүүлний доод өд хар, цээж, хэвлий, сүүлний доод өдүүдийг тусгаарласан 2 хөндлөн цагаан зураастай. Далавч хар, ногоон хосолсон тольтой. Бие гүйцсэн эм бодгалийн зүс бор. Толгойн дээд хэсэг илүү бараан, хөмсөг улбар шар, нүд дайрсан хар бараан зураастай. Нүдний урд, хушууний уганд, хацар дээрээ бөөрөнхий цагаан толбоор бусад нугаснуудаас ялгагдана.

Далавч дээрээ эрийн адил тольтой.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Испани, Франц, Нидерланд, Итали, Мальта, ОХУ, Казахстан, Узбекистан, Пакистан, Энэтхэг, Хятад, Балба, Монгол, Мянмар, Тайланд, Хонконг, Тайвань, БНАСАУ, БНСУ, Японд тархсан. Бангладешт тохиолдлын байдлаар таарна.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хөвсгөлийн Их Далбаа, Төв аймгийн Лүн сум, Орхон, Сэлэнгэ мөрөн, Цагаан Нуур, Онон, Балж, Хэрлэн, Улз, Дөч гол, Хөх, Дөрөө, Галуут, Бүс, Сүүжийн Цагаан, Хайчийн Цагаан, Хорийн Цагаан, Дэлгэр, Цагаан нуур (Монгол Дагуур), Халх, Нөмрөг гол, Буйр нуур, Ташгайн Таван нуурт (Буйр-Халх гол-Хянган) тэмдэглэгдсэн (Gombobaatar et al., 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Нүүдлийн үедээ томоохон нуур, цөөрөмд бусад нугасны хамт таарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдэллэн өнгөрдөг ховор зүйл бөгөөд Монгол орны зүүн хэсгээр 4-р сарын сүүлчээс 6-р сарын эхэн үед дамжин өнгөрдөг. Энэ хэсгээр намрын нүүдлийн үе буюу 9-р сарын эхээс 10-р сарын дунд хүртэлх хугацаанд зөвхөн залуу шувууд бүртгэгдсэн. Тэд нүүдлийн үедээ цагаанхөмсөг, шовтгоралаг зэрэг нугастай хамт цэнгэг болон давст нууруудаар байршдаг. Усны болон хуурай газрын ургамал, түүний үндсээр хооллох ба намрын нүүдлийн үедээ бусад нугасны хамт тариалангийн талбайд ч тохиолдоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ тодорхой бус. 2004 онд БНСУ-д 455,000-658,000, Хятадад 50-10,000, ОХУ-д 10,000-100,000 бие гүйцсэн бодгаль бий (IUCN Redlist, 2017) гэж тооцоолсон байна.

Тоо толгой буурах гол шалтгаан нь мал аж ахуй, уул уурхайн шууд ба дам нөлөөнөөс үүдэлтэйгээр нуур, гол орчмын зэгс, ургамал талхлагдсаны улмаас үүссэн амьдрах орчны доройтол юм. Мөн нуурын усанд хаясан загасны торноос шалтгаалан

хорогдохоос гадна, махыг хүнсний, өдийг нь гоёл чимэглэлд ашиглах зорилгоор хууль бусаар агнана (Gombobaatar et al., 2011; Гомбобаатар, Одхүү, 2018).

ХУДАЛДАА

Одоогоор манай орны хувьд гадаад худалдааны талаар мэдээ баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int>) тус тус бүртгэлтэй.

Байгалийн нугасны Монгол орон дахь тархац нутгийн 9.8% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан байна (Gombobaatar et al., 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Байгалийн нугас (*Anas formasa*) нь 143.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 28.6 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ЯМААНСҮҮЛТ НУГАС (ЦАГААНТОЛГОЙТ ЯМААНСҮҮЛ)

Oxyura leuccephala Scopoli, 1769

Баг: Галуу (*Anseriformes*) Овог: Нураг (*Anatidae*)

НЭРШИЛ:

Англи: White-headed Duck

Орос: Савка

Хятад: Baitou Yingweiya

Герман: Weisskopt-Ruderente

Франц: Erismature à tête blanche

Казах: Ақбас үйрек

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Эр, эм хэмжээгээрээ ойролцоо. Биеийн урт 430-480 мм, далавчны урт 145-170 мм, сүүлний урт 80-120 мм. Биеийн жин 500-865 г.

Хошуу хөөмөл мэт өргөн ба харьцангуй зантгар толгойтой. Сүүлний өд шаталсан урт, ямааны сүүл мэт годойх тул ийнхүү нэрлэсэн. Хөл биеийн хойт хэсэгт байрлах тул газар алхаж чадахгүй, сэлэхэд сайн зохилдсон нугас юм.

Бие гүйцсэн эрийн толгой цагаан, хар титэмтэй, хошуу тод цэнхэр (үржлийн бус үед хошуу хар), сүүл годойж харагдана. Бие гүйцсэн эмийн толгойн дээд хэсэг хүрэн, нүднээс ар тийш цагаан судалтай. Хошуу бараан саарал. Залуу бодгаль бие гүйцсэн эмтэй төсөөтэй ч нуруу болон биеийн

хажуу хэсэг бараан хүрэн бидэртсэн нарийн судал ихтэй.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Марокко, Португали, Испани, Алжир, Франц, Бельги, Нидерланд, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Ливийн Жамахири, Австри, Словени, Польш, Мальтад тархсан. Унгар, Словак, Монтенегро, Сербид утсан. Албани, Грек, Румын, Македони, Украйн, Болгар, Египет, Турк, ОХУ, Кипр, Израиль, Саудын Араб, Йордан, Сири, Ирак, Гүрж, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Монголд тохиолдлын байдлаар ховор үзэгдэнэ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Тэс ба Торхилог голын бэлчир, Увс нуурын эргэн тойрны зэгстэй жижиг нуур, цөөрөм (Увс нуурын хотгор), Хар-Ус нуур (1992 оны 7-р сард 5 бие гүйцсэн, 2 дэгдээхэй, 1995 оны 6-р сард 1 хос), Хар, Дөргөн нуур, Ховд голын адагт (Их Нууруудын хөндий) үржинэ. Нүүдлийн үедээ Тэс, Торхилог гол (1981 онд 15-18, 1985 онд 40 бодгаль), Айраг, Хяргас нуур (8 бодгаль), Хар-Ус (1995 онд 28, 1996 онд 12, 1998 онд 238 бодгаль), Хар, Дөргөн нуур ба Ховд голын адаг (Их Нууруудын хотгор), Ховд аймгийн Зэрэг нуур (1995 онд 1 бодгаль), Завхан голын сав, Булган аймгийн Хангал нуур, Увс нуур (2006 онд 51 бодгаль), Хар-Ус нуур (2006 онд 138 бодгаль), Төв аймгийн Цэгээн нуурт (2010 онд 4 бодгаль) тус тус бүртгэгдэж байсан (Gombobaatar *et al.*, 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Өндөр өвс, зэгс, шагшуурга бүхий том, жижиг нуур, цөөрөм болон томоохон тогтмол усан санд байршижтай.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын дундаас 5-р сарын эхэнд нүүдэллэн ирнэ. Энэ зүйлийн үржлийн талаар мэдээлэл хомс. Тэд цэнгэг устай нуур, цөөрмийн зэгс, шагшуурга, өндөр өвсөн дундах зэгс дээр, эсвэл усан дээр усны ургамлын иш, навчаар үүр засаж, цайвар өнгийн 5-15 өндөг гаргана. Өндөгнөөс 25-27 хонгийн дараа дэгдээхэй гарах ба эцэг, эх шувуу усны ургамал, усны шавж, түүний авгалдайгаар хооллоно. Нүүдлийн үедээ хосоороо, эсвэл 4-250 бодгаль сүрэглэн зэгс, шагшуурга бүхий цэнгэг уст нуур, цөөрмөөр тохиолдоно. Намрын нүүдэл 8-р сарын сүүлчээс эрчимжинэ (Gombobaatar *et al.*, 2011).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 2011 онд 7,900 - 13,100 бие гүйцсэн бодгальтай байсан бол өдгөө

5,300-8,700 болж цөөрсөн байна.

Тоо толгой буурах гол шалтгаан нь малын шууд нөлөө, усан цахилгаан станцын шууд ба дам нөлөө, мөн зэгс, усны ургамлын хаталт юм. Дэлхийн дулаарлаас шалтгаалан түүний амьдрах орчин ихээхэн хуурайшиж, хатах болсон. Нуурын усанд хаясан загасны тор, түймрээс шалтгаалан хорогддог (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

2006 онд 2 бодгалийг АНУ руу гаргасан баримт бий.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус оржээ.

Монгол орон дахь тархац нутгийн 20.3% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Цагаантолгойт ямаансүүл (*Oxyura leucoscephala*) нь 90.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 18.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ЗАГАСЧ ЯВЛАГ

Pandion haliaetus Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Явлаг (*Pandionidae*)

НЭРШИЛ:

Англи: Osprey

Орос: Скопа

Хятад: `E/ Yuying

Герман: Fischadler

Франц: Balbuzard pêcheur

Казах: Балықшы түйғын



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ


Биеийн урт эрийн хувьд 535-590 мм, харин эмд 575-620 мм хүрнэ. Эрийн далавчны урт 448-492 мм бол эмийнх 485-515 мм. Биеийн жин 1,300-1,900 г.

Бие гүйцсэн шувууны нуруу хүрэн, нүд шаргал. Биеийн доод хэсэг, толгой цагаан, гүеэг дагасан хүрэн бор судалтай. Хошуунаас нүдийг дайран шилээ хүрсэн өргөн хар судалтай. Согсоо жижиг. Хошуу бараан саарал ба зэтэр хөхвөр туяатай саарал. Хөл цайвар ногоон, хумс хар. Хүчирхэг том тарс, хуруу хайрсаар бүрхэгдсэн. Залуу шувууны зүс бие гүйцсэнтэйгээ тун төсөөтэй ч биеийн дээд хэсгийн бүрхүүл өд цайвар хөвөөтэй байдгаараа ялгарна.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Канад, АНУ, Мексик, Гватемал, Эл Сальвадор, Белиз, Гондурас, Никарагуа, Коста-Рика, Куба, Панам, Кайманы арлууд, Перу, Эквадор, Ямайка, Колумб, Чили, Гайти, Багам, Бразил, Аргентин, Венесуэль, Турк ба Кайгосын арлууд, Доминикан,

Аруба, Боливи, Нидерландын Антилез, Пуэрто Рико, Виржиний Арлууд, Их Британи, Парагвай, Ангила, Сент-Киттс Невис, Монтсерат, Гренада, Антигуа Барбуда, Гваделуп, Гринидад Тобаго, Гайана, Доминика, Сент-Винсент ба Гренадин, Мартиник, Сент Люсиа, Уругвай, Барбадос, Суринам, Сэнт Пьер ба Микелон, Францын Гайана, Бермуд, Гренланд, Исланд, Кабо-Верде, Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби, Гвиней, Марокко, Сьерра-Леоне, Мали, Либери, Ирланд, Португали, Испани, Алжир, Фароз Арлууд, Гибралтар, Буркина Фасо, Гана, Того, Нигер, Бенин, Бельги, Нигери, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Габон, Лихтенштейн, Сан-Томе Принсипи, Ливийн Жамахири, Австри, Конго, Швед, Ангол, Намиби, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Төв Африк, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серб, Албани, Ботсвана, Грек, Румын, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Туркменистан, Сейшел, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Мальдив, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапур, Бруней, Австрали, Хонконг, Тайвань, Филиппин, БНАСАУ, БНСУ, Япон, Шинэ Гвиней, Гуам, Соломоны Арлууд, Шинэ Каледонид тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Буянт, Ховд, Булган голын сав, Хотон, Хоргон, Даян нуурын хөндий (Монгол-Алтай), Ховд, Бөхмөрөн гол (Хархираа, Түргэний уулс), Торхилог ба Тэс гол (Увс нуурын хотгор), Тамирын гол (Хангайн тойрог), Идэр, Чулуут голын хөндий (Тарвагатай-Булнайн нуруу), Хөвсгөл нуур-Эгийн гол (Хөвсгөл тойрог), Шишгэд, Доод нуурын ус намгархаг газар (Дархадын хотгор), Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө гол (Орхон-Сэлэнгэ голын сав), Минж, Туул, Тэрэлж, Онон, Балж, Хүдэр, Булнайн гол (Хэнтийн тойрог), Хэрлэн голын эх (Хэрлэн-Улз голын сав), Нөмрөгийн голд (Буйр нуур-Халх гол-Хянган) үрждэг. Нүүдлийн үедээ дээр дурдсан үржлийн нутгууд болон Их Нууруудын хотгор, Хангай, Дундад Халхын хээр, Монгол Дагуурын хээр, Дорнод Монгол, Буйр нуур-Халх гол-Хянганы бүсийн томоохон гол, нуурын хөндийгөөр таарна (Gombobaatar *et al.*, 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Ой, ойт хээрийн загас элбэгтэй цэнгэг уст нуур, цөөрөм, голын хөндий даган амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд загасаар баялаг нуур, голын хөндийд нүүдэллэн ирж, өндөр шинэс, хуш, улиас дээр хуурай мөчир, гишүүгээр үүр засаж, цайвар саарал, бараан хүрэн толбо бүхий цайвар шаргал өнгийн 2-4 өндөг гаргана. Өндөгнөөс 35-38 хоногийн дараа ангаахай хагарч гарах ба тэдгээрийг эцэг, эх

шувууд жижиг, дунд зэргийн хэмжээтэй загасаар хооллоно. Үүрээ олон жил сэлбэн ашигладаг. Тэд 8-р сарын сүүлч, 9-р сарын эхээр нүүдэллэх ба энэ үедээ ганц нэгээр, эсвэл цөөн тоотой хамтдаа нүүнэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 100,000-500,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) хэмээн үнэлжээ.

Үржлийн нутагт уул уурхай, усан цахилгаан станц, аялал жуулчлал, модны зүй бус ашиглалт, түймэр зэрэг шууд ба дам нөлөө нь тэдний хэвийн амьдралд сөргөөр нөлөөлнө. Ус намгархаг газрын орчны доройтол, хэт загасчлал, усны бохирдол зэрэг нь түүний тоо толгойг бууруулах гол шалтгаан болно (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай орны хувьд гадаад худалдааны талаар мэдээ баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Загасч явлагийн Монгол орон дахь тархац нутгийн 11.5% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Загасч явлаг (*Pandion haliaetus*) нь 238.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 47.6 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ



БАЛЧ ГООРБИС

Pernis apivorus Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)
Овог: Харцара (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: European Honey Buzzard

Орос: Обыкновенный осоед

Хятад: Fengying

Герман: Wespenbussard

Франц: Bondrée apivore

Казах: Аражегіш

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Үнэлэх боломжгүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 520-680 мм. Эрийн далавчны урт 370-441 мм, эмийнх 372-447 мм. Сүүлний урт эрийн хувьд 210-276 мм, эмд 240-269 мм хүрнэ. Биеийн жин 600-950 г.

Бие гүйцсэн бодгалийн биеийн дээд хэсэг бор хүрэн, толгой саарал, хэвлий цагаан ба бор хүрэн толбо ихтэй. Согсоот гоорбистой ижил ч нисэх үед далавчны үзүүрт 5 өд хуруу мэт илт ялгарч харагдах шинжээрээ ялгардаг. Сүүлний үзүүр рүүгээ 3-4 хөндлөн өргөн бараан судалтай. Хошуу,

хумс хар. Зэтэр хар саарал. Залуу шувууны нурууны өд олон цайвар толботой ба толгой саарал биш. Нүд саарал, зэтэр цайвар шаргал.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Исланд, Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби, Гвиней, Марокко, Сьерра-Леоне, Мали, Либери, Ирланд, Португали, Испани, Алжир, Андорра, Их Британи, Фароз Арлууд, Гибралтар, Буркина Фасо, Франц, Гана, Того, Нигер, Бенин, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Габон, Лихтенштейн, Ливийн Жамахири, Гвиней, Австри, Конго, Швед, Ангол, Намиби, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Төв Африк, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Замби, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Зимбабве, Турк, Молдов, ОХУ,

Руанда, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Швейцарь, Кипр, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армэн, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Эмират, Оман, Сейшел, Узбекистан, Афганистанд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төвөөс баруун хойш 38 км зайд орших “Төвшин” жуулчны баазын улиас дээр (1998 оны 5-р сард 1 бодгаль), мөн “Жуулчин Говь” жуулчны баазын улиас дээр (1998 оны 8-р сард 1 бодгаль) тус бүр ажиглагдаж байсан. Гэвч эдгээр бүртгэл нь энэ зүйл шувууны үржлийн болон нүүдлийн үндсэн тархалтаас хэт алслагдсан байгаа тул эргэлзээ төрүүлнэ.



АМЬДРАХ ОРЧИН

Тохиромжтой амьдрах орчин нь балч болон шонхор зөгий элбэгтэй навчит болон холимог ой бөгөөд нүүдлийн үедээ тал хээрт ч таарах боломжтой.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд тохиолдлын байдлаар таарах зүйл бөгөөд 4-р сарын дундаас 5-р сарын эхэн (хаврын нүүдэл), 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд (намрын нүүдэл) тэмдэглэгдэж байсан. Зөгийн авгалдай, мөлхөгч, жижиг шувуу болон хөхтнөөр хооллоно (Gombobaatar *et al.*, 2011).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 2011 онд 350,000-1,000,000 бие гүйцсэн бодгаль байсан бол 2017 онд 280,000-420,000 хүртэл буурсан (BirdLife International, 2017) хэмээн үнэлжээ.

ХУДАЛДАА

Одоогоор манай орны хувьд худалдааны талаар мэдээ баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Балч гоорбис (*Pernis apivorus*) нь 80.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 16.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



СОГСООТ ГООРБИС

Pernis ptilorhynchus Temminck, 1821

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Oriental Honey Buzzard

Орос: Хохлатый осоед

Хятад: Fengtou Fengying

Герман: Schopfwespenbussard

Франц: Bondrée orientale

Казах: Айдарлы аражеріш

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 510-520 мм. Эрийн далавч 414-460 мм бол эмийнх 413-470 мм хүрнэ. Биеийн жин 1,000-1,300 г.

Эр, эм шувууд өнгө зүсний хувьд харьцангуй төсөөтэй. Бие гүйцсэн бодгалийн нуруу хүрэн, толгой сааралдуу, хошууны угаас нүд дайрсан бараан нарийн судалтай. Хэвлий хүрэн, судал, толбо ихтэй. Сүүл бараан хөндлөн хоёр судалтай. Нүд хүрэн туяатай хар. Хошууны уг хар бараан. Хөл шар, хумс хар. Эр шувуу согсоотой. Эмийн нүд шар ба согсоогүй. Залуу шувууны нуруу олон цагаан толбуудтай. Сүүлний судал нарийн байдгаараа ялгарна. Зүс нь ихээхэн хувьсамтгай.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Египет, Турк, ОХУ, Израиль, Саудын Араб, Йордан, Иран, Казахстан, Кувейт, Эмират, Оман, Узбекистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Мальдив, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапур, Бруней, Макао, Хонконг, Тайвань, Филиппин, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хэнтий, Хангайн нурууны холимог ойд үржих боломжтой. Нүүдлийн үедээ Тэрэлж, Онон, Балж, Улз, Хэрлэн гол (Хэнтийн тойрог), Туул, Орхон, Хараа, Сэлэнгэ голын хөндийн ойгоор тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Холимог болон навчит мод бүхий уул, голын хөндийд үржинэ. Нүүдлийн үедээ задгай хээрт тохиолдох бөгөөд таримал моддын дунд сууж байх нь ажиглагдана.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн дайрч өнгөрдөг (үрждэг байж болзошгүй) зүйл бөгөөд хавар 4-р сарын сүүлчээс 6-р сарын эхээр нүүдэллэн ирнэ. Үржлийн хосууд ой, ойт хээрийн бүсийн навчит болон холимог ойд үүрлэж, улаан хүрэн толбо бүхий цайвар өнгийн 1-3 өндөг гаргана. Өндөгнөөс 30-35 хоногийн дараа ангаахай гарах ба эцэг, эх шувуу шавж, хэдгэнэ, зөгийн авгалдайгаар хооллоно. Нүүдлийн үедээ ганц нэгээр, эсвэл 3-20 бодгаль бүхий сүрэг үүсгэн тайгын ойгоос говь цөл хүртэл таарна. Намрын нүүдэл идэш тэжээлийн олдоц, цаг агаарын байдлаас шалтгаалан 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд үргэлжилнэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээг 2011 онд 100,000–1,000,000 бие гүйцсэн бодгаль (Birdlife International, 2011) хэмээн үнэлжээ.

Үржлийн болон нүүдлийн нутагт уул уурхай, аялал жуулчлал, ойн зүй бус ашиглалт, түймэр зэрэг шууд ба дам нөлөөнөөс үүссэн амьдрах орчны доройтол нь тэдний амьдралд сөргөөр нөлөөлж байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай орны хувьд худалдааны тухай мэдээ баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Согсоот гоорбисын Монгол орон дахь тархац нутгийн 9.1% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Согсоот гоорбис (*Pernis ptilorhynchus*) нь 84.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 16.8 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



СОХОР ЭЛЭЭ

Milvus migrans Temminck, 1821

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Black kite

Герман: Schwarzmilan

Орос: Чёрный коршун

Франц: Milan noir

Хятад: Hei Yuan

Казах: Қара кезқұйрық

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (Gombobaatar *et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ


Эр нь эмээсээ биеэр арай жижиг. Биеийн урт 46-51 см. Эрийн далавчны урт 465-495 мм бол эмийнх 470-520 мм. Биеийн жин 567-1,000 г.

Эр, эм шувуудын зүс ижил. Бусад махчин шувуудаас ац хэлбэрийн сүүлтэйгээрээ ялгарна. Нуруу бараан хүрэн, сүүл болон залуур өд хөндлөн бараан судал ихтэй. Хошуу, хумс хар. Зэтэр шар. Залуу шувууны биеийн дээд хэсэг цайвар, улбар шаргал толбо ихтэй, сүүлний өдний үзүүр цайвар байдгаар нь ялгана.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Их Британи, Исланд, Кабо-Верде, Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби, Гвиней,

Марокко, Сьерра-Леоне, Мали, Либер, Ирланд, Португали, Испани, Алжир, Гибралтар, Буркина Фасо, Франц, Гана, Того, Нигер, Бенин, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Габон, Лихтенштейн, Австри, Конго, Швед, Ангол, Намиби, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Төв Африк, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Замби, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Зимбабве, Турк, Молдов, Лесото, ОХУ, Руанда, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Швейцарь, Кипр, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Коморос, Мадгаскар, Майотте, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Туркменистан, Сейшел, Узбекистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Шри Ланк, Балба, Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Вьетнам, Камбож, Сингапур, Бруней, Австрали, Папуа Шинэ Гвинейд тархсан.




ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 1,000,000-2,500,000 бодгалтай (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Ойн зүй бус ашиглалт, түймэр зэргийн нөлөөгөөр амьдрах орчин нь доройтож байна. Үлийн цагаан оготны тоо толгойг зохицуулах зорилгоор хэрэглэсэн хоронд дам байдлаар хорддог. Элэг нь хүний элэгний хорт хавдрыг анагаадаг хэмээх цуу үгэнд итгэж хууль бусаар агнах, арилжих, хурга ишиг шүүрч болзошгүй гэж нутгийн малчид буудан хорооно. Өндөр хүчдлийн цахилгаанд цохиулж олноор эндэнэ (Gombobaatar *et al.*, 2011; Гомбобаатар, Одхүү, 2018).

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол орны ой тайгаас говь цөл хүртэлх хад цохио, мод бүхий үүрлэх боломжтой бүх газарт тархсан. Хот суурин газрын ойролцоо харьцангуй олон тоотой байршина.



₮ ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор 2002, 2006, 2011 онд өд, өндөг зэргийг АНУ, Герман улс руу гаргасан. 2006 онд 1 бодгалийг агнуулан АНУ руу илгээжээ (CITES-ийн тайлан, 2017).

Щ ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус оржээ.

Сохор элээний Монгол орон дахь тархац нутгийн 12.7% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

☞ АМЬДРАХ ОРЧИН

Хадан хясаа, ой, ойт хээр, голын хөндийн ой, хот суурин бараадан амьдарна. Нүүдлийн үедээ задгай тал хээрт ч тохиолдоно.

🔄 АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн, үрждэг ердийн тохиолдох зүйл. Тэд 3-р сарын сүүлчээс 4-р сарын дунд үед нүүдэллэн ирж, хадан хясаа, мод, голын хөндийн элсэн эрэг, өндөр хүчдэлийн шон, барилга байгууламж дээр үүрлэнэ. Гол төлөв улаан бор толбо бүхий цагаан өнгийн 3-4 ширхэг өндөг гаргаж, 28-30 хоног дарж ангаахай болгоно. Ангаахай 40 гаруй хоногийн дараагаас нисэж эхэлнэ. Ихэвчлэн оготно, чичүүл, хулгана, зараа, жижиг шувуу, царцаа болон хаягдал хүнсний үлдэгдлээр хооллоно. Нүүдлийн үедээ ганц нэгээр, эсвэл 3-30 бодгаль бүхий жижиг сүрэг үүсгэнэ. Намар 9-р сарын сүүлчээс 10-р сарын эхэнд нүүдэллэнэ (Gombobaatar *et al.*, 2011).

🏠 ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Сохор элээ (*Milvus migrans*) нь 78.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 15.6 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



СААРАЛ ХУЛД

Circus cyaneus Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Hen Harrier (Northern Harrier, Marsh Hawk)

Орос: Полевой лунь

Хятад: Beiwei Yao

Герман: Kornweihe

Франц: Busard Saint-Martin

Казах: Түз құладыны

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Эрийн биеийн урт 441-515 мм бол эмийнх 490-561 мм. Эрийн далавчны урт 330-362 мм, эмийн хувьд 360-390 мм хүрнэ. Биеийн жин 362-600 г.

Бие гүйцсэн эр бодгалийн толгой, хоолой, цээж болон биеийн дээд хэсэг, 2-р зэргийн дэвүүр болон залуур саарал. Цээжний бусад хэсэг, хэвлий цагаан ба 1-р зэргийн дэвүүр өд хар. Бие гүйцсэн эмийн хондлой өргөн цагаан толботой, чихний бүрхүүл тод илрээгүй, нүд тойрсон цагаан судалгүй, далавчны үзүүр хар, далавчны доод даруул өд ууссан бараавтар хүрэн судалтай. Залуу шувууны цээж өргөн судал бүхий улбар хүрэн, далавчны дээд бага бүрхүүл өд цайвар, далавчны 1-р зэргийн дэвүүрийн 4-р өд хамгийн урт байдгаараа бусад хулдын залуу шувуунаас ялгарна.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Канад, АНУ, Мексик, Гватемал, Эль Сальвадор, Белиз, Гондурас, Никарагуа, Коста-Рика, Куба, Панам, Кайманы арлууд, Ямайка, Колумб, Гайти, Багам, Венесуэль, Турк, Доминикан, Нидерланд, Пуэрто Рико, Их Британи, Гренада, Антигуа Барбуда, Гваделуп, Доминика, Барбадос, Сэнт Пьер ба Микелон, Бермуд, Гренланд, Исланд, Сенегал, Марокко, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Фароз Арлууд, Гибралтар, Франц, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Лихтенштейн, Ливийн Жамахири, Австри, Швед, Чех, Словени, Польш, Мальта, Хорват, Босни, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Турк, Молдов, ОХУ, Кипр, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Ирак, Гүрж, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Андорра, Пакистан, Тажикистан, Энэтхэг, Киргиз, Хятад, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапур, Хонконг, Тайвань, БНАСАУ, БНСУ, Японоор тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Орхон, Сэлэнгэ (Орхон-Сэлэнгэ голын сав), Онон, Балж гол (Хэнтийн тойрог), Халх, Дэгээ, Нөмрөг, Цагаан Чулуут, Азарга гол, Буйр, Шавар, Ташгайн Таваннуурт (Буйр нуур-Халх гол-Хянган) үржинэ. Нүүдлийн үедээ Монгол Алтай, Их Нууруудын хотгор, Хангай, Хөвсгөл, Дархадын хотгор, Орхон-Сэлэнгэ голын сав, Хэнтий, Дундад Халх, Дорнод Монгол, Буйр нуур-Халх гол-Хянган, Нууруудын хөндий, Зүүнгарын говиор тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Ойт хээр, ойн захын голын задгай хөндий, зэгс бүхий ус намагтай амьдрах орчныг шүтэх ба нүүдлийн үедээ задгай тал хээрт түгээмэл таарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын дундаас 5-р сарын эхэнд нүүдэллэн ирж өндөр өвс, зэгс бүхий гол, нуурын орчимд газар дээр хуурай өвс, зэгсээр үүр засна. Эр нь 2-3 эмтэй эвцэлдэх ба эм шувууд гол төлөв 4-6, маш ховор тохиолдолд 8 өндөг гаргаж 30 орчим хоног дарна. Ангаахай 35-40 хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Тачир ургамалтай газарт оготно, чичүүл, жижиг шувууд болон тэдгээрийн ангаахайгаар хооллоно. 8-р сарын сүүлчээс 10-р сарын эхэнд нүүдэллэх ба гол төлөв ганц нэгээр, эсвэл цөөн тоогоор хамт ниснэ. Зарим бодгалиуд өвлийн улиралд үлийн цагаан оготно бүхий хээр,

цөлөрхөг хээрийн бүсийн гол, нуурын хөндийгөөр тохиолдоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 2011 онд 1,300,000 бие гүйцсэн бодгаль байсан бол өдгөө 100,000-500,000 хүрч буурсан (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Үржлийн нутагт малын тоо ихсэх, уул уурхай болон усан цахилгаан станц, аялал жуулчлал зэрэг хүчин зүйлс түүний амьдрах орчныг доройтуулж, үржлийн амжилтыг бууруулж байна. Мөн бэлчээрийн хортон мэрэгч устгах хор цацаж байгаа нь идэш тэжээлээр дамжин дам хордож эндэх шалтгаан болно (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай орны хувьд худалдааны тухай баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус оржээ.

Саарал хулдын Монгол орон дахь тархац нутгийн 8.1% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Саарал хулд (*Circus cyaneus*) нь 36.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 7.2 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ХЭЭРИЙН ХУЛД

Circus macrourus Gmelin, 1771

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Pallid Harrier

Орос: Степной лунь

Хятад: Саоуван Yao

Герман: Steppenweihe

Франц: Busard pâle

Казах: Дала құладыны

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Ховордож болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Мэдээлэл дутмаг” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт эрийн хувьд 437-480 мм, эмд 480-525 мм хүрнэ. Эрийн далавчны урт 310-356 мм, эмийнх 345-391 мм. Биеийн жин эрд 235-416 г, эмд 252-550 г хүрнэ.

Бие гүйцсэн эр саарал хулдтай төсөөтэй ч харьцангуй цайвардуу толгой, биеийн доод хэсэг, далавчны дэвүүр өдний үзүүр хар биш, мөн толгой хоолой, гүеэ саарал байдгаараа ялгардаг. Бие гүйцсэн эмийн бусад хулдаас ялгарах онцлог нь 2-р зэргийн дэвүүр бараан, толгойн судал их тод илэрсэн, далавчны доод хэсэг судал болон толбогүй, далавчны дэвүүр өдний үзүүр бараан

гэхдээ саарал хулдтай адил тод хар биш. Залуу шувууны 1-р зэргийн дэвүүр өд жигд судалжсан, далавчны дэвүүр өдний үзүүр хар биш, нарийн цайвар хөмсөгтэй ба өргөн цайвар судал дагзны хажуугаас чихний араар хоолой руу орсон байх бөгөөд чихний бүрхүүл өд тод бараан бор хүрэн.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Исланд, Сенегал, Мавритани, Гамби, Гвиней, Сьерра-Леоне, Мали, Либериа, Испани, Алжир, Их Британи, Гибралтар, Буркина Фасо, Франц, Гана, Того, Нигер, Бенин, Бельги, Нигери, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Лихтенштейн, Ливийн Жамахири, Австри, Конго, Швед, Ангол, Намиби, Чех, Словени, Чад, Мальта, Хорват, Төв Африк, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Ботсвана, Грек, Румын, Македони, Финланд, Судан, Замби, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Зимбабве, Турк, Молдов, Лесото, ОХУ, Руанда, Бурунди, Танзани, Уганда,

Мозамбик, Швейцарь, Кипр, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армэн, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Афганистан, Пакистан, Энэтхэг, Мальдив, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Мянмар, Малайз, Японд тархсан. Латви, Вьетнам улсад устсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол Алтайгаас зүүн тийш Их Нууруудын хотгор, Хангай, Хөвсгөлийн тойрог, Хэнтийн баруун урдуур (Туул гол) нүүдлийн үедээ дайрч өнгөрнө.



АМЬДРАХ ОРЧИН

Хээр тал, нуур, голын хөндийн өндөр өвс, зэгс, намагтай задгай орчныг бараадан нүүдлийн үедээ таардаг.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд зусдаг, нүүдлийн дайрч өнгөрдөг зүйл бөгөөд үржлийн тухай баримт бүртгэгдээгүй. Хавар 4-р сарын дундаас 5-р сарын эхэнд, намар 8-р сарын сүүлчээс 10-р сарын эхэн үед манай оронд ажиглагдана. Нүүдлийн үедээ ганц нэгээр, эсвэл 3-4 тоогоор задгай хээрт тохиолдоно. Хоёр нутагтан, жижиг шувуу, мэрэгчээр хооллоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 18,000-30,000 бие гүйцсэн бодгаль (Birdlife International, 2011, 2017) хэмээн үнэлжээ.

Үржлийн нутагт малын тоо ихсэх, уул уурхай болон усан цахилгаан станц, аялал жуулчлал зэрэг нь түүний амьдрах орчныг доройтуулна. Мөн бэлчээрийн хортон мэрэгч цөөрүүлэх зорилгоор ашигласан хоронд дам байдлаар хордох эрсдэл ихтэй (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

АНУ руу 2002 онд 1 шувууг агнуулан гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://www.cms.int/en/species>) болон Азийн Улаан ном (2001)-нд тус тус бүртгэсэн.

Хээрийн хулдын Монгол орон дахь тархац нутгийн 9.2% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хээрийн хулд (*Circus macrourus*) нь 77.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 15.4 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



НУГЫН ХУЛД

Circus pygargus Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцара (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Montagu's Harrier

Орос: Луговой лунь

Хятад: Wuhui Yao

Герман: Wiesenweihe

Франц: Busard cendré

Казах: Шалгын құладыны

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Мэдээлэл дутмаг” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт эрийн хувьд 410-465 мм, эмд 470-520 мм. Эрийн далавчны урт 342-389 мм, эмийнх 365-395 мм. Биеийн жин эрд 227-305 г, эмд 254-445 г хүрнэ.

Бие гүйцсэн эр нь саарал хулдтай төсөөтэй ч далавчны 2-р зэргийн дэвүүр өдний дээгүүр тууш хар судал үргэлжлэх ба 1-р зэргийн дэвүүр доороосоо бараан, далавчны доод тал болон хэвлийд улбар хүрэн судалтайгаараа ялгардаг. Бие гүйцсэн эм нь саарал болон хээрийн хулдын эмтэй төсөөтэй ч далавчны дээрх хар судал,

далавчны дээр богино хар судал, мөн өргөн хөмсөг, бүдэг чихний бүрхүүл өдтэй учир цайруу толгойтой харагдана. Залуу бодгаль нь хээрийн хулдтай төсөөтэй ба далавчны үзүүрийн хэсэг илүү бараан, толгой цайруу, дэвүүр өдний үзүүр бүхэлдээ бараан зэргээрээ ялгарна.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Исланд, Кабо-Верде, Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби, Гвиней, Марокко, Сьерра-Леоне, Мали, Либер, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Гибралтар, Буркина-Фасо, Франц, Гана, Того, Нигер, Бенин, Андорра, Бельги, Нигери, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Лихтенштейн, Ливийн Жамахири, Австри, Конго Улс, Конго, Швед, Намиби, Чех, Чад, Польш, Мальта, Хорват, Төв Африк, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани,

Ботсвана, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Замби, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Зимбабве, Турк, Молдов, Лесото, ОХУ, Руанда, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Швейцарь, Кипр, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Мальдив, Хятад, Шри Ланк, Балба, Бангладешт тархсан. Словенид утсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Энэ зүйл нь Увс нуур орчмын задгай хээр, Тэс, Торхилог гол (Увс нуурын хотгор), Шишгид голд (Дархадын хотгор) нүүдлийн үедээ бүртгэгдсэн.



АМЬДРАХ ОРЧИН

Ойт хээр, голын хөндий, зэгс бүхий задгай орчныг шүтэн байршина.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд зусдаг, нүүдлийн дайрч өнгөрдөг зүйл бөгөөд хавар 4-р сарын дундаас 5-р сарын эхэн үед, намар 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэн үед тохиолдоно. Нүүдлийн үедээ ганц нэгээр, эсвэл цөөн тоогоор нисэх ба жижиг мэрэгч,

бор шувуу, хоёрнутагтан, шавжаар хооллоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 100,000 үржлийн бодгаль (BirdLife International, 2011) хэмээн үнэлсэн. Манай орны хувьд тоо толгой нь тодорхойгүй.

Малын тоо ихсэх, уул уурхай болон усан цахилгаан станц, аялал жуулчлалын бааз, түймэр зэрэг хүний хүчин зүйлийн улмаас түүний амьдрах орчин доройтож байна. Бэлчээрийн хортон мэрэгч устгах зорилгоор цацсан хоронд дам өртөх аюултай (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай оронд энэ зүйлийн худалдааны баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Нугын хулдын Монгол орон дахь тархац нутгийн 11% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Нугын хулд (*Circus pygargus*) нь 51.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 10.2 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



АЛАГ ХУЛД

Circus melanoleucos Pennant, 1769

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Pied Harrier

Орос: Пегий лунь

Хятад: Que Yao

Герман: Scheckweile

Франц: Busard pie

Казах: Ала құладың

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Мэдээлэл дутмаг” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.


ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 46-51 см. Эрийн далавчны урт 344-367 мм, эмийнх 355-387 мм хүрнэ. Биеийн жин эрд 265-325 г, эмийн хувьд 455 г.

Бие гүйцсэн эр бодгаль бусад хулдаас эрс ялгаатай бөгөөд толгой, хоолой, гүеэ, шилэн хүзүү, нуруу, далавчны үзүүр хар, биеийн доод бусад хэсэг цагаан. Бие гүйцсэн эм нь идэр насны дорнын хулдтай тун төсөөтэй ч хондлой дээрээ цагаан, сүүл дээр хөндлөн бараан судалтай зэргээрээ ялгардаг. Залуу бодгалийн биеийн доод хэсэг улбардуу бор хүрэн юмуу бараавтар бор хүрэн судалтай, хондлойн судал тод цагаан зэргээрээ онцлог.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

ОХУ, Пакистан, Энэтхэг, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапур, Бруней, Хонконг, Тайвань, Филиппин, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хэрлэн, Улз, Халх, Нөмрөг голын савын зэгс, шагшуурга, ус намгархаг газар бараадан амьдарна.



АМЬДРАХ ОРЧИН

Гол, нуурын хөндийн өндөр зэгс, шагшуурга, өндөр ургасан ургамал бүхий ус намгархаг газарт үржих ба нүүдлийн үедээ задгай хээрт тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд ховор тохиолдох, нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын дундаас 5-р сарын эхэнд ирнэ. Нуур, голын хөндийн өтгөн, өндөр зэгс шагшуурга, намаг бүхий хэсэгт газар дээр хуурай өвс, зэгсээр үүр барьж, хүрэн толбо бүхий цагаан, эсвэл ногоовор туяатай цагаан өнгийн 4-5 өндөг гаргаж, 30 орчим хоног дарна. Жижиг мэрэгч, хоёрнутагтан, шавжаар хооллоно. Нүүдлийн үедээ ганц нэгээр, эсвэл 2-3 тоогоор ниснэ. Намрын нүүдэл 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд явагдана.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 10,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2011) бөгөөд тэдгээрийн тоо толгой буурсаар байна.

Үүрлэдэг нутагт малын тоо ихсэх, дэлхийн дулаарал, хээрийн түймэр зэрэг нөлөөнөөс

түүний амьдрах орчин доройтож, үржлийн амжилт буурдаг. Бэлчээрийн хортон мэрэгч болох үлийн цагаан оготныг устгах зорилгоор хэрэглэсэн хоронд дам өртөх аюултай (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай орны хувьд худалдсан тухай баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Алаг хулдын Монгол орон дахь тархац нутгийн 11.9% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Алаг хулд (*Circus melanoleucus*) нь 36.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 7.2 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



НАМГИЙН ХУЛД

Circus aeruginosus Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Western Marsh Harrier

Орос: Камшовый лунь (Болотный лунь)

Хятад: Baitou Yao

Герман: Rohrweihe

Франц: Busard des roseaux

Казах: Саз құладыны

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт нь эрийн хувьд 495-540 мм, эм нь 521-600 мм. Эрийн далавчны урт 360-418 мм, эмийнх 392-440 мм хүрнэ. Биеийн жингийн хувьд эр 405-544 г, эм 662-1,105 г хүрнэ.

Бие гүйцсэн эрийн далавчны үзүүр хар, сүүл цайвар саарал, далавчны дээд хэсэг саарал-бор хүрэн-хар гэсэн гурван өнгөтэй. Биеийн доод хэсэг цайвар бөгөөд хэвлий, шуумаг өд, сүүлний доод даруул улбардуу хүрэн. Цээж, биеийн хажуу хэсэг тууш судал ихтэй. Бие гүйцсэн эм нь бор хүрэн зүстэй бөгөөд сүүл улбардуу хүрэн бор, толгой, хоолой, цээжний хөндлөн судал, далавчны доод хэсэг цайвардуу шаргал. Залуу шувуу бие гүйцсэн эмтэй төсөөтэй ч илүү бараан байна.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Исланд, Кабо-Верде, Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби, Гвиней, Марокко, Сьерра-Леоне, Мали, Либер, Португали, Испани, Алжир, Их Британи, Буркина Фасо, Франц, Гана, Того, Нигер, Бенин, Андорра, Бельги, Нигери, Нидерланд, Норвег, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Габон, Лихтенштейн, Австри, Конго, Швед, Ангол, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Төв Африк, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Замби, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Зимбабве, Турк, Молдов, ОХУ, Руанда, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Кипр, Малави, Этиоп, Кени, Саудын Араб, Йордан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Туркменистан, Сейшел, Узбекистан, Мавритус, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Мальдив, Хятад, Шри Ланк, Балба,

Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Сингапурт тархсан. Ирланд, Израиль, Ливан, Люксембургт утсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Увс нуур (Увс нуурын хотгор), Хар-Ус нуурт (Их Нууруудын хотгор) үрждэг. Нүүдлийн үедээ дээрх газруудаас гадна Ачит, Үүрэг нуур (Монгол-Алтай), Бөөнцагаан нуур орчмын цөлөрхөг хээр, уулын хуурай хээр, Орог нуур, Таацын Цагаан нуур (Нууруудын хөндий), Булган голд (Баруун хуурайн хотгор) тохиолдоно. Тархалтын зүүн хязгаар тодорхойгүй.



АМЬДРАХ ОРЧИН

Баруун бүсийн зэгс, шагшуурга ихтэй томоохон нуур, голуудын хөндийн ус намгархаг газар шүтэн амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын дундаас 5-р сарын эхэнд нүүдэллэн ирдэг. Үүрээ гол, нуурын хөндийн өндөр өвс, зэгс шагшуурга бүхий хэсэгт газар дээр хуурай өвс, зэгсээр барьж, жижиг бор цоохор толбо бүхий ногоон туяатай цагаан өнгийн ихэвчлэн 4-5 өндөг гаргана. Өндгөө 33-38 хоног дарж ангаахай болгох ба ангаахай 40 орчим хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Ихэнх шувууд 8-р сарын сүүлч, 9-р сарын дундуур нүүдэллэх ба энэ үедээ ганц

нэгээр, эсвэл 2-3 тоогоор ниснэ (Gombobaatar et al., 2011).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 2011 онд 500,000-2,000,000 бие гүйцсэн бодгаль байсан бол 2017 онд 500,000-1,000,000 бодгаль болж буурсан байна (BirdLife International, 2017).

Үүрлэх нутагт малын тоо ихсэх, усан цахилгаан станц, хуурайшилтын нөлөөгөөр ус намгархаг газрууд доройтолд орж, түүний үржлийн амжилтыг бууруулж байна (Gombobaatar et al., 2011).

ХУДАЛДАА

Монгол орноос 1 бодгалийг 2002 онд агнуурын зорилгоор АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) баримт бий.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Намгийн хулдын Монгол орон дахь тархац нутгийн 8.3% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar et al., 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Намгийн хулд (*Circus aeruginosus*) нь 40.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 8.0 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ДОРНЫН ХУЛД

Circus spilonotus Каур, 1847

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Eastern Marsh Harrier

Орос: Азиатский лунь (Восточный болотный лунь)

Хятад: Baifu Yao

Герман: Mangroveweihe

Франц: Busard d'Orient

Казах: Саз құладыны

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Эрийн биеийн урт 495-540 мм, эмийнх 521-600 мм. Далавчны урт эрд 360-418 мм, эмд 392-440 мм. Биеийн жин эрд 405-544 г, эмийн хувьд 662-1,105 г хүрнэ.

Намгийн хулдтай төсөөтэй ба эрийн зүс хувьсамтгай. Бие гүйцсэн эр нь цайвардуу саарал зүстэй ба толгой, хоолойдоо хар судалтай, нуруу болон далавчны дээд хэсэгт хар толбо

судал ихтэй. Биеийн доод хэсэг цагаан ба хар судлуудтай. Алаг хулдын эмтэй төсөөтэй. Бие гүйцсэн эм нь намгийн хулдтай төсөөтэй бөгөөд хондлой дээрээ цагаан зүстэй, биеийн доод болон дээд хэсэг нь улбардуу хүрэн бор, дэвүүр өд сааралдуу байдгаараа ялгаатай. Залуу бодгаль бие гүйцсэн эм намгийн хулдтай ижил ч цээжээрээ цайвар өргөн хөндлөн судалтай, биеийн дээд хэсэг бараан, цайвар хондлойтой харагдана.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

ОХУ, Хятад, Монгол, Бангладеш, Мянмар, Кокос (Кийлинг) Арлууд, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапур, Бруней, Австрали, Хонконг, Тайвань, Филиппин, БНАСАУ, Япон, Папуа Шинэ Гвинейд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Онон, Балж гол (Хэнтийн тойрог), Хэрлэн, Улз гол (Хэрлэн-Улз голын сав), Халх, Нөмрөг, Азарга гол, Буйр, Ташгайн Таван нуур (Буйр нуур-Халх гол-Хянган) зэрэг өндөр өвс, зэгс шагшуурга бүхий гол, Нууруудын хөндийгөөр үржинэ. Хангай, Хөвсгөлийн тойрог, Орхон-Сэлэнгийн сав, Дорнод Монголын тал, Буйр нуур-Халх гол-Хянганы нутгаар нүүдлийн үедээ тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Монгол орны гол, нуурын хөндийн зэгс шагшуургатай ус намгархаг газрыг шүтэн амьдардаг.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын дундаас 5-р сарын эхэнд нүүдэллэн ирж, гол, нуурын хөндийн өндөр өвс, зэгс шагшуурга бүхий хэсэгт газар дээр хуурай өвс, зэгсээр үүр барьж, жижиг бор цоохор толбо бүхий ногоон туяатай цагаан өнгийн ихэвчлэн 4-5 өндөг гаргана. Өндөгнөөс 32-35 хоногийн дараа ангаахай гарах ба ангаахай 40 орчим хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Тэд 8-р сарын сүүлч, 9-р сарын эхээр нүүдэллэх ба энэ үедээ ганц нэгээр, эсвэл 2-3 бодгаль ниснэ (Gombobaatar et al., 2011).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 40,000-60,000 бие гүйцсэн бодгаль бөгөөд тэдгээрийн тоо толгой тогтвортой байна (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Малын тоо толгой ихсэх, уул уурхай, усан цахилгаан станц, аялал жуулчлал, түймэр зэрэг хүчин зүйлсийн нөлөө түүний амьдрах орчныг доройтуулж, үржлийн амжилтыг бууруулж байна. Бэлчээрийн хортон мэрэгчдийг устгах зорилгоор хор цацах нь идэш тэжээлээр дамжин хордох, тоо толгойн буурах нөхцөл болно (Gombobaatar et al., 2011).

ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны талаар баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Дорнын хулдын Монгол орон дахь тархац нутгийн 9.7% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar et al., 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Дорнын хулд (*Circus spilonotus*) нь 42.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 8.4 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ҮЛЭГ ХАРЦАГА

Accipiter gentilis Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Northern Goshawk

Герман: Habicht

Орос: Тетеревятник

Франц: Autour des palombes

Хятад: Cang Ying

Казах: Қаршыға

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Эр нь эмээс биеэр жижиг. Биеийн урт 430-610 мм. Эрийн далавчны урт 298-323 мм, эмийнх 330-362 мм. Биеийн жин эрийн хувьд 838-1,050 г, эмийнх 1,000-1,477 г.


Бие гүйцсэн эрийн нуруу хэсэг хөхвөр саарлаас бор саарал, биеийн доод хэсэг цагаан ба хөндлөн бор хүрэн судалтай. Хөмсөг өргөн цагаан. Залуур өд 4-5 хөндлөн судалтай. Бие гүйцсэн эм эртэйгээ төсөөтэй ч нуруу бараавтар бор саарал

ба цээжний хөндлөн судал өргөн, хөмсөг арай нарийн. Залуу шувуу бор хүрэн зүстэй ба биеийн доод хэсэг тууш судал ихтэй.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Канад, АНУ, Мексик, Сэнт Пьер ба Микелон, Бермуд, Марокко, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Гибралтар, Франц, Андорра, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Лихтенштейн, Ливийн Жамахири, Австри, Швед, Чех, Словени, Польш, Хорват, Босни, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Турк, Молдов, ОХУ, Кипр, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Гүрж, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Эмират, Оман, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан,

Энэтхэг, Хятад, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мьянмар, Тайланд, Вьетнам, Хонконг, Тайвань, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Тайгын ой, ойт хээрийн навчит болон шилмүүст ой, Ховд голын хөндий (Монгол-Алтайн тойрог), Хангай, Хэнтий, Хөвсгөлийн тойрог, Орхон-Сэлэнгэ мөрний сав, Хэрлэн-Улз гол сав, Буйр нуур-Халх гол-Хянганы бүсэд үржинэ. Нүүдлийн үедээ дээрх газруудаас гадна Увс нуурын хотгор, Их Нууруудын хотгор, Хан Хөхий, Тарвагатай, Булнай, Гурвансайхан уул, Нууруудын хөндий, Дорнод Монголын тал хээрт байршина.



АМЬДРАХ ОРЧИН

Ой, ойт хээр, голын хөндийн хөгшин эсвэл идэр шилмүүст болон холимог ойд амьдарна. Нүүдлийн үедээ таримал ойд таарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн, үрждэг, дайран өнгөрдөг зүйл бөгөөд 4-р сарын дундаас 5-р сарын эхэнд нүүдэллэн ирж 5-р сарын дунд үеэс голын хөндий, тайгын ой, ойт хээрийн навчит болон шилмүүст ойд модон дээр хуурай иш, мөчрөөр үүр засна. Бараан толбо бүхий цэнхэр туяатай цагаан өнгийн гол төлөв 2-5 өндөг гарган, 36-42 хоног дарж ангаахай болгох ба ангаахай 40 орчим хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Дунд зэргийн хэмжээтэй ойн шувуу, жирх, бараан хэрэм, урт сүүлт зурам зэрэг хөхтнөөр хооллоно. 9-р сарын сүүлчээс 11-р сарын эхэнд

намрын нүүдэл явагдах ба энэ үеэр мод, бут, хад асга бүхий задгай газар, заримдаа хот суурин газрын таримал ойд тохиолдоно. Жижиг шувуу, оготно, чичүүл, огдойгоор голчлон хооллоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 1,000,000-2,500,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Модны зүй бус ашиглалт, уул уурхай, түймэр, аялал жуулчлал, хүний шууд нөлөөнөөс түүний амьдрах орчин доройтож, улмаар алдагдана. Арабын шонхор баригчдын идлэг шонхор барихаар тавьсан урхитай тагтааг барьж эндэнэ (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Манай оронд худалдааны тухай баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Үлэг харцагын Монгол орон дахь тархац нутгийн 8.8% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Үлэг харцага (*Accipiter gentilis*) нь 86.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 17.2 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



МОРИН ХАРЦАГА

Accipiter nisus Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Eurasian Sparrow Hawk

Орос: Перепелятник

Хятад: Que Ying

Герман: Sperber

Франц: Epervier d'Europe

Казах: Қырғи

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Эрийн биеийн урт эр 300-320 мм, эмийнх 375-440 мм. Далавчны урт эрийн хувьд 200-219 мм, эмд 240-219 мм. Биеийн жин эрд 150-170 г, эмд 240-300 г хүрнэ.

Бие гүйцсэн эрийн нуруу хэсэг хөхвөр саарал, хэвлий цайвар ба улбардуу бор хүрэн хөндлөн судалтай. Дэвүүр, залуур өднүүд бараан хөндлөн судлуудтай. Бие гүйцсэн эм шувуу бүхэлдээ бор хүрэн. Биеийн доод хэсэг бор хүрэн өргөн хөндлөн судалтай. Хөл, зэтэр шар. Хумс хар, хошуу бараан саарал. Залуу шувуу бор хүрэн зүстэй ба биеийн доод хэсэг бараан хүрэн бор судал толбо ихтэй.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Исланд, Баруун Сахар, Мавритани, Гамби, Марокко, Мали, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Фароз Арлууд, Гибралтар, Франц, Нигер, Андорра, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Лихтенштейн, Ливийн Жамахири, Австри, Свалбард Ян Майен, Швед, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Турк, Молдов, ОХУ, Танзани, Кипр, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Эмират, Оман, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Бруней, Хонконг, Тайвань, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Буянт, Ховд гол орчмын навчит болон шилмүүст ой (Монгол-Алтайн тойрог), Тэс гол (Тэс голын хөндий), Завхан, Хүнгүй голын хусан төгөл бүхий хөндий (Завханы цөлөрхөг хээр), Хангай, Хэнтий, Хөвсгөлийн тойрог, Хэрлэн-Улз голын сав, Буйр нуур-Халх гол-Хянганы бүсэд үржинэ. Нүүдлийн үедээ дээрх газруудаас гадна Их Нууруудын хотгор, Нууруудын хөндий, Алтайн Өвөр, Зүүн говийн баруун ба хойд хэсгээр тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Шилмүүст болон холимог ой, голын хөндий, татмын ой шугуйд үржих ба нүүдлийн үедээ хот суурин газрын цэцэрлэгт таарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг, дайран өнгөрдөг зүйл бөгөөд 3-р сарын сүүлчээс 4-р сарын эхэнд нүүдэллэн ирж, 4-р сарын сүүлч, 5-р сарын дунд үеэс голын хөндий, нуур орчмын тайгын ой, ойт хээрийн холимог ойд ихэвчлэн шилмүүст мод дээр хуурай иш, мөчирөөр үүр засна. Эм бодгаль улаан хүрэн толбо бүхий цэнхэр туяатай цагаан өнгийн гол төлөв 3-4 өндөг гаргаж, 32-42 хоног дарна. Хөхбүх, хөмрөг, хөөндэй, бужирга мэтийн жижиг шувууд, оготно, огдой, жирх зэрэг жижиг

мэрэгчдээр хооллоно. 8-р сарын сүүлчээс 9-р сарын сүүлч үед намрын нүүдэл үргэлжлэх ба энэ үеэр мод, бут, хад асга бүхий задгай газар, заримдаа хот суурин газрын таримал ойд ганц нэгээр, эсвэл 3-9 тоотой тохиолдоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 2,200,000-3,300,000 үржлийн бодгаль (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Үржлийн нутагт модыг зүй бусаар ашиглах, уул уурхай, жуулчны бааз байгуулах, ойн түймэр гарах зэрэг нь түүний амьдрах орчныг доройтуулна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор 2000 онд тус шувууны 1 дээжийг АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Морин харцагын Монгол орон дахь тархац нутгийн 7.8% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Морин харцага (*Accipiter nisus*) нь 23.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 4.6 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ҮҮРСЭЭ ХАРЦАГА

Accipiter badius Gmelin, 1788

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Shikra (Little-banded Goshawk)

Орос: Тювик

Хятад: He'er Ying

Герман: Schikrasperber

Франц: Epervier shikra

Казах: Мықи

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Үнэлэх боломжгүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ


Биеийн урт 28-35 см. Эрийн далавчны урт 182-228 мм бол эмийнх 153-160 мм. Биеийн жин 160-275 г хүрнэ.

Бие гүйцсэн эрийн биеийн дээд хэсэг цайвардуу саарал, ооч, хоолой дагасан тууш судалтай, биеийн доод хэсэг цагаан ба бор шаргал хөндлөн судал ихтэй. Бие гүйцсэн эм эртэй төсөөтэй ч эрээс арай бор, биеэр харьцангуй том. Залуу шувуу нь цайвардуу бор хүрэн нуруутай, тод

илэрсэн хоолой дагасан тууш судалтай. Хошуу хар. Хошууны зэтэр болон хөл шар.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Сенегал, Мавритани, Гамби, Гвиней, Сьерра-Леоне, Мали, Либер, Буркина Фасо, Гана, Того, Нигер, Бенин, Нигери, Камерон, Конго, Ангол, Намиби, Чад, Төв Африк, Өмнөд Африк, Ботсвана, Судан, Замби, Зимбабве, Лесото, Руанда, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Швейцарь, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Эритри, Ирак, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Казахстан, Кувейт, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикистан, Энэтхэг, Киргиз, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапурт тархсан. Азербайджанд утсан.



ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 500,000-1,000,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Модны зүй бус ашиглалт, уул уурхай, жуулчны бааз, түймэр зэргээс шалтгаалан түүний амьдрах орчин алдагдаж байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Энэ зүйлийн нийт 5 дээжийг 2011 онд АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) баримт бий.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Үүрсээ харцага (*Accipiter badius*) нь 22.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 4.4 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Өмнөговь аймгийн Даланзадгад хотоос холгүй “Жуулчин” аялал жуулчлалын баазын орчимд 1986 оны 5-р сарын 29-нд 1 бодгаль ажиглагдсан.



АМЬДРАХ ОРЧИН

Шилмүүст болон холимог ой, голын хөндийн ой, хот суурин газрын цэцэрлэгт хүрээлэнд тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд тохиолдлоор таарах зүйл бөгөөд хаврын нүүдлийн үедээ ганцхан удаа тэмдэглэгдсэн. Манай орноор хаврын нүүдлийн үедээ 4-р сарын сүүлчээс 5-р сарын сүүлч, намар 8-р сарын сүүлчээс 9-р сарын сүүлч хүртэлх хугацаанд Алтайн Өвөр говийн баянбүрдүүд, Үенч, Бодонч, Булган голын шугуйгаар дайран өнгөрөх боломжтой. Томоохон шавж, мэлхий, гүрвэл, хааяа жижиг шувуу, амьтдаар хооллоно.



ШУНГААЧ ХАРЦАГА

Accipiter gularis Temminck et Schlegel, 1844

Баг: Шонхор (*Falconiformes*)
Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Japanese Sparrow Hawk

Орос: Малый перепелятник

Хятад: Riben Songque Ying

Герман: Trillersperber

Франц: Epervier du Japon

Казах: Шүйілгіш қаршыға

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (Gombobaatar *et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Эр нь эмээсээ биеэр жижиг. Биеийн урт 230-300 см. Эрийн далавчны урт 158-170 мм, эмийнх 182-201 мм. Биеийн жин 192 г хүрнэ.

Бие гүйцсэн эр шувуу бараавтар хөхвөр саарал нуруутай, биеийн доод хэсэг нарийн бор шаргал

хөндлөн судалтай, нүдний өнгө улбар хүрэн ба нүдний зовхин хүрээ нарийн шаргал. Эм нь эртэйгээ ихээхэн төсөөтэй ч биеэр жижиг, цээж, хэвлийдээ хүрэн бор хөндлөн судалтай, хоолойдоо нарийн босоо судалтай. Залуу шувууны хоолойн босоо судал тод хар, цээж нь өргөн бараан хүрэн судалтай. Хошуу хар. Нүд, хошууны зэтэр, хөл шар.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

ОХУ, Энэтхэг, Хятад, Монгол, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапур, Бруней, Макао, Хонконг, Тайвань, Филиппин, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.



заримдаа хот суурин газрын таримал ойд ганц нэгээр, эсвэл 2-3 тоогоор тохиолдоно.


ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 10,000-100,000 үржлийн насны бодгальтай хэмээн үнэлжээ (Gombobaatar *et al.*, 2011).

Түүний үржлийн болон дайрч өнгөрдөг орчин, нөхцөл нь ойн зүй бус ашиглалт, уул уурхай, жуулчны бааз, түймэр зэргээс шалтгаалан доройтож байна (Gombobaatar *et al.*, 2011).

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Тэс голын хөндийгөөс зүүн тийш Хангай, Хэнтий, Хөвсгөлийн тойрог, Туул голын хөндий, Богд уул, Онон голын хөндийн ой, ойт хээрийн навчит болон шилмүүст ойд үүрлэнэ. Их Богдод үүрлэх боломжтой тухай мэдээ бий. Нүүдлийн үедээ тал хээр, говь цөлийн бүсэд тохиолдоно.



ХУДАЛДАА

Одоогоор манай оронд худалдааны баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Шунгаач харцагын Монгол орон дахь тархац нутгийн 8.3% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

АМЬДРАХ ОРЧИН

Шилмүүст болон холимог ой, мод, бут бүхий голын хөндий, татмын ой шугуйг шүтэн амьдарна. Нүүдлийн үедээ хот суурин газрын цэцэрлэгт хүрээлэнд таарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд ховор тохиолдох нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд хавар 4-р сарын дундаас 5-р сарын эхэнд нүүдэллэн ирж, тайгын ой, ойт хээр, нуур, голын хөндийн шилмүүст, эсвэл навчит модонд үүрлэнэ. Эм нь улаан хүрэн толбо бүхий цэнхэр туяатай цагаан өнгийн гол төлөв 4-6 өндөг гаргана. Өндөгнөөс 28-30 хоногийн дараа ангаахай гарна. Хөхбүх, хөмрөг, хөөндэй, бужирга мэтийн жижиг шувууд, оготно, огдой, жирх зэрэг жижиг мэрэгчдээр хооллоно. 8-р сарын сүүлчээс 9-р сарын дунд үед намрын нүүдэл үргэлжлэх ба энэ үеэр мод, бут, хад асга бүхий задгай газар,

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Шунгаач харцага (*Accipiter gularis*) нь 15.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 3.0 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ТАРЛАН САР

Buteo lagopus Pontoppidan, 1763

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Rough-legged Buzzard

Орос: Зимняк (Мохноногий канюк)

Хятад: Maojiao Kuang

Герман: Rauhfussbussard

Франц: Buse pattue

Казах: Айнаканат тілеміш

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Эрийн биеийн урт 510-600 мм, эмийнх 555-600 мм. Эр бодгалийн далавчны урт 416-450 мм бол эмийнх 435-470 мм. Биеийн жин 800-1,227 г хүрнэ.

Бие гүйцсэн шувууны толгой, нуруу, мөрний хэсгийн хүрэн өдүүд цайвар эмжээртэй, хэвлий бор хүрэн, цээж, гүеэний хэсэг судал, толбуудтай. Сүүлний уг цагаан ба үзүүр нь 2-3 хөндлөн бараан судалтай. Далавчны 1 ба 2-р дэвүүр өдний үзүүр хүрэн. Далавчны атгаалын хэсэгт доод талаасаа бараан хүрэн өнгийн том толбо тод харагдана.

Тарс хуруугаа хүртэл өдөөр бүрхэгдсэн. Хошуу бараан. Хөл, хошууны зэтэр шар.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Канад, АНУ, Мексик, Сэнт Пьер ба Микелон, Бермуд, Исланд, Ирланд, Испани, Их Британи, Фароз Арлууд, Франц, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Лихтенштейн, Ливийн Жамахири, Австри, Свалбард Ян Майен, Швед, Чех, Словени, Польш, Мальта, Хорват, Босни, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Украин, Болгар, Эстони, Беларусь, Турк, Молдов, ОХУ, Кипр, Израиль, Йордан, Ливан, Гүрж, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Узбекистан, Афганистан, Тажикстан, Хятад, Монгол, Бутан, Тайвань, БНАСАУ, БНСУ, Японд тархжээ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Орхон-Сэлэнгийн сав, Их Нууруудын хотгор, Дундад Халхын хээрийн цасны нимгэн, үлийн цагаан оготны идэвхтэй колонийг даган өвлийн улиралд байршина.



АМЬДРАХ ОРЧИН

Задгай тал хээр, уулсын хөндий, хотос, голын хөндийд өвөлжих ба нүүдлийн үедээ ойт хээрт таарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд өвөл орж ирдэг зүйл бөгөөд уулын хээр, харганат хээр болон цөлийн хээрийн хойд хэсгийн үлийн цагаан оготно, чичүүл элбэг тархсан, нимгэн цастай нутгаар цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан 10-р сарын эхээс 11-р сарын эхэн үед нүүдэллэн ирдэг. Ихэвчлэн ганц нэгээр, эсэл 3-6 тоогоор тохиолдоно. Хавар 2-р сарын сүүлч, 3-р сарын эхээр хойд зүгт нүүдэллэж эхэлнэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 300,000-1,000,000 үржлийн насны бодгаль (BirdLife International, 2017) хэмээн үнэлжээ.

Уул уурхай, газрын тосны олборлолт, жуулчны бааз, мэрэгчийн хоронд дамаар хордож энддэг. Мөн өндөр хүчдлийн цахилгаанд цохиулж үхнэ (Gombobaatar et al., 2011).

ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны мэдээ баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

Тарлан сарын Монгол орон дахь тархац нутгийн 7.5% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar et al., 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Тарлан сар (*Buteo lagopus*) нь 70.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 14.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ



ШИЛИЙН САР

Buteo hemilasius Temminck et Schlegel, 1844

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Upland Buzzard

Орос: Мохноногий курганник

Хятад: Да Каунг

Герман: Mongolenbussard

Франц: Buse de Chine

Казах: Жүнбалак тілеміш

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 610-720 мм. Эрийн далавчны урт 445-480 мм, эмийнх 490-504 мм. Биеийн жин 800-1,227 г хүрнэ.

Тарлан сартай төсөөтэй ч сүүл цайвар, залуурын үзүүрт цөөн нарийн хөндлөн судалтай. Зүсний 3 ялгаатай хэлбэр (цайвар, бараан, улбар хүрэн) байна. Тарс хуруугаа хүртэл өдөөр бүрхэгдсэн. Залуу шувууны залуур өд хөндлөн бараан нарийн судал олонтой. Хошуу, хумс хар. Зэтэр, хөл шар.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

ОХУ, Иран, Казахстан, Узбекистан, Тажикстан, Энэтхэг, Хятад, Балба, Монгол, Бутан, Хонконг, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол Алтай, Говь-Алтайн тойрог, Их Нууруудын хотгор, Хангай, Хөвсгөл, Хэнтийн тойрог (тайга болон д.т.д 3000 м-ээс дээш газрууд орохгүй), Дундад Халхын хээр, Дорнод Монголын хээр тал, Буйр нуур-Халх гол-Хянганы тойрог, Нууруудын хөндий, Хойд ба Зүүн Говийн хотгорт идэш тэжээлийн элбэгшилээс хамааран үржинэ. Улирлын шилжилтийн үед Алтайн Өвөр говь, Говь-Алтайн зарим нутгаар тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Уулын болон ойт хээрийн харганатай орчин, гол, нуурын хөндийн дэрс бүхий нутгийн задгай орчныг шүтэж амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд ердийн тохиолдох суурин зүйл боловч залуу шувууд өмнө зүгт нүүдэг байж болзошгүй. Тэд 3-р сарын сүүлчээс 4-р сарын эхэнд буцаж ирдэг. Ихэнх бие гүйцсэн шувууд үлийн цагаан оготно элбэгтэй нутагт өвөлжинө. 4-р сарын сүүлч, 5-р сарын эхээр үржлийн шувууд мод, хавцал хад, чулуу, газар дээр, эсвэл хаягдсан худаг, машины кабин, өндөр хүчдэлийн шон, малын саравч гэх мэт байгалийн болон хиймэл байгууламж дээр амьдрах орчны онцлогоос шалтгаалан харганы иш, малын яс, ноос, металл утас, хуванцар, даавуу гэх мэт зүйлсийг ашиглан үүр засна. Ангаахайн тоо идэш тэжээлээс хамаарах боловч гол төлөв 3-4 өндөг гаргаж, 28-35 хоног дарж ангаахай болгоно. Эцэг, эх шувууд ангаахайгаа үлийн цагаан оготно, чичүүл, огдой зэрэг мэрэгч, туулай хэлбэртэн, мөн жижиг шувуугаар хооллоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээг 2001 онд 10,000 бие гүйцсэн бодгаль хэмээн үнэлсэн боловч түүнээс хойш тоо толгойн үнэлгээ хийгдээгүй байна.

Малын тоо толгойн хэт өсөлт, уул уурхай, газрын тосны олборлолт, хээрийн түймэр зэрэг нь түүний амьдрах орчныг доройтуулж байгаа бөгөөд мэрэгчдийн тоо толгойг зохицуулах зорилгоор цацсан хоронд дам өртөх, өндөр хүчдэлд цохиулах, өндөр хүчдэлд үүрлэсэн үед өндөг, ангаахайг зориудаар унагах, хууль бусаар агнах, машинд мөргүүлэх зэрэг олон шалтгаан энэ зүйлийн хэвийн амьдралд сөргөөр нөлөөлж байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

1981 онд ЗХУ руу амьтны хүрээлэнд, 2000, 2002, 2006, 2011, 2012 онд шинжлэх ухааны зорилгоор цус, эдийн дээж, өндөг зэргийг АНУ, Герман улс руу, 2016 онд хувийн хэрэгцээнд 1 хөлийг АНУ гаргаж, бие гүйцсэн 1 бодгалийг 2007 онд БНСУ-аас импортолсон (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

Шилийн сарын Монгол орон дахь тархац нутгийн 9% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Шилийн сар (*Buteo hemilasius*) нь 84.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 16.8 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ТАЛЫН САР

Buteo rufinus Cretzschmar, 1827

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Long-legged Buzzard

Орос: Курганник

Хятад: Zongwei Kuang

Герман: Adlerbussard

Франц: Buse féroce

Казах: Тілеміш

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (Gombobaatar *et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 573-595 мм. Эрийн далавчны урт 405-438 мм, эмийнх 442-473 мм. Биеийн жин ойролцоогоор 2,000 г хүрнэ.

Эр, эм хоорондоо ижил зүстэй. Шилийн сартай ихээхэн төсөөтэй ч улбардуу бор хүрэн зүс, тарс нүцгэн, залуур улбардуу, хөндлөн судалгүй байдгаараа ялгарна. Саруудын залуу шувуудыг хооронд нь ялгахад хэцүү ч тарс нүцгэн, улбардуу зүс зэргийг харгалзана.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Кабо-Верде, Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби, Марокко, Мали, Португали, Испани, Алжир, Буркина Фасо, Франц, Гана, Того, Нигер, Бельги, Нигери, Нидерланд, Норвег, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Ливийн Жамахири, Австри, Швед, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Босни, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Ботсвана, Грек, Румын, Македони, Финланд, Судан, Украин, Болгар, Беларусь, Египет, Турк, ОХУ, Танзани, Уганда, Кипр, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмарт тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хонгорын элсний заган ойд үрждэг. Нүүдлийн үедээ Туул гол, Хойд говь, Нууруудын хөндий, Завхан голын хөндий, Булнай уул, Дундад Халхын Хээр (Төв аймгийн Сэргэлэн сум, Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Дорноговь аймгийн Айраг сум), Хойд ба Зүүн говь, Говь-Алтайн тойрог, Алтайн Өвөр говийн хойд хэсгээр тохиолдоно. Үлийн цагаан оготны нягтшлаас хамааран Дундад Халхын хээрт орж ирдэг (Gombobaatar *et al.*, 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Говь цөлийн заган ой, харганат хээр, уулын хээрийн хөндийг шүтнэ.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын дундаас 5-р сарын эхэн үед нүүдэллэн ирж, 4-р сарын сүүлч, 5-р сарын эхээр бургас, заг, улиас, эсвэл хадан дээр харгана, модны мөчирөөр үүр засна. Жижиг улаан хүрэн толбо бүхий цайвар өнгийн гол төлөв 2-5 өндөг гаргана. Өндөгнөөс 28-30 хоногийн дараа ангаахай хагарч гарна. Ихэнхдээ оготно, чичүүл, зусаг, огдойгоор, заримдаа шувуугаар хооллоно. Намрын нүүдэл 9-р сарын эхээс 10-р сарын эхэнд явагдах ба энэ үед ганц нэгээр, эсвэл цөөн тоогоор таарна.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 100,000-500,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) хэмээн тооцоолсон байна.

Малын тоо толгойн хэт өсөлт, уул уурхай, загийг түлшинд ашиглах зэрэг нь түүний амьдрах орчныг доройтуулж, мэрэгчдийн тоо толгойг зохицуулах зорилгоор хэрэглэсэн хоронд дам өртөж хордоно. Өндөр хүчдэлд цохиулан олноор энддэг (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

2002 онд АНУ руу нийт 2 бодгалийг цуглуулгын зорилгоор, мөн 2011, 2012 онд судалгааны тодорхой тооны дээжийг АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

Талын сарын Монгол орон дахь тархац нутгийн 12.1% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Талын сар (*Buteo rufinus*) нь 74.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 14.8 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ОЙН САР

Buteo buteo Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Common Buzzard

Орос: Обыкновенный канюк (Сарыч)

Хятад: Putong Kuang

Герман: Mäusebussard

Франц: Buse variable

Казах: Жамансары

Тайлбар: Манай оронд амьдрах ойн сарын 2 салбар зүйлийг эдүгээ 2 бие даасан зүйл (*Buteo buteo*, *Buteo japonicus*) болгон салгасан. Бид энд дээрх хоёр салбар зүйлийг нэгтгэсэн байдлаар бичлээ.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ


Эр, эмээсээ биеэр жижиг. Биеийн урт 50-57 см. Эрийн далавчны урт 343-400 мм, эмийнх 358-423 мм. Биеийн жин 1,000 г хүрнэ.

Бие гүйцсэн шувууны зүс талын сартай тун ижил. Биеэр харьцангуй жижиг, залуу өд дээрээ нарийн хөндлөн бараан судал олонтой, цээжээр өргөн хөндлөн цайвар судал илэрсэн байдгаар ялгана. Бие гүйцсэн шувуунаас цайвар нүд, залуур өдний дээрх хөндлөн судал олон, цээжний зарим судал тууш байдгаар нь ялгана.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Исланд, Кабо-Верде, Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби, Марокко, Сьерра-Леоне, Мали, Либери, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Фароз Арлууд, Гибралтар, Франц, Гана, Того, Андорра, Бельги, Нигери, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Габон, Лихтенштейн, Ливийн Жамахири, Австри, Конго, Швед, Ангол, Намиби, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Төв Африк, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серб, Албани, Ботсвана, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Замби, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Зимбабве, Турк, Молдов, Лесото, ОХУ, Руанда, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Швейцарь, Кипр, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Мальдив, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапур, Бруней, Хонконг,

Тайвань, Филиппин, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хангай, Хөвсгөл, Хэнтийн тойргийн ой, ойт хээр, голын хөндийн хөгшин мод бүхий ойд үржинэ. Мөн Монгол-Алтайн тойрог, Их Нууруудын хотгор, Дорнод Монголын тал хээр, Нууруудын хөндийгөөр нүүдлийн үедээ тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Ой, ойт хээрт үржих ба нүүдлийн үедээ тал хээр, гол, нуурын хөндий, хад асга, говь цөлд тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын дундаас 5-р сарын эхэн үед нүүдэллэн ирж, 5-р сарын эхээр ой, ойт хээр, нуур, голын хөндийн навчит болон шилмүүст мод, эсвэл хад асган дээр хуурай иш, мөчирөөр үүр засна. Жижиг улаан хүрэн толбо бүхий цагаан өнгийн гол төлөв 3-6 өндөг гаргаж, 33-35 хоног дарж ангаахай болгоно. Ангаахай 40-45 хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Оготно, огдой, хулгана, шавж, гүрвэлээр хооллоно. Намрын нүүдэл 8-р

сарын сүүлчээс 9-р сарын дундуур явагдах ба энэ үедээ гол төлөв ганц нэгээр, эсвэл 3-8 тоогоор тохиолдоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 2,100,000-3,700,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Уул уурхай, ойн зохисгүй ашиглалт, түймэр зэргийн нөлөөгөөр түүний амьдрах орчин доройтож байна. Мөн өндөр хүчдэлд цохиулан олноор энддэг (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор судалгааны дээж болон агнасан 3 бодгалийг АНУ руу 2000 онд гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

Ойн сарын Монгол орон дахь тархац нутгийн 8.0% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Ойн сар (*Buteo buteo*) нь 67.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 13.4 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



САРЖУУ ХАРЦГАЙ

Butastur indicus Gmelin, 1788

Баг: Шонхор (*Falconiformes*)
Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Grey-faced Buzzard
Орос: Ястребиный сарыч
Хятад: Huilian Kuangying

Герман: Kiefernteesa
Франц: Busautour a joues grises
Казах: -

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Үнэлэх боломжгүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.


ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 41-46 см. Биеийн жин 375-433 г хүрнэ. Бие гүйцсэн шувууны цээжний дээд хэсэг, хүзүү улаан хүрнээс хар хүрэн. Толгой бараан саарал, хоолой цагаан, сахал тод хар. Нуруу, далавчны ар хэсэг бор, гэдэс хэвлий, далавчны өвөр хэсэг нь улбардуу бор судлуудтай. Залуу шувууны зүс улбар хүрэн ба хэвлий хар хүрэн судалтай.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

ОХУ, Хятад, Монгол, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапур,

Бруней, Хонконг, Тайвань, Филиппин, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хэнтийн Хонин нугын судалгааны сууринд

ажиглагдсан (Gombobaatar *et al.*, 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Шилмүүст болон холимог ойд амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд ердөө ганц удаа тайгын холимог ойд бүртгэгдсэн ба тохиолдлын байдлаар таарах зүйл юм. Иймээс нүүдлийн үедээ буюу 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд (хаврын нүүдэл), мөн 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд (намрын нүүдэл) тохиолдож болзошгүй. Шавж, мэлхий, могой, гүрвэл болон жижиг мэрэгчдээр хооллоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээг 2001 онд 100,000 бие гүйцсэн бодгалиас бүрдэж байна (IUCN Redlist, 2017) хэмээн тооцоолжээ. Түүнээс хойш дахин тоо толгойн үнэлгээ хийгдээгүй байна.

Энэ зүйлийн тоо толгой буурах гол шалтгаан нь уул уурхай, ойн зохисгүй ашиглалт, түймэр зэрэгтэй холбоотой байж болно (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай оронд худалдааны тухай баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Саржуу харцгай (*Butastur indicus*) нь 22.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 4.4 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



МОГОЙЧ ЗАГАЛАЙ

Circaetus gallicus Gmelin, 1788

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Short-toed Snake-Eagle (Short-toed Eagle)

Орос: Обыкновенный змеяед

Хятад: Duanzhi Diao

Герман: Schlangennadler

Франц: Circaète Jean-le-Blanc

Казах: Жыланжегіш бүркіт

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй” зүйл (Gombobaatar *et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Эрийн биеийн урт 670-720 мм, эмийнх 720 мм. Далавчны урт эрийн хувьд 520-552 мм, эмд 520-570 мм хүрнэ. Биеийн жин эрд 1,500-2,000 г, эмд 1,513-2,324 г байна.

Бие гүйцсэн шувууны нуруу бор хүрэн, биеийн доод хэсэг бор хүрэн хөндлөн судал, толбо ихтэй. Шар нүдтэй. Савар хөх бор. Хошуу эвэрлэг бороос бараан саарал. Зүсний хувьсал ихтэй.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби, Гвиней, Марокко, Сьерра-Леоне, Мали, Либер, Португали, Испани, Их Британи, Гибралтар, Буркина Фасо, Франц, Гана, Того, Нигер, Бенин, Андорра, Бельги, Нигери, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Ливийн Жамахири, Конго, Швед, Ангол, Намиби, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Төв Африк, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Ботсвана, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Замби, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Турк, Молдов, Лесото, ОХУ, Руанда, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Кипр, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг,

Киргиз, Хятад, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мьянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапур, Зимбабвед тархсан. Австрид тохиолдлын байдлаар үзэгдэнэ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хэнтийн нурууны баруун өмнөд хэсэг, Сэлэнгэ мөрний савд үржинэ. Нүүдлийн үедээ Орхон, Сэлэнгэ, Туул голын хөндий, Сүхбаатар аймгийн Хужаа Шаамар, Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Зүүн Хайлаастай, Шүтэгийн Баянгол, Өөшийн говь, Ноён сум, Галбын говийн Батаагийн голд нүүдлийн үедээ тэмдэглэгдсэн (Gombobaatar *et al.*, 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Говь цөлийн хайлаас, тооройг шүтэн амьдарна. Нүүдлийн үедээ тал хээр, говь цөлд тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын дундаас 5-р сарын эхэнд ирж, хайлаас модон дээр хуурай мөчирөөр үүр засна. Цагаан өнгийн 1 өндөг гаргаж, 40-47 хоног дарсны дараа ангаахай өндөгнөөс хагарч гарна. Ангаахай 70-75 хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Гол төлөв могой, гүрвэлээр хооллоно. Тэд 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд нүүдэллэх ба энэ үедээ ойт хээр, хээр, говь цөлийн бүсэд ганц нэгээр, эсвэл 3-4 тоогоор тохиолдоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 100,000-200,000 бие гүйцсэн бодгиас бүрдэх бөгөөд тэдгээрийн тоо толгой харьцангуй тогтвортой байна (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Малын нөлөө, уул уурхай зэргээс шалтгаалан түүний амьдрах орчин доройтож байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны тухай баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

Могойч загалайн Монгол орон дахь тархац нутгийн 11.9% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Могойч загалай (*Circaetus gallicus*) нь 140.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 28.0 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

УУЛЫН СОГСООТБҮРГЭД

Spizaetus nipalensis Hodgson, 1836

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)



НЭРШИЛ:

Англи: Mountain Hawk-eagle

Орос: Хохлатый орёл

Хятад: Ying Diao

Герман: Bergadler

Франц: Aigle montagnard

Казах: Айдарлы таубүркіт

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Үнэлэх боломжгүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт эрд 700-745 мм, эмд 770-830 мм. Эрийн далавчны урт 419-465 мм, эмийнх 445-508 мм.

Бие гүйцсэн шувууны зүс бор хүрэн, хэвлийгээс тарс хүртэл хөндлөн бараан судалтай. Далавч өргөн мохоо хэлбэртэй. Сүүл хөндлөн бараан тод судалтай. Түүний үзүүр цайвар эмжээртэй. Дагз дээрээ урт өрөвлөг өд-согсоотой. Залуу шувуудын биеийн доод хэсэгт судал толбо багатай эсвэл сийрэг тууш судалтай.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

ОХУ, Пакистан, Энэтхэг, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бутан, Мянмар, Тайланд, Лаос, Вьетнам, Камбож, Хонконг, БНСУ, Тайвань, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Улаанбаатар хотод Туул голын хөндий Сонгины тохойд бүртгэгдсэн.



АМЬДРАХ ОРЧИН

Тайгын шилмүүст болон холимог ойд амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд ганц удаа бүртгэгдсэн, тохиолдлын байдлаар үзэгдэх зүйл бөгөөд Туул голын хөндийд Сонгины тохой орчимд навчит, холимог ойд 1993 оны 6-р сарын 14-нд 1 бодгаль тэмдэглэгдэж байсан. Жижиг хөхтөн, шувуу, гүрвэлээр хооллоно (Gombobaatar *et al.*, 2011).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 2011 онд 10,000 бие гүйцсэн бодгальтай байсан бол түүнээс хойш энэ зүйлийн тоо толгой буурсаар байна (Birdlife International, 2011; 2017) хэмээн үнэлсэн.

Уул уурхайг эмх цэгцгүй хөгжүүлэх, аялал, амралтын газар олныг байгуулах, хүн, машин техник их холхих, ойг зохисгүй ашиглах зэрэг нь

түүний амьдрах орчныг доройтуулах шалтгаан болж байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай орны хувьд худалдааны тухай мэдээ байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Уулын согсоотбүргэд (*Spizaetus nipalensis*) нь 220.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 44.0 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



БАХИМ БҮРГЭД (БАХИМ БҮРГЭДЭЙ)

Hieraetus pennatus Gmelin, 1788

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Booted Eagle

Орос: Орёл-карлик

Хятад: Xue Sundiao (Xiao Diao)

Герман: Zwergadler

Франц: Aigle botté

Казах: Бақалтақ бүркіт

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ


Биеийн урт 480-630 мм. Эрийн далавчны урт 380-395 мм, эмийнх 405-435 мм. Сүүлний урт эрд 187-202 мм, эмд 196-230 мм хүрнэ.

Бие гүйцсэн болон залуу шувууд элээтэй тун төсөөтэй ч сүүл ацлаагүй, мөн мөрний дээр жижиг цагаан толботой. Өнгө зүсний бараан ба цайвар хэлбэр бий. Хошуу хар. Хошууны зэтэр, хөл шар.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби,

Марокко, Сьерра-Леоне, Мали, Либери, Португали, Испани, Алжир, Гибралтар, Буркина Фасо, Франц, Гана, Того, Нигер, Бенин, Бельги, Нигери, Нидерланд, Герман, Швейцарь, Итали, Тунис, Камерон, Ливийн Жамахири, Австри, Конго, Швед, Ангол, Намиби, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Төв Африк, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серб, Албани, Ботсвана, Грек, Румын, Македони, Финланд, Судан, Замби, Украин, Болгар, Беларусь, Египет, Зимбабве, Турк, Молдов, Лесото, ОХУ, Руанда, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Кипр, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Эмират, Оман, Туркменистан, Сейшел, Узбекистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Сингапурт тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Ховд голын хөндий, Булган сум, Хархираа, Түргэний уулс, Даян нуур (Монгол-Алтайн тойрог), Булнайн тойрог, Цэцэрлэг (Хангайн тойрог), Борнуур, Богдхан уул, Туул гол, Хөгнөцагаан уул (Хэнтийн тойрог) орчмын нутагт өндөглөнө. Хөвсгөл, Хангай, Хэнтийн тойрог, Монгол Дагуур, Дорнод Монгол, Дундад Халх, цөлийн хээрээр нүүдлийн үедээ таарна.



АМЬДРАХ ОРЧИН

Тайгын ой, ойт хээр, голын хөндийн шилмүүст болон холимог ой бүхий нутагт амьдардаг.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын дундаас 5-р сарын эхэнд нүүдэллэн ирж, 4-р сарын сүүлч, 5-р сарын эхэн үед үржиж эхэлнэ. Навчит болон холимог ой бүхий голын хөндий, тайгын ой, ойт хээрт шилмүүст модон дээр иш мөчирөөр томоохон үүр барьж, цагаан өнгийн гол төлөв 1-2 өндөг гаргана. Үржлийн үедээ бие гүйцсэн шувууд ойт хээр, ойн орчмын задгай газарт ганц нэгээр халин нисэж оготно, огдой, урт сүүлт зурам зэрэг хөхтөн амьтан, жижиг болон дунд зэргийн хэмжээтэй шувуугаар

хооллож, ангаахайгаа тэжээнэ. Нүүдлийн үедээ ой, ойт хээрт ганц нэгээр, хосоороо, эсвэл 2-3 тоогоор ниснэ. Идэш тэжээлийн олдоц, цаг агаараас шалтгаалан 8-р сарын сүүлчээс 9-р сарын дундуур нүүдэллэнэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 149,000-188,000 бодгаль (BirdLife International, 2017) гэж тооцоолжээ.

Ойн зүй бус ашиглалт, түймэр, эмх замбараагүй аялал жуулчлал, хорт бодис, өндөр хүчдлийн нөлөөгөөр түүний тоо толгой цөөрөх эрсдэлтэй (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор 2002 онд судалгааны дээжийг Герман улс руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

Бахим бүргэдийн Монгол орон дахь тархац нутгийн 9% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Бахим бүргэд (*Hieraatus pennatus*) нь 64.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 12.8 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ХАРСУН БҮРГЭД (ХАРСУН БҮРГЭДЭЙ)

Hieraetus fasciatus Vieillot, 1822

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Bonelli's Eagle

Орос: Ястребиный орёл

Хятад: Baifu Sundiao

Герман: Habichtsadler

Франц: Aigle de Bonelli

Казах: Кыргы бүркіт

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Үнэлэх боломжгүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 660-790 мм. Эрийн далавчны урт 460-490 мм, эмийнх 490-520 мм. Сүүлний урт эрд 240-266 мм, эмд 253-292 мм хүрнэ.

Бие гүйцсэн шувуу бахим бүргэдэйтэй төсөөтэй ч сээр нуруу дээгүүрээ том цагаан толботой, мөн далавчны уртын дагуу бараан судал үргэлжилнэ. Биеийн доод хэсэг цагаан нарийн бор хүрэн судал ихтэй. Сүүлний үзүүр өргөн бараан эмжээртэй. Залуу шувууд бие гүйцсэнтэйгээ ойролцоо ч

сүүлний эмжээр илрээгүй төдийгүй биеийн доод хэсэг ухаа.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Мавритани, Марокко, Португали, Испани, Алжир, Гибралтар, Франц, Бельги, Нидерланд, Люксембург, Герман, Итали, Тунис, Дани, Ливийн Жамахири, Австри, Швед, Чех, Хорват, Босни, Унгар, Словак, Серби, Монтенегро, Албани, Грек, Румын, Македони, Болгар, Египет, Турк, Кипр, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Ирак, Гүрж, Джибути, Йемен, Армен, Иран, Казахстан, Кувейт, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Лаос, Хонконг, Вьетнамд тархана.



ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 20,000-50,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Түүний тоо толгой буурах гол шалтгаан нь ойг зүй бусаар ашиглах, түймэр зэрэг хүний хүчин зүйл болно.

ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны талаарх мэдээ байхгүй.

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Өмнөговь аймгийн Хан Богд сумын нутагт 1987 оны 9-р сарын 3-нд тэмдэглэсэн.



АМЬДРАХ ОРЧИН

Шилмүүст болон холимог ойд амьдарна. Нүүдлийн үедээ тал хээрт ч таарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай оронд зөвхөн 2 удаа тэмдэглэсэн бөгөөд тохиолдлын байдлаар ховор үзэгдэх зүйл юм. Ойд үржих боловч 4-р сарын дундаас 5-р сарын эхэн, 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд нүүдлийн үедээ тал хээр, говь цөл, өндөр ууланд тохиолдох боломжтой. Туулай зэрэг хөхтөн амьтан, дунд зэрэг хэмжээтэй шувуугаар хооллоно.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>) болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Харсун бүргэд (*Hieraaetus fasciatus*) нь 58.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 11.6 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ТАРВАЖИ БҮРГЭД

Aquila nipalensis Hodgson, 1833

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Steppe Eagle

Орос: Степной орел

Хятад: Саоуан Диао

Герман: Steppenadler

Франц: Aigle des steppes

Казах: Дала қыраны



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Устаж болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 720-810 мм. Далавчны урт 540-650 мм. Биеийн жин эрийн хувьд 2,400-3,900 г бол эмд 4,800 г хүрнэ.

Бие гүйцсэн шувууны биеийн ерөнхий зүс бор хүрэн, толбо судалгүй. Дэвүүр болон залуур өд харьцангуй өргөн хөндлөн бараан судалтай. Эм нь эрээс арай том. Хошууны зэтэр, завж, хөл тод шар. Бусад бүргэдээс ялгах чухал шинж бол завж нүдний ард харалдаа хүртэл үргэлжилнэ. Залуу бодгалийн далавчны 1 ба 2-р зэргийн дэвүүрийн үзүүр, далавчны доод их даруул өд болон дээд даруул өд өргөн цайвар судалтай байх ба 3-4 дэх жилээс бие гүйцсэн бодгалийнхтай ижил болно. Хөл нь хуруугаа хүртэл өдөөр бүрхэгдсэн.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Мали, Испани, Франц, Нигер, Нигери, Нидерланд, Норвег, Герман, Итали, Тунис, Дани, Камерон, Конго, Швед, Ангол, Намиби, Чех, Чад, Польш, Хорват, Өмнөд Африк, Унгар, Словак, Албани, Ботсвана, Грек, Финланд, Судан, Замби, Украин, Эстони, Египет, Зимбабве, Турк, ОХУ, Руанда,


Бурунди, Танзани, Уганда, Швейцарь, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Жибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Хятад, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Тайланд, Малайз, Вьетнам, Сингапур, БНАСАУ-д тархсан. Румын, Болгар, Молдов улсад утсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол Алтай, Говь-Алтайн тойрог (д.т.д 2,500 метрээс доош өндөрт), Их Нууруудын хотгор, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн тойрог (өтгөн ой, ус намгархаг газраас бусад), Дундад Халхын хээр, Дорнод Монголын тал, Буйр нуур-Халх гол-

Хянганы бүс нутаг, Нууруудын хөндий, Хойд говь, ховор тохиолдолд Алтайн Өвөр говь, Зүүн говийн Хотгорын ойт хээр, уулын хээр, хээр, цөлийн хээрт үржинэ. Үржлийн хосын нягтшил тухайн орчны үлийн цагаан оготно, зурамны популяцийн хэмжээнээс хамаарна.



АМЬДРАХ ОРЧИН

Ойт хээр, хээр, цөлөрхөг хээрийн бэсрэг уулс, уулс хоорондын хөндийн мэрэгчид, ялангуяа үлийн цагаан оготно элбэгтэй нутагт олноор амьдардаг.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн, үрждэг, түгээмэл тохиолдох зүйл бөгөөд 3-р сарын сүүлчээс 5-р сарын эхэн үед нүүдэллэн ирж, 5-7-р сард үрждэг. Үржлийн шувууд үлийн цагаан оготно ихтэй хээр талд хад, цохио, газар зэрэг байгалийн, шон, машины кабин, орхигдсон барилга байгууламжийн дээвэр зэрэг хиймэл биет дээр үүр засна. Улаан хүрэн, бараан толбо бүхий цагаан өнгийн 1-3 (гол төлөв 2) өндөг гаргаж, 45 орчим хоног дарж ангаахай болгоно. Гол төлөв монгол тарвага, хярс, бор туулай, үлийн цагаан оготно, урт сүүлт зурам, зараа, гэрийн ямаа (ишиг) зэрэг хөхтөн амьтан, боролзой богширго, бөвөөлжин өвөөлж, монгол болжмор, хөхвөр тагтаа, дагуур ятуу, наран бөднө, монгол ногтруу зэрэг шувууд, шавжаар хооллоно. Залуу шувууд 8-р сарын сүүлчээс 10-р сарын эхэнд өвөлжих нутаг руу (Хятадын Шар мөрөн ба Миконг гол) нүүдэллэнэ (Gombobaatar *et al.*, 2011).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 50,000-75,000 бие гүйцсэн бодгальтай бөгөөд сүүлийн жилүүдэд тэдгээрийн тоо толгой буурсаар байна (BirdLife International, 2017). Манай оронд 1,500-2,000 хос бий (Болд, Цэвээнмядаг, 2001).

Тоо толгой буурах үндсэн шалтгаан нь малын тоо толгойн хэт өсөлт, уул уурхай, ой, хээрийн

түймэр зэргийн нөлөөгөөр түүний амьдрах орчин доройтох, мөн хоронд дам өртөж хорогдох, Арабын шонхор баригчдын тавьсан урхитай тагтааг барих, өндөр хүчдэлд цохиулах, мөргөх, хөл, хумсыг гоёл чимэглэл хийх, эд эрхтнийг шашны зан үйлд ашиглах зорилгоор хууль бусаар агнах, нутгийн малчид буудан хороох, машинд мөргүүлэх зэрэг болно (Gombobaatar *et al.*, 2011; Гомбобаатар, Одхүү, 2018).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор 2002, 2006, 2009, 2011 онд судалгааны дээжийг АНУ, Герман, Словак улс руу явуулж, агнасан хоёр бодгалийг 2004, 2006 онд АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

Тарважи бүргэдийн Монгол орон дахь тархац нутгийн 7.8% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Тарважи бүргэд (*Aquila nipalensis*) нь 253.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 50.6 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

БОР БҮРГЭД

Aquila clanga Pallas, 1811

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Greater Spotted Eagle

Орос: Большой подорлик

Хятад: Wu Diao

Герман: Schelladler

Франц: Aigle criard

Казах: Шанқылдақ қыран



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Эмзэг”, бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Эр, эмээс биеэр жижиг. Биеийн урт 660-740 мм. Эрийн далавчны урт 485-530 мм, эм 515-560 мм. Биеийн жин эрд 1,600-2,000, эмд 2,150-3,200 г хүрнэ.

Бие гүйцсэн шувуу тарважи бүргэдтэй тун төсөөтэй ч түүнээс арай бараан зүстэй, шуумаг өд богино тул урт хөлтэй харагдана. Мөн хондлой орчимд цагаан толботой ба далавчны доороос атгаал орчимд таслал мэт цагаан судалтай зэргээрээ ялгарна. Дэвүүр болон залуур өдний хөндлөн бараан судал нарийн төдийгүй хоорондоо харьцангуй ойр байдаг онцлогтой. Бие гүйцсэн шувуутай төсөөтэй ч нуруу, далавчны дээд хэсэг, биеийн доод хэсгээрээ цацарсан мэт цайвар толбо ихтэй.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Марокко, Ирланд, Португали, Испани, Их Британи, Гибралтар, Франц, Бельги, Нидерланд,

Люксембург, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Ливийн Жамахири, Австри, Словени, Чад, Польш, Хорват, Босни, Унгар, Словак, Серб, Монтенегро, Албани, Грек, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Замби, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Турк, Молдов, ОХУ, Танзани, Уганда, Кипр, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Афганистан, Пакистан, Энэтхэг, Киргиз, Хятад, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапур, Макао, Хонконг, Тайвань, БНАСАУ, БНСУ, Япон улсад тархсан. Румынд устсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хэнтийн тойрог, Эг, Сэлэнгэ мөрний сав газрын тайгын ой, ойт хээрт үржинэ. Их Нууруудын хотгор, Их Уул, Тарвагатайн нуруу, Тэрх болон Идэрийн гол, Халх, Онон, Балж голын хөндий, Архангай аймгийн Өгий нуур, Булган аймгийн Баян-Овоо, Хутаг-Өндөр ба Айрхан нуурын хооронд, Хэнтий аймгийн Баянголын хөндий, Хараа гол, Тэрэлж, Төв аймгийн Атарт тэмдэглэгдсэн.



АМЬДРАХ ОРЧИН

Уулсын ой, нуур, голын хөндийн шилмүүст болон холимог ойд байршилтгай. Нүүдлийн үедээ тал хээрт ч тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг, дайрч өнгөрдөг ховор тохиолдох зүйл бөгөөд 4-р сарын дундаас 5-р сарын эхэнд нүүдэллэн ирнэ. Нуур, голын хөндийн ойролцоох ойн шилмүүс болон навчит модон дээр том үүр барьж, бор, саарал толбо бүхий сааралдуу өнгийн 1-3 өндөг гаргаж, 42-44 хоног дарж ангаахай болгох боловч гол төлөв 1 ангаахай бойжиж, 60-65 хоногийн дараагаас ниснэ. Жижиг, дунд зэрэг хэмжээтэй хөхтөн амьтан, шувуу, могой, мэлхийгээр хооллоно. 9-р сарын эхээс 10-р сарын эхэнд ихэвчлэн ганц нэгээр нүүдэллэн ниснэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 3,300-8,800 бие гүйцсэн бодгальтай бөгөөд тэдгээрийн тоо толгой буурсаар байна (BirdLife International, 2017).

Малын тоо толгойн хэт өсөлт, уул уурхай, ой, хээрийн түймэр зэргээс шалтгаалан түүний амьдрах орчин доройтож байна. Мэрэгчдийн

хоронд хордох, мөн Арабын шонхор баригчдын тавьсан урихтай тагтааг барих, өндөр хүчдэлд цохиулах, мөргөх, эд эрхтнийг шашны зан үйлд ашиглах зорилгоор хууль бусаар агнах зэрэг нь тэдгээрийн амьдралд сөргөөр нөлөөлж байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Одоогоор манай оронд худалдааны тухай баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016), Азийн Улаан ном (2001)-нд оруулсан.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

Бор бүргэдийн Монгол орон дахь тархац нутгийн 12.1% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Бор бүргэд (*Aquila clanga*) нь 353.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 71.2 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ЦАРМЫН БҮРГЭД

Aquila chrysaetos Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Golden Eagle

Орос: Беркут

Хятад: Jin Diao

Герман: Steinadler

Франц: Aigle royal

Казах: Бүркіт



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 750-900 мм. Далавчны дэлгэмэл урт 1,900-2,270 мм. Биеийн жин нь эрд 2,840-4,450 г, эмд 3,630-6,665 г хүрнэ.

Биеийн ерөнхий зүс бараан хүрэн, зулай, дагз болон далавчны дээд бага даруул өд алтлаг өнгөртэй бор шаргал. Хошуу доош махир, бахим, хурц. Хошууны зэтэр, хөл тод шар. Хан бүргэдтэй төсөөтэй ч сүүл урт, дагзны арын өд алтлаг бор шаргал ба дал мөрөнд цагаан толбогүй. Залуу шувууны биеийн өд хар хүрэн, далавч алаг (дэвүүр болон залуур өдний уг цагаан, үзүүр хэсэг хар).

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Канад, АНУ, Мексик, Сэнт Пьер ба Микелон, Баруун Сахар, Мавритани, Марокко, Мали, Португали, Испани, Алжир, Их Британи, Гибралтар, Франц, Андорра, Бельги, Нидерланд,

Норвег, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Лихтенштейн, Ливийн Жамахири, Австри, Швед, Чех, Словени, Польш, Мальта, Хорват, Босни, Унгар, Словак, Серби, Монтенегро, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Турк, Молдов, ОХУ, Кипр, Этиоп, Израиль, Саудын Араб, Йордан, Сири, Ирак, Гүрж, Йемен, Армэн, Иран, Азербайджан, Казахстан, Киргиз, Кувейт, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Хятад, Балба, Монгол, Бутан, БНАСАУ, БНСУ, Японд тархсан. Ирландад тохиолдлын байдлаар үзэгдэнэ. Ливанд утсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол Алтай, Говь-Алтайн тойрог, Их Нууруудын хотгор (уулын бэл, хавцал), Хангай, Хэнтий, Хөвсгөлийн тойрог (ус, шигүү ой, суурин газраас бусад), Дундад Халхын хээр, Дорнод Монголын тал хээр (хад асгат уул, уулын хадтай энгэр, голын хуурай сайр), Буйр нуур-Халх гол-Хянганы бүс, Зүүнгарын говь (Булган голын хөндий), Алтайн Өвөр говь (уулын хяр), Хойд болон Зүүн говь (хадархаг энгэр)-д үржих ба үржлийн бус үедээ өндөр өргөгдсөн бараг бүх газарт тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Ойт хээр, уулын хээр, тал хээр, цөлийн хээрийн хавцал хад, цохиотой орчинд байршижтай.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны суурин өндөглөдөг зүйл бөгөөд үржлийн нутаг орчимдоо жилийн турш байршина. Өндөр уул, ойт хээр, уулын хээр, хээр, цөлийн хээрийн хадан хавцал, элсэн эрэг, модон дээр үүрлэнэ. Улаан хүрэн, бор саарал, толбо бүхий цагаан өнгийн гол төлөв 1-2 өндөг гаргах ба 43-45 хоногийн дараа өндөгнөөс ангаахай гарна. Ангаахай 63-70 хоногийн дараа нисэх чадвартай болно. Үлийн цагаан оготно, монгол чичүүл, тарвага, бор туулай, хярс, шар үнэг зэрэг хөхтөн болон дагуур ятуу, хөхвөр тагтаа, хахилаг, шувуудын ангаахайгаар хооллоно. Заримдаа харсүүлт, бөхөнгийн янзага барина.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 100,000–200,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Малын тоо толгойн хэт өсөлт, уул уурхай, ой, хээрийн түймэр зэргээс шалтгаалсан түүний амьдрах орчны доройтол үржлийн хосод сөргөөр нөлөөлнө. Үлийн цагаан оготны тоо толгойг зохицуулах зорилгоор цацсан хоронд өртөх, Арабын шонхор баригчдын тавьсан урхитай тагтааг барих, өндөр хүчдэлд цохиулах, мөргөх,

хөл, хумс, толгой зэргийг гоёл чимэглэл, бэлэг дурсгал хийж арилжих, өдийг шашны зан үйлд ашиглах, экспортлох, Казах иргэд ангаахайг үүрнээс авч тэжээх, гэрэл зураг даруулж ашиг олох зорилгоор хууль бусаар агнах, барих, хурга ишиг шүүрч болзошгүй хэмээн нутгийн малчид буудан хороох зэрэг нь түүний тоо толгойг цөөрүүлэх шалтгаан болно (Gombobaatar *et al.*, 2011; Гомбобаатар, Одхүү, 2018).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор амьдаар болон дээж, өд зэргийг АНУ, ОХУ, Казахстан, Япон улс руу 2006, 2010, 2013, 2014 онд гаргаж, харин худалдааны зорилгоор ОХУ, Япон улс руу 4 бодгалийг амьдаар болон өдийг нь 2001-2016 онд гаргажээ. Цирк, аялал жуулчлалын үзэсгэлэнд 1 шувууг амьдаар нь 2009 онд Словак улс руу, өдийг нь 2001, 2006 онд АНУ, Япон улс руу экспортолсон (CITES-ийн тайлан, 2017).

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

Цармын бүргэдийн Монгол орон дахь тархац нутгийн 9.0% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Цармын бүргэд (*Aquila chrysaetos*) нь 402.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 80.4 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ООЧ ЁЛ

Gypaetus barbatus Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Bearded Vulture (Lammergeier)


Орос: Бородач

Хятад: Ну Wujiu

Герман: Bartgeier

Франц: Gypaète barbu

Казах: Сақалтай



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Ховордож болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” зүйл (Gombobaatar et al., 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 950-1,250 мм. Далавчны урт 710-910 мм. Биеийн жин 4,500-7,800 г хүрнэ.

Нуруу бараан хөх-саарал. Толгой, шил хүзүү, биеийн доод хэсэг бүхэлдээ цайвар ч хадны төмөр ихтэй ус, шаврыг биеийн цээж, хэвлийдээ түрхэх тул улбардуу шаргал туяатай ухаа шаргал харагдана. Нүднээс урагш хошууны угийг дайран доош унжсан сахал мэт багц өдтэй. Хоолойн доод хэсгээр хүзүүний зүүлт мэт харагдах өвөрмөц бараан өнгийн хөндлөн судалтай. Залуур өд зэв хэлбэртэй. Залуу шувуу бүхэлдээ бараан хүрэн зүстэй ба зэв хэлбэрт сүүл илт ялгарам.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Мавритани, Марокко, Португали, Испани, Алжир, Франц, Андорра, Герман, БНАСАУ, Швейцарь, Тунис, Австри, Намиби, Чех, Хорват, Өмнөд Африк, Албани, Грек, Румын, Македони, Судан, Болгар, Египет, Зимбабве, Турк, Лесото, ОХУ, Танзани,


Уганда, Мозамбик, Кипр, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Палестин, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Балба, Монгол, Бутанд тархсан. Итали, Лихтенштейн, Босни, Монтенегро, Сербид утсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Ховд аймгийн Чаг нуурын хөндий, Говь-Алтай аймгийн Тахийн тал (Монгол-Алтайн тойрог), Говийн ДЦГ, Гурвансайхан уул (Говь-Алтайн тойрог), Сийлхэм, Хархираа, Түргэний уулс, Жаргалант, Бумбат Хайрхан, Алтан Хөхийн нуруу

(Их Нууруудын хотгор), Завхан голын хөндий, Хан Тайширын нуруу, Зүүнгарын говь, Байтаг Богд, Их Хавтаг, Тахийн Шар Нуруу (Баруун Хурай), Их Богд, Битүүтийн Ам (Нууруудын хөндий), Аж Богд, Идрэнгийн Нуруу, Алтан Уул, Цагаан Богд, Сэврээ, Нэмэгт, Ноён, Баян Бор, Тост уул, Хан Богд уул, Борзонгийн говь, Зүүн говийн хотгор, Эрдэнэсант уул, Дундад Халхын хээр, Адаацаг уул, Бага газрын чулуу, Зоргол Хайрхан уул, Хустайн БЦГ, Хоргын тогоо, Тэрхийн Цагаан нуур орчимд үржинэ. Мөн Чойрын Богд, Их Сансар уул, Дархан, Язаар, Тоонот, Батхаан, Хөгнөхаан уул болон Хангайн тойрог орчмын нутагт тэмдэглэгдсэн.



АМЬДРАХ ОРЧИН

Өндөр уул, ойт хээр, говь цөлийн бүсийн бэсрэг уул, тал хээрийн боржин чулуун хадан цохио бүхий уулсаар амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны суурин зүйл бөгөөд үржил 2-р сарын эхээс 8-р сарын дунд хүртэл үргэлжилнэ. Өндөр уул, ойт хээр, уулын хээрийн орой хэсгийн эгц цавчим өндөр хадны орой орчмын ирмэг тавцанд ургамлын мөчир, амьтны яс, үс ноос, эсгий зэргээр үүр засна. Бор шаргал толбо бүхий цагаан өнгийн 1-2 өндөг гаргана. Түүнээс 53-60 орчим хоногийн дараа ангаахай гарна. Ангаахай 107-117 хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Үхсэн малын яс, чөмгөөр голчлон хооллоно. Ёл нь хурганы гуятай дүйцэх том ясыг залгиж, хоол боловсруулах хүчирхэг системээрээ түргэн хугацаанд боловсруулах чадвартай. Мөн тэд залгихад хүндрэлтэй том ясыг авч өндөрт хөөрч, хадан дээр унаган хагалж, бутарсан жижиг хэсгүүд болон чөмгийг түүж идэх өвөрмөц чадвартай. Энэ чадварыг залуу шувууд эзэмшиж суртлаа 7 хүртэлх жил зарцуулдаг.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 2011 онд 2,000-10,000 бие гүйцсэн бодгаль байсан (Birdlife International, 2011) бол өдгөө 1,300-6,700 болж буурсан (BirdLife International, 2017) байна.

Уул уурхай, аялал жуулчлал, орчны бохирдол, хуурайшилт зэрэг нь түүний амьдрах орчныг доройтуулж байна. Мөн чихмэл хийх, эд эрхтнийг ардын эмчилгээ, гоёл чимэглэлд ашиглах зорилгоор хууль бусаар агнадаг ба хурга, ишгийг шүүрч болзошгүй гэж нутгийн малчид буудан хороох нь түүний тоо толгойг цөөрүүлэх шалтгаан болно (Gombobaatar *et al.*, 2011; Гомбобаатар, Одхүү, 2018).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор 2002 онд 2 шувууны дээжийг АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>) болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн байна.

Ооч ёлын Монгол орон дахь тархац нутгийн 8.9% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Ооч ёл (*Gypaetus barbatus*) нь 540.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 108.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ДЭЛТ ЁЛОН

Neophron percnopterus Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцара (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Egyptian Vulture

Орос: Стервятник

Хятад: Bai Wujiu

Герман: Schmutzgeier

Франц: Vautour percnoptère

Казах: Жұртшы

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Устаж болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Үнэлэх боломжгүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ


Биеийн урт 630-745 мм. Далавчны урт 468-520 мм. Биеийн жин 2,100-2,400 г хүрнэ.

Эр, эм шувууны өнгө зүс ижил. Бие гүйцсэн шувууд цагаан, ягаавтар туяатай. Дэвүүр өд, хошуу хар. Урт, нарийхан, бага зэрэг махир хошуутай. Гүеэ нүцгэн. Нүүр хэсэг нүцгэн ба шар арьсаар бүрхэгдсэн. Залуур нь 14 өдтэй. Залуу шувууны бие хар хүрэн, хүзүү, нурууны өдний үзүүр улбар бор, ууц, сүүлний доод хэсэг улбар хүрэн. Хошуу бараан бор. Нүүрний нүцгэн арьс ягаавар туяатай шаргал.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Кабо-Верде, Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби, Гвиней, Марокко, Мали, Португали, Испани, Алжир, Их Британи, Гибралтар, Буркина Фасо, Франц, Гана, Того, Нигер, Бенин, Бельги, Нигери, Норвег, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Ливийн Жамахири, Австри, Свалбард Ян Майен, Конго, Швед, Ангол, Намиби, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Босни, Өмнөд Африки, Унгар, Словак, Серби, Монтенегро, Албани, Ботсвана, Грек, Румын, Македони, Финланд, Судан, Украин, Болгар, Эстони, Египет, Зимбабве, Турк, Молдов, Лесото, ОХУ, Танзани, Уганда, Мозамбик, Кипр, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Палестин, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Катар, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад,

Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Мянмарт тархжээ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Гурвансайхан уул ба Борзонгийн говь хоорондын өндөр ууланд 1980-аад оны үед анх ажиглагдсан. Түүнээс хойш Мөнххайрхан ууланд 1996 оны 5-р сарын 24-нд 1 бодгаль, Гурвансайхан уулын Дүнгэнээгийн хавцалд 1998 оны 6-р сарын 24-нд 1 бодгаль тус тус тэмдэглэсэн (Gombobaatar *et al.*, 2011) байна.



АМЬДРАХ ОРЧИН

Өндөр уулсын хавцал, ханан хад, бартаа саад ихтэй орчинд байршижтай.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд тохиолдлын байдлаар үзэгдэх зүйл бөгөөд цөөн удаа бүртгэгдсэн. Үхсэн амьтан, амьтны нялх төл, шавж гэх мэт олон төрлийн зүйлээр хооллоно. Тэд 3-р сарын эхээс 5-р сарын

эх (хаврын нүүдэл), 8-р сарын сүүлчээс 10-р сарын эх (намрын нүүдэл)-нд манай орны өмнөд хэсгийн өндөр уулсаар үзэгдэх боломжтой.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 12,000-38,000 үржлийн насны бодгиас бүрдэх бөгөөд тэдгээрийн тоо толгой буурсаар байна (BirdLife International, 2017).

Энэ зүйлийн тоо толгой буурах гол шалтгаан нь уул уурхай, аялал жуулчлал зэрэг хүний хүчин зүйл болно (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны талаар мэдээ баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>) болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Дэлт ёлон (*Neophron percnopterus*) нь 190.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 36.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

НӨМРӨГ ТАС

Aegypius monachus Linnaeus, 1766

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Cinereous Vulture

Орос: Чёрный гриф

Хятад: Tu Jiu

Герман: Mönchsgeier

Франц: Vautour moine

Казах: Тазқара



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Ховордож болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gom-bobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ


Монгол орны хамгийн том шувууны нэг. Биеийн урт 1,000-1,200 мм. Далавчны урт 720- 820 мм. Биеийн жин 7,500-12,000 г хүрнэ.

Биеийн ерөнхий зүс хар хүрэн. Хошуу хар, бахим, доош махир. Хошууны зэтэр цайвар ягаан. Хүзүү бүхэлдээ маш богино ноолуур өдөөр бүрхэгдсэн учир “нүцгэн” мэт харагдана. Энэ хэсгийг “Тасын булга” гэж нутгийн хүмүүс нэрлэнэ. Бие гүйцсэн шувууны толгой хүзүү цайвар шаргалдуу бол харин залуу шувууных хар хүрэн. Хөл цийлгэр ягаан.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Испани, Гибралтар, Франц, Нидерланд, Герман, Швейцарь, Тунис, Польш, Хорват, Босни, Унгар, Словак, Монтенегро, Серби, Грек, Латви, Судан, Украин, Болгар, Беларусь, Египет, Турк, ОХУ, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Ирак, Гүрж, Йемен, Армен, Иран, Азербайджан,


Казахстан, Кувейт, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Хонконг, Тайвань, БНАСАУ, БНСУ, Японд тархсан. Австри, Чех улсад тохиолдлын байдлаар таарна. Итали, Словени, Румын, Молдов, Кипрт утсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол Алтай, Говь-Алтайн тойрог, Сийлхэмийн нуруу, Хархираа, Түргэний уулс, Их Нууруудын хотгор (Жаргалант, Бумбат, Алтан Хөхий), Завхан голын хөндий (Их, Бага Буурал), Хангай, Хэнтий,

Хөвсгөлийн тойрог (шигүү ойгоос бусад), Хэрлэн-Улз голын сав, Дорнод Монголын хээр (уулын бэл, хээрийн хад асга бүхий намхан уулс), Зүүнгарын говь, Баруун Хурай (Байтаг Богд, Их Хавтаг, Тахийн Шар нуруу), Алтайн Өвөр говь (Аж Богд, Атас Чингис, Эрдэнийн нуруу, Алтан уул, Цагаан Богд, Сэврээ, Нэмэгт, Тост), Хойд говь, Зүүн говийн уулсаар үржинэ. Нүүдлийн болон үржлийн бус үедээ тайга, ус намгархаг газар, суурин газраас бусад бараг бүх уулархаг бүс нутгаар сэг зэм хайн ганц нэгээр, эсвэл сүргээр тааралдана.



АМЬДРАХ ОРЧИН

Өндөр уул, ойт хээр, уулын хээр, цөлийн хээрийн боржин чулуун хад цохиотой нутагт үүрлэнэ. Тайга, ус намгархаг газар, суурин газраас бусад бараг бүх орчинд сэг зэм хайн ганц нэгээр, эсвэл сүрэглэн тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны суурин, үрждэг зүйл бөгөөд зарим бодгалиуд нүүдэллэнэ. 3-р сарын эхэн үед уулын орой, энгэрийн борсгор хад, хавцал дээр, эсвэл хайлаас, улиас, хус модон дээр хуурай модлог ургамлын иш, мөчир зэргээр том үүр засаж, улаан хүрэн, саарал толбо бүхий цагаан өнгийн ихэвчлэн 1, ховор тохиолдолд 2 өндөг гаргана. Өндөгнөөс 54-56 хоногийн дараа ангаахай гарах ба ангаахай 90-110 хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Малын сэг зэмээр хооллоно. Залуу шувууд 9-р сарын сүүлчээс өвөлжих нутаг болох Өмнөд Солонгос, Балба, Хойд Солонгос, Хятад руу нүүдэллэдэг.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 15,600-21,000 бие гүйцсэн бодгальтай бөгөөд түүний тоо толгой буурсаар байна (BirdLife International, 2017).

Энэ зүйлийн тоо толгойд сөргөөр нөлөөлж буй гол хүчин зүйлс гэвэл малын тоо хэт өсөх, уул уурхай, аялал жуулчлалын бааз олноор байгуулах, орчны

бохирдолт зэргээс үүдэлтэй амьдрах орчны доройтол, мөн хурга, ишиг шүүрч болзошгүй хэмээн нутгийн иргэд буудаж хороох, өд, хумс, хөлийг шашны зан үйлд, махыг эмчилгээнд хэрэглэх, худалдах зорилгоор хууль бусаар агнах, өндөр хүчдэлийн шугам мөргөж эндэх зэрэг болно (Gombobaatar *et al.*, 2011; Гомбобаатар, Одхүү, 2018).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор дээж болон 1 бодгалийг 2002, 2005, 2006, 2012 онд АНУ, Грек, Герман улс руу гаргажээ. Худалдаа, хувь хүний сонирхол, амьтны хүрээлэнд илгээх зорилгоор амьд бодгаль, өд, хөл зэргийг 2000-2002, 2009, 2012, 2016 онд АНУ, Япон, Словак улс руу, мөн нийт 7 бодгалийг агнуулан 2002-2004 онд АНУ болон Швейцарь улс руу экспортолсон (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн байдаг.

Нөмрөг тасын Монгол орон дахь тархац нутгийн 12.7% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Нөмрөг тас (*Aegypius monachus*) нь 972.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 194.4 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



УХАА ХАЖИР

Gyps fulvus Hablizl, 1783

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Eurasian Griffon (Griffon Vulture)

Орос: Белоголовый сип

Хятад: Wujju

Герман: Gänsegeier

Франц: Vautour fauve

Казах: Ақбас құмай

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 900-1,125 мм. Эрийн далавчны урт 700-735 мм, эмийнх 690-710 мм. Эр, эм шувуу өнгө зүсний хувьд ижил ч эр нь эмээс бага зэрэг том.


Бие гүйцсэн шувууны зүс цайвар хул, толгой, хүзүүний богино өд цагаан ноолууртай. Бор шаргалдуу нуруу, улбар хэвлийтэй. 1-р зэргийн дэвүүр, залуурын өд бараан хүрэн. Хималайн

хажиртай тун төсөөтэй ч далавчны доод даруул тод цагаан байдаггүй. Хошуу шаргалдуу. Залуу шувууны нуруу бараан хүрэн, толгой цайвар, Хималайн хажираас илүү бор хул зүстэй.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Сенегал, Баруун Сахар, Мавритани, Марокко, Мали, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Гибралтар, Франц, Того, Нигер, Бельги, Нидерланд, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Ливийн Жамахири, Австри, Чех, Словени, Польш, Мальта, Хорват, Босни, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Грек, Македони, Финланд, Латви, Судан, Украин, Болгар, Эстони, Египет, Турк, ОХУ, Кипр, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Палестин, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Джибути, Йемен, Армен,

Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Балба, Монгол, Бангладешт тархсан. Румынд утсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хархираа уул, Булган голын сав (Зүүнгарын говь), Монгол Алтай, Говь-Алтайн тойрог, Их Нууруудын хотгор, Хангайн тойргийн өмнөд, баруун өмнөд салбар уулс, Нууруудын хөндийд тэмдэглэсэн тухай баримт бий.



АМЬДРАХ ОРЧИН

Өндөр уулсын хадан цохиогоор байршижтай.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн, дайрч өнгөрдөг зүйл бөгөөд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд нүүдэллэн ирнэ. Хээрийн нөхцөлд ялгаж танихад хүндрэлтэй. Бусад тасуудын адил задгай газарт идэш тэжээл хайн өндөр халин нисэж, үхсэн амьтны сэг зэмээр хооллоно. Үхсэн амьтан дээр нөмрөг тас, Хималайн хажиртай хамт цуглана.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 500,000-1,000,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Малын тоо өсөх, уул уурхай, аялал жуулчлал зэрэг нь түүний амьдрах орчныг доройтуулах ба өд, хумс, хөлийг шашны зан үйлд ашиглах, гоёл чимэглэл хийх, худалдах зорилгоор хууль бусаар агнадаг байх талтай (Gombobaatar et al., 2011).

ХУДАЛДАА

Манай оронд энэ зүйлийн худалдааны тухай баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралт (<http://www.cms.int/en/species>) болон Азийн Улаан ном (2001)-нд тус тус бүртгэсэн байдаг.

Ухаа хажирын Монгол орон дахь тархац нутгийн 13.5% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан (Gombobaatar et al., 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Ухаа хажир (*Gyps fulvus*) нь 540.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 108.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ХИМАЛАЙН ХАЖИР

Gyps himalayensis Hume, 1869

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Харцага (*Accipitridae*)

НЭРШИЛ:

Англи: Himalayan Griffon

Орос: Гималайский гриф

Хятад: Gaoshen Wujiu

Герман: Schneegeier

Франц: Vautour de l'Himalaya

Казах: Гималай құмайы

📖 ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Ховордож болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (Gombobaatar *et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

🔍 ТАНИХ ШИНЖ

Биеийн урт эрд 1,243 мм, эмд 1,497 мм. Далавчны урт 765-893 мм. Биеийн жин 10-12 кг хүрнэ.

Эр, эм шувуу өнгө зүсний хувьд ижил. Ухаа хажиртай гадаад шинжээрээ тун төсөөтэй ч бие гүйцсэн бодгалийн далавчны доод даруул цагаан, биеийн дээд хэсэг цайвар хонгор байдгаараа ялгарна. Нүцгэн хүзүүний угийг тойрсон цагаан урт өдтэй.

🌐 ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

ОХУ, Казахстан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Балба, Монгол, Бутан, Тайланд, Малайзад тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Говь-Алтайн тойрог, Их Нууруудын хотгор, Хангайн тойргийн төв ба өмнөд хэсэг, Хэнтийн тойргийн баруун өмнөд, зүүн өмнөд хэсэг, Дундад Халхын хээр (Чойрын Богд, Их Сансар, Дархан, Язаар, Тооно, Баянхутаг, Мөнххаан уул), Нууруудын хөндий, говь (Алтайн Өвөр)-д тархсан. Гурвансайхан уул (Говь-Алтайн тойрог)-нд үрждэг байж болох ч баримт нотолгоо байхгүй.



АМЬДРАХ ОРЧИН

Өндөр уулсын эгц цавчим хад цохио бүхий орчныг шүтнэ. Хооллох үедээ уулс хоорондын болон голын хөндийд нөмрөг тасын хамт тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн, дайрч өнгөрдөг зүйл бөгөөд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд нүүдэллэн ирж, 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд буцна. Өндөр уулын бүсэд үрждэг байж болзошгүй ч нотолгоо байхгүй. Бусад тасуудын адил задгай газарт идэш тэжээл хайн өндөрт халин нисэж, үхсэн амьтны сэг зэмээр хооллоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 66,000-334,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Уул уурхай, аялал жуулчлалын нөлөөгөөр зарим нутагт түүний амьдрах орчин доройтож байгаа

бөгөөд өд, хумс, хөлийг шашны зан үйл, гоёл чимэглэл хийх, худалдах зорилгоор хууль бусаар агнаж байх талтай (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны талаар баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

Хималайн хажирын Монгол орон дахь тархац нутгийн 8.5% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хималайн хажир (*Gyps himalayensis*) нь 807.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 161.4 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ИДЛЭГ ШОНХОР

Falco cherrug Gray, 1834

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Шонхор (*Falconidae*)

НЭРШИЛ:

Англи: Saker Falcon

Орос: Балобан

Хятад: Lie Sun

Герман: Würgfalkе

Франц: Faucon sacre

Казах: Ителги



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Устаж болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 470-570 мм. Далавчны урт эрд 340-390 мм, эмд 370-420 мм. Эрийн жин 735-1,025 г, эмийнх 975-1,350 г хүрнэ (*Гомбобаатар*, 2013).

Идлэг шонхор нь морфологийн полиморфизм буюу биеийн гадаад өнгө, зүсийн хувьд олон янз бөгөөд энэ нь нас, хүйс, тархац нутгаасаа хамаарч хувьсамтгай. Гэвч дэвүүр болон залуур өдний толбо, судлын тоо, хэмжээ нь бодгаль бүрт үл давтагдах шинжтэй тул өдөөр бодгалийг таньж болно. Эр шонхорын толгой, цээж цайвардуу, биеийн доод хэсэг судал, толбо багатай. Эм нь цээж, хэвлийдээ толбо, судал ихтэй. Хошуу хөхвөр саарал. Хошууны нүцгэн арьс буюу зэтэр шар ба залуу шувуунд хөхвөр саарал, харин идэр насны эсвэл заримдаа бие гүйцсэний хувьд хөхвөрдүү шаргал байж болно. Хөл тод шар, хөхвөр шаргал (1-2 настай), эсвэл хөхвөр саарал (залуу буюу энэ жилийн шувуу). Залуу шувуудын биеийн доод хэсэг бараан өргөн судалтай. Цагаан шонхор, шилийн шонхороос биеийн дээд хэсэг бор шаргал толботой бараан хүрэн, биеийн доод хэсэг дусал хэлбэрийн толботой цагаан ба сахал богино, харьцангуй сийрэг байдаг онцлогтой (*Гомбобаатар*, 2013).

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Сенегал, Мавритани, Марокко, Мали, Испани,

Франц, Герман, Итали, Тунис, Дани, Камерон, Ливийн Жамахири, Австри, Швед, Чех, Чад, Польш, Мальта, Хорват, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Грек, Румын, Финланд, Судан, Украин, Болгар, Беларусь, Египет, Турк, Молдов, ОХУ, Бурунди, Танзани, Кипр, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Джибути, Йемен, Армен, Иран, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Балба, Монгол, Бангладешт тархсан. Туркменистанд устсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хөвсгөл, Хангай, Хэнтийн өтгөн шигүү тайга, өндөр уулсын 3,000 м-ээс дээш өндөрт тэмдэглэгдээгүй бөгөөд бусад бүхий л нутагт идэш тэжээлийн нөөцөөс шалтгаалан харилцан адилгүй нягтшилтай тархана. Говь цөлд тоо толгой цөөнө.



АМЬДРАХ ОРЧИН

Ойт хээр, уулын хээр, хээр, говь цөлийн хад асга, хавцал, элсэн эрэгт идэш тэжээлийн элбэгшилээс шалтгаалан тархана.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд зарим бодгалиуд өвөлждөг. Үржлийн хосууд 4-р сарын дундаас гол төлөв хон хэрээ, тарважи болон цармын бүргэд, сохор элээ зэрэг бусад шувуудын хад, мод, элсэн эрэг, өндөр хүчдэлийн шон, барилга байшин, газар дээр зассан хуучин, эсвэл шинэхэн үүрийг булаан үүрлэдэг. Тэд үүр барьдаггүй, бусдын барьсан үүрийг ашиглах ба зарим нь үүрээ олон жил дараалан ашиглана. Бараан хүрэн толбо бүхий улаан хүрэн өнгийн гол төлөв 3-4 өндөг гарган, 26-34 хоног дарж ангаахай болгоно. Ангаахай өндөгнөөс хагарч гарснаас хойш 40-42 хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Идэш тэжээлийн хувьд үлийн цагаан оготно, монгол чичүүл, дагуур огдой зэрэг жижиг хөхтөн, шоорон эвэрт болжмор, дэрсний жиргэмэл, монгол болжмор зэрэг шувуудаар голчлон хооллоно. Залуу бодгалиуд 10-р сарын эхээр нүүдэллэж Хятадын хойд, баруун хойд хэсэгт хүрч өвөлждөг. Харин бие гүйцсэн бодгалиуд үүр орчимдоо өвөлжинө.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 12,200–29,800 бие гүйцсэн бодгальтай бөгөөд тэдгээрийн тоо толгой буурсаар байна (BirdLife International, 2017) гэжээ. Манай улс идлэг шонхорын тооллогыг хэд хэдэн удаа хийсэн бөгөөд 1999 онд 3,000 хос, 2000 онд 2,200 хос, 2002 онд 6,050 бодгаль байсан бол 2003 онд тоо толгой өмнөх жилүүдийнхээс 50% бага үнэлэгдсэн. 1998-2005 онд үржлийн хосын нягтшил Монгол орны төв, зүүн, баруун хэсгийн судалгааны таван талбайд дунджаар 0.47 бодгаль (min. 0.13, max 0.97) байв (Гомбобаатар, 2006).

Малын тооны хэт өсөлт, уул уурхайн олборлолт, аялал жуулчлалын зохисгүй үйл ажиллагааны улмаас түүний амьдрах орчин доройтож байна. Тоо толгойн бодит нөөцийн үнэлгээнд тулгуурлалгүйгээр олон тоогоор гадаад оронд худалдах, Арабын шонхорчдын тавьж орхисон урхитай тагтааг барьж, улмаар урхинд орооцолдож эндэх, өндөр хүчдэлд цохиулах, утас мөргөж үхэх, өндөр хүчдэлд үүрлэсэн шонхорын өндөг, ангаахайг зориудаар унагаж хороох, үлийн цагаан оготно устгах зорилгоор бэлчээрт цацсан

хорт бодист дам хордож эндэх, чихмэл үзүүлэн хийх, хумс хөлийг авах, эд эрхтнээр гоёл чимэглэл хийж худалдах, өдийг бөөгийн шашны зан үйлд хэрэглэх зорилгоор зориудаар хөнөөх зэрэг нь энэ зүйлийн тоо толгой цөөрөх шалтгаан болно (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Байгаль орчны төлөв байдлын тайлан, олон улсын конвенцийн тайлан зэрэг албан бичигт дурдсанаар нийт 3,836 (1994-1995 онд 80 бодгаль, 1996 онд 25, 1997 онд 202, 1998 онд 25, 1999 онд 61, 2000 онд 50, 2001 онд 184, 2002 онд 303, 2003 онд 392, 2004 онд 365, 2005 онд 385, 2006 онд 185, 2007 онд 233, 2008 онд 240, 2009 онд 292, 2010 онд 216, 2011 онд 140, 2012 онд 148, 2013 онд 30, 2014 онд 40, 2015 онд 240 бодгаль) бодгалийг 1994-2015 онд Арабын улс орнууд руу шинжлэх ухаан, бэлэглэл, арилжааны зорилгоор гаргажээ.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн байдаг.

Идлэг шонхорын Монгол орон дахь тархац нутгийн 7.9% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).



ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Идлэг шонхор (*Falco cherrug*) нь 16,000.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 3,200.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ШУУМАН ШОНХОР

Falco subbuteo Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Шонхор (*Falconidae*)

НЭРШИЛ:

Англи: Eurasian Hobby (Hobby, Northern Hobby)


Орос: Чеглок

Хятад: Yan Sun

Герман: Baumfalke

Франц: Faucon hobereau

Казах: Жағалтай



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт эрийн хувьд 320-350 мм, эмд 330-368 мм. Далавчны урт эрд 247-275 мм, эмд 258-296 мм. Биеийн жин эрийн хувьд 165.2 г, эмд 247 г хүрнэ.

Бие гүйцсэн шувуу хөхвөр туяатай хар зүстэй ба сахал хэлбэрт өд өргөн, тод хар. Хэвлийн доод хэсэг, гуя, сүүлний доод даруул өд улбардуу хүрэн бор (эмийнх арай бүдэг). Нүд, хошууны зэтэр, хөл тод шар. Залуу шувуу Амарын шонхорын залуу шувуутай төсөөтэй ч биеэр том, шуумаг өд тод улбардуу хүрэн, сахал өд тод, өргөн зэргээрээ ялгарна.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Канад, АНУ, Исланд, Сенегал, Мавритани, Гамби, Гвиней, Марокко, Мали, Либери, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Фароз Арлууд, Гибралтар, Буркина Фасо, Франц, Гана, Того, Бенин, Андорра, Бельги, Нигери, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Габон, Лихтенштейн, Ливийн Жамахири, Австри, Конго, Швед, Ангол,

Намиби, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серб, Албани, Ботсвана, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Замби, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Зимбабве, Турк, Молдов, Лесото, ОХУ, Руанда, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Туркменистан, Сейшел, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Мальдив, Хятад, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Хонконг, Тайвань, БНАСАУ, БНСУ, Японд тархсан. Кипр улсад утсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Ачит, Үүрэг нуурын хөндий (Монгол-Алтайн тойрог), Увс нуур, Тэс Нарийн, Торхилог гол (Увс нуурын хотгор), шилмүүст ба холимог ой (Тэс голын хөндий), Ховд голын адаг (Их Нууруудын хотгор), Булган голын хөндийгөөс (Зүүнгарын говь) Зүүн говь, Тарвагатай-Булнайн нуруу, (Хангайн тойрог), Хөвсгөлийн тойрог, Дархадын хотгор, Туул голын эх, Тэрэлж, Онон, Балж, Хүдэр, Булнайн, Хэрлэн гол (Хэнтийн тойрог), Улз голын эх, Онон, Балж, Хэрлэн голын хөндий, Буйр нуур-Халх гол-Хянганы бүсийн өндөр уул, тайгын өтгөн шигүү ой, ус намаг, суурин газраас бусад газарт үржинэ. Нүүдлийн үедээ говь цөлийн бүсэд таарна.



АМЬДРАХ ОРЧИН

Тайгын ой, ойт хээрийн навчит болон шилмүүст модтой гуу жалга, голын хөндий, сайр даган амьдарна. Заримдаа говь цөлийн хайлаас, тоорой дээр үүрлэсэн байх нь бий. Нүүдлийн үедээ задгай хээр, говь цөлийн бүсэд тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн, үрждэг, ердийн тохиолдох зүйл. 4-р сарын дундаас 5-р сарын сүүлч үед нүүдэллэн ирнэ. Үржлийн хосууд өөрсдөө үүр засахгүй учир алаг шаазгай, хар хэрээ, алагтуу хэрээ, эсвэл сохор элээний ой, ойт хээр, голын хөндийн модон дээр барьсан үүрийг сонгож үүрлэнэ. Эм шонхор улаан хүрэн толбо бүхий шаргал өнгийн гол төлөв 2-4 өндөг гаргаж, 28 хоног даран ангаахай болгоно. Ангаахай 30 орчим хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Тэд жижиг мэрэгчид, шийхнүүхэй, болжмор, цэгцгий, богширго, бөднө шувууны дэгдээхэй, гүрвэл, хоёрнутагтан, царцаа, соно зэргээр хооллоно. Нүүдлийн үедээ ганц нэгээр, эсвэл 3-4 тоогоор задгай хээр, уулын хээрт тохиолдоно. Намар 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд нүүдэллэнэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 500,000-1,000,000 бие гүйцсэн бодгальтай бөгөөд тэдгээрийн тоо

толгой буурсаар байна (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Малын тооны хэт олширол, уул уурхайн олборлолт, аялал жуулчлалын зохисгүй үйл ажиллагаа, ойн хэт ашиглалт, ойн түймрээс шалтгаалсан амьдрах орчны доройтол, үржлийн үед үүрэнд хүн мал ойртож тайван байдлыг алдагдуулах, улмаар үржлийн нутгаас дайжих, үлийн цагаан оготно устгах зорилгоор бэлчээрт цацсан хорт бодист хордож эндэх зэрэг нь түүний тоо толгойг цөөрүүлэх шалтгаан болно (Gombobaatar et al., 2011).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор тус шувууны дээжийг 2002, 2011 онд АНУ, Герман улс руу, агнуурын зорилгоор 1 бодгалийг 2002 онд АНУ руу тус тус гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>) болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Шууман шонхорын Монгол орон дахь тархац нутгийн 7.5% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar et al., 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Шууман шонхор (*Falco subbuteo*) нь 23.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 4.6 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ХАЙРГУУНА ШОНХОР

Falco columbarius Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Шонхор (*Falconidae*)

НЭРШИЛ:

Англи: Merlin

Орос: Дербник

Хятад: Huibei Sun

Герман: Merlin

Франц: Faucon émerillon

Казах: Тұрымтай



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ


Биеийн урт эрийн хувьд 276-311 мм, эмд 315-343 мм. Эрийн далавчны урт 221-236 мм, эмийнх 248-258 мм. Эрийн биеийн жин 170-215 г, эмийнх 218-255 г хүрнэ.

Бие гүйцсэн эрийн нуруу хөхвөр саарал ба нарийн хар гол бүхий бүрхүүл өдтэй. Сахал тод биш. Биеийн доод хэсэг цайвар ба улбардуу бор хүрэн тууш судал ихтэй. Шуумаг өд, шил хүзүү улбардуу бор хүрэн. Бие гүйцсэн эм шувууны зүс бараан хүрэн зүстэй бөгөөд биеийн доод хэсэг цайвар, өргөн бор хүрэн судалтай. Залуу шувуу бие гүйцсэн эмтэй төсөөтэй ч биеийн доод хэсгийн бор хүрэн судлын хэмжээ шулуун хэлбэртэй нарийн (шуумаг өд, хэвлий хэсгийн хэмжээ том төдийгүй цайвар толботой). Хошууны зэтэр, хөл шар.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Канад, АНУ, Мексик, Гватемал, Эл Сальвадор, Белиз, Гондурас, Никарагуа, Коста-Рика, Куба, Панам, Кайманы арлууд, Перу, Эквадор, Ямайка, Колумб, Гайти, Багам, Бразил, Венесуэль, Турк ба Кайгосын арлууд, Доминикан, Аруба, Нидерландын Антилез, Пуэрто Рико, Сент-Киттс

Невис, Монтсерат, Гренада, Антигуа Барбуда, Гваделуп, Гринидад Тобаго, Гайана, Доминика, Сент-Винсент ба Гренадин, Мартиник, Сент Люсиа, Барбадос, Бермуд, Гренланд, Исланд, Марокко, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Фароэ Арлууд, Гибралтар, Франц, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Ливийн Жамахири, Австри, Швед, Чех, Словени, Польш, Хорват, Босни, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Турк, ОХУ, Кипр, Израиль, Саудын Араб, Йордан, Сири, Ирак, Армэн, Иран, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Хятад, Балба, Монгол, Лаос, Вьетнам, Япон, БНАСАУ, БНСУ-д тархсан. Сенегал, Лихтенштейн, Свалбард Ян Майен, Мальта, Судан, Ливан, Йемен, Бахрейн, Кувейт, Оман, Бутан, Тайланд, Филиппинд тохиолдлын байдлаар үзэгдэнэ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Сийлхэм, Хархираа, Түргэний уулс, Ховд голоос Үенч голын хөндий, Баян-Өлгий аймгийн Сагсай сум, Баянтэс сум, Тэсийн голын холимог ой, Сэвсүүл, Баруун Хөвсгөл, Хангайн нурууны Салхит Ганга, Өвөрхангайн Хужирт, Булнайгаас Тарвагатай, Хэрлэн голын эх ба дунд биеэр, Хөгнөхаан уул (Зүүн Хангай)-д үржинэ. Нүүдлийн үедээ үржлийн нутгаас гадна Дундад Халхын хээр, Хойд Говь, Монгол Дагуурын хээр, Халх голын савд тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Голын хөндийн бургас, улиас зэрэг шаазгайн үүр олонтой, эсвэл уулсын ой, ойт хээрийн навчит болон холимог мод ургасан хажуу, бэлээр байршина. Нүүдлийн үедээ задгай тал хээр, говь цөлд тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд зарим бодгаль өвөлжинө. Тэд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд үржлийн болон зусах нутагтаа нүүдэллэн ирэх ба үржил 5-р сарын сүүлчээс 6-р сарын эхэн үед эхэлнэ. Гол төлөв алаг шаазгай, хар хэрээ, алагтуу хэрээний модон дээр барьсан үүрийг сонгон үүрлэнэ. Улаан, хүрэн толбо бүхий бор шаргал өнгийн гол төлөв 3-4 өндөг гаргаж, 28-32 хоног дарж ангаахай болгоно. Жижиг шувуу, мэрэгчээр голчлон хооллох ба зарим үед гүрвэл, нисдэг томоохон шавжаар хооллоно. Ихэнх залуу шувуу, зарим бие гүйцсэн шувууд 9-р сард өвөлжих нутаг руу нүүдэллэнэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 500,000-2,000,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн.

Үржлийн нутаг дахь малын тооны хэт өсөлт, уул уурхай болон ойн хэт ашиглалт, түймэр зэргээс шалтгаалан түүний амьдрах орчин доройтож байна. Үржлийн үед үүрэнд хүн, мал ойртож тайван байдлыг алдагдуулна. Үлийн цагаан оготно устгах зорилгоор бэлчээрт цацсан хорт дам хордож эндэнэ. Хумс, хөлийг авах, эд эрхтнээр гоёл чимэглэл хийж худалдах зорилгоор зориудаар хөнөөж байх талтай (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор энэ шувууны 3 дээжийг 2012 онд АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>) болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэгдсэн.

Хайргууна шонхорын Монгол орон дахь тархац нутгийн 7.0% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хайргууна шонхор (*Falco columbarius*) нь 22.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 4.4 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ТУРАМТАЙ ШОНХОР

Falco vespertinus Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Шонхор (*Falconidae*)

НЭРШИЛ:

Англи: Red-footed Falcon

Орос: Кобчик

Хятад: Hongjiao Sun

Герман: Rotfussfalke

Франц: Faucon kobez

Казах: Бөктергі

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Ховордож болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Үнэлэх боломжгүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт эрийн хувьд 284-315 мм, эмд 278-332 мм. Далавчны урт эрд 224-253 мм, эмд 235-255 мм. Биеийн жин эр бодгальд 130-164 г, эмд 162.5-197.3 г хүрнэ.

Бие гүйцсэн эр нь Амарын шонхорын эртэй төсөөтэй боловч далавчны доод өд цагаан биш байдгаараа эрс ялгарна. Эмийн хувьд Амарын шонхорын эмээс биеийн доод хэсэг улбардуу бор шарга байдгаараа мэдэгдэхүйц ялгаатай. Хошууны зэтэр шар, хошуу хар. Залуу шувуу нь

Амарын шонхорын залуу шувуутай тун төсөөтэй ч, биеийн дээд хэсэг, толгой илүү цайвардуу хүрэн бор байдгаараа ялгаатай.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Сенегал, Мавритани, Гамби, Марокко, Мали, Либери, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Гибралтар, Буркина Фасо, Франц, Гана, Того, Нигер, Бенин, Бельги, Нигери, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Габон, Лихтенштейн, Сан-Томе Принсипи, Ливийн Жамахири, Австри, Швед, Ангол, Намиби, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Төв Африк, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Ботсвана, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Судан, Замби, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Зимбабве, Турк, Молдов, Лесото, ОХУ, Руанда, Бурунди, Танзани, Кипр, Малави, Этиоп,

Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Монгол, Кувейт, Бахрейн, Оман, Туркменистан, Сейшел, Узбекистан, Афганистан, Тажикстанд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Төв аймгийн Бүрэн сум, Бор нуур, Хүдэрийн даваа, Баруун хойд Хэнтий, Хустайн БЦГ, Халх голын савд тэмдэглэгдсэн. Ялангуяа Хустай болон Халх голын тэмдэглэл ихэд эргэлзээтэй бөгөөд Амарын шонхортой андуурсан байх магадал өндөр юм.



АМЬДРАХ ОРЧИН

Нисдэг шавж элбэгтэй ойт хээр, голын хөндий, чийглэг нуга бараадна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд тохиолдлын байдлаар таарах зүйл. Шавжийг агаарт барин хооллох бөгөөд

заримдаа жижиг хөхтөн, шувууг ч барина.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 300,000-800,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2015) хэмээн үнэлсэн.

Ойн хэт ашиглалт, түймэр зэрэг нь түүний хэвийн амьдралд сөргөөр нөлөөлөх талтай (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны талаарх баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Турамтай шонхор (*Falco vespertinus*) нь 20.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 4.4 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



АМАРЫН ШОНХОР

Falco amurensis Radde, 1863

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Шонхор (*Falconidae*)

НЭРШИЛ:

Англи: Amur Falcon

Орос: Амурский кобчик (Кобчик)

Хятад: Amu'er Sun

Герман: Amurfalke

Франц: Faucon de l'Amur

Казах: Бөктергі

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 260-300 мм. Далавчны урт эрд 220-230 мм, эмд 230-235 мм. Биеийн жин 114-140 г хүрнэ.

Бие гүйцсэн эрийн зүс хар хөх. Эрийн далавчны доод хэсэг цагаан. Цээж, хэвлий хөх саарал. Шуумаг өд улбардуу бор шаргал. Бие гүйцсэн эм бүхэлдээ хөхвөр саарал нуруутай ч бараан хөндлөн судал, толбо ихтэй. Биеийн доод хэсэг цагаан ба бараан судал, толбо ихтэй. Шуумаг өд улбар шаргал. Идэр насны эр нь эм ба эр шувууны завсрын шинжтэй. Залуу шувууны сахал бүдэг бөгөөд ялгарах онцлог нь биеийн дээд хэсэг бараан хүрэн, биеийн доод хэсгийн судал, толбо бараан хүрэн. Хошууны зэтэр, тарс улбар шаргал.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Сент Хелена, Итали, Конго, Ангол, Намиби, Өмнөд Африк, Ботсвана, Замби, Зимбабве, Лесото, ОХУ, Руанда, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Швейцарь, Малави, Этиоп, Кени, Сомали, Йемен, Оман, Сейшел, Афганистан, Пакистан, Энэтхэг, Мальдив, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Тайланд, Лаос, Хонконг, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Дэлгэр мөрөн, Идэр, Чулуут голын адгаас Улз голын эх хүртэл Хангайн хойд хэсгээс зүүн тийш Туул голын хөндий, Хэрлэн, Халх, Нөмрөг гол, Онон голын сав, Хөвсгөлөөс Үүр ба Эгийн гол, Орхон, Сэлэнгэ, Ерөө, Хараа голын хөндийд үржинэ. Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Ханбогд, Галбын говь, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт үржинэ. Нүүдлийн үедээ Дундад Халхын хээр, Хойд говиор дайран өнгөрнө (Gombobaatar *et al.*, 2011).



АМЬДРАХ ОРЧИН

Тайгын ой, ойт хээр, голын хөндий, уулын хээрийн навчит, шилмүүст, холимог ой бүхий орчинд амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд үржлийн хосууд 5-р сард нүүдэллэн ирж, 6-8-р сард үржинэ. Ихэвчлэн ой мод бүхий голын хөндий, ойт хээр, хээрийн хэсэгхэн төгөл дунд бургас, нарс, улиас, хайлаас, хус мод дээрх алаг шаазгай, хар хэрээ, алагтуу хэрээ, заримдаа сохор элээ, шилийн сарын хуучин, эсвэл шинээр зассан үүрийг эзлэн үүрлэдэг. Эм шонхор улаан хүрэн толбо бүхий цагаан, эсвэл бор шаргал өнгийн гол төлөв 2-6 өндөг (ховор тохиолдолд 7) гаргаж, 30 орчим хоног дарж ангаахай болгоно. Ангаахай 27-29 хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Гол төлөв оготно, царцаа, голиогоор, говьд гүрвэлээр хооллох боловч залуу шувууд жижиг шувууны ангаахай, оготно, соно, мэлхий, жижиг бах, царцаа зэргийг иднэ. Нүүдлийн үедээ буюу 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэн үед нуур, голын хөндий, задгай хээрт ихэвчлэн 4-30 тоогоор тохиолдох ба цахилгааны утас, шон дээгүүр эгнэн суух, оготно, царцаагаар хооллох нь түгээмэл ажиглагдана.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 1,000,000-аас цөөнө бие гүйцсэн бодгальтай (Global Raptor Information Network, 2015) гэж үнэлсэн.

Тоо толгой цөөрөх шалтгаан нь ойн хэт ашиглалт, түймэр, аялал жуулчлалын ажиллагааны улмаас түүний амьдрах орчин доройтож байна. Үржлийн үед үүрэнд хүн, мал ойртож үржлийн амжилтыг бууруулах, үлийн цагаан оготныг устгах зорилгоор хэрэглэсэн бэлчээрт цацсан хорт бодист дам хордон эндэж болно (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор энэ шувууны 270 дээж, 15 өд, 7 өндгийг 2002 онд Герман улс руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>) болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Амарын шонхорын Монгол орон дахь тархац нутгийн 7.2% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Амарын шонхор (*Falco amurensis*) нь 28.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 5.6 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ЗЭЭРД ШОНХОР

Falco naumanni Fleischer, 1818

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Шонхор (*Falconidae*)

НЭРШИЛ:

Англи: Lesser Kestrel

Орос: Степная пустельга

Хятад: Huangzhua Sun

Герман: Rötelfalke

Франц: Faucon crécerellette

Казах: Дала күйкентайы



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Эр, эм бараг ижил хэмжээтэй. Биеийн урт 310-335 мм. Далавчны урт 223-248 мм. Бие гүйцсэн эрийн жин 90-172 г, эмийнх 138-208 г хүрнэ.

Эрийн толгой, далавчны дээд хэсэг, сүүл хөхвөр саарал. Сүүлний өд өргөн бараан эмжээртэй. Биеийн бусад хэсэг хүрэн зээрд. Биеийн доод хэсэг цайвардуу хүрэн өнгөтэй. Эм нь начин шонхорын бие гүйцсэн эмтэй төсөөтэй ч харьцангуй жижиг биетэй, залуур өдний голын хоёр өд урт, биеийн доод хэсэг нарийн бараан судалтай ба хумс цайвар. Залуу шувууны биеийн зүс бие гүйцсэн эмэгчнйхтэй ижил ч цайвар хумстай байдаг онцлогтой.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Сенегал, Мавритани, Гамби, Гвиней, Марокко, Сьерра-Леоне, Мали, Либер, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Гибралтар, Буркина Фасо, Франц, Гана, Того, Нигер, Бенин, Бельги, Нигери, Герман, Итали, Тунис, Дани, Камерон, Габон, Лихтенштейн, Ливийн Жамахири, Конго,


Швед, Ангол, Намиби, Чад, Мальта, Хорват, Төв Африк, Босни, Өмнөд Африк, Монтенегро, Серб, Албани, Ботсвана, Грек, Румын, Македони, Судан, Замби, Украин, Болгар, Египет, Зимбабве, Турк, Молдов, Лесото, ОХУ, Руанда, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Свазиланд, Кипр, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Туркменистан, Сейшел, Узбекистан, Афганистан, Пакистан, Палестин, Энэтхэг, Мальдив, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Мянмар, Японд тархсан. Чех, Лаос, Словакид утсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Ачит, Үүрэг нуур (Монгол-Алтайн тойрог), Чонохарайх гол, Хар-Ус нуур (Их Нууруудын хөндий), Булган голын эх, Мөнххайрханы нуруу

(д.т.д 2700 метрээс доош), Увс нуурын хотгор, Дархадын хотгор, Хөвсгөлийн тойроогоос Хангайн тойрог хүртэл Хан Хөхийгөөс Орхон, Сэлэнгэ голын сав, Хэнтийн нурууны баруун бие Бор нуур, Тэрэлж, Мэлхий хад, Онон, Улз голын сав, Дундад Халхын хээр, Аж Богд уул, Их Богд, Арц Богд, Гурвансайхан уул, Хөх уул (д.т.д 2000 м хүртэл) (Говь-Алтайн тойрог), Баруун хуурайгаас Даланзадгадын нисэх буудал, Цэций уул, Зүүн говь, Хойд говь, Нууруудын хөндий, Завханы цөлөрхөг хээрийн хотгороос Шаргын говь, Алтайн Өвөрөөр үржинэ. Мөн нүүдлийн үедээ уул, хээр, говь цөлийн бүсээр тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Ойт хээр, уулын хээр, говь цөлийн хад цохио, навчит ойн захаар амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд нүүдэллэн ирж, 6-8-р сард үржинэ. Ойт хээр, уулын хээр, хээр, цөлийн хээрийн задгай орчинд 2-20 хос бүлээр үржинэ. Тэд өөрсдөө үүр засахгүй бөгөөд хад чулуу, хавцал, малын хашаа, барилга байгууламжийн нарийн завсар, нүх, хэрээ, шаазгай, сохор элээ зэрэг шувууны хуучин эсвэл шинээр барьсан үүрийг эзлэн үүрлэнэ. Эм шонхор улбар шар, улбар хүрэн толбо бүхий цагаан эсвэл бор шаргал өнгийн гол төлөв 4-5 өндөг гаргана. Өндөгнөөс 28 хоногийн дараа ангаахай гарна. Ангаахай ойролцоогоор 26-28 хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Тэд царцаа, голио, цох, мэлхий, бах, гүрвэл, жижиг шувуу, мэрэгчдээр хооллоно. Намрын нүүдэл 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэн үед ойт хээр, говь цөлд 4-120 тоогоор сүрэглэж, өндөр хүчдэлийн шонгийн утас дээгүүр суудаг.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ тодорхойгүй. Европт 61,000-76,100 (Birdlife International, 2015), Сенегалд 28,600 гаруй, Өмнөд Африкт 98,000,

Хятадад 200-2,000 бие гүйцсэн бодгаль (Бразил, 2009) байна (IUCN, 2017) гэж үнэлсэн.

Малын хэт өсөлт, уул уурхай, аялал жуулчлалын зохисгүй үйл ажиллагаанаас хамааран түүний амьдрах орчин доройтож байна. Үржлийн үед үүрэнд хүн, мал ойртож үржлийн амжилтыг бууруулдаг. Үлийн цагаан оготныг цөөрүүлэх зорилгоор бэлчээрт цацсан хорт бодист дам хордож эндэх ба өндөр хүчдэлийн шугамын утас мөргөх зэрэг нь түүний тоо толгойг цөөрүүлэх шалтгаан болно (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор энэ шувууны дээж, ед, өндөг зэргийг 2000, 2002 онд АНУ, Герман улс руу, агнуурын зорилгоор 4 бодгалийг 2002, 2004 онд АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>) болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Зээрд шонхорын Монгол орон дахь тархац нутгийн 7.8% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батласан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Зээрд шонхор (*Falco naumanni*) нь 37.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 7.4 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

НАЧИН ШОНХОР

Falco tinnunculus Linnaeus, 1758

Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Шонхор (*Falconidae*)

НЭРШИЛ:

Англи: Common Kestrel

Орос: Обыкновенная пустельга

Хятад: Hong Sun

Герман: Turmfalke

Франц: Faucon crécerelle

Казах: Көдімгі күйкентай



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ


Биеийн урт эрийн хувьд 310-357 мм, эмд 330-380 мм. Далавчны урт эрд 230-258 мм, эмд 242-275 мм. Биеийн жин эрийн хувьд 168-188 г, эмийнх 224-261 г хүрнэ.

Бие гүйцсэн эрийн толгой үнсэн саарал, биеийн дээд хэсэг хар толбо ихтэй. Биеийн доод хэсэг цайвардуу улбар хүрэн. Хумс хар. Бие гүйцсэн эм шувуу нь зээрд шонхорын эмтэй төсөөтэй ч биеэр харьцангуй том, хумс хар байдгаараа ялгаатай. Хошууны зэтэр шар. Залуу шувууны хумс хар, биеийн доод хэсгийн судал өргөн бор хүрэн.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Канад, АНУ, Виржиний Арлууд, Ангилал, Сент-Китс Невис, Монтсерат, Антигуа Барбуда, Гваделуп, Доминика, Сент-Винсент ба Гренадин, Мартиник, Сент Люсия, Барбадос, Сэнт Пьер ба

Микелон, Францын Гайана, Бермуд, Гренланд, Исланд, Кабо-Верде, Сенегал, Баруун Сахар, Мавритани, Гамби, Гвиней, Марокко, Сьерра-Леоне, Мали, Либери, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Фароз Арлууд, Гибралтар, Буркина Фасо, Гана, Того, Нигер, Бенин, Андорра, Бельги, Нигери, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Габон, Лихтенштейн, Ливийн Жамахири, Австри, Свалбард Ян Майен, Конго, Швед, Ангол, Намиби, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Төв Африк, Босни, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Ботсвана, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Замби, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Зимбабве, Турк, Молдов, Лесото, ОХУ, Руанда, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Свазиланд, Кипр, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армэн, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Мальдив, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Камбож, Сингапур, Бруней, Хонконг, Тайвань, Филиппин, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.




ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 4,000,000-6,500,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) гэж үнэлсэн.

Малын хэт өсөлт, уул уурхай, ойн хэт ашиглалт, түймэр, аялал жуулчлалын зохисгүй үйл ажиллагааны улмаас түүний амьдрах орчин доройтож байна. Үржлийн үед үүрэнд хүн, мал ойртож үржлийн амжилтыг бууруулна. Үлийн цагаан оготно устгах зорилгоор бэлчээрт цацсан хорт бодист дам байдлаар хордож эндэнэ. Өндөр хүчдэлийн шугамын утас мөргөж, цохиулж олноор үхнэ (Gombobaatar *et al.*, 2011).

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол орны ус намаг, тайгын өтгөн шигүү ой, д.т.д 3,500 метрээс өндөр уулаас бусад бүх нутагт байршдаг.



ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор энэ шувууны 3 дээж, 3 бодгалийг 2002 онд АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>) болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Начин шонхорын Монгол орон дахь тархац нутгийн 7.9% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

АМЬДРАХ ОРЧИН

Ой, ойт хээр, уулын хээр, говь, цөлийн бэсрэг уулсын хад цохио, хавцал, элсэн эрэг, навчит болон шилмүүст модтой хэсгээр амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл. Тэд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд нүүдэллэн ирж, 5-р сарын сүүлч, 6-р сарын эхээр үржинэ. Үүр засахгүй бөгөөд хад чулуу, хавцал, малын хашаа, барилга байгууламжийн нарийн завсар, нүх, хэрээ, шаазгай, сохор элээ зэрэг шувууны хуучин, эсвэл шинээр барьсан үүрийг эзлэн үүрлэнэ. Эм шонхор улбар шар, улбар хүрэн толбо бүхий цагаан эсвэл бор шаргал өнгийн гол төлөв 4-5, ховор тохиолдол 8-9 өндөг гаргах бөгөөд 27-30 хоногийн дараа ангаахай болно. Ангаахай ойролцоогоор 27-40 хоногийн дараагаар нисэх чадвартай болно. Царцаа, голио, цох, жижиг шувууны ангаахай, мэрэгчээр хооллоно. Идэш тэжээл хангалуун жил зарим бодгалиуд өвөлжинэ.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Начин шонхор (*Falco tinnunculus*) нь 21.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 4.2 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ХАРХИРАА ТОГОРУУ

Grus grus Linnaeus, 1758

Баг: Тогоруу (*Gruiformes*)

Овог: Тогоруу (*Gruidae*)

НЭРШИЛ:

Англи: Common Crane

Орос: Серый журавль

Хятад: Hui He

Герман: Graukranich

Франц: Grue cendrée *Grus grus*

Казах: Сұр тырна



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Ховордож болзошгүй” зүйл (Gombobaatar et al., 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 1140 мм. Далавчны урт эрд 580-660 мм, эмд 540-640 мм. Биеийн жин 3,000-6,100 г хүрнэ.

Эр нь эмээс биеэр арай том, өнгө зүсээр ижил. Бие гүйцсэн шувууны биеийн ерөнхий зүс хөх саарал. Дух, шанаа, хүзүү хар. Зулай дээрээ улаан толботой. Нүднээс доош хүзүүний хоёр захаар хүзүү хүрсэн цагаан судалтай. Сүүлний өд, 3-р зэргийн дэвүүр өд сагсайн харагдана. Нүд цийлгэр шар. Залуу шувууны толгой шаргалдуу бор, хүзүүний хэсэгт хар зүс илрээгүй.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Канад, АНУ, Исланд, Мавритани, Марокко, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Фароз Арлууд, Гибралтар, Франц, Нигер, Бельги, Нигери, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Лихтенштейн, Ливийн Жамахири, Свалбард Ян Майен, Швед, Чех, Словени, Польш, Мальта, Хорват, Босни, Унгар, Словак, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Турк, ОХУ, Кипр, Этиоп, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Джибути, Йемен, Армен,


Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Палестин, Тажикстан, Энэтхэг, Хятад, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Лаос, Вьетнам, Камбож, Хонконг, БНАСАУ, БНСУ, Японд тархсан. Австри, Монтенегро, Сербид устсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Ачит, Үүрэг нуур, Бөхмөрөн голын тохой (Монгол Алтайн тойрог), Увс нуур, Тэс Нарийн, Торхилог голын тохой (Увс нуурын хотгор), Хар-Ус, Хар нуур (Их Нууруудын хотгор), Завхан голын зэгш шагшуурга (Жаргалант сум), Орхон гол (Хангайн тойрог), Хөвсгөл, Дархадын Хотгор (Хөвсгөлийн тойрог), Сэлэнгэ, Ерөө гол (Орхон-Сэлэнгэ мөрний сав), Хараа, Туул, Хэрлэн, Онон, Балж голын эх (Хэнтийн тойрог), Хэрлэн голын хөндий (Дундад Халхын хээр), Улз голын сав (Монгол Дагуурын хээр)-д үржинэ. Мөн Их Нууруудын хотгор, Нууруудын хөндий, Булган голийн хөндий (Зүүнгарын говь), Орхон голын эх, Сангийн далай, Өгий нуур (Хангайн тойрог), Тэрхийн Цагаан, Сангийн Далай, Тэлмэн, Хар нуур (Тарвагатай-

Булнайн нуруу), Орхон, Сэлэнгэ, Эг, Хараа, Ерөө голын адаг (Орхон-Сэлэнгэ голын сав), Халх, Дэгээ, Нөмрөг, Цагаан Чулуут, Могойт, Азарга, Галдастайн гол, Буйр, Шавар, Ташгайн Таван нуур, Хонгор нуур (Буйр нуур-Халх гол-Хянганы тойрог), Бөөнцагаан, Улаан, Орог, Таацын Цагаан нуур, Цагаан, Урт гол (Нууруудын хөндий), Булган голын хөндий (Зүүнгарын говь)-д нүүдлийн үедээ тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Нүүдлийн болон үржих үедээ зэгс, шагшуурга, өндөр өвс бүхий нуур, голын хөндий болон тариан талбай, хуурай хээрт тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглдөг зүйл бөгөөд Хангайн тойрог, Орхон, Улз голын хөндийгөөр 4-р сарын эхэн үед ажиглагдана. Нүүдлийн оргил үе 4-р сарын дундуур тохиох ба 20-300 тоогоор сүрэлгэж, Орхон, Туул, Сэлэнгэ, Хараа, Онон, Хурх, Улз голын хөндийн тариан талбайгаар хэсэг хугацаанд саатна. Үржлийн хосууд өндөр өтгөн өвс, зэгс шагшуурга бүхий нуур, голын хөндийд хуурай өвс, зэгс, мөчирөөр газар дээр үүр засаж, бор, улаан хүрэн толбо бүхий шаргал ногоон өнгийн 1-2 өндөг гаргана. Хосууд өндгөө 28-31 хоног ээлжлэн дарна. Дэгдээхэй 1-3 хоногийн дараагаас үүрээ орхин эцэг, эхээ дагаж, 65-70 хоногийн дараагаас нисэх чадвартай болно. 4-6 жилийн дараа бие гүйцэнэ. Тэд хавар, зундаа ургамлын үндэс, усны ургамлын нахиа, цэцэг, жимс, ногоон ургамлын ургал хэсэг, навч, шавж, зөөлөн биетэн болон бусад сээрнууруугүйтэн, мэлхий, бах зэрэг сээрнууруутан амьтдаар хооллоно. Харин намрын улиралд тэд ургамлын үндэс, навч, үр, шавж болон тариан талбайд үр тариагаар хооллоно. Бие гүйцсэн шувууд намрын нүүдлийн өмнө хоёр жил тутамд нэг удаа бүрэн гууждаг бөгөөд шинэ өд ургах хүртэл 40 орчим хоногийн турш нисэх чадвараа алддаг. Намрын нүүдэл 8-р сарын сүүлчээр эхэлдэг бөгөөд тариан талбайд цуглаж 200-500 бодгалтай том сүрэг үүсгэнэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 491,000-503,000 бие гүйцсэн бодгаль (Wetland International, 2015) гэж тооцоолсон.

Малын тооны өсөлт, хадлан, уул уурхай, түймэр, аялал жуулчлал зэрэг хүний үйл ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж түүний тоо толгой буурсаар байна. Мөн өндөг, дэгдээхэй малын хөлд гишгэгдэх, нохой, бүргэд, үнэг, хярс зэрэг махчдад бариулах зэрэг нь түүний тоо толгойг цөөрүүлэх шалтгаан болж байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны мэдээ баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>) болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэгдсэн байна. Хархираа тогорууны Монгол орон дахь тархац нутгийн 8.2% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хархираа тогоруу (*Grus grus*) нь 220.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 44.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ӨВӨГТ ТОГОРУУ (ӨВӨГТ ТОГИРУУ)

Anthropoides virgo Linnaeus, 1758

Баг: Тогоруу (*Gruiformes*)

Овог: Тогоруу (*Gruidae*)

НЭРШИЛ:

Англи: Demoiselle Crane

Орос: Журавль-красавка

Хятад: Suoyu He

Герман: Jungfernkranich

Франц: Grue demoiselle

Казах: Акбас тырна



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 950 мм. Далавчны урт эрд 466-540 мм, эмд 453-560 мм. Биеийн жин 2,300-3,060 г хүрнэ. Бие гүйцсэн шувуу хархираа тогоруутай ижил ч хар өнгийн урт зогдор мэт өдтэй ба хүзүү, хацар, дух, дагзнаас бусад биеийн хэсэг хөхвөр саарал, сүүл болон 3-р зэргийн өд доош унжсан байдгаараа ялгарна. Нүднээс арагш шил хүзүү хүртэл нарийн цагаан хэсэг өдтэй. Залуу шувууны биеийн ерөнхий зүс бие гүйцсэнтэйгээ төсөөтэй ч толгой болон цээжний зогдор өд хөгжөөгүй, бүдэг зүстэй. Нүд улаан хүрэн. Хошуу шаргал ногоон. Хөл хар.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Марокко, Португали, Испани, Алжир, Нигери, Норвег, Герман, Итали, Дани, Швед, Чех, Чад, Мальта, Хорват, Унгар, Словак, Серби, Грек, Румын, Финланд, Судан, Украин, Болгар, Египет, Турк, Молдов, ОХУ, Кипр, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Йемен, Армэн, Иран, Азербайджан, Казахстан, БНСУ, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан,

Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргизстан, Хятад, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Японд тархсан. Тунист бүс нутгийн хэмжээнд устсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙШИЛ НУТАГ

Монгол Алтай, Говь-Алтай (д.т.д 2200 метрээс доош), Их Нууруудын хотгорын ихэнх нутаг, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн тойргийн тал хээр, Дундад Халх болон Монгол Дагуурын хээр, Дорнодын тэгш тал, Буйр нуур-Халх гол- Хянганы бүс, Нууруудын хөндий, говь цөлөөр тархсан. Нүүдлийн үедээ Монгол орны тайгын ой, өндөр уулаас бусад бараг бүх задгай орчинд тохиолдоно. Нүүдлийн үедээ тал хээрийн нуур, тариан талбайд 4,000-8,000 бодгаль бүхий том сүрэг үүсгэнэ.



АМЬДРАХ ОРЧИН

Ойт хээр, уулын болон цөлийн хээрийн тачир ургамалтай нутагт голын дэнжид байршилтгай боловч нүүдлийн үедээ олон янзын амьдрах орчинд тохиолдох боломжтой.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл. Шаргын говь, Туул голын хөндий, Баруун Хэнтий, Нууруудын хөндий, Их Нууруудын хотгорт хамгийн түрүүнд 4-р сарын сүүлчээр нүүдэллэн ирнэ. Үндсэн нүүдэл баруун талд Булган, Үенч голын хөндий, Монгол Алтайн уулсаар, төвийн бүсэд Орхон, Сэлэнгэ, Туул, Хараа голуудаар, зүүн талд 115°-118° өргөрөгийн дагуу явагддаг. Үржлийн нутаг нь тухайн бүсийн онцлогоос хамааран ялгаатай. Монгол орны баруун хэсэгт үржлийн хосууд хуурай хээрт үүрлэдэг бол дорнод хэсэгт уснаас холгүй хайрга дээр үүрлэнэ. Нуур, голоос холгүй задгай хуурай орчин, толгод, гүвээний орой, уулсын хөндий, тариалангийн талбайд байршилтгай. Айлын ойролцоо чоно, дорго, цармын ба хээрийн бүргэд зэрэг махчдын нөлөө бага, мөн малчид шувууны үүр, өндгийг гэмтээхийг цээрлэдэг учир бусад газартай харьцуулахад айл орчимд энэ зүйлийн тоо толгойн нягтшил өндөр. Ойт хээр, уулын хээр, цөлийн хээр болон тал хээрийн тачир ургамалтай нутагт газар дээрх хайргыг бага зэрэг хонхойлон үүр засах ба 5-р сарын эхээр бор, улаан хүрэн толбо бүхий ногоовтор саарал өнгийн 2 (ховор тохиолдолд 3) өндөг гаргана. Голын сайрын хайрган дунд өндөглөсөн тохиолдолд өндгийг ялгаж харахад хүндрэлтэй. Эр, эм шувууд өндгийг 28-30 хоног дарсны эцэст дэгдээхэй гарна. Дэгдээхэй өндөгнөөс гарснаас хойш ойролцоогоор 55-56 хоногтойдоо нисэж эхэлнэ. Өндөг, нялх дэгдээхэйд махчин амьтан, эсвэл хүн ойртоход эцэг, эх шувууд далавчаа хугалсан, эсвэл хөлөө гэмтээсэн мэт хуурмаг хөдөлгөөн хийх, эсвэл үхсэн мэт хэвтэх зэргээр тэдний анхаарлыг өөр чигт хандуулдаг. Дэгдээхэй болон бие гүйцсэн шувууд идэш тэжээлийн олдцоос хамааран царцаа, голио, цох, ургамлын үр, үндэс, навч, цэцгээр хооллоно. Намрын нүүдэл 8-р сарын 3 дахь долоо хоногос эхэлнэ. Монгол орны баруун хэсгээс (Ховд аймаг) нүүдэллэсэн шувуу Гималай дээгүүр даван нисэж Энэтхэгт хүрч өвөлжинө.

ОХУ-ын Дагуур, Монгол орны зүүн хэсгийн зарим бодгалиуд Хятадад өвөлждөг (Gombobaatar *et al.*, 2011).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 230,000-261,000 бие гүйцсэн бодгаль (Birdlife International, 2015) хэмээн үнэлсэн.

Манай орны хувьд тоо толгойн үнэлгээ хийгдээгүй боловч тоо толгой буурах гол шалтгаан нь гэрийн малын тооны өсөлт, уул уурхай, түймэр, аялал жуулчлал, орчны бохирдол зэрэг хүний үйл ажиллагаанаас шалтгаалсан амьдрах орчны доройтол, бэлчээрийн мэрэгчдийг цөөлөх зорилгоор цацсан хорт бодист дам хордох, өндөр хүчдэлийн шугамын утас мөргөх зэрэг болно (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор 2000, 2002, 2006, 2012 онд судалгааны дээжийг, 2002 онд 1 бодгалийг агнуулж АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>) болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн.

Өвөгт тогорууны Монгол орон дахь тархац нутгийн 7.6% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр өвөрт тогоруу (*Grus virgo*) нь 112.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 22.4 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ХОНИН ТООДОГ

Otis tarda Linnaeus, 1758

Баг: Торогүү (*Gruiformes*)

Овог: Тоодог (*Otididae*)

НЭРШИЛ:

Англи: Great Bustard

Орос: Дрофа

Хятад: Da Bao

Герман: Grosstrappe

Франц: Outarde barbue

Казах: Дуадақ



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” зүйл (Gombobaatar *et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн хэмжээгээр эр нь эмээсээ бараг 2 дахин том. Биеийн урт 750-1,050 мм. Далавчны урт эрд 595-635 мм, эмд 440-495 мм. Эрийн жин 7,000-1,400 г, эмийнх 3,800-6,500 г хүрнэ.

Бие гүйцсэн шувууны толгой, хүзүү хөхвөр саарал эсвэл цагаан. Эрэгчин эрүү дороо сахал маягийн урт цагаан өдтэй төдийгүй хүзүү бүдүүн харагдана. Нуруу бор шаргал, хөндлөн бор, хар судал, толбуудтай. Залуу шувууны зүс бие гүйцсэн эм шувуутай адил ч бүдэг зүстэй, толгой бор шаргалдуу байна. Хошуу хар саарал.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Марокко, Ирланд, Португали, Испани, Гибралтар, Бельги, Нидерланд, Люксембург, Герман, Итали, Австри, Мальта, Хорват, Унгар, Словак, Монтенегро, Серб, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Украин, Болгар, Египет, Турк, Молдов, ОХУ, Кипр, Израиль, Саудын Араб, Тунис, Ливан, Ирак, Гүрж, Армэн, Иран, Азербайджан, Казахстан, Туркменистан, Узбекистан, Пакистан, Тажикстан, Киргиз, Хятад, Монгол, БНАСАУ, БНСУ, Японд тархсан. Алжир, Их Британи, Франц, Швейцарь, Дани, Швед, Польшид устсан. Мянмарт тохиолдлын байдлаар тааралдана.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Ховд голын хөндий, Увс нуурын хотгор, Тэс голын хөндий, Ачит нуурын баруун захаар, Тэсийн голоос зүүн тийш Хойд Хангай, Хөвсгөл нуур, Эгийн голын хөндийгөөс Орхон-Сэлэнгэ голын хөндий, Сүхбаатар хот (Сэлэнгэ аймаг), Өгий нуур, Баруун Хэнтийгээс (Мандал, Хараа голын хөндий) Хэрлэн голын эх, Онон голын хөндий (Хурх, Барх гол), Улз голын хөндий, Халх, Нөмрөг голын хөндий, Буйр, Ташгайн Таван Нуур (Буйр нуур-Халх гол-Хянганы тойрог), Булган голын хөндий (Баруун хурай)-д үржинэ. Мөн Хар-Ус, Хар, Дөргөн, Хяргас, Айраг нуур, Ховд голын тохой (Их Нууруудын хотгор), Завхан, Тэс, Орхон, Сэлэнгэ гол, Сангийн далай, Өгий нуур, Орхоны хөндий Хужирт (Хангайн тойрог), Хөвсгөл нуур, Эгийн гол (Хөвсгөлийн тойрог), Шишгид ба Доод нуурын ус намгархаг газар (Дархадын хотгор), Зэлтэр гол (Сэлэнгэ аймаг), Барх гол (Хэнтий аймгийн Батширээт сум), Улз гол (Хэнтий аймгийн Норовлин сум), Хурх гол (Хэнтий аймгийн Биндэр сум), Монгол Дагуур (үржлийн шувуу ховор), Дундад Халхын хээр, Дорнод Монголын тал, говийн нам дор газраас

Гурвансайхан уулын бэл, Хэрлэн, Халх гол, Буйр нуур, Мэнэнгийн тал, Нөмрөгийн ДЦГ (үржлийн шувуу ховор), Булган голын хөндий (Зүүнгарын говь), говиор нүүдлийн үедээ тархана.



АМЬДРАХ ОРЧИН

Ойт болон уулын хээр, нуур ба голын хөндийн нуга, тариан талбайд үржих ба нүүдлийн үедээ говь цөлд ч ажиглагдана.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд зарим бодгаль өвөлждөг. Тэд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхээр үржлийн нутагтаа нүүдэллэн ирж (өвөлжсөн шувууд мөн үржлийн нутагруугаа шилжинэ), хялганат хээр, голын хөндий, нуга, ой ба хээрийн заагт байршина. 5-р сарын эхээр үржлийн эр шувууд орооны бүжиг хийж эхэлнэ. Эр бодгаль 4-5 дахь жилээс бэлэг боловсорч үржилд ордог байхад эм бодгаль 1 дэх жилээс үржилд орно. Тоодог ойт хээр, хээр, голын хөндийн хайргархаг хөрстэй, сийрэгдүү өндөр өвстэй (заримдаа элсэрхэг хөрстэй, өтгөн ургамалтай) орчин, мөн тариан талбайд газар малтан хонхойлж, цайвар бор, бараан, саарал том толбо бүхий ногоовор өнгийн 2-3 (заримдаа 4) өндөг гаргана. Эм шувуу өндгөө 25-29 хоног дарж дэгдээхэй болгох ба дэгдээхэй 30-35 хоногийн дараагаас нисэх чадвартай болно. Тэд цох, царцаа, бусад үе хөлтөн зэрэг шавж, ургамлын үр, навч, цэцэг, нахиа, үр тариа, ховор тохиолдолд хулгана, жижиг шувууны ангаахай, гүрвэл, мэлхийгээр хооллоно. Энэ зүйл тоодог Эг, Үүр (Тэшиг ба Хонгор бригад, Хишиг-Өндөр, Шархын Адаг, Хантай, Тэшиг, Тариалан сумдын голын хөндийн тариан талбай), Орхон, Сэлэнгэ, Хурх, Хэрлэн голын хөндий, Лаг нуурт цасны бүрхүүлийн зузаан, идэш тэжээлийн олдцоос хамааран өвөлждөг. Нүүдлийн бодгалиуд 9-р сарын сүүлчээс 10-р сарын дунд үед нүүдэллэнэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 44,000-57,000 бие гүйцсэн бодгаль бөгөөд тэдгээрийн тоо толгой буурсаар байна (IUCN Red List, 2017) хэмээн үнэлсэн. Н.Цэвээнмядаг 2003 онд Монгол орны

тоодгийн популяци 1,500-1,700 бодгальтай (Gombobaatar *et al.*, 2011) гэж тооцоолсон.

Газар тариалан, бэлчээрийн хэт ашиглалт, уул уурхай, түймэр, аялал жуулчлал, орчны бохирдол зэрэг хүний үйл ажиллагаанаас шалтгаалсан амьдрах орчны доройтол, бэлчээрийн мэрэгч цөөлөх зорилгоор хэрэглэсэн хорт бодист дам хордох, өндөр хүчдэлийн шугамын утас мөргөж эндэх, түүнийг хулгайгаар агнаж арьс, өд, махыг ашиглах зэрэг нөлөөнөөс тоо толгой нь буурч байна (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор судалгааны дээж, өд зэргийг 2002, 2006-2008, 2010, 2016 онд АНУ, Япон улс руу, 1 бодгалийг агнуулж 2002 онд АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>) болон “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ийн нэг, хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) бүртгэсэн байдаг.

Хонин тоодогийн Монгол орон дахь тархац нутгийн 6.1% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хонин тоодог (*Otis tarda*) нь 465.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 93.5 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ЦАГААН УУЛЬ (ЦАГААН УУЛЬЖ)

Nyctea scandiaca Linnaeus, 1758

Баг: Ууль (*Strigiformes*)

Овог: Ууль (*Strigidae*)

НЭРШИЛ:

Англи: Snowy Owl (Snow Owl)

Орос: Белая сова

Хятад: Хуехиао

Герман: Schnee-Eule

Франц: Harfang des neiges

Казах: Ақ жапалақ

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Эмзэг”, бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 590-610 мм. Далавчны урт эрд 386-441 мм, эмд 423-467 мм. Биеийн жин 1,600-2,000 г хүрнэ.

Бие гүйцсэн эр, эм шувуудын бүх биеийн өд дун цагаан бөгөөд эмийн биеийн дээд, доод хэсэг

жижиг бараан толбо ихтэй. Тарсны өд өтгөн, хуруу хүртэл үргэлжилнэ. Хошуу, хумс хар. Залуу эрийн биеийн зүс бие гүйцсэн эмийнхтэй адил.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Канад, АНУ, Сэнт Пьер ба Микелон, Бермуд, Гренланд, Исланд, Ирланд, Португали, Их Британи, Фароз Арлууд, Франц, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Дани, Австри, Свалбард Ян Майен, Швед, Чех, Польш, Хорват, Унгар, Словак, Серби, Албани, Финланд, Латви, Украин, ОХУ, Иран, Казахстан, Туркменистан, Пакистан, Энэтхэг, Киргиз, Хятад, Монгол, БНАСАУ, БНСУ, Японд тархана.



ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 28,000 бие гүйцсэн бодгаль бөгөөд тэдгээрийн тоо толгой буурч байна (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн. Манай орны хувьд тоо толгойн үнэлгээ хийгдээгүй.

Тархац нутгийн хүрээнд бэлчээрийн хэт ашиглалт, уул уурхай зэрэг хүний үйл ажиллагаанаас шалтгаалсан амьдрах орчны доройтол, бэлчээрийн мэрэгчдийг цөөлөх зорилгоор хэрэглэсэн хорт бодист дам хордох зэрэг нь түүний хэвийн амьдралд сөргөөр нөлөөлнө (Gombobaatar et al., 2011).

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Увс нуурын хотгор, Хангайн нурууны хойд хэсэг, Хөвсгөлийн тойрог, Орхон, Сэлэнгэ мөрний сав, Онон, Балж голын хөндий (Хэнтийн тойрог), Улз голын хөндий (Монгол Дагуурын тойрог), Халх, Нөмрөг гол, Буйр нуур (Буйр нуур-Халх Гол-Хянганы тойрог), Хэрлэн гол (Дундад Халхын хээр) орчимд өвөл, хавар эрт тааралдана.



ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны талаарх баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://checklist.cites.org>) бүртгэсэн.

Цагаан уулийн Монгол орон дахь тархац нутгийн 9% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar et al., 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Цагаан ууль (*Nyctea scandiaca*) нь 280.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 56.0 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

АМЬДРАХ ОРЧИН

Үлийн цагаан зэрэг мэрэгч ихтэй ойт хээр, уулын хээр, гол болон нуурын хөндийн задгай орчинд амьдрах дуртай.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд өвөл орж ирдэг зүйл бөгөөд цаг агаарын онцлогоос шалтгаалан 11-р сарын сүүлчээс 12-р сарын эхэн үеэр нимгэн цастай, үлийн цагаан оготно, дагуур огдой, монгол чичүүл зэрэг идэш тэжээл элбэгтэй газраар 4-р сарын сүүлч хүртэл байршина. Ангуучлах үедээ дов толгод, хад чулуу, шон зэрэг өндөрлөг биетийн оройгоос ажиглан суух, довтолох, эсвэл нам өндрөөр алгуурхан халин нисэх аргыг хэрэглэнэ. Тэд 2-р сараас 4-р сарын сүүлч үед буцаж нүүнэ.



ЭГЭЛ ШАРШУВУУ

Bubo bubo Linnaeus, 1758

Баг: Ууль (*Strigiformes*)

Овог: Ууль (*Strigidae*)

НЭРШИЛ:

Англи: Eurasian Eagle-owl (Eagle-owl)

Орос: Филин

Хятад: Diaoxiao

Герман: Uhu

Франц: Grand-duc d'Europe

Казах: Үкі

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 560-760 мм. Далавчны урт 400-470 мм. Биеийн жин 2,100-3,200 г хүрнэ.

Биеийн зүс бор шаргалдуу ба бараан, хар судал, толбо ихтэй. Биеийн доод хэсэг шаргалдуу саарал байх бөгөөд тууш судал ихтэй. Эр нь эмээсээ биеэр арай жижиг, цайвар. Нүд том, улбардуу шаргал. Толгойн оройд чих мэт өдтэй. Хошуу хар саарал. Хөл шаргалдуу бор, тарс өдөөр бүрэн хучигдсан.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Мавритани, Мали, Португали, Испани, Их Британи, Гибралтар, Франц, Нигер, Андорра, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман,

Швейцарь, Итали, Дани, Лихтенштейн, Австри, Швед, Чех, Словени, Чад, Польш, Хорват, Босни, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Украин, Болгар, Эстони, Беларусь, Турк, Молдов, ОХУ, Израиль, Ливан, Сири, Ирак, Гүрж, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Монгол, Хонконг, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Манай орны байгалийн бүх бүс, бүслүүрийн хадархаг уулс, хээрийн хад, чулуурхаг толгод, хавцал хад бүхий нуурын эрэг, голын өндөр элсэн эрэг, голын хөндийн ойн захаар (тайгын шигүү ой, ямар ч модгүй тэгш тал ба говь цөл, ус намгархаг газраас бусад) үржинэ.



АМЬДРАХ ОРЧИН

Өндөр уулс, ойт хээр, уулын хээр, хээр, говь цөлийн өндөр хад цохиотой хадархаг орчин, голын хөндийн элсэн эрэг, гүн жалга, баянбүрд зэрэг орчинд байршижтай.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд суурин үрждэг зүйл бөгөөд жилийн турш үржлийн нутаг орчимдоо байршина. Үржлийн хосууд гол төлөв уулын бут, өндөр өвсөөр халхлагдсан хадны хонгил, хөндийд, хадан цохио, хавцлын засварт, мөн жалга судаг, том модны хонгил, бусад шувууны ашиглаж байсан томоохон үүр болон газар дээр бага зэрэг хонхойлж өндөглөнө. Үүрлэж буй газар нь орчноос ялгарахааргүй сайн далдлагдсан байх ба шилийн сар, жунгаа, хон хэрээ зэрэг бусад шувуудын үүрнээс холгүй сонгосон байх нь бий. Цагаан өнгийн гол төлөв 2-3 (хааяа 4-5) өндөг гаргаж, 34-36 хоног дарж ангаахай болгоно. Ангаахай 42-70 хоногийн дараагаас нисэж эхлэх ба 100 орчим хоногийн дараа сайн нисэх чадвартай болдог. Сибирь алагдаага, орог зусаг, дагуур зараа, туулай зэрэг шөнийн идэвхтэй хөхтөн амьтад, морин харцага, идлэг шонхор, хотны бүгээхэй, улаанхушуут жунгаа гэх мэт шувуудаар түлхүү хооллоно. Үржлийн хосууд үүр орчимдоо өвөлжинө.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 100,000-500,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) гэж

үнэлсэн. Манай орны хувьд тоо толгойн үнэлгээ хийгдээгүй.

Тархац нутгийн хүрээнд бэлчээрийн хэт ашиглалт, уул уурхай, жуулчны бааз, ой, хээрийн түймэр, машин техник, орчны бохирдол зэрэг хүний үйл ажиллагаанаас шалтгаалсан амьдрах орчны доройтол, бэлчээрийн мэрэгч цөөлөх зорилгоор хэрэглэсэн хорт бодис, өндөр хүчдэлд цохиулах, мөргөж эндэх, казах иргэд болон бөөгийн шашны зан үйлд өд, сарвууг ашиглах, гоёл чимэглэл хийх зорилгоор хулгайгаар агнах, зэрэг нь түүний тоо толгойг цөөрүүлэх шалтгаан болно (Gombobaatar *et al.*, 2011; Гомбобаатар, Одхүү, 2018).

ХУДАЛДАА

Аялал жуулчлалын үзэсгэлэн, сургалтын зорилгоор 1 чихмэлийг 1998 онд Япон руу, хувийн зорилгоор 3 өдийг 2016 онд АНУ руу, 1 бодгалийг 2004 онд АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://checklist.cites.org>) бүртгэсэн.

Эгэл шаршувууны Монгол орон дахь тархац нутгийн 7.8% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Эгэл шаршувуу (*Bubo bubo*) нь 454.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 90.8 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

СООТОН ГУЙВАНГА (ЯВЛИГ УУЛЬ)

Asio otus Linnaeus, 1758

Баг: Ууль (*Strigiformes*)

Овог: Ууль (*Strigidae*)



ГУРАВДУГААР БҮЛЭГ

НЭРШИЛ:

Англи: Long-eared Owl

Орос: Ушастая сова

Хятад: Chang'er Xiao

Герман: Waldohreule

Франц: Hibou moeun-duc

Казах: Ұзынкұлақ жапалақ

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ


Биеийн урт эрийн хувьд 335-370 мм, эмд 350-385 мм. Эрийн далавчны урт 280-315 мм, эмийнх 285-312 мм. Биеийн жин 210-420 г хүрнэ.

Биеийн гадаад шинжээрээ шар шувуутай төсөөтэй бөгөөд биеэр жижиг байдгаараа ялгагдана. Биеийн дээд хэсэг тууш бараан хүрэн судал, толбо бүхий шаргалдуу бор хүрэн. Биеийн доод хэсэг илүү цайвар. Толгойн оройд чих хэлбэрт өд байх агаад гол хэсгээрээ хар. Нүдний солонгон бүрхүүл улбар шаргал.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Канад, АНУ, Мексик, Куба, Сэнт Пьер ба Микелон, Бермуд, Исланд, Марокко, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Фароз Арлууд, Гибралтар, Франц, Андорра, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали,

Тунис, Дани, Лихтенштейн, Австри, Свалбард Ян Майен, Швед, Чех, Словени, Польш, Мальта, Хорват, Босни, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Украин, Болгар, Эстони, Беларусь, Египет, Турк, Молдов, ОХУ, Кипр, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Ирак, Гүрж, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Балба, Монгол, Бутан, Мянмар, Лаос, Хонконг, Тайвань, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хотон, Хоргон, Ачит нуур, Ховд, Булган гол (Монгол-Алтайн тойрог), Увс нуурын баруун хойд хэсэг, Тэс гол (Их Нууруудын хотгор), Тамир, Хануй, Орхон голын эх, Тарвагатай-Булнайн нуруу (Хангайн тойрог), Хөвсгөл нуур, Эг гол (Хөвсгөлийн тойрог), Шишгид гол, Доод нуурын ус намгархаг газар (Дархадын хотгор), Орхон, Сэлэнгэ, Эг, Хараа гол (Орхон-Сэлэнгэ голын сав), Туул, Тэрэлж, Онон, Балж, Хүдэр, Булнайн голын эх, Хэрлэн Баян Улаан, Богдхан уул (Хэнтийн тойрог), Улз, Хэрлэн гол, Монгол Дагуурын хээр, Дундад Халхын хээр, Буйр нуур-Халх гол-Хянганы бүс нутаг, Булган гол (Баруун хуурайн хотгор, Зүүнгарын говь)-д үржинэ. Мөн хээр, цөлийн хээр, Алтайн Өвөр говь, Зүүн говьд нүүдлийн үедээ тааралдана.



АМЬДРАХ ОРЧИН

Тайга, ойт хээр, нуур ба голын хөндийн навчит болон холимог ой. Нүүдлийн үедээ говь цөлд тохиолдож болно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд зарим бодгаль өвөлжинө. Тэд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд нүүдэллэн ирж нуур ба голын хөндийн төгөл, тайга, ойт хээрийн навчит болон холимог төрөл бүрийн ойд модны хонгил, эсвэл хар хэрээ, шаазгай, махчин шувуудын хуучин үүрэнд үүрлэнэ. Цагаан өнгийн 4-5 (ховор тохиолдолд 8 хүртэл) өндөг гаргаж, 25-30 хоног дарна. Өндөгнөөс гарсан ангаахай 23-24 хоногийн дараагаас үүрээ орхин ниснэ. Шөнийн идэвхтэй бөгөөд гол төлөв оготно, орог зусаг, огдой, туулай, заримдаа жижиг, дунд хэмжээтэй шувуугаар хооллоно. Ихэнх бодгаль 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд нүүдэллэх ба цөөн тооны бодгаль идэш тэжээлийн олдцоос шалтгаалан өвөлждөг.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 2,000,000-5,500,000 үржлийн насны бодгаль (BirdLife International, 2017) гэж үнэлсэн. Манай орны хувьд тоо толгойн үнэлгээ хийгдээгүй.

Тархац нутгийн хүрээнд ой, бэлчээрийн хэт ашиглалт, уул уурхай, аялал жуулчлалын бааз, ой, хээрийн түймэр, машин техникийн нөлөөгөөр түүний амьдрах орчин доройтож байна. Бэлчээрийн мэрэгч цөөрүүлэх зорилгоор хэрэглэсэн хорт бодист дам хордох, өндөр хүчдэлийн шугамын утас мөргөж олноор эндэнэ. Казах иргэд болон бөөгийн шашны зан үйлд өд, сарвууг ашиглах, гоёл чимэглэл хийх зорилгоор хулгайгаар агнана (Gombobaatar *et al.*, 2011; 2017; 2018).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор 1 дээжийг 2002 онд АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://checklist.cites.org>) бүртгэсэн.

Соотон гуйвангын Монгол орон дахь тархац нутгийн 10.8% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Соотон гуйванга (*Asio otus*) нь 50.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 10.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ХУЛГАР ГҮЙВАНГА (ГҮЙВАНГУУ УУЛЬ)

Asio flammeus Pontoppidan, 1763

Баг: Ууль (*Strigiformes*)

Овог: Ууль (*Strigidae*)

НЭРШИЛ:

Англи: Short-eared Owl

Орос: Болотная сова

Хятад: Duan'er Xiao

Герман: Sumpfohreule

Франц: Hibou des marais

Казах: Саз жапалақ

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт эрийн хувьд 340-415 мм, эмийн хувьд 350-392 мм. Далавчны урт эрд 281-329 мм, эмд 285-335 мм. Биеийн жин 350-410 г хүрнэ.

Өнгө зүсний хувьд эр, эм шувууд ижил. Бие гүйцсэн шувууд соотон гуйвангатай төсөөтэй бөгөөд 1-р зэргийн дэвүүр өдний үзүүрт 2-3 хөндлөн судалтай, мөн толгойн оройд байрлах чих хэлбэрт өд богино, нүдний солонгон бүрхүүл шаргал байдгаараа ялгаатай. Хумс хар, хошуу бараан. 1-р зэргийн дэвүүр өдний гадна талын өдлөг 4 мм орчим нарийссан байна.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Канад, АНУ, Гватемал, Белиз, Коста Рика, Куба,

Кайманы арлууд, Перу, Эквадор, Колумб, Чили, Гайти, Багам, Бразил, Аргентин, Венесуэль, Турк ба Кайкосын Арлууд, Доминикан, Боливи, Пуэрто Рико, Виржиний Арлууд, Парагвай, Доминика, Мартиник, Уругвай, Барбадос, Бермуд, Гренланд, Исланд, Сенегал, Мавритани, Гвиней, Марокко, Мали, Либери, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Франц, Нигер, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Итали, Тунис, Дани, Лихтенштейн, Ливийн Жамахири, Австри, Свалбард Ян Майен, Чех, Словени, Польш, Мальта, Хорват, Босни, Унгар, Словак, Монтенегро, Серб, Албани, Грек, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Украйн, Болгар, Эстони, Беларусь, Египет, ОХУ, Уганда, Кипр, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Энэтхэг, Киргиз, Мальдив, Хятад, Шри Ланк, Балба, Бангладеш, Бутан, Мянмар, Тайланд, Малайз, Лаос, Вьетнам, Сингапур, Хонконг, Филиппин, БНАСАУ, БНСУ, Японд тархана.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Ачит, Үүрэг нуурын хөндий (Монгол-Алтайн тойрог), Хар-Ус, Хар нуур, Увс нуур, Тэс гол, Шаргын говь (Их Нууруудын хотгор), Бөөнцагаан, Айраг нуур (Нууруудын хөндий), Хангай, Хөвсгөл, Хэнтийн тойрог, Улз, Хэрлэн гол, Монгол Дагуурын хээрийн нуур ба голууд, Дундад Халхын хээр, Халх, Дэгээ, Нөмрөг, Могойт, Азарга, Галдастай голын хөндий, Буйр, Шавар, Ташгайн Таван нуурын хөндий (Буйр нуур-Халх гол-Хянганы тойрог)-д үржинэ. Мөн Дундад Халх, Хангай, Хэнтий, Халх гол-Буйр нуур-Хянганы бүсийн ойт хээр, хээр, уулсын хөндийгөөр нүүдлийн үедээ тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Ой, ойт хээр, нуур, голын хөндийн төгөл, бургасан шугуй, намаг нүүдлийн үедээ говь цөл, тариалангийн талбайд ч тааралдана.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд зарим бодгаль нүүдэллэнэ. Нүүдлийн бодгалиуд 4-р сарын дундаас 5-р сарын эхэн үед ирж, голын хөндийн бут сөөг бүхий татам нуга, намгархаг орчинд газар бага зэрэг хонхойлон хагд өвс дэвсэж, цагаан өнгийн 4-8 (ховор тохиолдолд 10-14) өндөг гаргаж, 24-28 хоног дарна. Ангаахай 12-17 хоногийн дараа үүрээ орхих боловч дахин 10 хоногийн дараагаас нисэх чадвартай болдог. Оготно, зусаг, огдой, жижиг шувуу, заримдаа

шавжаар хооллоно. 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд зарим бодгалиуд өвөлжих нутгаа зорин нүүнэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 350,000-2,000,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) гэж үнэлсэн. Манай орны хувьд тоо толгойн үнэлгээ хийгдээгүй.

Тархац нутгийн хүрээнд ой, бэлчээрийн хэт ашиглалт, уул уурхай, түймэр, машин техникийн шууд ба дам нөлөөгөөр түүний амьдрах орчин доройтож байна. Бэлчээрийн мэрэгч цөөлөх зорилгоор хэрэглэсэн хорт бодис, өндөр хүчдэлийн шугамын утас мөргөж эндэх зэрэг нь түүний тоо толгойг цөөрүүлэх шалтгаан болно (Gombobaatar *et al.*, 2011; Гомбобаатар, Одхүү, 2018).

ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны мэдээ байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://checklist.cites.org>) бүртгэсэн.

Хулгар гуйвангын Монгол орон дахь тархац нутгийн 7.4% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хулгар гуйванга (*Asio flammeus*) нь 56.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 11.6 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ



ЕРДИЙН ОРВОЛГО (ОРВОЛГО УУЛЬ)

Otus scops Linnaeus, 1758

Баг: Ууль (*Strigiformes*)

Овог: Ууль (*Strigidae*)

НЭРШИЛ:

Англи: Eurasian Scops Owl (Scops Owl, Common Scops-Owl)

Орос: Сплюшка

Хятад: Hong/Xi Hong Jiaoxiao

Герман: Zwergohreule

Франц: Petit duc scops

Казах: Маубас жапалақ

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (Gombobaatar *et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт эрийн хувьд 185-220 мм, эмд 200-226 мм. Эрийн далавчны урт 142-161 мм, эмийнх 146-166 мм. Биеийн жин 80-82.5 г хүрнэ.

Бие гүйцсэн шувууны ерөнхий зүс модны холтос мэт хээтэй бор саарлаас улбардуу бор хүрэн хүртэл хувьсдаг. Биеийн хажуу, доод хэсгээр нарийн тод хар судалтай. Чих хэлбэрийн урт өд толгойн оройд илэрнэ. Нүдний солонгон бүрхүүл шар. Хошуу хар.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Исланд, Сенегал, Баруун Сахар, Мавритани,


Гамби, Гвиней, Марокко, Сьерра-Леоне, Мали, Либери, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Гибралтар, Буркина Фасо, Франц, Гана, Того, Нигер, Бенин, Андорра, Бельги, Нигери, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Тунис, Дани, Камерон, Лихтенштейн, Ливийн Жамахири, Австри, Конго, Швед, Ангол, Намиби, Чех, Словени, Чад, Польш, Мальта, Хорват, Төв Африк, Өмнөд Африк, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Ботсвана, Грек, Румын, Македони, Латви, Литва, Судан, Замби, Украин, Болгар, Беларусь, Египет, Зимбабве, Турк, Молдов, Лесото, ОХУ, Руанда, Бурунди, Танзани, Уганда, Мозамбик, Свазиланд, Кипр, Малави, Этиоп, Кени, Израиль, Саудын Араб, Йордан, Ливан, Сири, Эритри, Ирак, Гүрж, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Бахрейн, Катар, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Шри Ланк, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мянмар, Индонез, Тайланд, Малайз, Лаос,

Вьетнам, Камбож, Сингапур, Хонконг, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Булган голоос (Монгол-Алтайн тойрог), Тэс гол (Их Нууруудын хотгор), зүүн тийш Туул, Тэрэлж гол, Онон голын эх, Улз голын хөндий (Хэнтийн тойрог)-д үржинэ. Мөн Хангайн тойрогт үржлийн үедээ тохиолдоно. Нүүдлийн үедээ ихэнх нутгаар тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Тайга, ойт хээр, нуур, голын хөндийн навчит болон холимог ойд байршина. Нүүдлийн үедээ говь цөлд тохиолдохоос гадна, таримал модыг даган байрших нь бий.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл бөгөөд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд ирж уулын тайгын ой, ойт хээр, нуур ба голын хөндийн навчит болон холимог ойд модны хонгил, заримдаа бусад шувуудын орхисон үүрэнд үүрлэнэ. Цагаан өнгийн гол төлөв 3-4 өндөг гаргаж, 24-25 хоног дарж ангаахай болгоно. Ой, ойт хээрийн оготно, хулгана, жижиг шувуу, заримдаа шавжаар хооллоно. Ангаахай үүрээ 20 хоногийн дараагаас орхих боловч 30 орчим хоног үүр орчимдоо

байршина. Цаг агаараас шалтгаалан 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэн үед нүүдэллэх ба энэ үедээ ой, хад асгаар тохиолдоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 800,000-1,400,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) гэж үнэлсэн. Манай орны хувьд тоо толгой тодорхойгүй.

Тархац нутгийн хүрээнд ой, бэлчээрийн хэт ашиглалт, уул уурхай, жуулчны бааз, түймэр, машин техник, орчны бохирдол зэргээс шалтгаалсан амьдрах орчны доройтол зэрэг нь түүний хэвийн амьдралд сөргөөр нөлөөлнө (Гомбобаатар, Одхүү, 2018).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор дээж, арьс зэргийг 2011, 2012 онд АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) ажээ.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://checklist.cites.org>) бүртгэсэн.

Ердийн орволгын Монгол орон дахь тархац нутгийн 10.7% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar et al., 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Ердийн орволго (*Otus scops*) нь 15.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 3.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ОЙН ОРВОЛГО

Otus sunia Hodgson, 1836

Баг: Ууль (*Strigiformes*)

Овог: Ууль (*Strigidae*)



НЭРШИЛ:

Англи: Oriental Scops Owl

Орос: Уссурийская совка

Хятад: Dongfang/Hong Jiaoxiao

Герман: Orient- Zwergohreule

Франц: Petit duc d'Orient

Казах: Қиыршығыс жапалағы

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Үнэлэх боломжгүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.


ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 180-210 мм. Далавчны урт эрийн хувьд 138-149 мм, эмд 140-158 мм. Биеийн жин 75-95 г хүрнэ.

Бие гүйцсэн шувуу биеийн зүсээр ердийн орволготой тун төсөөтэй. Тарс нь тарс ба хурууны үе хүртэл өдөөр хучигдаагүй, далавчны гадна талаас тоолоход 1-р зэргийн дэвүүрийн 1-р өд нь 6-р өднөөсөө маш богино. 4 ба 5-р өд нь 3-р зэргийн дэвүүр өднөөс урт харагдана. Хошуу хар саарал. Хөл бор саарал.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

АНУ, ОХУ-аас Тайланд хүртэл Зүүн Ази болон Зүүн өмнөд Азийн ихэнх орон, Монголд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Дорнод аймгийн Мэнэнгийн талд 1995 оны 6-р сард 1 бодгаль тэмдэглэгдсэн. Чойбалсан хот, Галуут нуурт бүртгэгдсэн тухай мэдээлэл бий.



АМЬДРАХ ОРЧИН

Их Хянган, Нөмрөгийн голын хөндийгөөр дамжин ирж Мэнэнгийн тал, Монгол Дагуурын холимог ойд амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд нүүдлийн дайрч өнгөрдөг зүйл бөгөөд үрждэг байх боломжтой. Тэд 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд Их Хянган, Нөмрөгийн голын хөндийгөөр дамжина. Амьдрах орчны хувьд ердийн орволготой ижил бөгөөд модны хонгилд үүрлэж, шавж, жижиг мэрэгчээр хооллоно. 8-р сарын сүүлчээс 9-р сарын эхэнд өвөлжих нутгаа зорин нүүдэллэнэ.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн хэмжээнд энэ зүйлийн популяцийн үнэлгээ хийгдээгүй. Хятадад 10,000-100,000 үржлийн хос, Тайваньд 1,000-аас ихгүй үржлийн хос, Солонгост 10,000 нүүдлийн бодгаль, Японд 100-100,00 үржлийн хос, ОХУ-д 100-10,000 үржлийн хос бий (Brazil, 2009) гэж үнэлсэн. Манай

орны хувьд тоо толгойн үнэлгээ хийгээгүй.

Ой болон бэлчээрийн хэт ашиглалт, уул уурхай, ой, хээрийн түймэр зэрэг нь түүний хэвийн амьдралд сөргөөр нөлөөлнө (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Манай оронд худалдааны тухай мэдээ баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://checklist.cites.org>) бүртгэсэн.

Ойн орволгын Монгол орон дахь тархац нутгийн 65.5% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Ойн орволго (*Otus sunia*) нь 15.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 3.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



САВАГТ АРИАН (САВАГТ УУЛЬ)

Aegolius funereus Linnaeus, 1758

Баг: Ууль (*Strigiformes*)

Овог: Ууль (*Strigidae*)

НЭРШИЛ:

Англи: Tengmalm's Owl (Boreal Owl)

Орос: Мохноногий сын

Хятад: Guixiao

Герман: Rauhfusskauz

Франц: Chouette de Tengmalm

Казах: Орман байғызы

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (Gombobaatar *et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 241-276 мм. Эрийн далавчны урт 154-178 мм, эмийнх 165-185 мм. Биеийн жин 120 г.


Өнгө зүсний хувьд эр, эм шувууд ижил. Бие гүйцсэн шувууны толгойн орой, нуруу жижиг цагаан толбо

ихтэй цайвар бор тул цоохор мэт харагдана. Нүүр хавтгай ба шар нүдийг тойрсон тод хар хүрээтэй. Хэвлий цагаан ч бүдэг бараан хүрэн өргөн судал, толбуудтай. Хошуу шар, хумс хар. Хумсаа хүртэл өдтэй.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Канад, АНУ, Сэнт Пьер ба Микелон, Испани, Их Британи, Франц, Андорра, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Итали, Дани, Лихтенштейн, Австри, Швед, Чех, Словени, Польш, Хорват, Босни, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Грек, Румын, Македони, Финланд,

Латви, Литва, Украин, Болгар, Эстони, Беларусь, Турк, ОХУ, Армен, Казахстан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Хятад, Монгол, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Булган гол (Баруун хуурайн хотгор), Ёлт гол (Монгол-Алтайн тойрог), Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулс, Хэрлэн, Улз голын сав, Монгол Дагуурын хээр, Халх, Нөмрөг гол (Буйр нуур-Халх гол-Хянган)-д үржинэ.



АМЬДРАХ ОРЧИН

Тайгын ойн гүн битүү хэсэгт амьдрах ба өвөлдөө ойт хээр, голын хөндийн шилмүүст болон холимог ой руу шилжинэ. Манай орны хувьд суурин, үрждэг зүйл бөгөөд уулын тайга, ойт хээр, голын хөндийн шилмүүст болон холимог ойд их алаг, хар тоншуул, бусад шувуудын хуучин үүрэнд 5-р сард үүрлэж, цагаан өнгийн гол төлөв 3-6 өндөг (заримдаа 10) гаргаж, 26-36 хоног дарна. Ангаахай 30-36 хоногийн дараа үүрээ орхих ба оготно, хулгана зэрэг жижиг мэрэгч, жижиг шувуудаар хооллоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 700,000-2,400,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) гэж үнэлсэн. Манай орны хувьд тоо толгой тодорхойгүй.

Ойн зүй бус ашиглалт, уул уурхай, жуулчны бааз, ойн түймэр зэрэг хүчин зүйлс тэдгээрийн амьдралд сөргөөр нөлөөлдөг (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор судалгааны 3 дээжийг 2012 онд АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://checklist.cites.org>) бүртгэсэн.

Савагт арианын Монгол орон дахь тархац нутгийн 10.0% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Савагт ариан (*Aegolius funereus*) нь 32.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 6.4 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ХОТНЫ БҮГЭЭХЭЙ

Athene noctua Scopoli, 1769

Баг: Ууль (*Strigiformes*)

Овог: Ууль (*Strigidae*)

НЭРШИЛ:

Англи: Little Owl

Орос: Домовый сыч

Хятад: Zongwenfu Xiao

Герман: Steinkauz

Франц: Chouette chevêche, Chevêche d'Athéna

Казах: Үйкүшік байғыз

📖 ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

🔍 ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 21 см. Далавчны урт эрд 158-172 мм, эмд 161-181 мм. Биеийн жин 180-198 г хүрнэ.

Биеийн ерөнхий зүс бараавтар бор хүрэн. Толгойн оройн хэсэг жижиг цагаан толбо ихтэй. Хэвлий, цээж, гүеэ өргөн бараан хүрэн судлуудтай. Хөмсөг өргөн тод цагаан. Хошуу шар, хумс бараан. Сүүл богино. Тарс харьцангуй урт.

🌐 ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Грек, Кипр, Баруун Сахар, Мавритани, Марокко, Мали, Ирланд, Португали, Испани, Алжир, Их Британи, Нигер, Андорра, Нидерланд, Норвег, Люксембург, Швейцарь, Итали, Тунис, Дани, Ливийн Жамахири, Австри, Швед, Чех, Польш, Мальта, Унгар, Монтенегро, Албани, Македони, Финланд, Латви, Литва, Судан, Украин, Беларусь, Турк, Молдов, Израиль, Йордан, Ливан, Сири, Ирак, Сомали, Джибути, Йемен, Армен, Иран, Азербайджан, Казахстан, Кувейт, Эмират, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Энэтхэг, Киргиз, Балба, Монгол, БНАСАУ, БНСУ, Шинэ Зеландад тархсан. Лихтенштейнд утсан байж болзошгүй.



хооллоно. Өвлийн улиралд цас нимгэн, идэш тэжээл элбэгтэй газрыг сонгон өвөлжинө.


ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 500,000-1,000,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) гэж үнэлсэн. Манай орны хувьд тоо толгойн үнэлгээ хийгдээгүй.

Бэлчээрийн хэт ашиглалт, уул уурхай, жуулчны бааз, ой хээрийн түймэр, орчны бохирдол, мэрэгч устгах зорилгоор цацсан хорт бодист дам хордох зэрэг нь түүний тоо толгойг цөөрүүлэх шалтгаан болно (Gombobaatar et al., 2011).

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол Алтай, Говь-Алтайн тойрог (өндөр уулын таг, чийглэг нугаас бусад), Их Нууруудын хотгор, Хангай, Хөвсгөл, Хэнтийн тойрог (тайгын шигүү ойгоос бусад), Дундад Халхын хээр, Монгол Дагуурын хээр, Дорнод Монголын тал, Буйр нуур-Халх гол-Хянганы бүс, Нууруудын хөндий, Баруун хуурайн хотгор, говь (Алтайн Өвөр, Хойд ба зүүн говь)-д үржинэ.



ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор 1 дээжийг 2000 онд, агнуурын зорилгоор 2 бодгалийг 2006 онд тус тус АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) ажээ.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://checklist.cites.org>) бүртгэсэн.

Хотны бүгээхэйн Монгол орон дахь тархац нутгийн 8.3% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar et al., 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хотны бүгээхэй (*Athene noctua*) нь 28.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 5.6 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

АМЬДРАХ ОРЧИН

Ойт хээр, хээр, цөлөрхөг хээрийн хад асгат уулс, элсэн эрэг, гол ба нуурын хөндий, таримал ой, барилга байгууламж зэрэг олон янзын амьдрах орчинд тархсан.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд суурин өндөглөдөг зүйл. Үржлийн хосууд хад, хавцал, модны хонгил, хаягдсан барилга, малын хашааны нүх зэрэгт үүрлэж, цагаан өнгийн гол төлөв 3-5 өндөг (заримдаа 8) гаргаж, 30 орчим хоног дарж ангаахай болгоно. Ангаахай 28-35 хоногийн дараа үүрээ орхин нисэх чадвартай болно. Оготно, зусаг, чичүүл, жижиг шувууд, гүрвэл, шавжаар



БУСЛАГ СҮЛИГ (БУСЛАГ БҮГЭЭХЭЙ)

Glaucidium passerinum Linnaeus, 1758

Баг: Ууль (*Strigiformes*)

Овог: Ууль (*Strigidae*)

НЭРШИЛ:

Англи: Eurasian Pygmy Owl

Орос: Воробьиный сыч

Хятад: Huatou Xiuliu

Герман: Sperlingskauz

Франц: Chevèchette d'Europe

Казах: Байгызша

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Хамгийн жижиг биетэй ууль бөгөөд бор шувуунаас ялимгүй том. Биеийн урт эрийн хувьд 152-170 мм, эмийнх 174-175 мм. Далавчны урт эрд 92-102 мм, эмд 100-102 мм. Биеийн жин эрд 56-61.5 г, эмд 70-78.8 г хүрнэ.

Бие гүйцсэн шувууны ерөнхий зүс сааралдуу бор хүрэн ба жижиг цайвар толбо ихтэй тул цоохор харагдана. Нүүр жижиг цайвар толбуудтай цоохор. Хөмсөг цагаан, хошуугаар тусгаарлагдсан. Биеийн доод хэсэг цагаан ба нарийн бор хүрэн судалтай. Савар, хумс хүртэл цагаан өдтэй. Нүд, хошуу шар.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Испани, Франц, Бельги, Норвег, Герман, Швейцарь, Итали, Дани, Лихтенштейн, Австри, Швед, Чех, Словени, Польш, Хорват, Босни, Словак, Серби, Румын, Финланд, Латви, Литва, Украин, Болгар, Эстони, Беларусь, ОХУ, Казахстан, Хятад, Монголд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙШИЛ НУТАГ

Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулсын өмнөд хэсэг, Их Хянганы уулсын ойд үржинэ.



АМЬДРАХ ОРЧИН

Хуш, шинэс бүхий шилмүүст ойд байршижтай.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд суурин өндөглөдөг зүйл бөгөөд шилмүүст модны хөндий, ховор тохиолдолд шаазгай болон бусад шувуудын үүрэнд үүрлэж, цагаан өнгийн гол төлөв 4-6 өндөг гаргана. Өндгөө 28 орчим хоног дарж ангаахай болгоно. Ангаахай 29-32 хоногийн дараагаас үүрээ орхино. Оготно, зусаг зэргээр хооллоно. Өвлийн улиралд голын хөндийн ой, ойт хээрт байршина.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 500,000-1,200,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) гэж үнэлсэн. Манай орны хувьд тоо толгойн үнэлгээ хийгдээгүй.

Ойн зохисгүй ашиглалт, уул уурхай, ойн түймэр зэрэг нь тэдний амьдралд сөргөөр нөлөөлдөг (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Манай орны хувьд худалдааны тухай баримт байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://checklist.cites.org>) бүртгэсэн.

Буслаг сүлигийн Монгол орон дахь тархац нутгийн 10.7% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Буслаг сүлиг (*Glaucidium passerinum*) нь 12.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 2.4 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ХАРСУН БЭГБААТАР

Surnia ulula Linnaeus, 1758

Баг: Ууль (*Strigiformes*)
Овог: Ууль (*Strigidae*)

НЭРШИЛ:

Англи: Hawk Owl (Northern Hawk Owl)

Орос: Ястребиная сова

Хятад: Mengxiao

Герман: Sperebereule

Франц: Chouette épervière

Казах: Қаршыға жапалақ

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al., 2011*) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт эр бодгалийнх 360-390 мм, эмийнх 390-410 мм. Далавчны урт эрд 221-241 мм, эмд 228-242 мм хүрнэ. Биеийн жин эрийнх 270-314 г, эмийнх 320-345 г.

Бие гүйцсэн шувууны нуруу бараавтар бор хүрэн

ба цагаан толбо ихтэй. Нүүр цагаан, нүүрний хоёр хажуугаар хар судалтай. Биеийн доод хэсэг бүхэлдээ цагаан ба бараан хүрэн хөндлөн судалтай. Харьцангуй урт сүүлтэй. Хумс хар. Нүд, хошуу шар. Залуу шувууны нуруу хар хүрэн. Хэвлий цагаан бор, хөндлөн судал бага илэрнэ.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Канад, АНУ, Бермуд, Испани, Их Британи, Фароз Арлууд, Франц, Бельги, Нидерланд, Норвег, Люксембург, Герман, Швейцарь, Дани, Австри, Швед, Чех, Польш, Унгар, Словак, Серб, Румын, Финланд, Украин, Эстони, ОХУ, Казахстан, Хятад, Монгол, БНАСАУ, Японд тархсан. Латвид устсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хангай, Хөвсгөл, Хэнтийн тойрог, Увс нуурын хөндий, Хэрлэн, Улз голын хөндийн бургасан төгөл, Буйр нуур-Халх гол-Хянганы мужид үржинэ.



АМЬДРАХ ОРЧИН

Тайгын шилмүүст болон холимог ойд амьдарна. Өвөлдөө ойт хээр, гол ба нуурын хөндийн шилмүүст болон холимог ой руу шилжинэ.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд суурин өндөглөдөг зүйл бөгөөд үржлийн хосууд тайга, ойт хээр, гол ба нуурын хөндийн шилмүүст болон холимог ойд модны хонгилд, эсвэл бусад шувуудын сайн халхлагдсан хуучин үүрэнд үүрлэнэ. Тэд 4-р сарын эхээр цагаан өнгийн гол төлөв 3-5 өндөг гаргаж, 30 орчим хоног дарж ангаахай болгоно. Ангаахай 23-27 хоногийн дараа үүрээ орхино. Шөнө, бүрэнхий цагаар ангуучилна. Оготно, хулгана, жижиг шувуудаар хооллоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 100,000-500,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) гэж үнэлсэн. Манай орны хувьд энэ зүйлийн тоо толгой тодорхойгүй.

Тархац нутгийн хүрээнд ойн хэт ашиглалт, ойн түймэр, аялал жуулчлал зэрэг нь тэдгээрийн хэвийн амьдралд сөргөөр нөлөөлж байна (Gombobaatar et al., 2011).

ХУДАЛДАА

Монгол улсаас гадаадад худалдаалсан тохиолдол байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://checklist.cites.org>) бүртгэсэн.

Харсун бэгбаатарын Монгол орон дахь тархац нутгийн 10.7% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar et al., 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Харсун бэгбаатар (*Surnia ulula*) нь 51.0 мян. төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 10.2 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ХУВ УУЛЬ (ХУВ БЭГБААТАР)

Strix uralensis Pallas, 1771

Баг: Ууль (*Strigiformes*)

Овог: Ууль (*Strigidae*)

НЭРШИЛ:

Англи: Ural Owl

Орос: Длиннохвостая неясыть

Хятад: Changwei Linxiao

Герман: Habichtkauz

Франц: Chouette de l'Oural

Казах: Кезкүйрық жапалақ

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт 500-590 мм. Далавчны урт эрд 328-344 мм, эмд 335-359 мм. Эрийн биеийн жин 500-950 г бол эмийнх 570-1,300 г хүрнэ.

Бие гүйцсэн шувууны зүс сааралдуу бор хүрэн бөгөөд гадаад шинжээрээ угалзан уультай ихээхэн төсөөтэй ч биеэр жижиг, нүд хар байдгаараа эрс ялгарна.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ


Испани, Норвег, Герман, Итали, Австри, Швед,

Чех, Словени, Польш, Хорват, Босни, Унгар, Словак, Монтенегро, Серби, Албани, Румын, Македони, Финланд, Латви, Литва, Украин, Болгар, Эстони, Беларусь, ОХУ, Казахстан, Хятад, Монгол, БНАСАУ, БНСУ, Японд тархсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хангай (Хойд Хангайгаас улсын хил хүртэл), Хөвсгөл, Хэнтийн тойрог (Богдхан уул хүртэл), Хархираа, Түргэний уулс, Хэрлэн-Улз голын ай савын бургасан төгөл, Буйр нуур-Халх гол-Хянганд үржинэ.



АМЬДРАХ ОРЧИН

Тайгын ойд үржинэ. Ойт хээр, нуур ба голын хөндийн шилмүүс болон холимог ойд тохиолдоно.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд суурин өндөглөдөг зүйл. Модны хонгил, махчин шувууны хуучин үүр, эсвэл модны үндэс орчимд газар дээр үүрлэнэ. Цагаан өнгийн гол төлөв 3-4 өндөг гаргана. Өндгөө 27-28 хоног дарж ангаахай болгоно. Ангаахай 30 гаруй хоногийн дараагаас үүрээ орхино. Ойд жижиг мэрэгч, шувуудаар голчлон хооллоно. Өвлийн улиралд нам дор газар буюу ойт хээр, голын хөндий, заримдаа таримал ойгоор байршина.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 350,000-1,200,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) гэж үнэлсэн. Манай орны хувьд тоо толгойн үнэлгээ хийгдээгүй.

Ойн хэт ашиглалт, уул уурхай, жуулчны бааз, ойн түймэр зэрэг хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй амьдрах орчны доройтол, мөн ойн хортонь эсрэг хэрэглэсэн хорт бодис нь түүний амьдралд сөргөөр нөлөөлдөг (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Шинжлэх ухааны зорилгоор 1 дээжийг 2000 онд АНУ руу, мөн 1 бодгалийг агнуулан 2006 онд АНУ руу гаргасан (CITES-ийн тайлан, 2017) байна.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://checklist.cites.org>) бүртгэсэн.

Хув уулийн Монгол орон дахь тархац нутгийн 10.6% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хув ууль (*Strix uralensis*) нь 148.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 29.6 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



УГАЛЗАН УУЛЬ (УГАЛЗАН БЭГБААТАР)

Strix nebulosa Forster, 1772

Баг: Ууль (*Strigiformes*)
Овог: Ууль (*Strigidae*)

НЭРШИЛ:

Англи: Great Grey Owl

Орос: Бородатая неясыть

Хятад: Wu Linxiao

Герман: Bartkauz

Франц: Chouette lapone

Казах: Сақалды жапалақ

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улс болон бүс нутгийн хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” зүйл (*Gombobaatar et al.*, 2011) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Биеийн урт эрийн хувьд 590-680 мм. Эрийн далавчны урт 405-436 мм, эмийнх 436-480 мм. Биеийн жин эрийн хувьд 700-810 г, эмд 950-1,200 г хүрнэ.

Эр, эм бодгалийн зүс ижил. Бие гүйцсэн шувууны нүүр цайвар, олон тооны нарийн хар цагирган судлуудтай. Цээж, хэвлий, хажуу бараан тууш судалтай. Нүд тод шар, хошууны хоёр талд хагас сар хэлбэрийн өргөн тод хөмсөг мэт судал байдгаараа хув уулиас ялгарна. Хумс хар хүрэн. Савар хумсаа хүртэл өд ноолууртай. Залуу шувууны хөл шар, нүд бор шарга.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Канад, АНУ, Норвег, Герман, Швед, Польш, Финланд, Литва, Украин, Беларусь, ОХУ, Казахстан, Хятад, Монголд тархсан. Латвид утсан.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Хөвсгөл, Хэнтийн уулын ойд тархсан.



АМЬДРАХ ОРЧИН

Уулын тайга, ойт хээр, голын хөндийн шилмүүст болон холимог ойг шүтнэ.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Манай орны хувьд суурин, үрждэг зүйл бөгөөд 5-р сараас модны хонгил, өмхөрсөн модны хөндий, заримдаа бусад махчин шувууны үүрэнд үүрлэж, цагаан өнгийн гол төлөв 3-5 өндөг гаргана. Өндөгнөөс 28-30 хоногийн дараа ангаахай гарна. Ангаахай 20-30 хоногийн дараагаас үүрээ орхих боловч 9-р сар хүртэл эцэг, эх шувуу тэдгээрийг тэжээнэ. Тэд шөнө, бүрэнхий цагаар оготно, хулгана, хэрэм зэрэг олон зүйл мэрэгч, заримдаа хөтүү зэрэг шувуугаар хооллоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Дэлхийн популяцийн хэмжээ 50,000-100,000 бие гүйцсэн бодгаль (BirdLife International, 2017) хэмээн үнэлсэн. Манай орны хувьд тоо толгойн үнэлгээ хийгдээгүй.

Энэ зүйлийн тоо толгой буурах гол шалтгаан нь тархац нутгийн хүрээнд ойн хэт ашиглалт, уул уурхай, жуулчны баазын шууд нөлөө, түймэр, орчны бохирдол зэрэг хүний үйл ажиллагаанууд

болно. Амьдрах орчны доройтол, бэлчээр, ойн хортон, мэрэгч устгах зорилгоор хор цацах, өд, хумс, махыг шашны зан үйлд хэрэглэх, чихмэл хийх, худалдах зорилгоор хууль бусаар агнах нь тэдний амьдралд сөргөөр нөлөөлдөг (Gombobaatar *et al.*, 2011).

ХУДАЛДАА

Монгол улсаас гадаадад худалдаалсан тохиолдол байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://checklist.cites.org>) бүртгэсэн.

Угалзан уулийн Монгол орон дахь тархац нутгийн 20.4% нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна (Gombobaatar *et al.*, 2011).

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Угалзан ууль (*Strix nebulosa*) нь 148.0 мян.төг, мөн тус тогтоолын хоёрдугаар хавсралтын “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-ээр зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих тохиолдолд 29.6 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

3.3

МӨЛХӨГЧ

СЭДВИЙН АГУУЛГА

МОНГОЛ УЛСААС КОНВЕНЦ (СІТЕС)-ИЙН ХОЁРДУГААР ХАВСРАЛТАД БҮРТГЭГДСЭН МӨЛХӨГЧ

1. Тэмээн сүүл могой (*Eryx tataricus*)



ТЭМЭЭН СҮҮЛ МОГОЙ

Eryx tataricus Lichtenstein, 1823

Баг: Хайрстан (*Squamata*)

Овог: Аварга могой (*Boidae*)

НЭРШИЛ:

Англи: Tatory sand boa

Орос: Восточный удавчик

Хятад: Sha mang (Dongfang Sha mang)

Герман: Tatarische Sandboa (Grosse Sandboa)

Франц: Boa des sables tartare

Казах: Құм жылан

ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Boa tatarica (Lichtenstein, 1823), *Eryx speciosus* (Carevskij, 1916) (<http://checklist.cites.org>).

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар бүс нутгийн хэмжээнд “Ховордож болзошгүй” зүйл (Terbish *et al.*, 2006) хэмээн үнэлсэн. Олон улсын хэмжээнд үнэлгээ хийгдээгүй.

ТАНИХ ШИНЖ

Их биеийн урт 98 см, сүүлийн урт 6-7 см тус тус хүрнэ. Эрүүн завсрын бамбай хайрснаас хойш ихэвчлэн 2-3, хааяа 4 бамбай хайрс оршино. Нүд нь хажуу тийш юмуу яльгүй дээш чиглэж сөлийсэн.

Нүдний хооронд нэг эгнээнд 7-9 тооны зөв биш олон өнцөгт бамбай хайрстай. Нүдний эргэн тойронд 10-14, ихэвчлэн 11-12 хайрс хүрээлэн оршино. Дээд уруулын хоёр дахь бамбай хайрс, гурав дахиас ихэвчлэн намхан, их биеийн хайрс 43-49, хэвлийн хайрс нарийхан учир их биеийн доод талыг бүрэн эзлээгүй, 169-213 тоотой байна. Их бие нь шаравтар бор өнгөтэй түүн дээр бор хүрэн, хар хүрэн, харавтар өнгийн торолсон толбууд нуруу, биеийн хажуугаар байрлана. Хэвлий нь цайвар өнгөтэй, толбо нь нилээд шигүү.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Иран, Туркменистан, Узбекистан, Афганистан, Тажикстан, Энэтхэгийн баруун хойд, Пакистаны баруун, Казахстаны зүүн, Хятадын хойд ба баруун хойд (Өвөр Монгол, Гансу, Шинжаан), Монголын өмнөт талын нутгаар тус тус тархжээ (Uetz нар, 2006).



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол орны Алтайн өвөр говийн бүс нутагт хамаарах Борзонгийн говь, Зээмэгийн говь, Ногоон цав, Толь булаг, Эхийн гол, Говь-Алтайн Алтай сумын төв орчим, Тахийн шар нурууны баруун хэсэг, Ногоон довонгийн ус зэрэг газарт тохиолдоно (Ананьева нар, 1997; Боркин нар, 1990; Мөнхбаяр, 1976; Тэрбиш, 1989).



АМЬДРАХ ОРЧИН

Элсэн цөлийн амьтан. Заг, зээргэнэ, нохой шээрэн, хармаг, торлог зэрэг мод, сөөг ургамалтай довцог элс, сайр садарга, сухай, зэгс, хулстай баянбүрдэд идээшин амьдрана.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Ихэвчлэн шөнийн амьдралтай. Эхийн голын баянбүрд орчимд өглөө эрт, оройн сэрүүнд үзэгдэнэ (Тэрбиш, 1989). Гүрвэл, мэрэгчдээр

хооллоно. Амьд зулзага төрүүлнэ. 3-р сарын эцэс, 5-р сарын эхээр ороо хөөцөлдөөнд орж, 3-34 хүртэл зулзагыг 7-р сарын эцсээс 8-р сар хүртэл гаргана (Богданов, 1960). Мэрэгч амьтдын нүхэнд орогноно. Хоргүй могой.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Говь, цөлийн заг, сухай зэрэг ургамлыг хэт ашигласны улмаас түүний амьдрах орчин доройтох, махчин шувууд, зараанд бариулах зэргээр хорогддог (Ананьева нар, 1997; Тэрбиш, 1989; Terbish нар, 2006) байна.

ХУДАЛДАА

Энэ талаар мэдээ байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын Улаан ном (1987; 1997; 2013; 2016)-нд оруулсан.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). Тэмээн сүүл могойны тархац нутгийн 33% орчим нь Говийн Их болон Говийн Бага Дархан цаазат газар зэрэг улсын тусгай хамгаалалтай газрын нутагт хамрагдсан (Terbish нар, 2006) байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Тус зүйлийн экологи-эдийн засгийн үнэлгээг хийгээгүй байна.


Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

3.4 ЗАГАС

СЭДВИЙН АГУУЛГА

МОНГОЛ УЛСААС КОНВЕНЦ (CITES)-ИЙН ХОЁРДУГААР ХАВСРАЛТАД БҮРТГЭГДСЭН ЗАГАСНУУД

1. Шивэр хилэм (*Acipenser baeri*)
2. Амар мөрний хилэм (Хар мөрний хилэм) (*Acipenser schrenckii*)



ШИВЭР ХИЛЭМ

Acipenser baeri Brandt, 1869

Баг: Хилэмтэн (*Acipenseriformes*)

Овог: Хилэмийнхэн (*Acipenseridae*)

НЭРШИЛ:

Англи: Siberian Sturgeon

Орос: Сибирский осетр

Хятад: Si Bi liya Xun (Dunwen Xun)

Герман: Sibirischer Stör

Франц: Esturgeon de Sibirie

Казах: Сібір бекіпесі

ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Acipenser stenorrhynchus (Nikol'skii, 1896),
Acipenser baeri chatys (Dryagin, 1948) (<http://checklist.cites.org>).

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Эмзэг” (Sturgeon Specialist Group, 1996), бүс нутгийн хэмжээнд “Устаж байгаа” зүйл (Осоок нар, 2006) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Уртассан ээрүүл хэлбэрийн биетэй. Биеийн урт 2 м хүрнэ. Монголд 1.5 м урт, 36 кг жинтэй хилэм тэмдэглэгдсэн байдаг (Дашдорж, 1976). Нуруу бор саарал, хэвэл цайвардуу шаргал. Биеийн тууш дагуу, нуруу, биеийн хажуу болон хэвлийн хэсгээр үргэлжилсэн нийт 5 эгнээ ясжсан том товхтой. Мөн толгойн хэсэгт ийм товхон хайрс бий. Ам нь хошууны дор хөндлөн байрлах ба түүний

өмнөт хэсэгт хоёр хос сахалтай. Сүүлийн сэлүүр гетероцеркаль.


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Байгаль, Зайсан нуур болон Обь мөрнөөс Колым хүртэл Сибирийн өргөн удам нутгийн гол, усан сангууд, Иртыш, Енисей мөрөнд тархжээ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол орны Сэлэнгэ, Орхон, Туул, Дэлгэр мөрөн, Эг, Хараа зэрэг Хойд мөсөн далайн ай савын голуудад байгалийн шивэр хилэм (*Acipenser baerii baicalensis Nikol'ski, 1896*) хэмээх салбар зүйл идээшин амьдардаг (Дашдорж, 1976; Баасанжав нар, 1983; Maurice Kottelat, 2006; Ососк нар, 2006).



АМЬДРАХ ОРЧИН

Цэнгэг устай усан сангуудын гүнд, ёроолын элс, лаг шавартай газруудад хушуугаа газар шүргүүлэн хэвтэх маягаар хөдөлгөөн багатай амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Өсөлт нь удаан боловч 60 хүртэл жил амьдардаг урт настай загас. Атуу 12-14, атуух 10-12 насандаа тус тус бэлэг боловсорч үржих чадвартай болно. Гэвч энэ зүйл загас жил бүр үржилд ордоггүй. Атуу 5 жил дутамд, атуух 3 жил дутамд тус тус нэг удаа зөвхөн урсгал голуудад түрсээ шахна. Байгаль нуурын саваас Сэлэнгэ мөрнийг өгсөн нүүдэллэсээр манай орны цэнгэг устай голуудад ирж 5-р сарын дундаас 6-р сарын эх хүртэл хугацаанд үржинэ. Бие гүйцсэн нэг атуу, голын ёроолын хайрга, хад чулууны гадарга, завсар зайд 211000-422000 хүртэл тооны түрс гаргана. Түрс нь хар. Их төлөв Байгаль нуурт, хааяа голын гүн цүнхээлд тус тус өвөлждөг. Шумуул, хоовгоны авгалдай, цөөн өргөст хорхой, зөөлөн биетэн, хажуу хөвөгчид зэрэг ёроолын элдэв амьтад, жижиг загас, тэдний түрсээр хооллоно.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Байгаль нуурт хилэм агнуурын нийт хэмжээ 19-р зуунд 2.5-3.0 мянган тонн хүрч байсан бол 20-р зууны дунд үед 200-215 тонн болж буурчээ.

Сэлэнгэ мөрний адаг орчимд амьдрах шивэр хилмийн нийт популяци ойролцоогоор янз бүрийн насны 19000 бодгиалиас бүрдэнэ. Үүнээс Сэлэнгэд нүүдэллэн ирж түрсээ шахдаг атуу дунджаар 100 орчим хэмээн үнэлжээ (Павлов нар, 1994).

Түрсээ олон жил өнжиж шахдаг, үржлийн явц удаан энэ зүйл загасны тоо толгой хууль бус агнуур, хулгайн ан, бие гүйцээгүй үед нь агнасны улмаас эрс хорогдож байна. Хот, суурингийн бохир шингэн, элдэв хог хаягдал, ашигт малмал, ялангуяа алт олборлолтын явцад үүсэж буй органик бус бохирдол, усан сангийн татралт, голдрилын өөрчлөлт зэргийн нөлөөгөөр шивэр хилмийн амьдрах орчин доройтож хомсдох болов.

ХУДАЛДАА

Мэдээ байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Энэ зүйлийг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу 1945 оноос хойш агнахыг хориглож ирсэн. Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), мөн “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус бүртгэсэн байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Шивэр хилэм (*Acipenser baeri*) 700.0 мян.төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



АМАР МӨРНИЙ ХИЛЭМ (ХАР МӨРНИЙ ХИЛЭМ)

Acipenser schrenckii Brandt, 1869

Баг: Хилэмтэн (*Acipenseriformes*)

Овог: Хилэмийнхэн (*Acipenseridae*)

НЭРШИЛ:

Англи: Amur Sturgeon

Орос: Амурский осетр

Хятад: Shi shi Xun

Герман: Amur Stör

Франц: Esturgeon de l'Amour

ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Acipenser multiscutatus (Tanaka, 1908) (<http://checklist.cites.org>).

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор зүйл” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад “Устаж болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Мэдээлэл дутмаг” зүйл (Осоок нар, 2006) хэмээн үнэлсэн.

ТАНИХ ШИНЖ

Уртассан зэрүүл хэлбэрийн биетэй, шөвгөр урт хошуутай. Биеийн урт дунджаар 1,73 м, жин нь 37 хүрнэ (Дулмаа, 2013). Нуруу шаргал, хүрэн бор юмуу бараг хар, хажуугийн товхноос доош хэвэл хэсэг цайвардуу шаргал. Нурууны сэлүүр, сүүлийн далбан нь яг нурууны адил зүстэй. Сүүлийн сэлүүр гетероцеркаль.

ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Амар мөрөн, түүний цутгал голуудаар тархжээ. Ханх нуурт нэг удаа тэмдэглэгдсэн байна.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙШИЛ НУТАГ

Онон голд тархсан. Балжийн голоос тэмдэглэх магадлалтай (Дашдорж, 1976).



АМЬДРАХ ОРЧИН

Урсгал, цэнгэг усны загас. Голын элс, хайрган ёроолтой, дөлгөөн урсгалтай хэсгийг шүтэн амьдарна.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Жилийн турш идэвхтэй. Хоовгон, өдөрч шавж, соно, шумуул, хаварч шавжийн авгалдай, хавч хэлбэртэн, зөөлөн биетэн, усны бясаа, дугариг хорхойгоор хооллоно. Үржлийн үед гол мөрдийн эх өөд нүүдэллэнэ. Атуу 11-14, атуух 8-10 насандаа тус тус бэлэг боловсорч үржих чадвартай болно. Бие гүйцсэн нэг атуу 27640-433940 хүртэл тооны түрс гаргана. Түрс нь хар. Энэ зүйл загасны биологи, экологийн талаар Монголд судалгаа хийгдээгүй.

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Монголд судлагдаагүй. Нийт тархац нутгийн хэмжээнд 2 ба түүнээс дээш насны бодгаль 2000-аас хэтрэхгүй (Кошелов, 2010). Эдгээрийн дотор үржлийн насны атуу тун цөөн. Хууль бус агнуур, хулгайн ан, Амар мөрний усны бохирдол, хайрганы олборлолт зэрэг нь энэ зүйл загасны тоо

толгой цөөрөх үндсэн шалтгаан болно (Крыхтин, 1972).

ХУДАЛДАА

Мэдээ байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Энэ зүйлийг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу 1995 оноос хойш агнахыг хориглож ирсэн. Амьтны тухай хууль (2012)-д нэн ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралт (<http://checklist.cites.org>), мөн “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-ийн хоёрдугаар хавсралтад (<http://www.cms.int/en/species>) тус тус оржээ. Онон голын адаг орчмын нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулаад байна.



ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хар мөрний хилэм (*Acipenser schrenckii*) 1,330.0 мян. төг байдаг.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

3.5

ШАВЖ

СЭДВИЙН АГУУЛГА

МОНГОЛ УЛСААС КОНВЕНЦ (СІТЕС)-ИЙН ХОЁРДУГААР ХАВСРАЛТАД БҮРТГЭГДСЭН ШАВЖ

1. Аполлон (*Parnassius apollo*)



АПОЛЛОН

Parnassius apollo Linnaeus, 1758

Баг: Хайрсан далавчтан (Эрвээхэйтэн) (*Lepidoptera*)

Овог: Дэвүүрлэгтнийхэн (*Papilionidae*)

НЭРШИЛ:

Англи: Apollo or Apollo butterfly

Орос: Аполлон

Казах: Аполлон кобелек

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Ховор зүйл”-ээр оруулсан (Шийрэвдамба нар, 2016). Европын зэрлэг амьтан ба амьдрах орчныг хамгаалах тухай Бернийн конвенцийн хоёрдугаар хавсралт, Европын холбооны зөвлөлийн “Амьдрах орчинг хамгаалах тухай тогтоол”-ын IV хавсралтад тус тус орсон (Гантигмаа, 2014) байна.

ТАНИХ ШИНЖ

Далавчны дэлгэмэл урт 70-94 мм. Цагаан юмуу цайвар шаргал өнгийн далавчтай, түүний оройн хэсэг өнгөгүй тунгалаг. Өмнөд далавч тус бүр таван хар, хойд далавч тус бүр голдоо цагаантай, хар хүрээ бүхий хоёр том улаан толботой. Тэмтрүүл нь хар булцуутай. Их бие нь үсэрхэг (Коршунов, 2002; Намхайдорж нар, 2013).


ДЭЛХИЙД ТАРХСАН БАЙДАЛ

Европын нийт нутаг дэвсгэрт болон Кавказ, Сибирь, Баруун хойд Хятадад тархжээ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ, БАЙРШИЛ НУТАГ

Монгол Алтайн төв хэсэг, Дархадын хотгор, Саяны нуруу, Хөвсгөл нуурын сав, Тарвагатайн нуруу, Төв Хангай, Баруун Хэнтий, Богдхан уул, Онон голын сав, Хэрлэнгийн эхээр тохиолдоно.



АМЬДРАХ ОРЧИН

Уулархаг нутагт ойн цоорхой, зах, наранд эзвэр энгэр газрыг шүтэн амьдарна. Өндөр уулсын бүс нутгийн гол, мөрдийн хөндийн алаг өвст болон уулын тагийн чийглэг нугаар тохиолдоно (Намхайдорж нар, 2013).

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

6-р сарын сүүлчээс 7-р сарын эхний 10 хоног дуустал, ойролцоогоор 2 сарын хугацаанд ниснэ. Хөгжлийн үе шат бүрдээ тодорхой ургамалжилт бүхий ялгаатай амьдрах орчинг шүтэн амьдарна. Тухайлбал, хүрэнцэр нь могойн идээ (*Sedum spp.*) зэрэг идэш тэжээлийн ургамал бүхий орчинд голдуу амьдарч байснаа хүүхэлдэйлэх үедээ хад асга, бут, чулууны зай завсар зэрэг хорогдох боломжтой, аюул осол бага орчинд шилжинэ. Хүүхэлдэй нь хоёр долоо хоногт бойждог. Жилд нэг удаа үржилд орно (Намхайдорж нар, 2013).

ТОО ТОЛГОЙ, ХОМСДОХ ШАЛТГААН

Байршил нутагт мал сүрэг бэлчих, хадлан хадах, олноор цуглуулах зэргээс тоо толгой нь цөөрч,

хорогдох магадлалтай гэж үздэг (Намхайдорж нар, 2013). Дур булаам сайхан өнгөтэй, хүний анхаарал татсан гоё ганган амьтан тул байгальд зугаалж буй амрагчид, хүүхдүүд, жуулчид олноор цуглуулж цөөрүүлэх нөлөө нилээд бий. Гэвч тодорхой мэдээ баримт, нотолгоо байхгүй.

ХУДАЛДАА

Энэ талаар мэдээ байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэлтэй (<http://checklist.cites.org>) амьтан. Тус зүйлийн тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хэсэгчлэгдэн хамрагдсан байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Тус зүйлийн экологи-эдийн засгийн үнэлгээг хийгээгүй байна.

Амьтны тухай хууль (2012) болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.6, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

3.6 УРГАМАЛ

СЭДВИЙН АГУУЛГА

МОНГОЛ УЛСААС КОНВЕНЦ (CITES)-ИЙН ХОЁРДУГААР ХАВСРАЛТАД БҮРТГЭГДСЭН УРГАМЛУУД

1. Цөлийн аргамжинцэцэг (*Cistanche deserticola*)
2. Цоохор саадганцэцэг (*Cypripedium guttatum*)
3. Томцэцэгт саадганцэцэг (*Cypripedium macranthum*)
4. Шар саадганцэцэг (*Cypripedium calceolus*)
5. Булцуут түдэнхавх (*Calypso bulbosa*)
6. Хөхөө цүнхрэг (*Neottianthe cuculata*)
7. Сэрхэн хөхөөцэцэг (*Gymnadenia conopsea*)
8. Гурвалсан шүрэнүндэс (*Corallorhiza trifida*)

ЦӨЛИЙН АРГАМЖИН ЦЭЦЭГ (ЦАГААН ГОЁО)

Cistanche deserticola Ma.

Баг: *Magnoliophytina*

Овог: Гувшаахайтан (*Orobanchaceae* Vent).

НЭРШИЛ:

Англи: Desert cistanche

Орос: Цистанхе пустынний

Хятад: Roucongong

Герман: Wuesten Anschlag

Франц: Désert cistanche

Казах: -



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Монгол оронд *Cistanche* төрлийн 4 зүйл тэмдэглэсэн. *Cistanche lanzhonensis* Zhang., *Cistanche ningxidensis* Ma. нь ховор бөгөөд зөвхөн Дорнод говийн тойрогт тэмдэглэгдсэн, заг болон хармагийн үндэс дээр ургана. Харин *Cistanche salsa* нь говийн бүсэд нэлэнхий тархсан, заг, улаан бударгана, шар мод, дэрс, хармаг зэргийн үндэс дээр ургадаг, биеэр жижиг юм.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор ургамал” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй” зүйл (Нямбаяр нар, 2012) хэмээн үнэлсэн. Олон улсад үнэлгээ хийгдээгүй байна.

ТАНИХ ШИНЖ

Элсэн хөрсөнд ургана. 30-150 см өндөр, махлаг салаалдаггүй, баганархуу бөөрөнхий иштэй ургамал. Голч нь 5-15 см, шар өнгөтэй. Ишний гадаргууд 1.5 см урт, 4-8 мм өргөн олон хайрсан илтэстэй, тэдгээр нь ишний суурьт бөөгнөрсөн, дээшлэхдээ сийрэг.

Ишний үзүүрт хөрснөөс дээш цухуйсан махлаг бүдүүн голтой, түрүү баг цэцэгтэй. Цэцгийн дагавар навч 2.5-3.5 см урт. Цоморлиг хонхорхуу


11-15 мм урт, таван салбанлаг. Дэлбэ хоолойрхуу 30-45 мм урт, бага зэрэг бөхөгөр, шаравтар, цагаан боровтор туяатай, хатахдаа улбар хүрэн болдог, салбангийн үзүүр мохоо дугариг. Дохиурын доод хэсэг, тоосовч нь буржгар урт зөөлөн үсэрхэг, тоосовчийн үзүүр хурц шовгор. Үр боловсрох орон зууван, угтаа шар балавчтай.

ДЭЛХИЙН ТАРХАЦ

БНХАУ-ын Гансу, Шаанши, Чинхай, Шинжан, Ниншиа, Өвөр Монголын хойд, Монголын өмнөд бүс нутгаар тархсан.

МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ

Монгол Алтай, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Дорнод говь, Алтайн цаад говиор тархсан байна.





УРГАХ ОРЧИН

Говь цөлийн элсэнд заг модны үндэс дээр шигдэн ургана.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Хуурай, дулаан уур амьсгалд дасан зохицсон, олон наст, өвслөг, шимэгч мөлжуур (паразит) ургамал. Үндэслэг ишээр түгэн ургах ба үрээр үржих нь харьцангуй удаан.

НӨӨЦ ХОМСДОХ ШАЛТГААН

Байгаль дахь нөөц тун бага. Энэ ургамлыг худалдаа, эмчилгээний зориулалтаар хууль бусаар олборлох нь ховордлын гол шалтгаан болно. Загийг түлшинд хэрэглэх, цөлжилт, бэлчээрийн талхагдал, амьдрах орчны доройтлын улмаас түүний нөөц хомсдож, устгах аюул нүүрлээд байна.

ХУДАЛДАА

БНХАУ-д хууль бусаар худалдаалдаг. Хил, гааль дээр их, бага хэмжээгээр хураагдсан мэдээ баримт бий.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Байгалийн ургамлын тухай хууль

(1995)-ийн 3-р зүйлийн 3 дахь заалтаар байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устгах аюул нүүрлэсэн, тус хуулийн хавсралтаар тогтоосон Нэн ховор ургамлын жагсаалтад орсон ургамал. Энэ зүйлийг Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан байна.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). Түүний тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хэсэгчлэн хамруулаад байна.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Тус зүйлийн экологи-эдийн засгийн үнэлгээг хийгээгүй.

Байгалийн ургамлын тухай хууль (1995), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.8 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.7, 11.21, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ЦООХОР СААДГАНЦЭЦЭГ (ТОЛБОТ СААДГАНЦЭЦЭГ)

Cypripedium guttatum Sw.

Баг: *Magnoliophytina*
Овог: Цэгрэмтэн
(*Orchidaceae* Juss.)

НЭРШИЛ:

Англи: Lady-slipper, Mocassin flower

Орос: Башмачок пятнистый, Венерин башмачок

Хятад: Bauhualulan

Герман: Gesprenkelter Frauenschuh

Франц: Sabot de vénus

Казах: Секпіл шолпанкебіс



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Монгол оронд энэ төрлийн 3 зүйл тэмдэглэсэн. *Cypripedium calceolus*, *Cypripedium macranthum*.



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд үнэлгээ хийгдээгүй байна.



ТАНИХ ШИНЖ

Нарийхан үндэслэг иштэй, 15-25 см өндөр иштэй, түүний доод хэсэгт 5-10 см урт, 3-4 см өргөн, бараг зэрэгцээ хоёр зууван навчтай, навчис хатахдаа хар болдог. Цэцгийн доод навч уртавтар нарийн 1.5-2 см урт. Ишний үзүүрт ганц цэцэгтэй. Шадар эрхтний навчинцар 4, мохоо, 1.5-2 см урт, уруул нь

уутархуу, 2 см урт, цагаан юмуу шаравтар дэвсгэр дээр ягаан өнгийн толботой.





ДЭЛХИЙН ТАРХАЦ

Беларусь, ОХУ (Оросын Европ тивийн хэсэг, Сибирь болон Алс Дорнодын мужууд), БНХАУ (Хэбэй, Хэйлонгжан, Жилин, Лайонин, Өвөр Монгол, Ниншиа, Шаанши, Шандон, Шанси, Сичиуан, Төвд болон Юннан), Солонгос, Бутан, Аляск, Канадын хойд хэсэг (Юкон болон Баруун хойд мужууд)-ээр тархжээ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ

Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол-Дагуур (баруун хойт), Хянганы нуруу (Хан-Чандмань уул)-аар тархсан байна.



УРГАХ ОРЧИН

Шинэс, нарс-хус, хусан ой, ойн нуга.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Ногоон навчтай, олон наст өвслөг ургамал.

НӨӨЦ ХОМСДОХ ШАЛТГААН

Тухайн ургамлын амьдрах орчны доройтол, мод огтлол, эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар түүх, бүс нутгийн худалдаа, ойн түймэр, байгалийн ган гачиг, агаарын хэмийн өөрчлөлт, нөхөн төлжих чадвар муу, тархац нутгийн хязгаарлагдмал байдлаас болоод ховордсон.

ХУДАЛДАА

Тодорхой мэдээ байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3-р зүйлийн 3 дахь заалтаар байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устгах аюул нүүрлэсэн, тус хуулийн хавсралтаар тогтоосон Нэн ховор ургамлын жагсаалтад орсон ургамал.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). Цоохор саадганцэцгийн үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулсан.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Тус зүйлийн экологи-эдийн засгийн үнэлгээг хийгээгүй.

Байгалийн ургамлын тухай хууль (1995), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.8 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.7-7.9, 7.17, 11.21, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ТОМЦЭЦЭГТ СААДГАНЦЭЦЭГ

Cypripedium macranthum Sw.

Баг: *Magnoliophytina*

Овог: Цэгрэмтэн (*Orchidaceae* Juss.)

НЭРШИЛ:

Англи: Grand lady's slipper

Орос: Башмачок крупноцветный

Хятад: Dahualulan

Герман: Großblütiger Frauenschuh

Франц: Sabot de Vénus à grandes fleurs

Казах: Ірі гүлді шолпанкебіс



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Монгол оронд энэ төрлийн 3 зүйл тэмдэглэсэн. *Cypripedium calceolus*, *Cypripedium guttatum*.



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор ургамал” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар бүс нутгийн хэмжээнд “Устаж байгаа” зүйл (Нямбаяр нар, 2012) хэмээн үнэлсэн. Олон улсад үнэлгээ хийгдээгүй байна.



ТАНИХ ШИНЖ

Бүдүүн үсэрхэг үндэслэг иштэй, ишиндээ 3-5 энгийн зууван навчтай, 20-40 см өндөр. Навчис цуваа байрлалтай, ишээ тэвэрсэн, навчны илтэс 8-15 см урт, 5-8 см өргөн, ишний суурьт хайрсан

угларгатай. Ишний үзүүрт гол төлөв нэг, хаяа хоёр том ягаан цэцэгтэй. Уруул нь 4-4.5 см урт, цул улбар ягаан өнгөтэй. Шадар эрхтний навчинцар мөн адил ягаан өнгөтэй 4-5 см урт, нарийн шовх үзүүртэй.



ДЭЛХИЙН ТАРХАЦ

Беларусь, ОХУ (Оросын Европ тивийн хэсэг, Сибирь болон Алс Дорнодын мужууд), БНХАУ (Хэбэй, Хэйлонгжан, Жилин, Лайонин, Өвөр Монгол, Шандон, Тайван) Япон, Солонгост тархжээ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ

Хөвсгөл (баруун тал), Хэнтий, Монгол-Дагуур (баруун тал)-аар тархсан байна.



УРГАХ ОРЧИН

Сийрэг шинэс, шинэс-хус, улиангар-хус, нарс, хусан ой, ойн нуга, ойн зах.

АМЬДРАЛЫН ӨНЦЛОГ

Ногоон навчтай, олон наст өвслөг ургамал.

НӨӨЦ ХОМСДОХ ШАЛТГААН

Тухайн ургамлын амьдрах орчны доройтол, мод огтлол, эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар түүх, бүс нутгийн худалдаа, ойн түймэр, байгалийн ган гачиг, агаарын хэмийн өөрчлөлт, нөхөн төлжих чадвар муу, тархац нутгийн хязгаарлагдмал байдлаас болоод ховордсон.

ХУДАЛДАА

Мэдээлэл байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3-р зүйлийн 3 дахь заалтаар байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюул нүүрлэсэн, тус хуулийн хавсралтаар тогтоосон Нэн ховор ургамлын жагсаалтад орсон ургамал. Энэ зүйлийг Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан байна.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). Томцэцэгт саадганцэцгийн үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулсан.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Тус зүйлийн экологи-эдийн засгийн үнэлгээг хийгээгүй.

Байгалийн ургамлын тухай хууль (1995), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.8 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.7-7.9, 7.17, 11.21, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ШАР СААДГАНЦЭЦЭГ

Cypripedium calceolus L.

Баг: *Magnoliophytina*

Овог: Цэгрэмтэн (*Orchidaceae* Juss.)

НЭРШИЛ:

Англи: Yellow lady's slipper

Орос: Башмачок настоящий

Хятад: Lulan

Герман: Marien-oder Gelber Frauenschuh

Франц: Sabot de Vénus

Казах: Көдімгі шолпанкебіс



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Монгол орноос энэ төрлийн 3 зүйл тэмдэглэсэн. *Cypripedium guttatum*, *Cypripedium macranthum*.



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор ургамал” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” зүйл (Нямбаяр нар, 2012) хэмээн үнэлсэн. Олон улсад үнэлгээ хийгдээгүй байна.



ТАНИХ ШИНЖ

Үерхэг нугачаа, бүдүүн, хөндлөн хар үндэслэг иштэй, ишэндээ 4-5 навчтай, 20-40 см өндөр. Навч зууван, 6-10 см урт, 2-4 см өргөн, шовх үзүүртэй. Ишний үзүүрт 2-3 (хаяа 1) цэцэгтэй. Цэцгийн





ДЭЛХИЙН ТАРХАЦ

Европ тивээс зүүн тийш Ази хүртэл өргөн тархсан. Өөрөөр хэлбэл, Испаниас зүүн тийшээ Номхон далайн эрэг хүртэл Европын бүх улсууд, ОХУ, БНХАУ-ын зүүн хойд хэсэг (Хэйлонгжианг, Жилин, Лайонинг, Өвөр Монгол), Монгол, Солонгос, Японы Ребун арлаар тархжээ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ

Хэнтий, Монгол-Дагуур (Ноён уул, Хараа гол)-аар тархсан байна.



УРГАХ ОРЧИН

Ойн бүсийн гол горхийн эрэг, хусан төгөл, ойн нуга, ойн хаяа.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Ногоон навчтай, олон наст өвслөг ургамал.

НӨӨЦ ХОМСДОХ ШАЛТГААН

Тухайн ургамлын амьдрах орчны доройтол, мод огтлол, эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар түүх, бүс нутгийн худалдаа, ойн түймэр, байгалийн ган гачиг, агаарын хэмийн өөрчлөлт, нөхөн төлжих чадвар муу, тархац нутгийн хязгаарлагдмал байдлаас болоод ховордсон.

ХУДАЛДАА

Мэдээлэл байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3-р зүйлийн 3 дахь заалтаар байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюул нүүрлэсэн, тус хуулийн хавсралтаар тогтоосон Нэн ховор ургамлын жагсаалтад орсон ургамал. Энэ зүйлийг Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан байна.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). Шар саадганцэгцгийн үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулсан.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Тус зүйлийн экологи-эдийн засгийн үнэлгээг хийгээгүй.

Байгалийн ургамлын тухай хууль (1995), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.8 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.7-7.9, 7.17, 11.21, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



БУЛЦУУТ ТҮДЭН ХАВХ

Calypso bulbosa (L.) Reichb.

Баг: *Magnoliophytina*

Овог: Цэгрэмтэн (*Orchidaceae* Juss.)

НЭРШИЛ:

Англи: Calypso

Орос: Калипсо пузырчатая

Хятад: Budailan

Герман: Norne (Orchideen)

Франц: Calypso bulbeux

Казах: -



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Монгол оронд энэ төрлийн 1 зүйл тэмдэглэсэн. Төсөөтэй өөр зүйл бүртгэгдээгүй.



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Монгол улсын Улаан номонд “Нэн ховор ургамал” (Шийрэвдамба нар, 2016), ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар бүс нутгийн хэмжээнд “Устаж байгаа” зүйл (Нямбаяр нар, 2012) хэмээн үнэлсэн. Олон улсад үнэлгээ хийгдээгүй байна.



ТАНИХ ШИНЖ

Өндөгөрхүү, бяцхан цагаан булцуунаас ургасан 8-20 см өндөр иштэй, түүний доод хэсэгт 2-3 хальслаг урт угларгатай. Булцууны доод хэсэгт нарийхан үндэстэй. Булцуунаас шовх үзүүртэй өндөгөрхүү, 2.5-4 см урт илтэстэй, 2-7 см урт

баруултай ганц навч ургана. Ишний үзүүрт ганц том цэцэгтэй. Цэцгийн дагавар навч ланцуйрхуу. Шадар эрхтний навчинцар 1.5-2 см урт. Уруул нь шаравтар, үзүүртээ ягаавтар, 2 см урт.





ДЭЛХИЙН ТАРХАЦ

Дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын сэрүүн бүс нутагт тархжээ. Калифорн, Роки уулсын систем, АНУ-ын хойд хэсгийн ихэнх мужууд, Канадын ихэнх хэсэг, Скандинавийн хойг, Европийн ихэнх хэсэг, ОХУ-ын Азийн хэсэг, Хятад, Монгол, Солонгос болон Японы нутаг дэвсгэрт энэ зүйлийг тэмдэглэсэн байна.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ

Монгол орны зүүн хэсгийн Монгол-Дагуураар тархсан байна.



УРГАХ ОРЧИН

Хөвдөрхөг сүүдэрсэг шилмүүст ой.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Ногоон навчтай, олон наст өвслөг ургамал.

НӨӨЦ ХОМСДОХ ШАЛТГААН

Тухайн ургамлын амьдрах орчны доройтол, мод огтлол, эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар түүх, бүс нутгийн худалдаа, ойн түймэр, байгалийн ган гачиг, агаарын хэмийн өөрчлөлт, нөхөн төлжих чадвар муу, тархац нутгийн хязгаарлагдмал байдлаас болоод ховордсон.

ХУДАЛДАА

Мэдээлэл байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3-р зүйлийн 3 дахь заалтаар байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюул нүүрлэсэн, тус хуулийн хавсралтаар тогтоосон Нэн ховор ургамлын жагсаалтад орсон ургамал. Энэ зүйлийг Монгол улсын Улаан ном (2013; 2016)-нд оруулсан байна.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). Булцуут түдэн хавхын үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулсан.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Тус зүйлийн экологи-эдийн засгийн үнэлгээг хийгээгүй.

Байгалийн ургамлын тухай хууль (1995), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.8 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.7-7.9, 7.17, 11.21, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ХӨХӨӨ ЦҮНХРЭГ

Neottianthe cuculata (L.) Schlechter.

Баг: *Magnoliophytina*

Овог: Цэгрэмтэн (*Orchidaceae* Juss.)

НЭРШИЛ:

Англи: Cucullated neottianthe

Герман: Kapuzenororchis

Орос: Неоттианта клобучковая

Казах: Шоғыр ұяғұл

Хятад: Eryedoubelian



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Монгол оронд энэ төрлийн 1 зүйл тэмдэглэсэн. Төсөөтэй өөр зүйл бүртгэгдээгүй.



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар бүс нутгийн хэмжээнд “Устаж байгаа” зүйл (Нямбаяр нар, 2012) хэмээн үнэлсэн. Олон улсад үнэлгээ хийгдээгүй байна.



ТАНИХ ШИНЖ

Үндсэндээ нэг бөөрөнхий, 10-12 мм бүдүүн булцуутай, 10-20 см өндөр, ишний суурь бараг эсрэг суусан 2-5 см урт, 1-3 см өргөн, зөөлөн хос навчтай, түүнээс дээш урт угларгатай 1-2 бяцхан навчтай. 3-8 см урт цацаг баг цэцэг 1 см голчтой,

суумал 6-20 ягаавтар цэцэг байрлана. Уруул нь 10 мм урт, урагш илүү гарсан гурван гүн салбанлаг, дундах нь илүү урт, өргөн ягаан, дээд гадаргуудаа хөхлүүртэй, түүний доор мөн урагш тахийсан, уруулаас хоёр дахин богино нарийн годойтой. Шадар эрхтний бусад навчинцар хумигдаж дээш шовойсон, 8 мм урт.





ДЭЛХИЙН ТАРХАЦ

Ази, Зүүн Европид тархжээ. Япон болон Сахалинаас Польш хүртэл, Хятад, Сибирь, Украин, Гималайн бүс нутагт тэмдэглэгдсэн.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ

Монгол орны Хэнтий, Хангай, Монгол-Дагуураар тархсан байна.



УРГАХ ОРЧИН

Шинэс-хусан ой, нарсан ой.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Ногоон навчтай, олон наст өвслөг ургамал.

НӨӨЦ ХОМСДОХ ШАЛТГААН

Тухайн ургамлын амьдрах орчны доройтол, мод огтлол, эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар түүх, бүс нутгийн худалдаа, ойн түймэр, байгалийн ган гачиг, агаарын хэмийн өөрчлөлт, нөхөн төлжих чадвар муу, тархац нутгийн хязгаарлагдмал байдлаас болоод ховордсон.

ХУДАЛДАА

Мэдээлэл байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3-р зүйлийн 3 дахь заалтаар байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюул нүүрлэсэн, тус хуулийн хавсралтаар тогтоосон Нэн ховор ургамлын жагсаалтад орсон ургамал.


Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). Хөхөө цүнхрэгийн үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулсан.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Тус зүйлийн экологи-эдийн засгийн үнэлгээг хийгээгүй.

Байгалийн ургамлын тухай хууль (1995), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.8 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.7-7.9, 7.17, 11.21, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ



СЭРХЭН ХӨХӨӨ ЦЭЦЭГ

Gymnadenia conopsea (L.) R. Br.

Баг: *Magnoliophytina*

Овог: Цэгрэмтэн (*Orchidaceae* Juss.)

НЭРШИЛ:

Англи: Fragrant orchid

Орос: Кукушник длиношпорцевый,
Кукушник комарниковый

Хятад: Shouzhangcang

Герман: Mücken-Händelwurz

Франц: Orchis moucheron



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Монгол оронд энэ төрлийн 1 зүйл тэмдэглэсэн. Төсөөтэй өөр зүйл бүртгэгдээгүй.



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар Олон улсад болон бүс нутгийн хэмжээнд үнэлгээ хийгдээгүй байна.



ТАНИХ ШИНЖ

Үндсэндээ салаархаг хоёр булцуутай, 20-40 см өндөр иштэй, ишиндээ 7-20 см урт, 2 см өргөн. 4-7 навчтай. Суумал цэцгүүд нь 5-15 см урт,

өтгөн цацаг баг цэцэг үүсгэнэ. Цэцгийн дагавар навч өвслөг ногоон, нарийхан шувтгар үзүүртэй, үрэвчээсээ урт. Цэцэг нь өтгөн ягаан, эсвэл цайвар ягаан. Шадар эрхтний гадаад навчинцар өндөгөрхүү мохоо, 3-4 мм урт, дотоод нь 5 мм, нарийхан 1.5 см урт, тахир.




ДЭЛХИЙН ТАРХАЦ

Европ, Азийн хойд хэсэг болон Гималайн нурууны хойд хэсгээр тархжээ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ

Монгол орны Хөвсгөл, Хангай, Хэнтий, Монгол-Дагуур, Хянганы уулсаар тархсан байна.



УРГАХ ОРЧИН

Сийрэг шинэсэн ой, хусан ой, ойн цоорхой, ойн нуга, сөөгөн ширэнгэ.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Ногоон навчтай олон наст өвслөг ургамал.

НӨӨЦ ХОМСДОХ ШАЛТГААН

Тухайн ургамлын амьдрах орчны доройтол, мод огтлол, эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар түүх, бүс нутгийн худалдаа, ойн түймэр, байгалийн ган гачиг, агаарын хэмийн өөрчлөлт, нөхөн төлжих чадвар муу, тархац нутгийн хязгаарлагдмал байдлаас болоод ховордсон.

ХУДАЛДАА

Мэдээлэл байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3-р зүйлийн 4 дэх заалтаар байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай, устаж болзошгүй бөгөөд Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Ховор ургамлын жагсаалтад орсон ургамал.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). Сэрхэн хөхөө цэцгийн үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулсан.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Тус зүйлийн экологи-эдийн засгийн үнэлгээг хийгээгүй.

Байгалийн ургамлын тухай хууль (1995), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.8 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.7-7.9, 7.17, 11.21, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ГУРВАЛСАН ШҮРЭНҮНДЭС

Corallorhiza trifida Chatel.

Баг: *Magnoliophytina*

Овог: Цэгрэмтэн (*Orchidaceae* Juss.)

НЭРШИЛ:

Англи: Trifid coralroot

Орос: Ладьян коралловый, Ладьян трехнадрезный

Хятад: Chanhulan

Герман: Korallenwurz

Франц: Racine de corail



ШИНЖЛЭХ УХААНЫ БУСАД ИЖИЛ НЭР

Монгол оронд энэ төрлийн 1 зүйл тэмдэглэсэн. Төсөөтэй өөр зүйл бүртгэгдээгүй.



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

ДБХХ-ны Улаан дансны ангилал, шалгуураар бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” зүйл (Нямбаяр нар, 2012) хэмээн үнэлсэн. Олон улсад үнэлгээ хийгдээгүй байна.



ТАНИХ ШИНЖ

Шүрэрхүү салаалсан үндэслэг иштэй, үндэсгүй, 10-25 см өндөр шаравтар иштэй, түүний доод хэсэгт 2-3 хальсан угларгатай. Ишний үзүүрийн

цацаг баг цэцэгт 3-10 ногоовтор бяцхан цэцэгтэй. Шадар эрхтний навчинцар ланцуйрхуу, 4 мм урт, тэдгээрийн 3 нь босоо, 2 нь доош унжсан, уруул бараг бүтэн зууван 2-3 мм урт.




ДЭЛХИЙН ТАРХАЦ

Хойд Америк, Евроазийн эх газрын Арктикийн бүслүүр дагаж тархсан бөгөөд АНУ, Канад, ОХУ, БНХАУ, Япон, Солонгос, Энэтхэг, Непал, Кашмир, Грийнланд, Пакистан болон Европийн ихэнх улсын нутагт тэмдэглэжээ.



МОНГОЛ ОРОН ДАХЬ ТАРХАЦ

Монгол орны Хөвсгөл, Хэнтийн нуруугаар тархсан.



УРГАХ ОРЧИН

Чийглэг шилмүүст болон холимог ой.

АМЬДРАЛЫН ОНЦЛОГ

Ногоон навчгүй, ялзмагаар хооллох (сапрофит) олон наст өвслөг ургамал.

НӨӨЦ ХОМСДОХ ШАЛТГААН

Тухайн ургамлын амьдрах орчны доройтол, мод огтлол, эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар түүх, бүс нутгийн худалдаа, ойн түймэр, байгалийн ган гачиг, агаарын хэмийн өөрчлөлт, нөхөн төлжих чадвар муу, тархац нутгийн хязгаарлагдмал байдлаас болоод ховордсон.

ХУДАЛДАА

Мэдээлэл байхгүй.

ХАМГААЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3-р зүйлийн 3 дахь заалтаар байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюул нүүрлэсэн, тус хуулийн хавсралтаар тогтоосон Нэн ховор ургамлын жагсаалтад орсон ургамал.

Мөн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэсэн (<http://checklist.cites.org>). Гурвалсан шүрэнүндэс цэцгийн үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулсан.

ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БА ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Тус зүйлийн экологи-эдийн засгийн үнэлгээг хийгээгүй.

Байгалийн ургамлын тухай хууль (1995), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль (2015)-ийн 24.8 дугаар зүйл, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 7.3, 7.7-7.9, 7.17, 11.21, 11.22 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

**ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН
ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ
КОНВЕНЦ (СІТЕС)-ИЙН ХОЛБОГДОЛТОЙ МОНГОЛ УЛСЫН
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖУУД**

КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДЭМЖИХ МОНГОЛ УЛСЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-той холбоотой Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор батлагдан хэрэгжиж буй зарим бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрөөс товчхон дурдвал, УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын баримт бичигт Байгаль орчны бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд (2007-2021 он), нэн ховор, ховор амьтны популяцийн тогтвортой байдал, хэвийн өсөлтийг хангахтай холбогдсон зохион байгуулалтыг шинэчлэн, тэдгээрийг хамгаалах эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлж, зориудын аргаар үржүүлэх, тэдгээрийн удмын санг бий болгож, генийн санг хамгаалахад биотехнологийн ололтыг ашиглаж, биологийн найдвартай нөөцтэй болох арга замыг судлан боловсруулах; ан амьтны нөөц, байршил нутгийг тогтоон хамгаалахад зориулагдсан дотоод, гадаадын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхүйц олон улсын байгууллага, хандивлагч орон, хувь хүний дэмжлэгтэй урт, богино хугацааны төслийг үр ашигтай хэрэгжүүлэхийг дэмжих; ховор, нэн ховор ургамлын тархац нутаг, нөөцийн судалгаа хийх, удмын санг хамгаалах, генийн сан байгуулах, бүртгэл, мэдээлэл-хяналт шинжилгээний тогтолцоо бүрдүүлэх, ашиглалтыг зохицуулан төлөвлөх, сэргээн ургуулах, тарималжуулах ажил зохион байгуулахаар тусгасан байдаг.

Монгол Улсын Засгийн газар 1996 оноос “Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр”-ийг дэмжин хэрэгжүүлсэн бөгөөд түүнээс хойш Монгол орны нийгэм, эдийн засаг, байгаль орчинд гарсан эрс өөрчлөлтүүд болон дээрх хөтөлбөрийн хэрэгжилтийн явцаас үзэхэд биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн хувьд конвенцийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, байгаль орчны талаар боловсруулан гаргасан төрийн бодлого, шийдвэрийн уялдааг хангасан байдлаар шинэчлэн боловсруулах шаардлага бий болсон. Иймээс, Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолоор “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр”-ийг батлав. Тус хөтөлбөрийн

4.4.2 дахь зорилгын 4-т унаган, нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхээр тусгасан байна. Дашрамд дурдахад, биологийн олон янз байдал гэдэг нь дэлхий дээрх амьд бие организмын олон янз байдал тухайлбал, хуурай газар, далай тэнгис, усан орчны экосистем, экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох амьтан, ургамал зэрэг амьд биет болон тэдгээрийн генетикийн олон янз байдлыг багтаасан нийлмэл ойлголт юм.

Монгол Улсын Засгийн газраас Монгол орны ховор ургамлын удмын санг хамгаалах, тэдгээрийн тархац нуггийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах, нөхөн сэргээх, үржүүлэх боломжийг судлах зорилго бүхий “Монгол орны ховор ургамлыг зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг 2002-2010 онд хэрэгжүүлсэн байна. Энэхүү хөтөлбөрийг шинэчлэн “Байгалийн ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Засгийн газар, сайдын тушаалаар өнгөрсөн жилүүдэд ховордсон амьтдыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх зорилготой “Халиун буга хамгаалах үндэсний хөтөлбөр (2000 он)”, “Аргаль хамгаалах үндэсний хөтөлбөр (2002 он)”, “Баданга хүдэр хамгаалах үндэсний хөтөлбөр (2009 он)”, “Мазаалай хамгаалах үндэсний хөтөлбөр (2013-2018 он)” зэргийг боловсруулан хэрэгжүүлснээс гадна, Байгаль орчны сайд (хуучин нэрээр)-ын 2005 оны 195 дугаар тушаалаар “Цоохор ирвэс үндэсний хөтөлбөр (2005-2010 он)”, Засгийн газрын 2003 оны 121 дүгээр тогтоолоор “Монгол орны идлэг шонхорыг хамгаалах үндэсний хөтөлбөр (2003-2010 он)”-ийг тус тус хэрэгжүүлж, тэдгээр хөтөлбөрүүд нь 2010 онд дууссантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар 2011 оны 277 дугаар тогтоолоор “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан билээ.

Тус хөтөлбөрийн зорилго нь экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, тогтвортой хөгжлийн шаардлагад нийцүүлэн нэн ховор, ховор амьтдын тоо толгой цөөрөх, амьдрах орчин доройтохоос сэргийлж, байгалийн жамаар хэвийн өсөж

үржих нөхцөлийг нь хангах, зориудаар үржүүлж, цөм сүргийг хамгаалах замаар тэдгээрийн тоо толгой, тархац нутгийг нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх явдал бөгөөд хөтөлбөрийг 2011-2021 оны хооронд үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Энэхүү хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд 5 үндсэн зорилгыг дэвшүүлжээ. Тухайлбал, нэн ховор, ховор амьтдын тоо толгой цөөрөх, амьдрах орчин доройтохоос сэргийлэх, тэдгээрийн хэвийн өсөлтийг хангахтай холбогдсон эрх зүй, эдийн засгийн тогтолцоог боловсронгуй болгож, олон улсын түвшинд хүргэх; нэн ховор, ховор амьтдын талаарх иж бүрэн судалгаа шинжилгээний ажлыг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эрчимжүүлж, шинжлэх ухааны дэвшилтэт ололт, технологийг нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, устаж болзошгүй амьтдын талаарх мэдлэг хүмүүжлийг иргэдэд олгох сургалт сурталчилгааг тогтмолжуулахаар тусгасан байна.

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн хэрэгжилтийг дэмжих зарим хууль тогтоомжийн холбогдох зүйл, заалтуудаас товчхон дурдвал, Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд “Монгол улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтанд байна. Монгол улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” хэмээн хуульчилсан байдаг.

УИХ-аас 1995 оны 5-р сарын 4-ний өдөр “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-д нэгдэн орох тухай 24 дүгээр тогтоол гарч, улмаар тус конвенцийг хэрэгжүүлэх хүрээнд 2002 оны 11-р сарын 7-ны өдөр “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль”-ийг баталсан байна. Энэ хууль нь Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийг хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалах зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилготой.

УИХ-ын 1995 оны 3-р сарын 30-ны өдөр баталсан “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах

эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг. Энэхүү хуульд 1998, 2002, 2005, хамгийн сүүлд 2017 оны 12-р сарын 7-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Монгол Улсын Засгийн газар улс орныхоо нийгэм, эдийн засгийн харилцаанд гарч буй өөрчлөлт шинэчлэлтэд нийцүүлэн, эдийн засгийн үр ашигтай, байгаль орчинд сөрөг нөлөө багатай тогтвортой хөгжлийг хангах зорилгоор эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгохоор байгаль орчны багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох чиглэлийг баримтлан ажиллаж, 2012 онд УИХ-аар Байгаль орчны багц хуулиудыг батлуулсан билээ. Ингэснээр, “Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн эрх зүйн орчинд ч мөн өөрчлөлт орсон юм. Тухайлбал, УИХ-аас 2012 оны 5-р сарын 17-ны өдөр “Амьтны тухай хууль”-ийг батлан гаргаснаар Амьтны аймгийн тухай болон Ан агнуурын тухай хуулиуд хүчингүй болсон байдаг. “Амьтны тухай хууль” нь амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.

УИХ-ын 1995 оны 4-р сарын 11-ний өдөр баталсан “Байгалийн ургамлын тухай хууль” нь ой болон таримал ургамлаас бусад ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Тус хуульд 1997, 2002, 2010, 2015 онд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

УИХ-ын 2012 оны 5-р сарын 17-ны өдөр баталсан “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль” нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулдаг. Энэхүү хуулийг УИХ-ын 1995 оны 5-р сарын 22-ны өдөр баталсан Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих

зөвшөөрлийн хураамжийн тухай, Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчин хамгаалах, байгалийн нөөцийн нөхөн сэргээлтийн арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээний тухай, Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлггэж ашигласны төлбөрийн тухай зэрэг байгалийн нөөц ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг тус тусад нь зохицуулж байсан хуулиудыг нэгтгэн шинэчлэн найруулсан байна.

УИХ-ын 2002 оны 11-р сарын 28-ны өдөр баталж, 2007, 2010, 2011, 2012, 2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль” нь амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

УИХ-ын 1994 оны 11-р сарын 15-ны өдөр баталж, 1997, 2002, хамгийн сүүлд 2017 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль” нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.

УИХ-ын 2008 оны 5-р сарын 20-ны өдөр шинэчлэн найруулж баталсан “Гаалийн тухай хууль” нь Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэнээс гомдол гаргах, түүнийг гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Тус хуульд 2010, 2012, 2015, 2016, 2017 онд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

УИХ-ын 2016 оны 12-р сарын 28-ны өдөр шинэчлэн найруулж баталсан “Монгол Улсын Хилийн тухай хууль”-ийн 17 дугаар зүйлд зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал,

тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх зорилгоор хилийн боомтод улсын хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналтын байгууллага, виз бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор гадаадын иргэн, харьяатын байгууллага ажиллана, 21 дүгээр зүйлд хүн, мал, амьтан, ургамлын халдварт өвчин Монгол Улсын болон хил залгаа улсын нутагт тархах аюулыг хязгаарлах зорилгоор өвчин гарсан голомтын хэсэгт улсын хил дээр зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр зогсоох, хязгаарлах, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох асуудлыг Засгийн газар шийдвэрлэхээр тусгасан байдаг.

УИХ-ын 2002 оны 5-р сарын 30-ны өдөр баталж, 2005, 2009, 2010, 2012, 2013, 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан “Зар сурталчилгааны туухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-д нэн ховор, ховор ургамал, амьтны жагсаалтад орсон болон тэдгээрийн үндэс, иш, мөчир, навч, бугын цусан эвэр, чив, засаа, согооны сүүл, сав, хүдрийн заар, баавгайн доньд зэрэг эрхтнийг бэлтгэх, худалдах, худалдан авах тухай зар сурталчилгааг хориглож, 14.2-т хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу тодорхой хугацаанд агнах, бэлтгэхийг хориглосон амьтан, ургамлын эд эрхтэн, түүхий эдийг худалдах, худалдан авах тухай зар сурталчилгаа явуулахыг хориглосон байдаг.

УИХ-ын 2017 оны 5-р сарын 11-ний өдөр шинэчлэн найруулж баталсан “Зөрчлийн тухай хууль”-ийн Долдугаар бүлгийн Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчлийн 7.3 дугаар зүйлд ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих, 7.6 дугаар зүйлд амьтны тухай хууль зөрчих, 7.7 дугаар зүйлд байгалийн ургамлын тухай хууль зөрчих, 7.8 дугаар зүйлд ургамал хамгааллын тухай хууль зөрчих, 7.17 дугаар зүйлд тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах зэрэгт хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгасан байна.

УИХ-ын 2015 оны 12-р сарын 03-ны өдөр шинэчлэн найруулж баталсан “Эрүүгийн хууль”-ийн Хорин дөрөвдүгээр бүлгийн Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн 24.5 дугаар зүйлд хууль бусаар ан агнах, 24.8 дугаар зүйлд байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх, 24.9 дүгээр зүйлд байгалийн тэнцэл алдагдуулах зэрэг тохиолдолд

хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгажээ.

“Амьтны тухай хууль (2012)”-ийн 7.1 дэх нэн ховор амьтны жагсаалтад орсон 31 зүйл амьтнаас 14 зүйл, Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан 36 зүйл ховор амьтнаас 12 зүйл, “Байгалийн ургамлын тухай хууль (1995)”-ийн хавсралт дахь нэн ховор ургамлын жагсаалтад орсон 133 зүйлээс 8 нь энэхүү конвенцийн нэг, хоёрдугаар хавсралтад бүртгэгдсэн зүйлүүд байна. Ингэснээр тэдгээр зүйлийн олон улсын худалдааг манай улсын хэмжээнд хянах нөхцөл бүрдсэн байна.

“Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралгай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)”-ийн дагуу конвенц (CITES)-ийн хавсралтад бүртгэгдсэн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох зөвшөөрөл, реэкспортлох, далай тэнгисээс олборлон оруулах гэрчилгээ авах хүсэлтээ Удирдан зохицуулах зөвлөлд гаргаж, Удирдан зохицуулах зөвлөл уг хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан зөвшөөрөл, гэрчилгээний загварын дагуу зөвшөөрөл, гэрчилгээг олгодог.

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн Үндэсний анхдугаар тайлан (2014)-д дурдсанаар, Конвенцийн Удирдан зохицуулах зөвлөлөөс конвенцид нэгдэн орсноос өнөөг хүртэл олгосон 800 гаруй экспорт, реэкспортын зөвшөөрлийн гэрчилгээгээр 85 зүйлийн амьтан, ургамлын гаралтай 189 төрлийн 15 мянга гаруй эд зүйл манай улсын хилээр 146 орон руу гарсан байгаагаас, 17 зүйл нь нэгдүгээр хавсралт, 61 зүйл нь хоёрдугаар хавсралт, 6 зүйл нь гуравдугаар хавсралтад бүртгэгдсэн ургамал,

амьтан байна. Тэдгээр эд зүйлээс судалгаа, шинжилгээний зорилгоор нийт 44 зүйлийн амьтан, түүний дотор 13 зүйл хөхтөн, 31 зүйл шувууны 5,800 гаруй эд эрхтний дээжийг 155 гэрчилгээгээр гадаадад гаргасан байна. Үүний дотор хулангийн 603, ирвэсний 342, мазаалайн 392, нөмрөг тасын 96, цармын бүргэдийн 517, чонын 357, идлэг шонхорын 682, мануулын 457, хонин тоодгийн 1911, аргалийн 574, хүрэн баавгайн 146 эд, эрхтний дээжийг гадаадад судалгаанд явуулжээ. Конвенц (CITES)-ийн нэгдүгээр хавсралтад орсон амьтдын дотор хулан адуу, мазаалай баавгайн гаралтай эд зүйлийн экспортын хэмжээ хамгийн их хувийг эзэлж байна. Конвенц (CITES)-ийн хоёрдугаар хавсралтад бүртгэлтэй амьтаас идлэг шонхор, саарал чоно, аргаль хонины гаралтай эд зүйлийг хамгийн олон тоогоор экспортолсон байна. Эдгээр экспорт, реэкспортын дүнгээс үзэхэд, агнуурын олз 331, хувийн эд зүйл 135, судалгаа шинжилгээний зорилгоор 139 экспортын гэрчилгээ олгосон байна. Худалдааны зорилгоор идлэг шонхор (2983 амьд бодгаль), чоно (1023 гаруй арьс)-ын эд зүйл хамгийн их хил давсан байна. Агнуурын зориулалтаар 31 зүйл ан амьтан, түүний дотор шилүүс, мануул, нөмрөг тас, талын бүргэд зэргийг экспортлосноос саарал чоно, аргаль хонь хамгийн олон тоотой байсан (Мягмарсүрэн нар, 2014) байна.

Энэхүү бүлгээс Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн хэрэгжилтийг дэмжих Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн холбогдох зүйл, заалтууд, Засгийн газрын тогтоол, Монгол Улсын Байгаль орчин, аялал жуучлалын сайдын тушаал, журам зэргийг харах боломжтой. Мөн тус бүлэгт дурдагдсан болон дурдагдаагүй бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг <http://www.legalinfo.mn> сайтаас дэлгэрүүлэн үзнэ үү.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ



АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬ (Шинэчилсэн найруулга)

2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

(Хэсэгчлэн авав)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Амьтны тухай хууль тогтоомж

2.1. Амьтны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулиар мал, гэрийн тэжээвэр амьтнаас бусад амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “амьтан” гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтад заасныг;

4.1.2. “тархац нутаг” гэж тухайн амьтны нутагладаг, нүүдэллэдэг, тэдгээрийн амьдрах тохиромжтой нөхцөл бүрдсэн газар нутгийг;

4.1.3. «нэн ховор амьтан» гэж тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой

эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг;

4.1.4. «ховор амьтан» гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг;

4.1.5. “биотехникийн арга хэмжээ” гэж амьтны амьдрах болон идэш тэжээлийн нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг;

4.1.6. “сэргээн нутагшуулах” гэж хамгаалах, өсгөн үржүүлэх зорилгоор устах аюулд орсон, ховордсон амьтны зүйлийг урьд амьдарч байсан нутагт нь зориудаар зөөвөрлөн нутагшуулах үйл ажиллагааг;

4.1.7. “агнуурын амьтан” гэж арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг;

4.1.8. “агнуурын нөөц” гэж хэвийн өсөлт, үржилтийг нь алдагдуулахгүй агнах, барих боломжтой агнуурын амьтны тоо, хэмжээг;

4.1.9. “агнуурын бүс нутаг” гэж агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах зориулалт бүхий амьтны байршил, тархац нутгийг;

4.1.10. “агнуурын амьтны сүргийн бүтэц” гэж сүрэг дэх амьтдын нас, хүйсийн харьцааг;

4.1.11. “ан агнуурын менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичгийг;

4.1.12. “амьтны нөөцийг хамгаалах”

гэж амьтны сүргийн бүтцийн төлөв байдлыг доройтохоос урьдчилан сэргийлэх, тэдгээрийн жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр амьтны нөөцийг зүй зохистой ашиглах, гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, амьтны идэш тэжээлийн төлөө тэмцэл, хорогдлын шалтгааныг олж тодорхойлох, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, сэргээн нутагшуулах, өсгөн үржүүлэх, тэдгээрт хяналт тавих цогц үйл ажиллагааг; *(Энэ заалтад 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)*

4.1.13. “амьтныг өсгөн үржүүлэх” гэж амьтныг зохих журмын дагуу эзэмшилдээ авч, батлагдсан технологи, норм, нормативын дагуу тэжээврээр үржүүлэх замаар үр төлийг бойжуулан өсгөхийг;

4.1.14. “ангийн буу” гэж хийц, үзэмж, загвараараа байлдааны зэвсгээс ялгаатай, замагтай бууны хүхээнд нэг, дайзанд дөрвөөс илүүгүй, өөрөө цэнэглэгдэгч /хагас автомат/ бууны хүхээнд нэг, дайзанд таваас илүүгүй сумны багтаамжтай галт зэвсгийг;

4.1.15. “спорт агнуур” гэж анчин ан агнах, барих хэрэгцээгээ хангах зорилгоор ан амьтны эд, эрхтэнийг үзүүлэлтийн хувьд сонголт болгогүй агнах, барихыг;

4.1.16. “олзворын ан” гэж амьтны илүү үзүүлэлт бүхий эд, эрхтэнийг авах зорилгоор тусгай төлбөр төлж агнах, барихыг;

4.1.17. “агнах, барихыг түр хориглосон ан амьтан” гэж хуулиар агнах, барихыг хориглоогүй ч тархац, нөөц, хэвийн өсөж үржих, амьдрах орчин нөхцөл нь хомсдсон, муудсан, доройтсоны улмаас энэ хуулийн 5.2, 5.3-т заасан эрх бүхий байгууллагаас агнах, барихыг нь тодорхой хугацаагаар хориглосон амьтныг;

4.1.18. “харь амьтан” гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа амьтны зүйлийг;

4.1.19. “анчин” гэж аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон анчны үнэмлэхтэй иргэнийг;

4.1.20. “ангийн гаралтай түүхий эд” гэж амьтны арьс, шир, үс, өд, эвэр, толгой, цус, өөх, тос зэрэг эд эрхтэнийг;

4.1.21. “ан агнуур” гэж ангийн гаралтай түүхий эдийг ашиглах зорилгоор хуулиар заасан хугацаа, арга, хэрэгсэл, зөвшөөрлийн дагуу агнуурын амьтныг агнах, барих үйл ажиллагааг;

4.1.22. “агнуурын зохион байгуулалт” гэж агнуурын амьтны тархац, байршил, нөөц, төрөл, зүйл, тоо толгой, сүргийн бүтэц, өөрчлөлтийг

судлан тогтоож, агнуурын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлох үйл ажиллагааг;

4.1.23. “ангийн аж ахуй” гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 30.3-т заасны дагуу агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах үйл ажиллагааг ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу эрхэлдэг мэргэжлийн байгууллагыг;

4.1.24. “амьтны жам ёсны эрх” гэж амьтад идэш тэжээлээ олох, амьдрах идээшил, тархац нутгаа сонгох, үржил хөөцөнд орж, үр төлөө үлдээх, бүл сүрэгтэй дасан ижилсэх, айдас цочрол, хомроглон устгагдахаас ангид байхыг;

4.1.25. “амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж тухайн зүйл амьтны амьдрах орчин болон экологийн, эдийн засгийн, эрх зүйн, нийгмийн ач холбогдлоор нь үнэлсэн тусгай аргачлалын дагуу тооцсон амьтны мөнгөн үнэлгээг.

5 дугаар зүйл. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар төрийн болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

5.1. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. амьтныг хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

5.1.2. агнуурын нөөц ашигласны төлбөрийн дээд, доод хувь, хэмжээг тогтоох;

5.1.3. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

5.2. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.2.1. амьтныг хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

5.2.2. агнуурын нөөцийг ашиглах, импортлох, экспортлох хэмжээг хуульд заасан үндэслэлээр хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох;

5.2.3. амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгах;

5.2.4. энэ хуулийн 23.2-т заасан байгууллагын ажиллах журмыг батлах;

5.2.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

5.3. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.3.1. амьтныг хамгаалах, нутагшуулах,

өсгөн үржүүлэх, зохистой ашиглах ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлага зохицуулалт, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;

5.3.2. агнуурын нөөц бүхий аймаг болон ангийн аж ахуйн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

5.3.3. амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг боловсруулж, Засгийн газраар батлуулах;

5.3.4. сүргийн бүтцийн төлөв байдал, тархац, нөөцийг харгалзан тухайн агнуурын бүс нутагт ан хийх, эсхүл зарим зүйл агнуурын амьтныг агнах, барихыг тодорхой хугацаагаар хориглох;

5.3.5. агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх талаар технологи, норм, нормативыг батлах;

5.3.6. амьтны нөөцийн өөрчлөлтөд хяналт-

шинжилгээ хийх, ан, амьтны мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллээр хангах;

5.3.7. амьтан хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн менежментийн төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, тэдгээрийг боловсруулах заавар батлах;

5.3.8. амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах;

5.3.9. эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор энэ хуулийн 9.1,9.2, 9.4-9.7-д заасан хугацааг харгалзахгүйгээр амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох.

ХОЁРДУГААР БҮЛЭГ АМЬТАН ХАМГААЛАХ

6 дугаар зүйл. Амьтныг хамгаалах хэлбэр

6.1. Амьтныг дор дурдсан хэлбэрээр хамгаална:

6.1.1. амьтныг ашиглахад хорио, хязгаарлалт тогтоох;

6.1.2. нэн ховор, ховор амьтныг олон улсын болон Монгол Улсын “Улаан ном”, бусад холбогдох гэрээ, конвенцийн хавсралтад бүртгэх;

6.1.3. амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах;

6.1.4. амьтны удмын санг хамгаалах, үр хөврөлийг хадгалах;

6.1.5. амьтны нөөц тогтоож, ашиглалтыг зохицуулах;

6.1.6. амьтныг сэргээн нутагшуулах;

6.1.7. үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх;

6.1.8. биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

6.1.9. өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах; (Энэ заалтад 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

6.1.10. амьтныг хамгаалах арга хэмжээний үндэслэлийг гаргахад чиглэсэн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх;

6.1.11. иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтныг хамгаалах үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах.

6.2. Энэ хуулийн 6.1.1-6.1.6, 6.1.10, 6.1.11-д заасан үйл ажиллагааг төрийн захиргааны

төв байгууллага, 6.1.4, 6.1.6-6.1.9-д заасан үйл ажиллагааг байгаль орчны мэргэжлийн байгууллага, 6.1.7-6.1.9-д заасан үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд тус тус хэрэгжүүлнэ.

7 дугаар зүйл. Нэн ховор, ховор амьтныг хамгаалах

7.1. Нэн ховор амьтанд Мазаалай баавгай (*Ursus arctos gobiensis*), Хавтгай тэмээ (*Camelus bactrianus ferus*), Тахь адуу (*Equus ferus przewalskii*), Ойн буган цаа (*Rangifer tarandus*), Цоохор ирвэс (*Uncia uncia*), Баданга хүдэр (*Moschus moschiferus*), Молцог хандгай (*Alces alces*), Татаар бөхөн (*Saiga tatarica*), Голын халиу (*Lutra lutra*), Азийн минж (*Castor fiber*), Ойн унтаахай (*Dryomys nitedula*), Зүүн гарын даахай (*Stylodipus sungorus*), Борцгор хотон (*Pelicanus crispus*), Хургач бор (*Paradoxornis heudei*), Цагаан тогоруу (*Grus leucogeranus*), Хар мөрний хилим (*Acipenser schrenckii*), Шаргал үхэрдэй (*Tinca tinca*), Цөөвөр чоно (*Cuon alpinus*), Шивэр молцог хандгай (*Alces alces pfizenmayeri*), Дорнын молцог хандгай (*Alces alces camelooides*), Соргог бөхөн (*Saiga tatarica*), Монгол бөхөн (*Saiga borealis*), Алтайн чацуулин (*Talpa altaica*), Гозоорой зурам (*Citellus alaschanicus*), Сухайн чичүүл (*Meriones tamariscinus*), Давжаа алагдаага (*Allactaga elater*), Цагаантолгойт ямаансүүл (*Oxyura leucocephala*), Могойч загалай (*Circaetus gallicus*), Бор бүргэд (*Aquila clanga*), Усны нөмрөгбүргэд (*Aquila clanga*), Реликт цахлай (*Larus relictus*) зэрэг амьтан хамаарна.

7.2. Нэн ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар

агнаж, барьж болно.

7.3. Энэ хуулийн 7.2-т зааснаас бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглоно.

7.4. Нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

7.5. Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлөөр ховор амьтныг дараах тохиолдолд агнаж, барьж болно:

7.5.1. судалгаа, шинжилгээ, соёл, урлаг,

эмчилгээний зориулалтаар;

7.5.2. Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлсөн;

4.4. Энэ хуулийн 4.3-т заасан мэдээлэлд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, байршил, ашиглах хугацаа, хэмжээ, тоног төхөөрөмжийн хүчин чадал зэрэг шаардлагатай үзүүлэлтийг тусгана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨЛБӨР НОГДОХ ЗҮЙЛ, ҮНЭЛГЭЭГ ТОГТООХ

5 дугаар зүйл. Ургамал ашигласны төлбөр ногдох зүйл

5.1. Дараах ангиллын ургамалд төлбөр ногдуулна:

5.1.1. нэн ховор ургамал;

5.1.2. ховор ургамал;

5.1.3. элбэг ургамал.

7 дугаар зүйл. Ойн нөөц ашигласны төлбөр ногдох зүйл

7.1. Аливаа зориулалтаар ойгоос бэлтгэж ашигласан бүх төрлийн хэрэглээний мод, түлээнд төлбөр ногдуулна.

7.2. Ойн дагалт баялгийн нөөц самар, мөөг,

давирхай, шилмүүс, мөчир, үр, хусны шүүсэнд төлбөр ногдуулна.

8 дугаар зүйл. Ан амьтны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл

8.1. Төлбөр ногдох зүйл нь дор дурдсан зориулалтаар ашигласан ан амьтан байна:

8.1.1. ахуйн зориулалтаар агнасан, барьсан;

8.1.2. үйлдвэрлэлийн зориулалтаар агнасан, барьсан;

8.1.3. тусгай зориулалтаар агнасан, барьсан /соёл, шинжлэх ухаан, тусгай төлбөртэй/.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨЛБӨР ТООЦОХ ҮЗҮҮЛЭЛТ, ТЭДГЭЭРИЙГ ТОДОРХОЙЛОХ

9 дүгээр зүйл. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт

9.1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлтийг ургамлын тухайн үеийн жинг килограммаар илэрхийлсэн нэгж дэх тухайн зүйл ургамлын тоо, хэмжээг тооцоолсон экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар тооцно.

11 дүгээр зүйл. Ойн нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт

11.1. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг дор дурдсан үзүүлэлтээр тооцно:

11.1.1. ургаа мод огтолж, түүний үндсэн хэсгээс бэлтгэсэн хэрэглээний мод, түлээг нягт шоо метрээр, үзүүр, мөчрийг сийрэг шоо метрээр;

11.1.2. ойгоос хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүүг цэвэрлэж түлээ бэлтгэхэд сийрэг шоо метрээр.

11.2. Ойн дагалт баялгийн нөөцийг бэлтгэхэд хусны шүүсийг литрээр, бусад ойн дагалт баялгийн нөөцийг килограммаар тооцно.

12 дугаар зүйл. Ан амьтны нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт

12.1. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийг дараах үзүүлэлтээр тооцно:

12.1.1. үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийг килограммаар;

12.1.2. ахуйн зориулалтаар шувуу агнах,

загас барих иргэнээс төлбөрийг агнасан, барьсан шувуу, загасны ширхгээр;

12.1.3. ахуйн зориулалтаар агнах бусад ан амьтны төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээгээр;

12.1.4. ан амьтныг амьдаар нь барьж эзэмшин, гаршуулан үржүүлж, эмийн болон бусад түүхий эд бэлтгэж ашигласны төлбөрийг борлуулалтын орлогоор;

12.1.5. ан амьтныг амьдаар нь төрөөс худалдан авч өмчилсний төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээгээр;

12.1.6. гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь аливаа зориулалтаар гаргасан ан амьтны төлбөрийг тухайн ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнээр.

13 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэг, түүний төрөл

13.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт /цаашид “төлбөрийн орлогын хэсэг” гэх/ төсвийн жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө багтана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨЛБӨРИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ

14 дүгээр зүйл. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

14.1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээний дор дурдсан хувиар тооцон төгрөгөөр тогтооно:

Төлбөр ногдох байгалийн ургамал	Төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээний хувь	
	Доод	Дээд
1.Нэн ховор	25	30
2.Ховор	15	20
3.Элбэг	5	10

14.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 14.1-д заасан төлбөрийн хэмжээний хязгаарт багтаан ургамлын нөөц, тархац, ач холбогдол, ашиглагдах эрхтний онцлог, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан ургамлын нэр төрөл тус бүрээр төлбөрийн хэмжээг тогтооно.

17 дугаар зүйл. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

17.1. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн доод, дээд хязгаарыг дараах байдлаар тогтооно:

17.1.1. үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийг килограмм тутамд 700-1000 төгрөгөөр;

17.1.2. ахуйн, үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнасан бусад ан амьтны төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын

экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар;

17.1.3. ан амьтныг амьдаар барьж эзэмшин, гаршуулан үржүүлж эмийн болон бусад түүхий эд бэлтгэж ашигласны төлбөрийг уг түүхий эдийн борлуулалтын орлогын 10-20 хувиар;

17.1.4. ан амьтныг амьдаар нь төрөөс худалдан авч өмчилсний төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи эдийн засгийн үнэлгээний 90-100 хувиар;

17.1.5. гадаадын иргэнд агнуулсан ан амьтны нөөцийн төлбөрийг тухайн ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 80-90 хувиар;

17.1.6. амьдаар нь гадаад оронд гаргасан ан амьтны төлбөрийг гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 80-90 хувиар.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨЛБӨРӨӨС ЧӨЛӨӨЛӨХ, ХӨНГӨЛӨХ

19 дүгээр зүйл. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

19.1. Дараах зориулалт, хэрэгцээгээр байгалийн ургамлын нөөц ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө:

19.1.1. элбэг ургамлыг ахуйн хэрэгцээнд ашигласан иргэн;

19.1.2. ховор болон элбэг ургамлыг судалгаа шинжилгээний зориулалтаар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;

19.1.3. тариалангийн бүс нутгаас бусад нутагт байгалийн ургамлыг хадлан бэлчээрийн зориулалтаар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага. */Энэ заалтад 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

19.1.4. тариалангийн бүс нутагт байгалийн ургамлыг эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага. */Энэ заалтыг 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн/*

19.2. Элбэг ургамал ашигласны төлбөрийг хөнгөлж болох бөгөөд төлбөрийг хөнгөлөх нөхцөл, болзол, хувь, хэмжээг тухайн орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

22 дугаар зүйл. Ан амьтны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

22.1. Төлбөрөөс дараах тохиолдолд чөлөөлнө:

22.1.1. ан амьтныг нутагшуулан үржүүлэх зориулалтаар барих;

22.1.2. халдварт өвчний голомтыг устгах зорилгоор эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр ан амьтныг мэргэжлийн байгууллагаас зохион байгуулалттай агнаж устгах;

22.1.3. мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнах;

22.1.4. сорьц, дээж авах, хэмжилт хийх, им тэмдэг тавих, бөгжлөх, судалгааны хэрэгсэл зүүх зорилгоор ан амьтныг эрдэм шинжилгээний зориулалтаар түр барих.

22.2. Тодорхой нутаг дэвсгэрт ан амьтны тоог сийрэгжүүлэх, хүйсийн харьцааг зохицуулах, заазлах зорилгоор болон соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнахад төлбөрийг 80 хувь хүртэл хөнгөлж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТӨЛБӨР НОГДУУЛАХ, ТӨЛӨХ, ТАЙЛАГНАХ

23 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөх

23.1. Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна.

23.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ.

23.3. Сум, дүүргийн Засаг даргын томилсон төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан төлбөрийг бэлнээр хураан авсан тухай бүр сум, дүүргийн төсөвт тушаана.

24 дүгээр зүйл. Төлбөрийн жилийн тайлан гаргах

24.1. Төлбөрийн жилийн тайланг дор дурдсан хугацаанд гаргана:

24.1.1. ургамал, ус, ой, ан амьтны нөөц ашигласны төлбөр хураан авах эрх бүхий албан тушаалтан төлбөрийн тайлангаа дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор сум, дүүргийн татварын албанд;

24.1.2. сум, дүүргийн татварын алба тайлангаа дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн татварын албанд;

24.1.3. аймаг, нийслэлийн татварын алба тайлангаа дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад;

24.1.4. татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төлбөр, улсын нэгдсэн тайлангаа дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

24.2. Төлбөрийн тайлангийн маягтын загварыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

25 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

25.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

25.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. /Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/





ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ (Шинэчилсэн найруулга)

2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

(Хэсэгчлэн авав)

I ХЭСЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэнээс гомдол гаргах, түүнийг гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. *(Энэ хэсгийг 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)*

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “бараа” гэж гаалийн хилээр нэвтрүүлэх ачаа, тээш, эд юмс, валют, валютын үнэт зүйл, улс хоорондын шуудангийн илгээмж, бүх төрлийн эрчим хүч, мал, амьтан, ургамал зэрэг хөдлөх эд хөрөнгө болон энэ хуулийн 3.1.5-д зааснаас бусад тээврийн хэрэгслийг;

3.1.2. “монголын бараа” гэж энэ хуулийн 99.1-д заасан горимын дагуу боловсруулалт хийснээс бусад Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дээр чөлөөт эргэлтэд байгаа гадаадын бараа;

3.1.3. “гадаадын бараа” гэж энэ хуулийн

3.1.2-т зааснаас бусад бараа;

3.1.4. “чөлөөт эргэлтэд байгаа бараа” гэж гаалийн хууль тогтоомжоор тогтоосон хязгаарлалтгүйгээр Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт захиран зарцуулах бараа;

3.1.5. “тээврийн хэрэгсэл” гэж бараа болон зорчигчийг улс хооронд тээвэрлэж гаалийн хилээр 6 сараас дээшгүй хугацаагаар нэвтрэх бүх төрлийн тээврийн хэрэгсэл, түүний дотор чингэлэг, ердийн хөсөг, тухайн аяллын хугацаанд тээврийн хэрэгсэлд шаардагдах шатахуун, тосолгооны материал, сэлбэгийг;

3.1.6. “тээвэрлэгч” гэж гаалийн хилээр бараа, зорчигч нэвтрүүлэх, эсхүл гаалийн нутаг дэвсгэрт гаалийн хяналт дор тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг;

3.1.7. “гаалийн мэдүүлэг” гэж мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах мэдээлэл агуулсан бичиг баримтыг;

3.1.8. “мэдүүлэгч” гэж гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлж байгаа аливаа этгээдийг;

3.1.9. “гаалийн хилээр нэвтрүүлэх” гэж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрт оруулах, дамжуулан өнгөрүүлэх, гаргахыг;

3.1.10. “гаалийн зам” гэж гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийг Монгол Улсын хил, хилийн гаалийн байгууллагын, эсхүл гаалийн нэг байгууллагаас гаалийн нөгөө байгууллагын хооронд тээвэрлэхээр гаалийн удирдах төв байгууллагаас тусгайлан тогтоосон замыг;

3.1.11. “гаалийн хяналт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн хууль тогтоомжийг мөрдүүлж, биелэлтийг нь хангуулах зорилгоор

гаалийн байгууллагаас хэрэгжүүлэх цогц арга хэмжээг;

3.1.12. “гаалийн бүрдүүлэлт” гэж гаалийн хилээр нэвтрүүлэх барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс гаалийн бичиг баримтыг, шаардлагатай тохиолдолд барааг шалгах, ногдуулсан татварыг төлсний дараа барааг олгох, эсхүл гаалийн хилээр гаргахыг зөвшөөрөх хүртэлх цогц үйл ажиллагааг;

3.1.13. “гаалийн бүрдүүлэлтийн горим” гэж гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн талаар тогтоосон хэм хэмжээ, нөхцөл, шаардлагыг;

3.1.14. “тарифын бус хязгаарлалт” гэж Монгол Улсын хилээр бараа нэвтрүүлэхийг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тоон хязгаарлалт тогтоох болон бусад арга хэмжээг;

3.1.15. “хилийн гаалийн байгууллага” гэж хилийн боомт болон олон улсын нисэх онгоцны буудалд ажилладаг гаалийн байгууллагыг;

3.1.16. “гүний гаалийн байгууллага” гэж энэ хуулийн 3.1.15-д зааснаас бусад гаалийн байгууллагыг;

3.1.17. “гаалийн баталгаат бүс” гэж гаалийн баталгаат агуулах, үйлдвэрийн болон үзэсгэлэнгийн газар, барилгын талбай, гаалийн тусгай бүс, татваргүй барааны дэлгүүрийг;

3.1.18. “гаалийн хяналтын бүс” гэж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналт дор ачих, буулгах, шилжүүлэн ачих, хадгалах, тээвэрлэх, гаалийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор тусгайлан тогтоосон байр, агуулах, талбайг;

3.1.19. “гаалийн харилцаанд оролцогч” гэж гаалийн байгууллага болон мэдүүлэгч, гаалийн зуучлагч, тээвэрлэгч, гаалийн түр агуулахын болон баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч, банк, даатгалын байгууллагыг.

4 дүгээр зүйл. Гаалийн нутаг дэвсгэр, гаалийн хил

4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийг гаалийн нутаг дэвсгэр гэж үзнэ.

4.2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулсан гаалийн баталгаат бүсийн болон чөлөөт бүсийн нутаг дэвсгэр нь тарифын болон тарифын бус хязгаарлалтын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдоно. (Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан)

4.3. Монгол Улсын хилийг гаалийн хил гэж үзнэ.

4.4. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулсан гаалийн баталгаат бүсийг гаалийн нутаг дэвсгэрээс тусгаарласан шугам болон гаалийн хяналтын бүсийн хилийг гаалийн хилд тооцно.

5 дугаар зүйл. Гаалийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг ашиглах

5.1. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхэд шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг холбогдох этгээд гаалийн хууль тогтоомжид заасны дагуу гаалийн байгууллагад гаргаж өгнө.

5.2. Гаалийн байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 5.1-д заасан мэдээлэл, бичиг баримтыг хүлээн авч түүнийг гагцхүү гаалийн зорилгоор ашиглах бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд задруулах, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.

5.3. Гаалийн байгууллага, албан тушаалтнаас гаалийн хууль тогтоомжийн дагуу авсан төр, хувь хүний, байгууллагын нууцад хамаарах мэдээллийг ашиглах, хадгалахтай холбогдсон харилцааг нууцын хууль тогтоомжоор зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БАРАА, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ГААЛИЙН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

6 дугаар зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх зарчим

6.1. Аливаа этгээд энэ хууль болон Монгол Улсын олон улсын гэрээ /цаашид “олон улсын гэрээ” гэх/-нд заасан нөхцөл, журмын дагуу бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр чөлөөтэй нэвтрүүлэх эрхтэй.

6.2. Хуульд зааснаас бусад тохиолдолд бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр орсон үеэс мэдүүлэгчид олгох хүртэл, эсхүл бараа, тээврийн хэрэгслийг мэдүүлсэн үеэс улсын хилээр гарах хүртэлх хугацаанд тэдгээрийг ашиглах, эзэмших, захиран зарцуулахыг хориглоно.

7 дугаар зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх

7.1. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага бүхий хилийн боомтоор нэвтрүүлнэ.

7.2. Энэ хуулийн 7.1-д зааснаас бусад хилийн боомтоор бараа, тээврийн хэрэгслийг гаалийн удирдах төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр нэвтрүүлж болно.

7.3. Энэ хуулийн 7.2-т заасан зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллага дор дурдсан тохиолдолд олгоно:

7.3.1. гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын үед;

7.3.2. олон улсын гэрээнд заасан;

7.3.3. улсыг батлан хамгаалах зорилгоор гадаад улсаас тусламж авах;

7.3.4. хуульд заасан бусад.

7.4. Энэ хуулийн 7.3-т заасны дагуу бараа, тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэхэд гаалийн удирдах төв байгууллага гаалийн албан тушаалтныг томилон ажиллуулна.

7.5. Бараа, тээврийн хэрэгслийг энэ хуулийн 7.2-т заасны дагуу хилээр нэвтрүүлэх тохиолдолд мэдүүлэгч нь гаалийн удирдах төв байгууллагад хүсэлтээ гаргах бөгөөд түүнд холбогдох байгууллагын зөвшөөрөл, бараа, тээврийн хэрэгслийн жагсаалтыг хавсаргана.

8 дугаар зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглох, хязгаарлах

8.1. Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал улсын хилээр оруулах, гаргахыг хориглох барааны, Засгийн газар тарифын бус хязгаарлалттай нэвтрүүлэх барааны жагсаалтыг тухайн барааны ангиллын кодыг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу зааж тус тус батална.

8.2. Улсын хилээр оруулахыг хориглосон барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулахгүй.

8.3. Энэ хуулийн 8.2-т заасан барааг Монгол

Улсын нутаг дэвсгэрт оруулсан бол нэн даруй буцаан гаргах ба ийнхүү гаргах боломжгүй бол гаалийн хяналтын бүс, эсхүл түр агуулахад 3 хүртэл хоног хадгалах бөгөөд энэ хугацаанд иргэн, хуулийн этгээд бараагаа буцаан гаргаагүй бол гаалийн байгууллага бараа устгах горимын дагуу арга хэмжээг авна.

8.4. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалттай барааг хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн хилээр нэвтрүүлнэ.

8.5. Улсын хилээр гаргахыг хориглосон барааг гаалийн нутаг дэвсгэрээс гаргахгүй.

8.6. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхгүй.

8.7. Гаалийн удирдах төв байгууллага бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх хилийн боомт, гаалийн байгууллагын байршил, тэдгээрийн ажиллах цагийн хуваарийг болон гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан барааны тухай нийтэд мэдээлнэ.

8.8. Энэ хуулийн 8.3-т заасан үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг тухайн иргэн, хуулийн этгээд хариуцна.

8.9. Гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг хууль бусаар нэвтрүүлсэн, эсхүл нэвтрүүлэхийг завдсан үйлдэл нь энэ хуулийн 8.3-т хамаарахгүй.

9 дүгээр зүйл. Гаалийн бүрдүүлэлт, гаалийн хяналт

9.1. Гаалийн байгууллага, албан тушаалтан нь улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавьж, гаалийн бүрдүүлэлт хийх бөгөөд уг үүргээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжид зааснаас бусад шаардлага тавихыг хориглоно.



II ХЭСЭГ. ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ ХИЙХ

НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

24 дүгээр зүйл. Гаалийн бүрдүүлэлт хийх

24.1. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд энэ хуульд заасан журмын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

24.2. Бараа илгээх, хүлээн авах болон барааны гарал үүслийн улсаас үл хамааран гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд гаалийн бүрдүүлэлт хийнэ.

24.3. Гаалийн хилээр нэвтрүүлэх зарим бараа, тээврийн хэрэгслийн төрөл, онцлогийг харгалзан гаалийн бүрдүүлэлтийн журмыг энэ хуульд нийцүүлэн гаалийн удирдах төв байгууллагын дарга тусгайлан баталж болно.

25 дугаар зүйл. Гаалийн бүрдүүлэлт хийх газар, цаг

25.1. Гаалийн бүрдүүлэлтийг гаалийн байгууллага бүхий газарт, гаалийн удирдах төв байгууллагын даргаас тогтоосон цагт хийнэ.

26 дугаар зүйл. Гаалийн бүрдүүлэлтийн хураамж

26.1. Мэдүүлэгч гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээний хураамж төлнө.

26.2. Энэ хуулийн 26.1-д заасан хураамжийн хэмжээг үйлчилгээний зардлыг харгалзан гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно.

26.3. Энэ хуулийн 26.1-д заасан хураамжийг улсын төсөвт төвлөрүүлнэ.

27 дугаар зүйл. Гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагдах мэдээлэл, бичиг баримт

27.1. Гаалийн байгууллага гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг мэдүүлэгчээс гаргуулан авна.

27.2. Энэ хуулийн 27.1-д заасан мэдээлэл, бичиг баримт гаргаж өгөх хугацааг гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно.

27.3. Гаалийн удирдах төв байгууллага гаалийн бүрдүүлэлтийг хялбарчлах, түргэвчлэх зорилгоор гадаад улсын гаалийн байгууллагатай мэдээлэл, бичиг баримтыг харилцан хүлээн

зөвшөөрөх тухай гэрээ байгуулж болно.

27.4. Энэ хуулийн 27.1-д заасан мэдээлэл, бичиг баримтыг гадаад хэл дээр үйлдэж болох боловч шаардлагатай гэж үзвэл гаалийн байгууллага тэдгээрийг төрийн албан ёсны хэлээр үйлдүүлэн мэдүүлэгчээс гаргуулан авна.

27.5. Гаалийн байгууллага энэ хуулийн 27.1-д заасан мэдээлэл, бичиг баримтын эх хувийг, эсхүл түүний хуулбарыг гаргуулан авах бөгөөд шаардлагатай бол бичиг баримтын хуулбарыг эх хувьтай нь тулган шалгана.

27.6. Энэ хуулийн 27.1-д заасан мэдээлэл, бичиг баримтыг факс, нийтийн электрон шуудан, гаалийн байгууллагатай холбогдсон бусад байгууллагын мэдээллийн сүлжээ /цаашид “мэдээллийн сүлжээ” гэх/-гээр ирүүлж болно.

27.7. Мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн мэдээлэл, бичиг баримтыг хэвлэж эрх бүхий этгээдийн гарын үсгээр баталгаажуулна.

27.8. Мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн бичиг баримтыг эх хувьд тооцож болно.

28 дугаар зүйл. Гаалийн бүрдүүлэлт хийхэд мэдүүлэгч, эсхүл түүний төлөөлөгчийг оролцуулах

28.1. Гаалийн бүрдүүлэлт хийхэд мэдүүлэгч, эсхүл түүний төлөөлөгчийг оролцуулна.

28.2. Гаалийн байгууллага, албан тушаалтан гаалийн бүрдүүлэлт хийх үйл ажиллагааг хялбарчлах зорилгоор мэдүүлэгч, эсхүл түүний төлөөлөгчийн туслалцаа авч болно.

29 дүгээр зүйл. Гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт

29.1. Гаалийн хилээр нэвтрүүлэх дор дурдсан бараанд гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлтийг хийж болно:

29.1.1. гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас бий болсон хохирлыг арилгах зориулалтын бараа;

29.1.2. цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис;

- 29.1.3. мал, амьтан;
- 29.1.4. улс хоорондын шуудангийн илгээмж;
- 29.1.5. сонин, тогтмол хэвлэл, мэдээллийн болон эрдэм шинжилгээ, судалгааны материал;
- 29.1.6. амархан муудах, гэмтэх магадлал бүхий хадгалалтын онцгой нөхцөл шаардсан бараа;
- 29.1.7. донорын эд эрхтэн, цус, цусан бүтээгдэхүүн;
- 29.1.8. хуульд заасан бусад бараа.
- 29.2. Энэ хуулийн 29.1-д заасан бараанд гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд бүрдүүлж өгөх болзолтойгоор дараалал харгалзахгүй гаалийн бүрдүүлэлт хийнэ.
- 29.3. Энэ хуулийн 29.1-д заасан барааг мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд гаргаж өгөх баталгааг бичгээр гаргана.
- 29.4. Гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлтийг дараахь тохиолдолд хийхийг хориглоно:
- 29.4.1. гаалийн бичиг баримт зөрчилтэй;
- 29.4.2. мэдүүлсэн барааны тоо, хэмжээ зөрүүтэй, эсхүл үнийн дүн нь зөрчилтэй;

- 29.4.3. мэдүүлэгч нь гаалийн хууль тогтоомжийн зөрчил удаа дараа /2 буюу түүнээс дээш/ гаргаж байсан;
- 29.4.4. энэ хуулийн 29.3-т заасан баталгааг гаргаж өгөөгүй;
- 29.4.5. гаалийн болон бусад татвар, хураамж төлөөгүй, эсхүл төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн дагуу гаргаагүй.

30 дугаар зүйл. Гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт

- 30.1. Энэ хуульд заасан бичиг баримтыг шаардахгүйгээр гаалийн мэдүүлгийн зарим хэсгийг нөхөн бичүүлэх замаар гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийж, барааг гаалийн хилээр нэвтрүүлж болно.
- 30.2. Гаалийн хялбарчилсан бүрдүүлэлтийг дараахь тохиолдолд хийж болно:
- 30.2.1. барааг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадаас шууд гаалийн баталгаат бүсэд оруулах;
- 30.2.2. барааг гаалийн баталгаат бүсээс гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадад гаргах.

ЗУРГАДУГААР ДЭД БҮЛЭГ БАРАА МЭДҮҮЛЭХ

55 дугаар зүйл. Барааг гаалийн байгууллагад мэдүүлэх

- 55.1. Мэдүүлэгч гаалийн хилээр нэвтрүүлэх барааг энэ хуульд заасны дагуу гаалийн байгууллагад мэдүүлнэ.
- 55.2. Гаалийн хилээр нэвтрүүлэх барааг дараахь хэлбэрээр мэдүүлж болно:
- 55.2.1. бичгээр;
- 55.2.2. мэдээллийн сүлжээгээр;
- 55.2.3. зорчигч хувийн хэрэглээний эд зүйлийнхээ, мэдүүлэгч улс хоорондын шуудан илгээлтийн тухай тус тус амаар;
- 55.2.4. зорчигч улаан, ногоон гарцыг сонгох буюу үйл хөдлөлөөр.
- 55.3. Мэдүүлэгч энэ хуулийн 55.1-д заасан барааг гаалийн мэдүүлгийн маягтын дагуу мэдүүлнэ.
- 55.4. Гаалийн мэдүүлгийг мэдээллийн сүлжээгээр нөхөн бичиж хүргүүлж болно.
- 55.5. Гаалийн мэдүүлгийн маягтын загвар, түүнийг нөхөн бичих, шалгах зааврыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
- 55.6. Гаалийн мэдүүлгийн маягт олон улсын

- стандарт бүхий загварт нийцсэн байна.
- 55.7. Гаалийн мэдүүлэгт бичигдэх мэдээлэл нь гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, статистикийн мэдээлэл гаргах, гаалийн болон бусад татвар ногдуулахад шаардлагатай мэдээллээр хязгаарлагдана.
- 55.8. Гаалийн мэдүүлгийг монгол хэлээр үйлдэнэ.
- 55.9. Улсын хилээр нэвтрэх зорчигч болон тээврийн хэрэгслийн багийн гишүүний хувийн хэрэглээний эд зүйл болон бусад барааг зорчигчийн гаалийн мэдүүлгээр мэдүүлнэ.

56 дугаар зүйл. Нэг ачилтын барааг мэдүүлэх

- 56.1. Нэг илгээгчээс нэг хүлээн авагчид илгээх, тус тусдаа тээврийн бичиг баримт бүхий, барааны оноосон нэр, ангиллын код, гарал үүслийн улс нь ижил бөгөөд барааг нэг өдөр илгээж байгаа, эсхүл нэг өдөр хүлээн авч байгаа тохиолдолд нэг ачилт гэж үзэж, барааны гаалийн нэг мэдүүлгээр бүрдүүлэлт хийж болно.
- 56.2. Иж бүрдэл бүхий тоног төхөөрөмж, машин, техникийг тээвэрлэлтийн боломжоос

шалтгаалан эд анги, бүрдэл хэсгээр нь салгаж тээвэрлэсэн тохиолдолд нэг ачилтад хамааруулж болно.

56.3. Нэг тээврийн хэрэгсэлд ачигдсан олон нэр төрлийн бараа нь Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн нэг зүйлд хамрагдах бол мэдүүлэгчийн хүсэлтээр хамгийн өндөр тарифтай нэг бараагаар төлөөлүүлэн мэдүүлж болох бөгөөд энэ тохиолдолд бусад барааны нэр, тоо, хэмжээ, үнийг тусгасан баримтыг гаалийн мэдүүлэгт хавсаргана.

58 дугаар зүйл. Гаалийн мэдүүлэг өгөх хугацаа

58.1. Мэдүүлэгч гаалийн мэдүүлгийг энэ хуулийн 25.1-д заасан цагт гаалийн байгууллагад хүргүүлэх бөгөөд мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн гаалийн мэдүүлэг, мэдээлэл, баримт бичигт энэ хугацаа мөн адил хамаарна.

58.2. Мэдүүлэгч барааг гаалийн хяналтын бүс, эсхүл гаалийн түр агуулахад байх хугацаанд гаалийн байгууллагад мэдүүлнэ.

58.3. Гаалийн мэдүүлэг өгөх хугацааг сунгах үндэслэлтэй гэж үзвэл гаалийн байгууллага мэдүүлэгчийн хүсэлтээр уг хугацааг энэ хуулийн 44.1, 44.2-т зааснаар дахин нэг удаа сунгана.

59 дүгээр зүйл. Барааг урьдчилан мэдүүлэх

59.1. Илгээгч улсын нутаг дэвсгэрээс ачигдсан гадаадын барааг Монгол Улсын хилээр оруулахаас өмнө, эсхүл хилийн гаалийн байгууллагын хяналтаас гүний гаалийн байгууллагын хяналтад орохоос өмнө тус тус урьдчилан мэдүүлж болно.

59.2. Энэ хуулийн 59.1-д заасан барааны дагалдах бичиг баримтын хуулбарыг гаалийн байгууллага гаргуулан авах бөгөөд бараа ирсний дараа бичиг баримтын эх хувийг хуулбартай тулгаж шалгана.

60 дугаар зүйл. Бараа мэдүүлэхэд шаардагдах бусад бичиг баримт

60.1. Мэдүүлэгч гаалийн мэдүүлэгтээ барааны дагалдах бичиг баримтыг хавсаргаж гаалийн байгууллагад өгнө.

60.2. Гаалийн байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлэх болон гаалийн хууль тогтоомжид заасан шаардлагыг хангах хүрээнд барааны дагалдах бичиг баримтыг гаргуулан авна.

60.3. Мэдүүлэгч гаалийн мэдүүлэгт өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг нотлох зорилгоор дараах бичиг баримтыг гаалийн байгууллагад өгнө:

60.3.1. гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх;

60.3.2. тээврийн бичиг баримт;

60.3.3. тарифын бус хязгаарлалтад хамаарах бараанд шаардагдах зөвшөөрөл, лиценз;

60.3.4. хууль тогтоомжид тусгайлан заасан бараанд мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон дүгнэлт; (Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

60.3.5. Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд гарал үүслийг нотлох баримт бичиг. (Энэ заалтыг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмсэн)

61 дүгээр зүйл. Барааг гаалийн байгууллагад мэдүүлсэнд тооцох

61.1. Гаалийн байгууллага, албан тушаалтан гаалийн мэдүүлэг, барааны дагалдах бичиг баримтыг хүлээн авч бүртгэснээр барааг гаалийн байгууллагад мэдүүлсэнд тооцно.

62 дугаар зүйл. Гаалийн мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах

62.1. Мэдүүлэгч гаалийн байгууллагын хүлээн авсан гаалийн мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтээ бичгээр гаргана.

62.2. Гаалийн байгууллага дараахь тохиолдолд гаалийн мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө:

62.2.1. гаалийн мэдүүлгээр өгсөн мэдээлэл бүрэн бус бол;

62.2.2. гаалийн мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтээ мэдүүлэгчээс гаргах үед гаалийн байгууллага барааг шалгаж эхлээгүй бол;

62.2.3. гаалийн мэдүүлэгт оруулах нэмэлт, өөрчлөлт нь ногдуулсан гаалийн болон бусад татварын дүн, тарифын бус хязгаарлалтын арга хэмжээнд нөлөөлөхөөргүй бол.

62.3. Гаалийн байгууллага, албан тушаалтан өөрийн санаачилгаар, эсхүл бусад этгээдийн хүсэлт, даалгавраар гаалийн мэдүүлэг бичих буюу түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

63 дугаар зүйл. Гаалийн мэдүүлгийг шалгах

63.1. Гаалийн байгууллага, албан тушаалтан гаалийн мэдүүлгийг хүлээн авсан даруйд дараахь байдлаар шалгана:

63.1.1. гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт нь бүрэн, хүчин төгөлдөр эсэх;

63.1.2. гаалийн мэдүүлэг, барааны дагалдах бичиг баримтад дурдсан мэдээлэл үнэн зөв, бодитой, хоорондоо тохирч байгаа эсэх;

63.1.3. гаалийн болон бусад татварын

ногдуулалт зөв эсэх.

64 дүгээр зүйл. Гаалийн мэдүүлгийг буцаан авах

64.1. Гаалийн бүрдүүлэлтийн горимыг өөрчлөх зорилгоор мэдүүлэгч нь барааг гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулахаас өмнө гаалийн мэдүүлгээ буцаан авч болох бөгөөд энэ тухай хүсэлтээ бичгээр гаргана.

64.2. Гаалийн байгууллага энэ хуулийн 64.1-д заасан хүсэлтийг ажлын 3 хоногийн дотор нягтлан шалгаж, хүсэлтийг хүлээн авах эсэх талаар бичгээр хариу өгөх бөгөөд хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан бол үндэслэлийг дурдана.

64.3. Гаалийн байгууллага энэ хуулийн 64.1-

д заасан хүсэлтийг хүлээн авсан бол мэдүүлэгч нь ажлын 3 хоногийн дотор өөрчлөн сонгосон горимын дагуу барааг дахин мэдүүлнэ.

65 дугаар зүйл. Гаалийн мэдүүлгийг хүчингүй болгох

65.1. Гаалийн байгууллага дараахь тохиолдолд гаалийн мэдүүлгийг хүчингүй болгоно:

65.1.1. урьдчилан мэдүүлсэн бараа мэдүүлэгчээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирээгүй, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэрээс гараагүй;

65.1.2. гаалийн бүрдүүлэлтийн горим өөрчлөхөөр гаргасан мэдүүлэгчийн хүсэлтийг гаалийн байгууллага хүлээн авсан.

НАЙМДУГААР ДЭД БҮЛЭГ ГААЛИЙН БАЙГУУЛЛАГАД МЭДҮҮЛСЭН БАРААГ ОЛГОХ

71 дүгээр зүйл. Барааг олгох үндэслэл

71.1. Гаалийн байгууллагад мэдүүлсэн барааг дараахь тохиолдолд мэдүүлэгчид нь олгоно:

71.1.1. гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт бүрдсэн;

71.1.2. гаалийн бүрдүүлэлтийн сонгосон горимын нөхцөл, шаардлага хангагдсан;

71.1.3. гаалийн болон бусад татварыг төлсөн, эсхүл төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд зааснаар гаргасан;

71.1.4. гаалийн мэдүүлгийн дагуу бараанд гаалийн хяналт, шалгалт хийгдсэн;

71.1.5. энэ хуулийн 71.1.4-т заасны дагуу хийсэн хяналт, шалгалтаар зөрчил илрээгүй бол.

72 дугаар зүйл. Гаалийн хяналтад байх нөхцөлөөр бараа олгох

72.1. Гаалийн хяналтад байх нөхцөлтэйгээр дараахь барааг мэдүүлэгчид нь олгоно:

72.1.1. түр хугацаагаар оруулах, гаргах;

72.1.2. гаалийн баталгаат бүсэд оруулах;

72.1.3. гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөж чөлөөт эргэлтэд орсон.

72.2. Энэ хуулийн 72.1.1, 72.1.3-т заасан барааг гаалийн нутаг дэвсгэрт зориулалтын дагуу ашиглана.

VI ХЭСЭГ. ХАРИУЦЛАГА

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ ГААЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

290 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

290.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

290.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. (Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)





ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ (Шинэчилсэн найруулга)

2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

(Хэсэгчлэн авав)

ЕРӨНХИЙ АНГИ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

1. Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

1.2 дугаар зүйл. Хууль ёсны зарчим

1. Зөрчлийн шинжийг энэ хууль, бусад хууль, захиргааны хэм хэмжээний актаар тодорхойлно.
2. Зөрчил, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг энэ хуулиар тогтооно.
3. Тодорхой үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцсоныг мэдээгүй нь тухайн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг шийтгэл, албадлагын арга хэмжээ хэрэглэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
4. Энэ хуулийг төсөөтэй хэрэглэхгүй.
5. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдэд түүний төрөл, хэлбэр, өмч хөрөнгө, оршин байгаа газар, үйл ажиллагааны чиглэлээс үл хамааран шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

1.3 дугаар зүйл. Шударга ёсны зарчим

1. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна.
2. Энэ хуульд заасан зөрчил тус бүрд шийтгэл оногдуулна.

1.4 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хууль үйлчлэх

нутаг дэвсгэр, хугацаа

1. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд энэ хуулиар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.
2. Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан болон агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд энэ хуулиар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.
3. Зөрчилд тооцох, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг тухайн зөрчил үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулийн дагуу шийдвэрлэнэ.
4. Зөрчилд тооцохгүй болсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ.
5. Шинээр зөрчилд тооцсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хүндрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй.
6. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шийдвэрийг гүйцэтгэсэн бол хуулийг буцаан хэрэглэхгүй ба шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шийдвэрийг гүйцэтгээгүй байгаа тохиолдолд буцаан хэрэглэнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧИН, АМЬТАН, УРГАМЛЫГ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ

7.3 дугаар зүйл. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих

1. Монгол Улсын хуулиар ховор, нэн ховор амьтны жагсаалтад ороогүй боловч Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, эсхүл тэдгээрийн гаралтай эд зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих

1. Хугацаадууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг:

1.1. ашигласан;

1.2. барьсан;

1.3. агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан, зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Агнуурынбүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан бол зөрчил үйлдэхэд

ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7. Харь амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.7 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хууль зөрчих

1. Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж:

1.1. байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд;

1.2. элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор түүсэн, бэлтгэсэн, худалдсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний

төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Харь ургамлыг зөвшөөрөлгүйгээр байгальд тарималжуулсан, эсхүл гадаад улсаас оруулсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн,

эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ҮНЭТ ЦААС, БАНК, САНХҮҮ, ГААЛЬ, ТАТВАР, ДААТГАЛЫН ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ

11.21 дүгээр зүйл. Гаалийн тухай хууль зөрчих

1. Гаалийн тухай хууль зөрчиж:

1.1. гаалийн мэдүүлэгт барааг бичихгүй орхисон, эсхүл худал бичсэн;

1.2. гаалийн үнэ, барааны тоо хэмжээ, гаалийн бүрдүүлэлтийн горим, барааны нэр төрөл, марк, зориулалт, ангилал, гарал үүслийг худал мэдүүлсэн;

1.3. барааны хэлбэр дүрс, баглаа боодлыг өөрчилсөн, эсхүл гаалийн шалгалтаас нуун далдалсан;

1.4. гаалийн бичиг баримтыг сольсон, эсхүл засварласан;

1.5. гаалийн тэмдэглэгээг өөрчилсөн, эсхүл сольсон, эсхүл гэмтээж татвараас зайлсхийсэн болон зайлсхийхийг завдсан бол татварыг нөхөн төлүүлж, хүн, хуулийн этгээдийг нөхөн төлүүлсэн татварын дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Бараа, тээврийн хэрэгслийг нуувч болгон ашигласан, эсхүл гаалийн хяналт шалгалтаас гадуур улсын хилээр барааг нэвтрүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тухайн зөрчилд холбогдох барааг хурааж, эсхүл үнийг гаргуулж, хүн, хуулийн этгээдийг нөхөн төлүүлэх татварын дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Гаалийн мэдээллийн систем ашиглах журам зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Гаалийн хяналтын бүсийн дэглэмийг зөрчсөн нь бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй холбогдолгүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Гаалийн хяналтад байгаа барааг гаалийн

байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлгөсөн, эсхүл ачсан, эсхүл буулгасан, эсхүл шилжүүлэн ачсан нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийн шинжгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Гаалийн хяналтад байгаа барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй олгосон, гаалийн хилээр гаргасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7. Гаалийн зорилгоор хийх тэмдэглэгээг гэмтээсэн, өөрчилсөн, устгасан, эсхүл гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийн хүрэх газрын хаягийг өөрчилсөн нь барааг хууль бусаар нэвтрүүлэхтэй холбоогүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8. Гаалийн, эсхүл бусад татвар ногдуулахгүйгээр гаалийн хилээр түр хугацаагаар нэвтрүүлсэн бараа, тээврийн хэрэгслийг тогтоосон хугацаанд буцаан нэвтрүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9. Гаалийн татвар, бусад татварыг хууль бусаар буцаан авах зорилгоор гаалийн үнийг худал мэдүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10. Гаалийн татвар, бусад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан барааг зориулалтын бусаар захиран зарцуулсан, эсхүл үрэгдүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан

эд зүйл, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хууль тогтоомж, валютын ханш, тарифын хувь хэмжээг үндэслэн татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлсэн татварын дүнгийн 50 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11. Тарифын бус хязгаарлалт тогтоосон барааг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, эсхүл нэвтрүүлэхийг завдсан бол тухайн зөрчилд холбогдох барааг хурааж, эсхүл үнийг гаргуулж хүн, хуулийн этгээдийг нөхөн төлүүлэх татварын дүнгийн 50 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12. Гаалийн удирдах төв байгууллагаас баталсан барааг мэдүүлэх журам зөрчсөн нь энэ зүйлийн 1, 11 дэх хэсэгт заасан, бусад зөрчлийн бүрэлдэхүүнгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13. Хуульд заасан үүргээ зөрчсөн тээвэрлэгчийг долоон зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14. Гаалийн зуучлагч, мэдүүлэгч гаалийн хууль тогтоомжийг зөрчсөн, эсхүл хууль тогтоомжид заасан эрхээ хэтрүүлсэн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

15. Хуульд заасан гаалийн бүрдүүлэлтийн горимын шаардлага зөрчсөн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

16. Гаалийн баталгаат бүсэд оруулсан бараа, тээврийн хэрэгсэл алдагдсан, эсхүл гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр устгагдсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

17. Гаалийн бүрдүүлэлтэд холбогдох бичиг баримтыг засварласан, хуурамчаар үйлдсэн нь энэ хуульд заасан зөрчлийн шинжгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

18. Гаалийн хууль тогтоомжид заасан мэдээ, тайланг буруу гаргасан, эсхүл хугацаанд нь гаргаж өгөөгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тайлбар: Энэ зүйлийн 14 дэх хэсэгт заасан зөрчлийг давтан гаргасан гаалийн бүртгээгдсэн мэргэжилтний эрхийг цуцалж, гаргасан зөрчилд нь хуульд заасан шийтгэл ногдуулна.

-Барааг гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлэх зорилгоор тээврийн хэрэгслийг зориудаар тоноглох, зориулалтыг нь өөрчлөх зэргээр нуувч болгон ашигласан бол уг тээврийн хэрэгслийг хурааж, эсхүл үнийг нь гаргуулж улсын төсөвт төвлөрүүлнэ.

-Энэ зүйлд заасан “нөхөн төлбөр” гэдэгт зөрчил гарах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хууль тогтоомжид заасан татвар, хураамжийг хамруулан ойлгоно.

11.22 дугаар зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль зөрчих

1. Хорио цээрийн хяналт, шалгалтын үед амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын байцаагчийн зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслээс буулгасан бол хүнийг дөчин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт, ачилтыг хийлгээгүй, эсхүл амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодлын битүүмжлэлийг задалсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Илгээмжийн үйлчилгээ эрхлэгч байгууллага амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бүхий илгээмж ирсэн тухай мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн байгууллагад мэдэгдэж үзлэг, шалгалт хийлгээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Импорт, экспортын гэрчилгээгүй, эсхүл гэрчилгээнд бичигдсэн мэдээлэл хуурамч, эсхүл дагалдах бусад баримт бичигтэй тохирохгүй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд хүн, хуулийн этгээд амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн, тэдгээрийн хашлага,

дэвсгэр, сав, баглаа боодол, тээврийн хэрэгсэлд хорио цээрийн үзлэг, шалгалтыг хилийн боомт, гүний гаалийн хяналтын талбай дээр хийлгээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг:

6.1. импортлох;

6.2. экспортлох;

6.3. дамжуулан өнгөрүүлэх;

6.4. тээвэрлэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд шинжилгээ хийж

баталгаажуулах, тэдгээрийг саатуулах, эмчилгээ, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийхэд шаардагдах зардлыг хариуцахаас зайлсхийсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8. Хуульд заасан тохиолдолд улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон тухай мэдэгдэл хүлээн авсан хүн, хуулийн этгээд хориглосон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлогч улсад буцаах үүргээ биелүүлээгүй бол хүлээн авсан амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг устгаж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОН ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАЛАЛГҮЙ ХҮН МОНГОЛ УЛСАД ЗОРЧИХ ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ

16.1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих

1. Монгол Улсын:

1.1. хилийн болон хил орчмын дэглэм;

1.2. хилийн боомтод мөрдөх журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Хилийн боомтод хяналт шалгалтын

тогтоосон дарааллыг зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Зөвшөөрөлгүйгээр хилийн боомтын хяналт шалгалтын бүсэд үйл ажиллагаа явуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.





ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛЬ

1995 оны 10 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

(Хэсэгчлэн авав)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь худалдаа, аж үйлдвэрийн танхим болон худалдааны танхим /цаашид «танхим» гэх/-ын бүрэн эрх, үйл ажиллагааны үндсэн чиглэл, түүний тогтолцоо, зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох, танхим болон төрийн ба бусад байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн хоорондын харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Танхимын тухай хууль тогтоомж

1. Танхимын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ /Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр

сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд танхимын тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Танхимын тухай ойлголт

1. Танхим нь аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдаа, үйлдвэрлэл эрхлэхтэй холбогдсон нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах болон худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор байгуулсан ашгийг төлөө бус хуулийн этгээд мөн /Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.

2. /Энэ хэсгийг 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТАНХИМЫН ЗОРИЛТ, БҮРЭН ЭРХ, ТОГТОЛЦОО

4 дүгээр зүйл. Танхимын зорилт, бүрэн эрх

1. Танхим нь улс орны эдийн засгийн хөгжилд тус дэмжлэг үзүүлэх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай нөхцөл бүрдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудаас гадаад, дотоодын байгууллагатай худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, өөрийн орны бараа, бүтээгдэхүүнийг экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ.

2. Танхим нь дараахь бүрэн эрх эдэлнэ:

1/гишүүдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах асуудлаар төрийн байгууллагатай харилцах;

2/үйл ажиллагааны дүрэм, бүтэц, зохион байгуулалтаа батлах;

3/салбар болон төлөөлөгчийн газраа дотоод, гадаадад нээн ажиллуулах.

3. Танхим нь бүрэн эрхийнхээ хүрээнд дараахь үйл ажиллагаа явуулна.

1/дотоод, гадаадын зах зээлийн мэдээлэл солилцох;

2/дотоод, гадаадын эдийн засгийн байгууллага, үйлдвэр, худалдааныхны судалгааны болон ажил хэргийн төлөөлөгчид солилцох, уулзалт хэлэлцээг зохион байгуулах;

3/гадаадын аж ахуйн нэгж, байгууллагуудад үйлдвэрлэл, худалдаа эрхлэхтэй нь холбогдсон үйлчилгээ үзүүлэх;

4/дотоод, гадаадад үйлдвэр, худалдааны олон улсын болон төрөлжсөн үзэсгэлэн, яармаг зохион байгуулах;

5/реклам, сурталчилгааны үйлчилгээ үзүүлэх, уран сайхны зарлал, чимэглэлийн эхийг бэлтгэх, хийлгэх;

6/аж ахуйн нэгж, байгууллагууд зөвлөлгөө өгөх, үйлдвэр, худалдааны түнш эрх олохтой холбогдсон мэдээллээр хангах, боловсон хүчин бэлтгэхэд нь туслах болон бусад үйлчилгээ үзүүлэх;

7/олон улсын болон гадаад улсын худалдаа, эдийн засгийн байгууллага, танхим, худалдаа, үйлдвэрлэл дэмжих байгууллагатай хамтран ажиллах;

8/дотоодын шинээр бий болсон жижиг, дунд үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг сурталчлах, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах;

9/Монгол улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бусад үйл ажиллагаа явуулах.

5 дугаар зүйл. Танхимын тогтолцоо

1. Монгол Улсад үндэсний танхим нэг байна.
2. Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим байж болно.

6 дугаар зүйл. Үндэсний танхим

1. Монголын үндэсний танхимын зорилт, бүрэн эрхийг Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим хэрэгжүүлнэ.

2. Үндэсний танхим нь танхимын нийтлэг зорилт, бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ дараахь тодорхой бүрэн эрхтэй байна:

1/төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах, түүний дотоод, гадаадад тайлбарлан таниулах, хэрэгжилтэд нь тус дэмжлэг үзүүлэх;

2/худалдаа, үйлдвэрийнхний нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлөн илэрхийлэх, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах;

3/энэ хуульд өөрөөр заагаагүй бол экспортын барааны гарал, үүслийг гэрчлэх; */Энэ заалтад 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

4/хуульд зааснаар дэргэдээ гадаад худалдааны арбитр байгуулан ажиллуулах;

5/экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах;

6/давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан бараа нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржээр арилжих бараа бол түүний гарал үүслийг биржийн тодорхойлолтыг үндэслэн гэрчилнэ. */Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн/*

7 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн, аймаг дундын танхим

1. Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим тухайн нутаг дэвсгэрт нэг байна.

2. Аймаг, нийслэлийн, аймаг дундын танхим нь бие даан үйл ажиллагаа явуулна.





ХОВОРДСОН АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЗҮЙЛИЙН ГАДААД ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

2002 оны 11-р сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенци (цаашид “Конвенци” гэх)-ийг хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалах зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль тогтоомж

2.1. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах

тухай хууль тогтоомж нь Амьтны аймгийн тухай, Байгалийн ургамлын тухай, Ан агнуурын тухай, Гаалийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь зөвхөн дэлхийд ховордсон Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд, түүгээр хийсэн бүтээгдэхүүн (цаашид “эд зүйл” гэх)-ийг олон улсад худалдаалах хүрээнд үйлчилнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

4 дүгээр зүйл. Конвенцийг хэрэгжүүлэх байгууллага

4.1. Конвенцийг хэрэгжүүлэх үүрэг бүхий, орон тооны бус Удирдан зохицуулах болон Шинжлэх ухааны зөвлөл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд тус тус ажиллана.

4.2. Удирдан зохицуулах болон Шинжлэх ухааны зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх, зөвлөлийн ажиллах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.3. Удирдан зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн нь байгаль орчин, үйлдвэр, худалдаа, хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, гааль, мэргэжлийн хяналт хариуцсан төрийн захиргааны

байгууллага, байгаль орчны чиглэлийн төрийн бус байгууллагын төлөөлөлтэй байна.

5 дугаар зүйл. Удирдан зохицуулах зөвлөл

5.1. Удирдан зохицуулах зөвлөл дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. Монгол Улсад Конвенцийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.1.2. Конвенцийн хавсралтад орсон нэмэлт, өөрчлөлтийг зөвшөөрөх, эс зөвшөөрөх, нэмэлт тайлбар хийх тухай асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

5.1.3. Конвенцийн хавсралтад шинээр нэмэлт, өөрчлөлт оруулах санал, Талуудын бага хурлаар хэлэлцэх асуудал, тогтоолын төсөл боловсруулж Засгийн газарт уламжлах;

5.1.4. Конвенцийн хавсралтад орсон

амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлоход гаалийн хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг хүчингүй болгох;

5.1.5. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг реэкспортлох болон далай тэнгисээс олборлон оруулах, Конвенцид нэгдэн орохоос өмнө олж авсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлоход гэрчилгээ олгох;

5.1.6. энэ хуулийн 6.1-д заасан дүгнэлт, тодорхойлолтыг гаргуулахаар Шинжлэх ухааны зөвлөлд уламжлах;

5.1.7. Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон тайланг жил бүр Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлэх;

5.1.8. холбогдох хууль тогтоомжийн дагуу хураан авсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг борлуулах, устгах, байгальд нь эргүүлэн тавих ажлыг зохион байгуулах;

5.1.9. энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар бусад байгууллагуудтай хамтран ажиллах.

5.1.10. Конвенцийн 3 дугаар хавсралтад оруулах амьтан, ургамлын зүйлийн жагсаалтыг Шинжлэх ухааны зөвлөлтэй хамтран боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах. *(Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан)*

6 дугаар зүйл. Шинжлэх ухааны зөвлөл

6.1. Шинжлэх ухааны зөвлөл нь дор дурдсан дүгнэлт, тодорхойлолт гаргах үүрэгтэй:

6.1.1. Конвенцийн 1, 2 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, далай тэнгисээс олборлон

оруюулахад тухайн амьтан, ургамал оршин тогтноход хор хохирол учрах эсэх талаарх дүгнэлт;

6.1.2. Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтныг импортлож буй этгээд тухайн амьтныг арчилж маллах зохих нөхцөл бүрдүүлснийг нотолсон тодорхойлолт;

6.1.3. Конвенцид нэгдэн орохоос өмнө олж авсан, Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтныг гаршуулж тэжээсэн, ургамлыг тарьж ургуулсан, тэдгээрийн гаралтай эд зүйл болохыг нотолсон дүгнэлт;

6.1.4. Конвенцийн 1, 2 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн олон улсын худалдаа хийхэд байгаль орчинд хор хохирол учрах эсэх талаархи дүгнэлт.

6.2. Шинжлэх ухааны зөвлөл нь дор дурдсан асуудлаар Удирдан зохицуулах зөвлөлд зөвлөмж өгнө:

6.2.1. Конвенцийн 2, 3 дугаар хавсралтад орсон амьтан, ургамлын тоо хэмжээг харгалзан экспортыг хязгаарлах шаардлагатай эсэх талаар; *(Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан)*

6.2.2. Конвенцийн 2, 3 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн талаар. *(Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан)*

6.3. Энэ хуулийн 6.2-д заасан зөвлөмжийг Удирдан зохицуулах зөвлөл хүлээн аваагүй тохиолдолд Шинжлэх ухааны зөвлөл уг зөвлөмжийг хүлээн авах шаардлагатай гэж үзвэл байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд уламжлан шийдвэрлүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХОВОРДСОН АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЗҮЙЛИЙН ГАДААД ХУДАЛДААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

7 дугаар зүйл. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдаа

7.1. Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг ашиг олох зорилгоор худалдаалахыг хориглоно.

7.2. Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг зөвхөн судалгаа, шинжилгээ хийх, музей,

амьтны хүрээлэнд байршуулах, циркэд тоглуулах зориулалтаар олон улсад худалдаалж болно.

7.3. Конвенцийн 2, 3 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг ашиг олох зорилгоор худалдаалж болно. *(Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан)*

7.4. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу Конвенцийн хавсралтад орсон амьтан,

ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалахад тухайн амьтан, ургамлын оршин тогтнох байдалд аюул занал учруулахгүй, цаашид харшлахаар ашиглалт явуулахгүй байлгах нөхцөлийг хангах зорилгоор тусгай журмын дагуу явуулна.

7.5. Энэ хуулийн 7.4-т заасан журмыг байгаль орчны болон гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

7.6. Энэ хуулийг зөрчиж Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалахыг хориглоно.

8 дугаар зүйл. Зөвшөөрөл, гэрчилгээ

8.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох буюу импортлох зөвшөөрөл, реэкспортлох буюу далай тэнгисээс олборлон оруулах гэрчилгээ авах хүсэлтээ Удирдан зохицуулах зөвлөлд гаргана.

8.2. Удирдан зохицуулах зөвлөл уг хүсэлтийг хүлээн авч зөвшөөрөл, гэрчилгээ олгох асуудлыг шийдвэрлэнэ.

8.3. Зөвшөөрөл, гэрчилгээ олгох журам болон загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. (Энэ хэсгийг 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

8.4. Зөвшөөрөл, гэрчилгээ нь олгогдсон өдрөөс хойш 6 сарын дотор хүчинтэй байна.

8.5. Зөвшөөрөл, гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хориглоно.

9 дүгээр зүйл. Зөвшөөрөл, гэрчилгээ олгох, олгохоос татгалзах

9.1. Удирдан зохицуулах зөвлөл нь дараах нөхцөлийг харгалзан зөвшөөрөл, гэрчилгээ олгоно:

9.1.1. энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3-т заасан дүгнэлт, тодорхойлолтыг авсан эсэх;

9.1.2. Конвенцийн 1, 2 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох зөвшөөрөл олгохдоо шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 6.1.4-т заасан дүгнэлт авсан эсэх;

9.1.3. тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг хууль тогтоомжид заасны дагуу олж авсан тухай нутгийн захиргааны холбогдох байгууллага, албан тушаалтны тодорхойлолт;

9.1.4. реэкспортлох гэж буй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг энэ хууль болон зохих зөвшөөрлийн дагуу импортлосон

эсэх;

9.1.5. амьтан, ургамлын тээвэрлэлт нь зохих журмын дагуу хийгдсэн болон шаардагдах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх;

9.1.6. Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох зөвшөөрөл олгохдоо импортлогч улсын эрх бүхий байгууллагаас импортын зөвшөөрөл урьдчилан авсан эсэх;

9.1.7. тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олж авахдаа Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан барих зөвшөөрлийн хураамжийн тухай, Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуульд заасан төлбөр, хураамж тушаасан баримт бичиг.

9.2. Удирдан зохицуулах зөвлөл дараах үндэслэлээр зөвшөөрөл, гэрчилгээ олгохоос татгалзана:

9.2.1. энэ зүйлийн 9.1-д заасан нөхцлүүдийг хангаагүй;

9.2.2. хуурамч баримт бичиг ашигласан нь тогтоогдвол.

9.3. Бусдад шилжүүлсэн, хүчинтэй байх хугацаа дууссан, зөвшөөрөл, гэрчилгээг хүчингүйд тооцно.

10 дугаар зүйл. Хөнгөлөлт

10.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, ургамлыг гаршуулан тэжээсэн, тарьж ургуулсан бол тэдгээрийг Конвенцийн 2 дугаар хавсралтад орсон амьтан, ургамалд хамааруулан үзэж олон улсад худалдаалах зөвшөөрөл, гэрчилгээг энэ хуульд заасан журмын дагуу олгоно.

10.2. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлд хамаарах хувийн хэрэглээний зүйлээ импортлох, эсхүл импорлогч орны зөвшөөрөл шаардагдахаас бусад тохиолдолд экспортлохдоо зөвшөөрөл авахгүй.

10.3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлд хамаарах хувийн хэрэглээний эд зүйлийн жагсаалтыг гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

10.4. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг дамжуулан өнгөрүүлэхэд аливаа зөвшөөрөл авахгүй.

10.5. Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт бүртгэлтэй эрдэмтэн, эрдэм шинжилгээний байгууллагуудын хооронд ашиг олох зорилгогүйгээр түр ашиглах, бэлэглэх,

хандивлах, солилцох, музейд хадгалуулах зориулалтаар Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг зөвшөөрөлгүй импортлоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

11 дүгээр зүйл. Зөвшөөрөгдсөн боомт

11.1. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг Монгол улсын хилээр нэвтрүүлэх боомтыг Удирдан зохицуулах зөвлөлийн саналыг үндэслэн гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

12 дугаар зүйл. Конвенци, түүний хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах (Энэ зүйлийг 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон)

13 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

13.1. Энэ хуулийн хэрэгжилтэд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гаалийн болон орон нутгийн холбогдох байгууллага тус тусын эрх хэмжээний дагуу хяналт тавина

14 дүгээр зүйл. Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах

14.1. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 20 хүртэл хувиар тооцож мөнгөн шагналыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

15 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

15.1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. *(Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)*





ЭРҮҮГИЙН ХУУЛЬ (Шинэчилсэн найруулга)

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

(Хэсэгчлэн авав)

ЕРӨНХИЙ АНГИ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

1. Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2 дугаар зүйл. Хууль ёсны зарчим

1. Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно. *(Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)*

2. Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй.

3. Үйлдэл, эс үйлдэхгүйг шинээр гэмт хэрэгт тооцсон, шинээр эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тогтоосон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль энэ хуулийн бүрэлдэхүүн хэсэг болно. *(Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)*

4. Энэ хуулийн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална.

5. Энэ хуулийн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад захиргааны хэм хэмжээний актыг ашиглаж болно.

1.3 дугаар зүйл. Шударга ёсны зарчим

1. Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн

нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна. *(Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)*

2. Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй.

3. Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй. *(Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)*

4. Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. *(Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)*

5. Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна.

1.4 дүгээр зүйл. Гэм буруугийн зарчим

1. Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. *(Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)*

2. Гэм буруугүйгээр энэ хуульд заасан хохирол, хор уршиг учруулсан бол эрүүгийн

хариуцлага хүлээлгэхгүй. (Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

3. Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаагүй, хэргийн нөхцөл байдлын улмаас ухамсарлах боломжгүй байсан, учирч болох нийгэмд аюултай хор уршгийг урьдчилан мэдэх боломжгүй, мэдэх ёсгүй байсан бол хор уршиг гэм буруугүйгээр учруулсан гэж үзнэ. (Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

4. Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. (Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

1.5 дугаар зүйл. Эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. (Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. (Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

3. Гадаад улсын дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдвэл түүнд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ. (Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

4. Энэ хуульд заасан тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд энэ хуулиар эрүүгийн хариуцлага

хүлээлгэнэ. (Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

1.6 дугаар зүйл. Эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна үйлчлэх

1. Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суудаг харьяалалгүй хүн гадаад улсад энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, тухайн гэмт хэрэгт нь эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй бол энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. (Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүний үйлдсэн гэмт хэрэгт нь гадаад улсад ял оногдуулсан бол Монгол Улсын шүүх түүнд оногдуулсан ялыг энэ хуулийн дагуу хөнгөрүүлж, чөлөөлж болно. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол шүүх тухайн хүнийг энэ хуульд заасан үндэслэлээр гэм буруугийд тооцож болно.

3. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсад алба хааж байхдаа гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын цэргийн алба хаагчид энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. (Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

4. Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. (Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

5. Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн, харьяалалгүй хүн тус улсын хилийн гадна Монгол Улсын ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэж түүндээ ял шийтгүүлээгүй бол Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно. (Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

24.5 дугаар зүйл. Хууль бусаар ан агнах

1. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн

зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс

таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ. (Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон)

24.8 дугаар зүйл. Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх

1. Зохих зөвшөөрөлгүйгээр, хуульд зааснаас өөр зорилгоор нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтэнийг түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан бол таван мянга

дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ. (Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон)

24.9 дүгээр зүйл. Байгалийн тэнцэл алдагдуулах

1. Амьтан, ургамлын зүйлийг зөвшөөрөлгүйгээр гэмтээсэн, устгасан, газар, газрын хэвлий, агаар мандал, усны нөөцийг хордуулсан, бусад хэлбэрээр экологийн тогтолцоог алдагдуулсан бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. (Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

2. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.





УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ БҮЛЭГ БАРААНЫ ЖАГСААЛТ

	Бүлэг барааны бичиглэл	Улсын хилээр нэвтрэх ялгаа
1.	Мансууруулах бодис, тэдгээрийг хэрэг-лэх, үйлдвэрлэхэд зориулсан багаж хэрэгсэл, мансууруулах ургамал*	Гаргах, оруулах
2.	Судалгаа, шинжилгээний зориулалттайгаас бусад этилийн спирт	Оруулах
3.	Пиво ундааны хаягдал лаазнаас бусад хаягдал хар болон өнгөт төмөрлөг /ширэм, төмөр, ган, зэс, гууль, хөнгөн цагаан, тэдгээрийн хайлш/, цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй хар болон өнгөт төмөрлөг, зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа хар болон өнгөт төмөрлөгөөр хийсэн сэлбэг, бүтээгдэхүүн	гаргах

* Эмчилгээний зориулалтаар хилээр оруулж ирэх мансууруулах бодис, ургамлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолтоор хил нэвтрүүлнэ.

/1999 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 11 дүгээр, 2005 оны 46 дугаар, 2006 оны 3 дугаар тогтоолоор орсон нэмэлтийг тусгав./ /2006 оны 92 дугаар тогтоолоор орсон хасалтыг хийв. 2008-1-28/



УЛСЫН ИХ ХУРЛЫН 1998 ОНЫ 05 ДУГААР
ТОГТООЛЫН 2 ДУГААР ХАВСРАЛТ

**МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ТАРИФЫН БУС БУСАД ХЯЗГААРЛАЛТТАЙ
НЭВТРҮҮЛЭХ БҮЛЭГ БАРААНЫ ЖАГСААЛТ**

	Бүлэг барааны бичиглэл	Улсын хилээр нэвтрэх ялгаа
1	Ураны хүдэр ба түүний баяжмал	Гаргах
2	Онцгой хортой химийн бодис	Гаргах, оруулах
3	Зайлшгүй хяналтад байх эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалттай эд эрхтэн, донорын цус	Гаргах, оруулах
4	Буу, зэр зэвсэг, байлдааны хэрэгсэл, техник, тэдгээрийн эд анги, тоног хэрэглэл, тэсрэх бодис	Гаргах, оруулах
5	Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл	Түр гаргах
6	Ердийн түүх соёлын зүйл, амьтан, ургамал, эрдэс судлал, анатоми, археологи палеон-тологи, угсаатны зүй болон зоос судлалын чиглэлийн олдвор болон цуглуулга	Гаргах
7	Үржлийн мал	Гаргах
8	Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, ан амьтны холбогдолтой судалгааны ажлын сорьц, дээж	Гаргах
9	Мал, амьтны үр хөврөл, бичил биетний өсгөвөр	Гаргах





**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ТОГТООЛ**

ХОВОР УРГАМЛЫН ЖАГСААЛТ

(Монгол, латин нэрээр)

1. Давхарацан авлис • *Smelovskia bifurcata*
2. Ацан ажигана • *Stellaria dichotoma*
3. Дунд ажигана • *Stellaria media*
4. Дэрэн ажигана • *Stellaria pulvinata*
5. Цацраган ажигана • *Stellaria radians*
6. Унжгар азаргана • *Cirsium pendulum*
7. Регелийн алаглигцэцэг • *Minuartia Regeiana*
8. Туйлын алаглигцэцэг • *Minuartia arctica*
9. Цэх алаглигцэцэг • *Minuartia stricta*
10. Нүцгэн алтанбөөр • *Chrysosplenium nudicaule*
11. Нугараа алтантовч • *Matricaria recutita*
12. Геблерийн алтанцэгцүүхэй • *Hypericum Gebleri*
13. Голөвсөрхүү альчинга • *Butemus junceus*
14. Бүнгийн ангалзуур • *Lagochilus Bungei*
15. Богданы арвай • *Hordeum Bogdani*
16. Төрөлсөг арзгана • *Cousinia affinis*
17. Бөөнөг арзгар • *Sparganium glomeratum*
18. Дагуур арц • *Juniperus dahurica*
19. Хуурамч хонин арц • *Juniperus pseudosadina*
20. Нүцгэн багваахай • *Taraxacum glabrum*
21. Турьхан багваахай • *Taraxacum macilentum*
22. Үнгээмэл навчит багваахай • *Taraxacum armerifolium*
23. Сунагар баглуур • *Anabasis elatior*
24. Зантгар бамбай • *Valeriana capitata*
25. Эмийн бамбай • *Valeriana officinalis*
26. Чуйн банга • *Crepis czuensis*
27. Дорогостайскийн банздоо • *Saussurea Dorogostaiskii*
28. Екатерины банздоо • *Saussurea Catharinae*
29. Клеменцийн банздоо • *Saussurea Klementzii*
30. Мөсний банздоо • *Saussurea glacialis*
31. Навчирхэг банздоо • *Saussurea foliosa*
32. Өргөн навчит банздоо • *Saussurea latifolia*
33. Хурц банздоо • *Saussurea acuminata*
34. Тагийн барагжаа • *Woodsia alpina*
35. Гельцерийн башир • *Dianthus Hoeltzeri*
36. Зүүнгарын башир • *Dianthus soongoricus*
37. Ревердаттын биелэг өвс • *Poa Reverdattoii*
38. Хэвтээ биелэг өвс • *Poa supina*
39. Хэнтийн биелэг өвс • *Poa kenteica*
40. Гоо ботууль • *Festuca venusta*
41. Комаровын ботууль • *Festuca Komarovii*
42. Литвиновын ботууль • *Festuca Litvinovii*
43. Дөрвөлжин бөлбөө • *Nymphaea tetragona*
44. 5-рановын бөөнгөнө • *Rhizoplaca Baranovii*
45. Лазтгай навчит бударга • *Suaeda iinifolia*
46. Нанчиггсаг бударгана • *Salsola foliosa*
47. Ягаан бударгана • *Salsola rosacea*
48. Падгардуу бударганцар • *Climacoptera subcrassa*
49. Халбагандуу буниас • *Bunias cochlearioides*
50. Том үрт бүрз • *Galatella macroschiada*
51. Их бушилз • *Kobresia robusta*
52. Монгол бүйлэс • *Amygdalus mongolica*
53. Өвөр-уралын бүрээ • *Onosma transrhymense*
54. Дэлхээ бүүргэнт • *Pulicaria prostrata*
55. Говийн бэрмэг • *Limonium gobicum*
56. Грубовын бэрмэг • *Limonium Grubovii*
57. Усан гагнаа • *Tillaea aquatica*
58. Комаровын ганга • *Thymus Komarovii*
59. Монгол ганга • *Thymus mongolicus*
60. Павловын ганга • *Thymus Pavlovii*
61. Ягаан ганга • *Thymus roseus*
62. Жижиг гандбадраа • *Veronica perpusilla*
63. Порфирын гандбадраа • *Veronica Porphyriana*
64. Невскийн ганцаахай • *Lysiella Nevskii*
65. Алтлаг цэцэгт гичгэнэ • *Potentilla chrysantha*
66. Зүймэг гичгэнэ • *Potentilla inbricata*
67. Иконниковын гичгэнэ • *Potentilla Ikonnikovii*
68. Норвегийн гичгэнэ • *Potentilla norvegica*
69. Регелийн гичгэнэ • *Potentilla (Regeliana)*
70. Элсний гичгэнэ • *Potentilla arenosa*
71. Семеновын гиш • *Vicia Semenovii*
72. Хос цэцэгт гиш • *Vicia geminiflora*
73. Япон гиш • *Vicia japonica*
74. Гөлгөр говой • *Goldbachia Laevigata*
75. Иконниковын говой • *Goldbachia Ikonnikovii*
76. Зүүн гарын гоёо • *Cynomorium soongaricum*
77. Санчирын гол гэсэр • *Aster Sanczirii*
78. Уелиг гол өвс • *Juncus articulatus*
79. Мажар гозоохой • *Juncellus pannoynicus*
80. Гажиг гуриу-үрт • *Aulackspermum anomalum*
81. Наалдамхай гүүн хөх • *Scutellaria viscidula*
82. Навтгар гүүн хөх • *Scutellaria supina*
83. Паулсын гүүн хөх • *Scutellaria Paulsenii*

84. Жинхэнэ доёлз • *Moneses uniflora*
85. Дөрвөн эвэрт дөрвөлж • *Tetracme quadricornis*
86. Тагийн дурваалиг • *Phleum alpinum*
87. Голөвсдүү дэвхэргэнэ • *Ereogonia juncea (arenaria)*
88. Товчин дэвхэргэнэ • *Eromogonia androsacea*
89. Цагаан дэгд • *Gentiana algida*
90. Эргийн дэгд • *Gentiana riparia*
91. Согтоонги дэрс • *Achnatherum inebrians*
92. Юлдэн ерөндгөнө • *Vincetoxicum lanceolatum*
93. Зайдуу ерхөнгө • *Eremopyrum distans*
94. Тепентиновын жав • *Eucedanum terebinthaceum*
95. Дагуур жавай • *Cimicifuga dahurica*
96. Анхилзуурархуу жавхаа • *Ziziphora clinopodioides*
97. Алтайн жамъянмядаг • *Trollius Altaicus*
98. Ягаан жамъянмядаг • *Trollius Lilacinus*
99. Арави задарга (ацхайрс) • *Schismus arabicus*
100. Зүүнгарын заяахай • *Ligularia soongarica*
101. Долгиолог зираа • *Lactuca undulata*
102. Этүзнавчит зогдоргоно • *Clematis aethusifolia*
103. Говийн зорлог (азар) • *Calligonum gobicum*
104. Голөвсдүү зорлог (улаан түлээ) • *Calligonum junceum*
105. Дөл зохимон • *Senecio flammeus*
106. Өргөний зохимон • *Senecio argunensis*
107. Яваны зулзган цагаан • *Oenanthe javanica*
108. Прежевальскийн зурман сүүл • *Puccinellia Przewalskyi*
109. Гурвалсан зууч • *Cardamine Trifida*
110. Том навчит зууч • *Cardamine macrophylla*
111. Цагаан цэцэгт зууч • *Cardamine leucantha*
112. Үндэслэмтгий зэгс • *Scirpus radicans*
113. Чөдөр зэллэг цэцэг • *Calystegia hederacea*
114. Мартагдсан зэллэг цэцэг • *Calustegia subvolubilis*
115. Гөлгөр ивэргэнэ • *Herniaria glabra*
116. Эгэл идрээ • *Cichorium intybus*
117. Эгэл исрэг • *Oxalis acetosella*
118. Гурвалжин их зул • *Synurus deltiodes*
119. Зөөлөн лавай • *Asterothamnus molliusculus*
120. Үнэгэн сүүлхэй лидэр • *Sophoria alopecuroides*
121. Ильяний лууль • *Chenopodium Iljinii*
122. Цацаглаг лууль • *Chenopodium chinopodioides*
123. Цайвардуу маалинга • *Linum pallescens*
124. Эгэл маалинга • *Linum usitatissiraum*
125. Маралхай марал цэцэг • *Tanacetum tanacetoides*
126. Потанины махирс • *Lyciura Potaninii*
127. Бөөн цэцэгт мийнхумс • *Nepeta densiflora*
128. Нүцгэн мийнхумс • *Nepeta pannonica*
129. Өлчир мүгээ • *Rhodiola algida*
130. Туурсны наадгай • *Agrostemma githago*
131. Манин намгалж • *Callitriche hermaphroditica*
132. Сайхны намуу • *Papaver saichanense*
133. Хангайн намуу • *Papaver changaica*
134. Атамантархуу нахимдаг • *Stenocoelium athamahtoides*
135. Ахар цомирлогт нил • *Viola brachysepala*
136. Патрэны нил • *Viola Patrinii*
137. Толгодын нил • *Viola collina*
138. Шоргор нил • *Viola acuminata*
139. Эгэл нишингэ • *Phragmites communis*
140. Зэгслиг нуудгай • *Crypsis schoenoides*
141. Сүүдрийн ойн цагаан • *Moehringia umbrosa*
142. Бохир ортууз • *Oxytropis sordida*
143. Горбуновын ортууз • *Oxytropis Gorbunovii*
144. Комаровын ортууз • *Oxytropis Komarovii*
145. Крыловын ортууз • *Oxytropis Krylovii*
146. Ладыгины ортууз • *Oxytropis Ladyginii*
147. Монгол ортууз • *Oxytropis mongolica*
148. Нарийн ортууз • *Oxytropis tenuis*
149. Сапожниковын ортууз • *Oxytropis Saposhnikovii*
150. Сутайн ортууз • *Oxytropis sutaica*
151. Сэлмэн ортууз • *Oxytropis falcate*
152. Хоёр цэцэгт ортууз • *Oxytropis diantha*
153. Арзгар оточ өвч • *Bunium capillifolium*
154. Цөлийн өнчинцэрэв • *Krylovia eremophila*
155. Шар саахуу цэцэг • *Nuphar Lutea*
156. Дэвүүр үрт сагай • *Pugionium pterocarpum*
157. Крыловын садагнагва • *Lophanthus Krylovii*
158. Бунгийн салаагана • *Chorispora Bungeana*
159. Бушийн сараана • *Lilium Buschianum*
160. Потанины сараана • *Lilium Potaninii*
161. Альбертын сарнай • *Rosa Alibertii*
162. Беггерийн сарнай • *Rosa Beggeriana*
163. Хавтгай хатгуурт сарнай • *Rosa platyacantha*
164. Монгол сиймбий • *Batrachium mongolicum*
165. Кауфманы сиймбий • *Batrachium Kauffmanii*
166. Монгол сиймхийлэг • *Melandrium mongolicum*
167. Шивүүрт сондуут • *Acanthophyllum pungens*
168. Алтайн сонгино • *Allium altaicuro*
169. Максимовичийн сонгино • *Allium Maximoviczii*
170. Цагаан цэцэгт сонгино • *Ailium galanthum*
171. Эмгэн сонгино • *Allium condensatum*
172. Сэвгүй сорвоо • *Calamagrostis inexpansa*
173. Турчаниновын сорвоо • *Calamagrostis Turczaninovii*
174. Нэлгэмэр сунараа • *Asperula humifusa*
175. Хадны сунараа • *Asperula saxicola*
176. Арзгар сухай • *Tamarix hispida*
177. Тагийн сүүт өвс • *Euphorbia alpina*
178. Сөөгөнцөр сүхлээ • *Securinega suffruticosa*

179. Комаровын таван салаа • *Plantago Komarovii*
180. Нам тайжийн жинс • *Echinops nanus*
181. Толгойрхог тайр • *Gypsophila cephalotes*
182. Грубовын тарваган шийр • *Thermopsis Grubovii*
183. Монгол тарваган шийр • *Thermopsis mongolica*
184. Урт буурцагт тарваган шийр • *Thermopsis longicapra*
185. Үсхий тарваган шийр • *Thermopsis hirsutissima*
186. Ширэнгийн тарна • *Polygonum dumetorum*
187. Днеприйн тахилж • *Middendorfia borysthenica*
188. Том үрт тольт өвс • *Calutzkya macrocapra* •
189. Жинхэнэ том үрт • *Megacarpaea megalocarpa*
190. Тагийн тосондой • *Pinguicula alpine*
191. Монгол тост • *Brachanthemum mongolicum*
192. Ледебурин төлөгч-өвс • *Achillea Ledebourii*
193. Шоргор төлөгч-өвс • *Achillea acuminata*
194. Таван судалт төмөрдээ • *Lathyrus quinquenervius*
195. Нугын туйпланцар • *Phlomis pratensis*
196. Халхын голын тунхуу • *Chrysanthemum chalingolicum*
197. Зүүнгарын тутаргалж • *Piptatherum songaricum*
198. Жижиг жимст тэмээлж • *Camelina microcarpa*
199. Нугын тэшиг • *Tretocarya pratensis*
200. Анхил улаагана • *Ribes fragrans*
201. Анхилуун улаагана • *Ribes graveolens*
202. Арзаахай улаагана • *Ribes hispidulum*
203. Элдэв үст улаагана • *Ribes heterotrichum*
204. Анхил цагаан улалж • *Carex laliacea*
205. Бага улалж • *Carex parva*
206. Сэлэнгийн улалж • *Carex selengensis*
207. Туулайн улалж • *Carex leporina*
208. Цагаан улалж • *Carex alba*
209. Еротерусын улбуудай • *Cortusa Brotheri*
210. Дайрт унаган сүүл • *Schizachne callosa*
211. Хөвдөг усан хөрш • *Potamogeton natans*
212. Гялгар усан хөрш • *Potamogeton lucens*
213. Мохоодуу усан хөрш • *Potamogeton obtusifolius*
214. Уртхан усан хөрш • *Potamogeton praelongus*
215. Бяцхан цэцэгт хависгана • *Scorzonera parviflora*
216. Грубовын хависгана • *Scorzonera Grubovii*
217. Маалингадуу хавтгалж • *Meniocus linifolius*
218. Гоо хадаасгана • *Centaurn pulchellum*
219. Лозелийн хамбий • *Sisymbrium Loeselii*
220. Өргөсхөнт хамбий • *Sisymbrium subspinescens*
221. Алтайн хамбил • *Draba altaica*
222. Олон толгойт хамбил • *Draba multiceps*
223. Сибирь хамбил • *Draba sibirica*
224. Тэмээн харгана • *Caragana spinosa*
225. Зарзаахай харцгана • *Hieracium echioides*
226. Маалинган навчит хасалгана • *Diarthron linifolium*
227. Ломоносовын хасзул • *Olgaea Lomonosovii*
228. Налчгар хайрст хонгорзул • *Centaurea adpressa*
229. Нүцгэн хонгорзул • *Centaurea calva*
230. Хүрэн хонин зажлуур • *Linaria hepatica*
231. Зэгэл хоногбудуа • *Setaria glauca*
232. Хангайн хонхлой • *Adenophora changaica*
233. Ерөндөг хорс • *Aconitum anthoroideum*
234. Комаровын хорс • *Aconitum Komarovii*
235. Говийн хотир • *Zygophyllum gobicum*
236. Кашгар хотир • *Zygophyllum kaschgaricum*
237. Орхигдмол хотир • *Zygophyllum neglectum*
238. Өдлөг хотир • *Zygophyllum sianum*
239. Өргөн навчит хотир • *Zygophyllum latifolium*
240. Шовгор хотир • *Zygophyllum micronatum*
241. Нохойн хэлэрхүү хотой • *Leonurus panzerioides*
242. Ижлийн хошоон • *Melilotus Wolgicus*
243. Цагаан хошоон • *Melilotus albus*
244. Мөлхөө хошоонгор • *Trifolium repens*
245. Потанийн хөвдөл • *Cetraria Potaninii*
246. Дагуур хөвөнцөр • *Epilobium dahuricum*
247. Үсхий хөвөнцөр • *Epilobium hirsutum*
248. Будгийн хөхөргөнө • *Isatis tinctoria*
249. Хавтагнавчит хөхтолгой • *Eryngium planum*
250. Барзгартүүрт хувиланги • *Pedicularis dasystachys*
251. Цуулбар хувиланги • *Pedicularis fissa*
252. Шөмбөгөр хувиланги • *Pedicularis proboscidea*
253. Гажиг хулсанз • *Arundinella hirta*
254. Далжгар хумилж • *Alchemilla cyrtopleura*
255. Крыловын хумилж • *Alchemilla Krylovii*
256. Мөлгөр хумилж • *Alchemilla hebescens*
257. Павловын хумилж • *Alchemilla Pavlovii*
258. Хангайн хумилж • *Alchemilla changaica*
259. Сибирь хундгана • *Adorns sibirica*
260. Алтайн хунчир • *Astragalus altaicus*
261. Байтагийн хунчир • *Astragalus baitagensis*
262. Гранитовын хунчир • *Astragalus Granitovii*
263. Грегорийн хунчир • *Astragalus Gregorii*
264. Дани хунчир • *Astragalus danicus*
265. Дэрвээн хунчир • *Astragalus squarrosa*
266. Жимийн хунчир • *Astragalus dshinensis*
267. Курчум хунчир • *Astragalus Kurtschumensis*
268. Үнэгэн хунчир • *Astragalus vulpinus*

269. Хангайн хунчир • *Astragalus changaicus*
270. Хөөнгө буурцагт хунчир • *Astragalus physocarpus*
271. Ширүүн хунчир • *Astragalus scabrisetiformis*
272. Сормост хургалж • *Eragrostis cilianensis*
273. Хуурамч (марцны) хурганчих • *Rumex pseudonatronatus*
274. Сибирь хуш • *Pinus sibirica*
275. Цөөнмөчирт хэрээннүдэн • *Asparagus oligoclonus*
276. Хөрөл хялгана • *Stipa consanguinea*
277. Улбар хялгана • *Stipa rubens*
278. Цөлийн хялгаст • *Strigosella africana*
279. Дэгнүүлтэйхэн цагаансуль • *Elymus praecaespitosus*
280. Өндөр цагаансуль • *Elymus excelsus*
281. Памир цагаансуль • *Elymus pamiricus*
282. Федченкогийн цагаансуль • *Elymus Fedtschenkoii*
283. Давсны цахилдаг • *Iris halophila*
284. Юнатовын цомбогоно • *Microstigma Junatovii*
285. Толбот цэгцээхэй • *Achyrophorus maculatus*
286. Ягаан цээнэ • *Raeonea anojala*
287. Арзгар жимст чоногоно • *Jurinae chaetocarpa*
288. Гендерсоны чонохор • *Poa cynum Hendersonii*
289. Гашуувтар цэсэнцэр • *Solarium depilatum*
290. Бөхөөн чонын өргөс • *Carduus nutans*
291. Охоотын чөдөр өвс • *Atragene ochotensis*
292. Сибирь чулуудай • *Petrosimonia sibirica*
293. Литвиновын чулуудай • *Petrosimonia Litwinovii*
294. Ботуульхай шагшуурга • *Scholochloa festucacea*
295. Нүцгэн үрт шадалзай • *Rochelialeiocarpa*
296. Каспийн шарбударгана • *Kalidium caspicum*
297. Боргоцойлог шаргас • *Halocnemum atrobilaceum*
298. Алатав шиваантиг • *Pyrethrum alatavicum*
299. Гоё шиваантиг • *Pyrethrum pulchrum*
300. Хангайн шиваантиг • *Pyrethrum changaicum*
301. Саглагар шивэл • *Equisetum ramosissimum*
302. Цоохор шивэл • *Equisetum variegatum*
303. Нэг наст шивэрс • *Lycopodium annotinum*
304. Дагуур шимэрс • *Hedysarum dahuricum*
305. Бөхөгөр шогшрого • *Melica nutans*
306. Бүрсгэр шорно • *Frankenia pulverulenta*
307. Тэнгисийн шүдэлж • *Najas marina*
308. Их шүүдэргэнэ • *Chelidomum majus*
309. Нүцгэн шүхэргэнэ • *Cenolophium denudatum*
310. Монгол шээрэнгэ • *Silene Mongolica*
311. Жинхэнэ эвэр урт • *Carpoceras ceratocarpum*
312. Шивүүрт эмгэншилбэ • *Atraphaxis spinosa*
313. Нягт эмгэншилбэ • *Atraphaxis compacta*
314. Грубовын эрхэнцэг • *Torularia Grubovii*
315. Ганган юлт • *Goniolimon callicomum*
316. Говийн ялгуун цэцэг • *Cleome gobica*
317. Гэрцэгт ягаалзай • *Braya siliquosa*
318. Азийн төлөгч өвс • *Achillea asiatica*
319. Хар хорс • *Aconitum turczaninowii*
320. Элсний цулхир • *Agriophyllum pungens*
321. Шулуун сонгино (гогод) • *Allium linaria*
322. Анхил сонгино (гогод) • *Allium odorum*
323. Шувуун хөл (сарвуун) • *Allium anisopodium*
324. Халиар сонгино • *Allium victorialis*
325. Цагаан шаваг • *Artemisia rutifolia*
326. Хар шаваг (сайхан шаваг) • *Artemisia santolinifolia*
327. Монгол хунчир • *Astragalus mongolicus*
328. Пагдгар бадаан • *Bergenia crassifolia*
329. Илдэн игүүшин • *Cacalia hastate*
330. Жижиг жимст сархи • *Camelina microcarpa*
331. Феддийн аргамжин цэцэг • *Cistanche feddina*
332. Цагаан яргай • *Cornus alba*
333. Час улаан долоогоно • *Crataegus sanguinea*
334. Нангиад зээргэнэ • *Ephedra sinica*
335. Сахлай дигд • *Gentiana barbata*
336. Урал чихэр өвс • *Glycyrrhiza uralensis*
337. Өргөст тошлой • *Grossularia acicularis*
338. Сэрхэн хөхөө цэцэг • *Gymnadenia conopsea*
339. Зайдуу өдлөг нүцэгнүр • *Gymnocarpium remotepinnatum*
340. Хадны нүцэгнүр • *Gymnocarpium robertianum*
341. Сиймхий цэгцүүхэй • *Hypericum perforatum*
342. Шар цахилдаг • *Iris flavissima*
343. Потаниний цахилдаг • *Iris potanini*
344. Алтайн далан хальс • *Lonicera altaica*
345. Өрөл • *Malus baccata*
346. Урт навчит балгана • *Murycaria longifolia*
347. Өргөст ортууз • *Oxytropis aciphylla*
348. Үнэгэн сүүлхэй тарна • *Polygonum alopecuroides*
349. Хурган мэхээр • *Polygonum viviparum*
350. Дэрэвгэр жиргэрүү • *Saposhnikovia divaricata*
351. Байгаль гүүн хөх • *Scutellaria baicalensis*
352. Үлдэн могойн идээ • *Sedum aizoon*
353. Сибирь ерөндгөнө • *Vincetoxicum sibiricum*
354. Эгэл бавран • *Pteridium aquilium*
355. Нарсны төрлийн модны үр • *Pinus*

Тайлбар:

Засгийн газрын 2004 оны 165-р тогтоолоор 318-354 дэх зүйлүүдийг ховор ургамлын жагсаалтад нэмж, Засгийн газрын 2015 оны 410-р тогтоолоор 355 дахь зүйлийг өөрчилсөн).

Хар (Lichenes)

1. Шоландрийн Асахин • *Asahinea schklandero*
2. Барановын бөөнгөнө • *Rhizoplaca baranovii*
137	Нарийн хиазат	<i>Charadrius dubius</i>		0.4	**
138	Зэвэн хиазат	<i>Charadrius leschenaultii</i>		0.4	
139	Монгол хиазат	<i>Charadrius mongolus</i>		0.4	
140	Дорнын хиазат	<i>Charadrius veredus</i>		0.6	
141	Тэнгисийн хиазат	<i>Charadrius alexandrinus</i>		0.4	**
142	Урианхайн цагаан хиазат	<i>Eudromias morinellus</i>		0.4	
143	Хээрийн хавтгалж	<i>Chettusia gregaria</i>		0.8	
144	Умардын хавтгаалж	<i>Vanellus vanellus</i>		0.8	**
145	Саарал зуунхурга	<i>Microsarcops cinereus</i>		1.0	
146	Алаг хайргач	<i>Arenaria interpres</i>		0.6	**
147	Эгэл хилэнжигүүр	<i>Himantopus himantopus</i>		1.0	
148	Алаг ээтэн	<i>Recurvirostra avosetta</i>		1.2	**
149	Сүүлцагаан хөгчүү	<i>Tringa ochropus</i>		0.4	**
150	Шугуйн хөгчүү	<i>Tringa glareola</i>		1.8	**
151	Үхэр хөгчүү	<i>Tringa nebularia</i>		0.8	
152	Улаанхөлт хөгчүү	<i>Tringa totanus</i>		0.6	**
153	Хар хөгчүү	<i>Tringa erythropus</i>		0.6	**
154	Бүрдний хөгчүү	<i>Tringa stagnatilis</i>		0.4	**
155	Буурал хөгчүүхэй	<i>Heteroscelus brevipes</i>		0.6	
156	Цэлдэн хөгчүүхэй	<i>Heteroscelus incana</i>		0.6	
157	Эгэл хайргынхөгчүү	<i>Actitis hypoleucos</i>		0.4	**
158	Матигар хөгчүүлэг	<i>Xenus cinereus</i>		0.4	
159	Нарийн сэлээхэй	<i>Phalaropus lobatus</i>		0.4	

160	Улаан сэлээхэй	<i>Phalaropus fulicarius</i>		0.4	
161	Ноцоо ноололдой	<i>Phylomachus pugnax</i>		0.6	
162	Одой элсэг	<i>Calidris minuta</i>		0.4	
163	Шартүрүүт элсэг	<i>Calidris ruficollis</i>		0.4	**
164	Савар элсэг	<i>Calidris subminuta</i>		0.4	**
165	Темминскийн элсэг	<i>Calidris temminckii</i>		0.4	**
166	Хадуур элсэг	<i>Calidris ferruginea</i>		0.2	**
167	Хар элсэг	<i>Calidris alpina</i>		0.4	
168	Сүүл элсэг	<i>Calidris acuminata</i>		0.4	
169	Гурвалж элсэг	<i>Calidris alba</i>		0.4	
170	Шармаг элсэг	<i>Calidris canutus</i>		0.4	
171	Сямби шалчиг	<i>Limicola falcinellus</i>		0.6	
172	Бичил салалж	<i>Lymnocyptes minimus</i>		0.6	
173	Шөвгөн хараалж	<i>Gallinago gallinago</i>		0.8	**
174	Шугуйн хараалж	<i>Gallinago megala</i>		0.8	
175	Замбын хараалж	<i>Gallinago stenura</i>		0.8	**
176	Өнчин хараалж	<i>Gallinago solitaria</i>		0.8	
177	Буурал хомноот	<i>Scolopax rusticola</i>		1.2	**
178	Бичилхэн тутгалжин	<i>Numenius minutus</i>		1.0	
179	Морин тутгалжин	<i>Numenius arquata</i>		0.8	**
180	Мадагаскар тутгалжин	<i>Numenius madagascariensis</i>		1.0	
181	Бэсрэг тутгалжин	<i>Numenius phaeopus</i>		0.8	
182	Морин цууцал	<i>Limosa limosa</i>		0.8	**
183	Хурган цууцал	<i>Limosa lapponica</i>		0.8	
184	Хараалжин цууцил	<i>Limnodromus scolopaceus</i>		0.8	
185	Азийн цууцил	<i>Limnodromus semipalmatus</i>		3.6	
186	Ухаа хөгт	<i>Glareola maldivarum</i>		0.6	
187	Бэсрэг хайлгана	<i>Stercorarius pomarinus</i>		2.2	
188	Годон хайлгана	<i>Stercorarius parasiticus</i>		0.8	
189	Итэлгэн цахлай	<i>Larus ichthyaetus</i>		11.6	
190	Реликт цахлай	<i>Larus relictus</i>		34.2	
191	Хурган цахлай	<i>Larus minutus</i>		0.8	
192	Хүрэнтолгойт цахлай	<i>Larus ridibundus</i>		0.8	**

193	Бортолгойт цахлай	<i>Larus brunnicephalus</i>		1.0	
194	Шөвгөр цахлай	<i>Larus genei</i>		1.4	
195	Мөнгөлөг цахлай	<i>Larus argentatus</i>		2.4	**
196	Үхэр цахлай	<i>Larus cachinnans</i>		4.0	
197	Мөсний цахлай	<i>Larus hyperboreus</i>		3.8	
198	Харсүүлт цахлай	<i>Larus crassirostris</i>		1.8	
199	Үүлэн цахлай	<i>Larus canus</i>		1.6	
200	Гурванхуруут захлай	<i>Rissa tridactyla</i>		1.4	
201	Хүзүүвчит ягаандай	<i>Rhodostethia rosea</i>		1.2	
202	Хилэн хараалзай	<i>Chlidonias niger</i>		0.4	
203	Буурал хараалзай	<i>Chlidonias leucopterus</i>		0.4	**
204	Цагааншанаа хараалзай	<i>Chlidonias hybridus</i>		0.6	
205	Бахим амуулай	<i>Gelochelidon nilotica</i>		0.8	
206	Морин шунгуулай	<i>Hydroprogne caspia</i>		2.0	
207	Эгэл хараалай	<i>Sterna hirundo</i>		0.6	**
208	Хурган хараалай	<i>Sterna albifrons</i>		0.4	
IV. Тагтаатан					
209	Монгол ногтруу	<i>Syrhaptes paradoxus</i>		0.8	**
210	Ойн тагтаа	<i>Columba palumbus</i>		1.4	
211	Хүнхэл тагтаа	<i>Columba oenas</i>		1.0	
212	Хүрэвтэр тагтаа	<i>Columba eversmanni</i>		1.0	
213	Хөхвөр тагтаа	<i>Columba livia</i>		0.8	**
214	Хадны тагтаа	<i>Columba rupestris</i>		0.8	**
215	Буулгат хүүрзгэнэ	<i>Streptopelia decaocto</i>		0.8	
216	Өрнийн хүүрзгэнэ	<i>Streptopelia turtur</i>		0.8	
217	Дорнын хүүрзгэнэ	<i>Streptopelia orientalis</i>		0.6	**
218	Өөдсөн хүүрзгэнэ	<i>Streptopelia senegalensis</i>		0.8	
219	Эгэл хөхөө	<i>Cuculus canorus</i>		0.4	
220	Ханамал хөхөө	<i>Cuculus saturatus</i>		0.4	
221	Хурган хөхөө	<i>Cuculus poliocephalus</i>		0.4	
222	Жагар хөхөө	<i>Cuculus micropterus</i>		0.4	

223	Цагаан уульж	<i>Nyctea scandiaca</i>		56.0	
224	Эгэл шаршувуу	<i>Bubo bubo</i>		90.8	
225	Соотон гуйванга	<i>Asio otus</i>		10.0	
226	Хулгар гуйванга	<i>Asio flammeus</i>		11.6	
227	Ердийн орволго	<i>Otus scops</i>		3.0	
228	Ойн орволго	<i>Otus sunia</i>		3.0	
229	Савагт ариан	<i>Aegolius funereus</i>		6.4	
230	Хотны бүгээхэй	<i>Athene noctua</i>		5.6	
231	Буслаг сүлиг	<i>Glaucidium passerinum</i>		2.4	
232	Харсуун бэгбаатар	<i>Surnia ulula</i>		10.2	
233	Хув ууль	<i>Strix uralensis</i>		29.6	
234	Угалзан ууль	<i>Strix nebulosa</i>		29.6	
V. Бор шувуутан					
235	Монгол хуланжороо	<i>Podoces hendersoni</i>		26.0	
236	Наран энхэтбялзуухай	<i>Bombycilla japonica</i>		2.0	
237	Наран ажиндар	<i>Megalurus pryori</i>		2.0	
238	Өгөөлэй шулганаа	<i>Saxicola insignis</i>		8.4	
239	Бахимхушуу хурагч	<i>Paradoxornis heudei</i>		6.0	
240	Бургасны ураншувуу	<i>Remiz pendulinus</i>		1.4	
241	Янковскийн хөмрөг	<i>Emberiza jankowskii</i>		2.0	
242	Наран хөмрөг	<i>Emberiza yessoensis</i>		2.2	

Гурав. Загас (мян.төгрөгөөр)

№	Ан амьтны нэр		Соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнах, барих агнуурын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ	Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ
	Монголоор	Англиар		
1	Амарын хилэм	<i>Asipenser schrenckii</i>		
2	Шивэр хилэм	<i>Asipenser baerii baicalensis</i>		
3	Тул	<i>Hucho taimen</i>		
4	Зэвгэ	<i>Brachymystax lenok</i>	***	**
5	Цагаан загас	<i>Coregonus pidschian</i>	***	**
6	Цагаан хадар	<i>Coregonus chadary</i>	***	**
7	Байгалийн омель	<i>Coreginus migratorius</i>	***	**
8	Пельд	<i>Coregonus peled</i>	***	**
9	Монгол хадран	<i>Thymallus brevirostris</i>	***	**

10	Хөвсгөл хадран	<i>Thymallus nigrescens</i>	***	**
11	Сибирь хадран	<i>Thymallus arcticus</i>	***	**
12	Амарын хадран	<i>Thymallus grubii</i>	***	**
13	Цурхай	<i>Esox lucius</i>	***	**
14	Амарын цурхай	<i>Esox reicherti</i>	***	**
15	Улаан нүдэн	<i>Rutilus rutilus</i>	***	**
16	Байгалийн сугас	<i>Leuciscus baicalensis</i>	***	**
17	Зүүнгарын сугас	<i>Leuciscus dzungaricus</i>	***	**
18	Бух сугас	<i>Leuciscus idus</i>	***	**
19	Амарын сугас	<i>Leuciscus waleckii</i>	***	**
20	Алтайн сугас	<i>Oreoleuciscus potanini</i>	***	**
21	Нохой сугас	<i>Oreoleuciscus angusticephalus</i>	***	**
22	Улаан живэрт	<i>Pseudaspius leptcephalus</i>	***	**
23	Үхэрдэй	<i>Tinca tinca</i>		
24	Морин загас	<i>Hemibarbus labeo</i>	***	**
25	Толбот морин загас	<i>Hemibarbus maculatus</i>	***	**
26	Цагаан догтор	<i>Erythroculter erythropterus</i>	***	**
27	Улаан далбаат	<i>Chanodichthys mongolicus</i>	***	**
28	Өлгөр цагаан	<i>Culter alburnus</i>	***	**
29	Алтлаг хэлтэг	<i>Carassius carassius</i>	***	**
30	Мөнгөлөг хэлтэг	<i>Carassius gibelio</i>	***	**
31	Булуу цагаан	<i>Cyprinus carpio</i>	***	**
32	Цулбуурт	<i>Parasilurus asotus</i>	***	**
33	Гутаар	<i>Lota lota</i>	***	**
34	Алгана	<i>Perca fluviatilis</i>	***	**
35	Амарын хөөлөнхэй	<i>Pseudorasbora parva</i>	***	**
36	Зантаахай загас	<i>Mesocottus haitej</i>		

Тайлбар: (*)-Мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнахад төлбөр хураамжаас чөлөөлнө.

(**)-Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын дагуу ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээг тогтооно.

(***)-Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын дагуу үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийн хэмжээг тогтооно.

-Төл амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг тухайн бие гүйцсэн бодьгалийн экологи-эдийн засгийн үнэлгээний 70 хувиар тооцож, тогтооно.

ХОВОР АМЬТНЫ ЖАГСААЛТ

(Монгол, латин нэрээр)

Нэг. Хөхтөн

1. Дорны сармаахай • *Vespertilio superans*
2. Ойн булга • *Martes zibellina*
3. Говийн шилүүс • *Lynx lynx isabellina*
4. Суусар булга • *Martes foina*
5. Эрээн хүрнэ • *Vormela peregusna*
6. Хүрэн баавгай • *Ursus arctos*
7. Хулан адуу • *Equus hemionus hemionus*
8. Зэгсний зэрлэг гахай • *Sus scrofa nigripes*
9. Халиун буга • *Cervus elaphus*
10. Хар сүүлтий • *Gazella subgutturosa*
11. Аргаль хонь • *Ovis ammon*
12. Янгир ямаа • *Capra sibirica*
13. Элсний тажигдаахай • *Sabbingotus kozlovi*
14. Соотон алагдаахай • *Euchoreutes naso*

Хоёр. Шувуу

1. Одой галуу • *Anser erythropus*
2. Байгалийн нугас • *Anas formosa*
3. Ундар шумбуур • *Aythya nyroca*
4. Хан бүргэд • *Aquila heliaca*
5. Ооч ёл • *Gypaetus barbatus*
6. Азийн цууцил • *Limnodromus semipalmotus*
7. Монгол хулан жороо • *Podoces hemdersoni*
8. Хонин тоодог • *Otus tarda*
9. Усны бух • *Botaurus stellaris*
10. Бичил одой бух • *Ixobrychus minutus*
11. Зээрд дэглий • *Ardea purpurea*
12. Манхин галуу • *Anser albifrons*
13. Гээзэгт нугас • *Anas falcata*
14. Хуруут хун • *Cygnus olor*
15. Хархираа тогоруу • *Grus grus*
16. Цагаан сүүлт нөмрөг • *Haliaeetus albicilla*
17. Алтайн хойлог • *Tetraogallus altaicus*
18. Зэрлэг гургуул • *Phasianus colchicus*
19. Загийн бор • *Passer ammodendri*
20. Ойн шийхнүүхэй • *Anthus trivialis*
21. Шагшуургын шатан сүүлт • *Locustella luscinioides*
22. Өгөөлэй шулганаа • *Saxicola insignis*
23. Наран хөмрөг • *Emberiza yessoensis*
24. Шар элэгт хөмрөг • *Emberiza aureola*

Гурав. Мөлхөгч

1. Говийн нүцгэн хуруут гүрвэл • *Cyrtapodion elongatus*
2. Тойрмын хонин гүрвэл • *Phrynosephalus helioscopus*
3. Толбот могой гүрвэл • *Eremias arguta potanini*
4. Тэмээн сүүл могой • *Eryx tataricus*
5. Нарийн могой • *Coluber spinalis*

6. Эгэл загалмайт могой • *Vipera berus*

Дөрөв. Хоёр нутагтан

1. Шивэр гүлмэр • *Salamandrella keyserlingii*
2. Ногоон бах • *Bufo danatensis*
3. Модны мэлхий • *Hyla japonica*
4. Дорнодын мэлхий • *Rana chensinensis*

Тав. Загас

1. Тул • *Hucho taimen*

Зургаа. Дугуй амтан

1. Номхон далайн могор • *Lampetra japonica*

Долоо. Шавьж

1. Төст царцаа • *Eclipophleps similis*
2. Эмэлжановын голио • *Eulithoxenus emeljanovi*
3. Дамнуурга цэнхэр соно • *Aeshna juncea mongolica*
4. Шүтээн цох • *Scarabaeus typhoon*
5. Дорнын заар эвэрт цох • *Aromia moschata orientalis*
6. Аполлон эрвээхэй • *Parnassius apollo*
7. Эверсманн дэвүүр • *Parnassius evermanni*
8. Штуббендорфын дэвүүр • *Parnassius stubbendorfi*
9. Фэб дэвүүр • *Parnassius phoebus*
10. Зүүн сибирийн дэвүүр • *Parnassius tenedius*
11. Махаон дэвүүр • *Parnassius mashaon*
12. Одон бүгэг эрвээхэй • *Macroglossum stellatarum*
13. Инжирийн шумбуур • *Deilephila elpenor*
14. Голт борын шумбуур • *Sphinx ligustri*
15. Бэр цэцэгч шумбуур • *Hemaris tityus*
16. Хөвдний үхэр хэдгэнэ • *Bombus muscorum*
17. Модестус үхэр хэдгэнэ • *Bombus modestus*
18. Спорадикус үхэр хэдгэнэ • *Bombus sporadicus*
19. Байгалийн үхэр хэдгэнэ • *Bombus subbaicalensis*
20. Ихэр ирлэг ялаа • *Satanas gigas*

Найм. Хавч хэлбэртэн

1. Хар мөрний хавч • *Leander modestus*
2. Голын хавч • *Cambaroides dauricus*

Ес. Зөөлөн биетэн

1. Дагуурын сувдан хясаа • *Dahurinaia dahurica*
2. Дэлт танан хясаа • *Cristaria plicata*
3. Сэлэнгийн танан хясаа • *Anodonta sedakovi*
4. Монгол танан хясаа • *Middendorffinaia mongolica*

ЗАСГИЙН ГАЗРЫН 2013 ОНЫ 93 ДУГААР
ТОГТООЛЫН 2 ДУГААР ХАВСРАЛТ

ХОВОР АМЬТАН АГНАХ, БАРИХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага (цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх) нь халдварт өвчний голомтыг тогтоох зорилгоор ховор амьтныг агнах, барих зөвшөөрлийг эрдэм шинжилгээний байгууллагын гаргасан дүгнэлтийг үндэслэн албан бичгээр, бусад тохиолдолд тусгай зөвшөөрлийн маягтаар олгоно.

1.3. Тусгай зөвшөөрлийн маягт, спорт агнуур болон олзворын агнуурын чиглэлээр амьтан агнах, барих гэрээний үлгэрчилсэн загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Хоёр. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дордурдсанаар ойлгоно

2.1. “Эрдэм, шинжилгээ” гэдэгт амьтны биеийн бүтцийг судлах, эд, эрхтэнд нь гэмтэл учруулалгүйгээр судалгааны багаж, тэмдэг зүүх, хэмжилт хийх, эд эрхтэнээс сорьц авахыг;

2.2. “Соёл, урлагийн зориулалт” гэдэгт үндэстэн, ястны уламжлалт зан үйл, музейн үзмэр, урлагийн бүтээл, амьтны хүрээлэн, соёлын үзвэрт ашиглахыг;

2.3. “Эмчилгээний зориулалт” гэдэгт эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийн дагуу эмийн үйлдвэрлэл, эмчилгээний зорилгоор гаршуулан үржүүлэх замаар ашиглахыг;

2.4. “Агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч” гэж тухайн агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр сумын Засаг дарга, аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагатай Амьтны тухай хуулийн 22.5-д зааснаар эхний ээлжинд нэг жилийн хугацаатайгаар, цаашид арван жилийн давтамжтайгаар 30 хүртэл жилийн хугацаатай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;

2.5. “Зуучлагч байгууллага” гэдэгт спорт агнуур болон олзворын чиглэлийн агнуурыг

анчдад зуучлах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эрхэлдэг хуулийн этгээдийг.

Гурав. Судалгаа шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаарагнах, барих тусгай зөвшөөрөл олгох

3.1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан ан амьтны чиглэлийн мэргэжлийн байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллага нь ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнах, барих хүсэлтийг төрийн захиргааны төв байгууллагад бичгээр гаргана.

3.2. Ховор амьтныг судалгаа шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнах, барих хүсэлтэд амьтны зүйлийн нэр, тоо толгой, үндэслэл, агнах болон барих арга зүй, хугацаа, аймаг, сум, агнуурын бүс нутгийн нэрийг тодорхой заана.

3.3. Улсын тусгай хамгаалалттай газарт ховор амьтан барих тохиолдолд энэхүү журмын 3.2-т зааснаас гадна тухайн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаатай байгуулсан гэрээг хавсаргана.

3.4. Төрийн захиргааны төв байгууллага нь зөвшөөрлийг олгохдоо холбогдох төрийн болон судалгаа, шинжилгээ, эрүүл мэнд, мал эмнэлэг, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлт гаргуулж болно.

Дөрөв. Спорт агнуур болон олзворын чиглэлээр ан амьтанагнах тусгай зөвшөөрөл олгох

4.1. Тухайн агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч дараа онд тусгай зөвшөөрлөөр агнах амьтны тоо хэмжээний саналыг батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөө, хяналтын үнэлгээг үндэслэн жил бүрийн 10 дугаар сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ. (Энэ заалтыг ЗГ-ын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөн найруулсан)

4.2. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага нь энэхүү журмын 4.1-д заасан хүсэлт, аймгийн ан агнуурын

менежментийн төлөвлөгөөнд үндэслэн дараа онд тусгай зөвшөөрлөөр агнах амьтны тоо хэмжээний саналыг аймгийн хэмжээнд нэгтгэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ. *(Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөлт орсон)*

4.3. Төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай гэж үзвэл ан амьтны тоо толгойн хяналтын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар тухайн агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагчийн хөрөнгөөр хийлгэж болно.

4.4. Төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагын санал, аймгийн болон агнуурын бүс нутгийн батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөө, энэхүү журмын 4.3-т заасан үнэлгээний дүгнэлтийг харгалзаж дараа онд тусгай зориулалтаар спорт болон олзворын чиглэлээр агнах, барих амьтны тоо хэмжээний саналыг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлнэ. *(Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөлт орсон)*

4.5. Тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг Засгийн газар баталснаас хойш ажлын 14 хоногт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараа онд тусгай зөвшөөрлөөр агнах, барих амьтны тоо толгойг агнуурын бүс нутгаар хуваарилан батална.

4.6. Энэхүү журмын 2.4-т заасан байгууллага нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, зуучлагч байгууллагатай гурвалсан гэрээ байгуулж, заасан хуваарийн дагуу ан амьтан агнах ажлыг зохион байгуулна. *(Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөлт орсон)*

4.7. Тухайн агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч байгууллага нь гадаадын анчдад зуучлах үүргийг өөрөө хариуцан гүйцэтгэж байгаа тохиолдолд зөвхөн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулж болно. *(Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөлт орсон)*

4.8. Тухайн агнуурын бүс нутаг нь орон нутгийн тусгай хамгаалалттай газарт бүртгэгдсэн тохиолдолд энэхүү журмын 4.6, 4.7-д заасан гэрээг аймгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулна. *(Энэ заалтыг ЗГ-ын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөн найруулсан)*

4.9. Төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудлыг хариуцсан нэгж энэхүү журмын 4.6, 4.7-д заасан гэрээний эх хувь, агнуулах ангийн

төлбөр, хураамжийг төлсөн санхүүгийн баримтыг үндэслэн тусгай зөвшөөрөл олгоно.

Тав. Спорт агнуур болон олзворын чиглэлээр ан амьтанбарих тусгай зөвшөөрөл олгох

5.1. Амьтны тухай хуулийн 22.3-т заасны дагуу сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрийн нутаг дэвсгэртээ нарийвчилсан агнуур зохион байгуулалтад үндэслэн спорт агнуурын зорилгоор загас, олзворын чиглэлээр ховор шувуу барих газрыг тогтооно. Загасчлах газар нь агнуурын ховор загасны амьдрах орчинтой давхардах эсэхийг шийдвэрт тодорхой тусгана.

5.2. Агнуурын ховор загасны амьдрах орчинд зөвхөн Амьтны тухай хуулийн 21.1.6-д заасан аргаар загасчилна.

5.3. Төрийн захиргааны төв байгууллага агнуурын ховор загас, шувуу барих тусгай зөвшөөрлийг тухайн сум, дүүргийн Засаг дарга, зуучлагч байгууллагатай хийсэн гэрээ, барих ангийн төлбөр, хураамжийг төлсөн баримтыг үндэслэн олгоно *(Энэ заалтад Засгийн газрын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөлт орсон)*.

5.4. Агнуурын ховор загас барих нэг удаагийн тусгай зөвшөөрлийн хугацаа 14 хоног хүртэл байна. Агнуурын ховор загас барих тусгай зөвшөөрлийн төлбөрийг хүн/хоногоор тооцно.

Зургаа. Агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагчбайгууллагад тавигдах шалгуур үзүүлэлт

6.1. Энэхүү журмын 2.4-т заасан байгууллага нь хариуцаж байгаа агнуурын бүс нутгийн нарийвчилсан агнуур зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.

6.2. Ан агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймаг, сумын Засаг даргатай хамтран дүгнэж, тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад жил бүр хүлээлгэн өгнө.

6.3. Зуучлагч байгууллагатай хийсэн ховор амьтан агнах, барих ажил үйлчилгээний гэрээний биелэлтийг хангана.

6.4. Агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч байгууллага нь энэхүү журмын 4.6, 4.7-д заасан ховор амьтан агнах, барих гэрээний биелэлтийн тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад жил бүрийн 11 дүгээр сарын 15-наас өмнө хүргүүлнэ.

6.5. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу тусгай

зориулалтаар агнаж, барьсан ан амьтны төлбөрийн орлогын 50-иас доошгүй хувийг агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулна.

6.6. Агнуурын бүс нутагт тусгай зөвшөөрлөөр агнаж, барьсан ан амьтны төлбөрийн 50-иас доошгүй хувийг зөвхөн тухайн агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулна.

Долоо. Зуучлагч байгууллагад тавих шалгуур үзүүлэлт (Энэ хэсгийг Засгийн газрын 2017 оны 9-р тогтоолоор нэмсэн)

7.1. Зуучлагч байгууллага нь энэхүү журмын 4.6, 4.7-д заасны дагуу ховор амьтан агнах, барих ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

7.2. Зуучлагч байгууллага гадаадын болон дотоодын анчдад зуучлан ан хийлгэх мэргэжлийн боловсон хүчинтэй байна.

7.3. Зуучлагч байгууллага спорт агнуур болон олзворын ангийн чиглэлээр амьтан агнах, барихдаа Амьтны тухай хуульд хориглохоор заасан арга, зэвсэг хэрэгсэл хэрэглэхгүй, хориглосон үйл ажиллагааг явуулахгүй.

7.4. Ховор амьтан агнах, барих ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээний биелэлтийн тайланг

жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Найм. Бусад (Энэ хэсгийг Засгийн газрын 2017 оны 9-р тогтоолоор нэмсэн)

8.1. Засгийн газрын болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн дагуу тухайн жилд гадаадын иргэд (анчид)-д зуучлан агнуулах хуваарьт заасан ангаас угалз, тэхийг бүрэн агнуулж чадаагүй, эсхүл нийт ангийнхаа 75-аас доошгүй хувийг борлуулж чадаагүй зуучлагч байгууллагын дараа жилийн хуваарийг хасч тогтооно.

8.2. Зуучлагч байгууллага нь тухайн жилд гадаадын иргэд (анчид)-ээр тусгай зориулалтын анг агнуулахдаа хууль тогтоомжид хориглосон арга, хэрэгсэл ашигласан, эсхүл агнуурын бүс нутгийн хилийн заагаас гадна агнуулсан бол түүний агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын эрхийг цуцлах арга хэмжээг авна.

8.3. Иргэн, хуулийн этгээд нь энэ журам болон “Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам”-ыг зөрчсөн тохиолдолд тэдгээрийн мэргэжлийн байгууллагын эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.





**МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙДЫН ТУШААЛ**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД, ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХАМТАРСАН 2008 ОНЫ 120/51 ДҮГЭЭР
ТУШААЛЫН ХАВСРАЛТ

АМЬТНЫГ ШИНЖЛЭХ УХААНЫ ЗОРИУЛАЛТААР БАРЬЖ, ТЭМДЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол улсад амьтныг шинжлэх ухааны зориулалтаар барьж, тэмдэглэн судлахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Журмын “тэмдэглэх” гэдэгт амьтанд бүх төрлийн бөгж, ээмэг, хүзүүвч, микрочип (идэвхигүй бичил дамжуулагч), радио, акустик ба сансарын долгион дамжуулагч багаж, тусгай будагч бодис зэрэг бусад тэмдэг зүүх, тэмдэглэгээ хийх үйл ажиллагааг ойлгоно.

1.3. Журмын “шинжлэх ухааны зориулалтаар” гэдэгт гадаад, дотоодын мэргэжлийн байгууллага, баг, эрдэмтэн, судлаачдын зүгээс амьтны биологи, экологийн судалгаа, хяналт шинжилгээ хийх, өвчин эмгэгийн тархалтыг хянах, популяцийн хөдлөл, нүүдэл, шилжилт хөдөлгөөн, зан төрхийг судлах, эзэмшил нутгийг тодорхойлох, тоо толгойн үнэлгээ хийх зэрэг судалгааны ажил хамаарна.

1.4. Аж ахуйн зорилгоор тэжээвэр амьтан барих тэмдэглэхэд энэхүү журам хамаарахгүй.

1.5. Тив, бүс нутгийн хэмжээнд хэрэглэдэг, хүлээн зөвшөөрсөн тэмдгийг Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр хэрэглэж болно.

Хоёр. Оролцогч талуудын хүлээх эрх, үүрэг

2.1. Оролцогч талууд гэдэгт Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага, Биологийн хүрээлэн, хэрэгжүүлэгч этгээдүүд гэсэн 3 субъект хамрагдана.

2.2. Хэрэгжүүлэгч этгээд гэдэгт амьтан барьж, тэмдэглэх хүсэлт гаргаж, зөвшөөрөл авсан гадаад, дотоодын мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, судлаач байж болно.

2.3. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.3.1. Биологийн хүрээлэнгийн саналыг үндэслэн хэрэгжүүлэгч этгээдэд амьтан барьж, тэмдэглэх зөвшөөрөл олгох, эсвэл олгохоос татгалзах;

2.3.2. Шаардлагатай бол Биологийн хүрээлэн болон хэрэгжүүлэгч этгээдээс нэмэлт мэдээлэл гаргаж өгөхийг шаардах;

2.3.3. Энэ журмын 3-р зүйлд заасан амьтныг барьж, тэмдэглэх зааврыг батлаж, мөрдүүлэх;

2.4. Биологийн хүрээлэн нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.4.1. Амьтныг барьж, тэмдэглэх тухай хэрэгжүүлэгч этгээдээс тавьсан хүсэлтийг хүлээн авч, судлаж, хянаж нягтлаад ажлын 14 хоногт багтаан санал өгөх;

2.4.2. Амьтныг барьж тэмдэглэх талаар журмын 3 дугаар зүйлд заасан зааврыг боловсруулж, батлуулах;

2.4.3. Энэ журмын 2.3.1-д заасны дагуу зөвшөөрөл авсан хэрэгжүүлэгч этгээдтэй гэрээ байгуулж амьтны тэмдэг олгож зарцуулалтанд хяналт тавих;

2.4.4. Амьтныг барьж, тэмдэглэхтэй холбогдсон мэдээллийн санг энэхүү журмын 4.1-д заасны дагуу байгуулах, хөтлөх, нээлттэй, хүртээмжтэй байлгах;

2.5. Хэрэгжүүлэгч этгээд нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.5.1. Ямар амьтныг, хэзээ, хаанаас, хэдийг, ямар арга зүйгээр барих, уг амьтнаас ямар төрлийн, хэдий хэмжээний дээж авах, ямар тэмдэг тавих, ажлын үр дүнг хэрхэн тайлагнах зэргийг дэлгэрэнгүй дурдсан төсөл, хүсэлтээ Биологийн хүрээлэнд хүргүүлэх;

2.5.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн нөхцөлд 2.4.3-д заасан гэрээ байгуулах;

2.5.3. Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрөлд дурдагдсан тоо хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр амьтныг барьж, тэмдэглэх;

2.5.4. Амьтныг барьж, тэмдэглэх ажлыг гүйцэтгэхдээ журмын 3-д заасан зааврыг мөрдөх;

2.5.5. Амьтныг барьж, тэмдэглэхтэй холбогдон бий болсон мэдээллийг журмын 4.1-д заасны дагуу мэдээллийн санд оруулах, шаардлагатай тохиолдолд оролцогч талуудтай мэдээллээ солилцох;

Гурав. Амьтныг барьж, тэмдэглэх заавар

3.1. Амьтныг барьж, тэмдэглэх заавар нь

амьтантай энэрэнгүй харьцах, түүнд гэмтэл, үхэл учруулахгүйгээр барьж, тэмдэглэх, буцаан тавих, тэмдэглэгдсэн амьтнаас холбогдох мэдээллийг авахтай холбогдсон үйл ажиллагааны болон менежментийн арга хэмжээг тусгасан баримт бичиг юм.

3.2. Амьтныг барьж, тэмдэглэх заавар нь дараах агуулгыг багтаасан байна. Үүнд:

3.2.1. амьтан барих зөвшөөрөгдсөн болон хориотой арга, хэрэглэх бодис, ан амьтантай хэрхэн харьцах, зүүх эзэмж, бөгж, хүзүүвч зэргийг тодорхойлох;

3.2.2. Биологийн хүрээлэн, хэрэгжүүлэгч этгээдийн хооронд байгуулах гэрээний загвар, ажлын үр дүнг хэрхэн тайлагнах;

3.2.3. Амьтанд хэрэглэх тэмдэг дээр ямар мэдээлэл оруулж болох зэргийг бүрэн тусгасан байна.

Дөрөв. Мэдээллийн сан

4.1. Амьтныг барьж, тэмдэглэхтэй холбогдон бий болсон мэдээллийн санд дараах мэдээлэл багтсан байна. Үүнд:

4.1.1 Амьтанд зүүсэн тэмдэгний төрөл, дугаар, тэмдэглээний хэлбэр;

4.1.2. Тэмдэглэсэн амьтны зүйлийн нэр,

нас, хүйс, морфологийн болон бусад хэмжилтийн үзүүлэлт;

4.1.3. Амьтныг барьж, тэмдэглэсэн огноо, цаг, минут, газар нутгийн нэр, солбилцол, өндөршил, ландшафтын төрөл;

4.1.4. Тэмдэглэсэн амьтны бүртгэгдсэн дохиолол, түүний давтамж, байршил, шилжилт хөдөлгөөн, нүүдлийн зам, биологи, экологийн холбогдолтой мэдээлэл;

4.1.5. Тэмдэг зүүсэн, олсон, зураг авсан хүний талаарх мэдээлэл зэрэг болно.

4.2. Мэдээллийн сан гадаад, дотоодын мэргэжлийн баг, байгууллага, эрдэмтэн, судлаачдад нээлттэй, хүртээмжтэй байна.

Тав. Ан амьтанд зүүх тэмдгийг өмчлөх

5.1. Амьтанд зүүх тэмдгийг өмчлөх асуудлыг Биологийн хүрээлэн, хэрэгжүүлэгч этгээдийн хооронд байгуулсан гэрээг үндэслэн Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагашийдвэрлэнэ.

5.2. Улс, орон нутгийн төсөв, Байгаль хамгаалах сан, олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгээр хийлгэсэн тэмдэг төрийн өмч байна.



АМЬТНЫГ АМЬДААР НЬ БОЛОН АМЬТНЫ ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, СУДАЛГААНЫ АЖЛЫН СОРЬЦ ДЭЭЖИЙГ ГАДААД УЛСАД ГАРГАХ, ГАДААД УЛСААС ОРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нэн ховор амьтныг амьдаар болон Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хавсралтад бүртгэгдсэн амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйлээс бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Амьтны гаралтай түүхий эд зүйл гэдэгт Амьтны тухай хуулийн 4.1.20 дахь заалтад тусгасанг нийцүүлэн ойлгоно.

1.3. Энэхүү журмаар олгогдсон төрийн захиргааны төв байгууллагын эрх үүргийг гэрээгээр мэргэжлийн байгууллагын холбоо. судалгаа шинжилгээний байгууллагад шилжүүлж болно.

1.4. Энэхүү журмын 1.3-т заасны дагуу эрх шилжүүлэх гэрээ хийгдсэн тохиолдолд журмын 2.2, 2.4, 3.1, 3.4, 3.5-д тусгагдсан төрийн захиргааны төв байгууллагын эрхийг эрх шилжүүлэн авсан байгууллага хариуцна

Хоёр. Амьтныг амьдаар нь болон амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах

2.1. Зөвхөн мэргэжлийн болон судалгаа шинжилгээний байгууллага ховор болон элбэг амьтныг амьдаар нь гадаад улсаас оруулах, гадаад улсад гаргах үйл ажиллагааг зохион байгуулна.

2.2. Мэргэжлийн болон судалгаа ииинжилгээний байгууллага нь амьтныг сэргээн нутагшуулах, хувийн цуглуулгын сан хөмрөг бүрдүүлэх, баяжуулах, соёл урлаг, зоопарк, ашигтай шинж чанарыг ашиглах, судалгаа шинжилгээний зорилгоор гадаад улсаас оруулах, гадаад улсад гаргахдаа төрийн захиргааны төв байгууллагад албан ёсоор хүсэлтээ гаргана.

2.3. Хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг хамт бүрдүүлнэ. Үүнд:

2.3.1. Мэргэжлийн байгууллагын гэрчилгээ, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний

хуулбар;

2.3.2. Амьтан барих зөвшөөрөл;

2.3.3. Эзэмшлийн амьтан бол гарал үүслийн тодорхойлолт, зүүлт;

2.3.4. Тээвэрлэх, амьтдыг түр байршуулах сав, технологийг тусгасан аргачлал,

2.3.5. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

2.3.6. Зөвшөөрлийн гэрчилгээний үнэ төлсөн тухай баримт,

2.4. Амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах, дамжуулан өнгөрүүлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь төрийн захиргааны төв байгууллагад албан ёсоор хүсэлтээ гаргана.

2.5. Хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийн холбогдох хэсгийг хамт бүрдүүлнэ. Үүнд:

2.5.1. Иргэний үнэмлэх, аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.

2.5.2. Соёл урлаг, судалгаа шинжилгээний зориулалтаар амьтан агнах, барих зөвшөөрлийн хуулбар;

2.5.3. Үйлдвэрлэлийн зориулалтаар агнаж, барих гэрээний хуулбар;

2.5.4. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, зүйлийн гарал үүслийн тодорхойлолт, зүүлт,

2.5.5. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах талаар хүлээн авагч болон нийлүүлэгч талтай байгуулсан гэрээний хувь;

2.5.6. Амьтны түүхий эдийг худалдан авсан бол төлбөрийн баримт, худалдагч талын тодорхойлолт;

2.5.7. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах талаар хүлээн авагч болон нийлүүлэгч талтай байгуулсан гэрээний хувь;

2.5.8. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

2.5.9. Зөвшөөрлийн гэрчилгээний үнэ төлсөн тухай баримт,

2.6. Захиргааны зөрчлийн улмаас хураагдаж, улсын орлого болгосон амьтны гаралтай түүхий эдийг гадаадад гаргах, гадаадаас оруулах хүсэлт гаргах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ журмын 2.5.1, 2.5.3, 2.5.4, 2.5.7, 2.5.8, 2.5.9-д зааснаас гадна дараах баримт бичгийг нэмж бүрдүүлнэ. Үүнд:

2.6.1. Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийн тавьсан акт, ногдуулсан торгууль шийтгэврийн хуудас, түүнийг барагдуулсан тухай баримт бичиг;

2.6.2. “Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах нийтлэг журам”-д заасны дагуу тухайн сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн шийдвэр;

2.6.3. Улсын орлого болсон амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад худалдан борлуулах тухай Засаг даргын албан тоот, эсвэл захирамж.

2.6.4. Улсын орлого болсон амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдан авсан төлбөр төлсөн баримт.

Гурав. Амьтныг амьдаар нь болон амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах зөвшөөрөл олгох

3.1. Амьтанг амьдаар болон амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах иргэн, аж ахуйн нэгж, мэргэжлийн болон судалгааны байгууллагын хүсэлтийг хүлээн авсан албан тушаалтан ажлын 10 хоногт баггаан нягтлан үзэж, зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж, шийдвэрлүүлнэ.

3.2. Зөвшөөрлийг тусгай хэвлэмэл хуудсаар олгоно.

3.3. Зөвшөөрлийг нэг удаа олгох ба зөвшөөрлийн хүчинтэй хугацаа олгосон өдрөөс

хойш 60 хүртэл хоног байна.

3.4. Хүндэтгэх шалтгааны улмаас зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах зөвшөөрлийг ашиглаж чадахгүй тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын албан хүсэлт, гаалийн удирдах төв байгууллагын лавлагааны хамт зөвшөөрлийн хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3.5. Иргэн аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт, гаалийн удирдах төв байгууллагын лавлагаа, хүндэтгэх шалтгааныг нягтлан үзсэний үндсэн дээр зөвшөөрөл олгосон албан тушаалтан зөвшөөрлийн хугацааг 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

3.6. Зөвшөөрөлд заасан хэмжээгээр амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулахгүй тохиолдолд өмнөх зөвшөөрөл дээр гаалийн байгууллагын тэмдэглэгээг зайлшгүй хийлгэсэн байна.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйлийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, хууль бусаар гаргахыг завдсан, хууль бусаар гаргасан зэрэг үйлдэл нь мэргэжлийн хяналт, хил, гааль, цагдаагийн байгууллагаар албан ёсоор нотлогдсон тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйлийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах зөвшөөрөл олгохгүй ба өмнө олгосон зөвшөөрлийг хүчингүйд тооцно.

4.2. Гурав буюу түүнээс дээш амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах бол тэдгээрийн жагсаалтыг хавсралт байдлаар зөвшөөрөлд хавсаргана.



АН АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙН ГАРАЛ ҮҮСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ан агнах, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, тээвэрлэх үйл ажиллагаанд төв болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас хяналт тавих, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулахад оршино.

1.2. Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолт (цаашид «тодорхойлолт» гэх) нь ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг нийслэл, өөр аймаг, сум тэдгээрийн хооронд тээвэрлэх, худалдахад зохих журмын дагуу агнасан болохыг гэрчилсэн баримт болно.

1.3. Тодорхойлолтыг тухайн жилд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас баталсан ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнах агнуурын амьтны нэр, тоо хэмжээний жагсаалтад орсон амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдэд ан агнах эрхийн бичиг, гэрээг үндэслэн олгоно.

1.4. “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц”-ийн I, II дугаар хавсралтад бүртгэгдсэн ан амьтан болон Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.6-д заасан нэн ховор, ховор ан амьтан агнахад олгох зөвшөөрлийг тодорхойлолтын адил үзнэ.

1.5. Судалгаа, шинжилгээний зориулалтаар ан амьтан агнахад олгох зөвшөөрлийг тодорхойлолтын адил үзнэ.

Хоёр. Тодорхойлолтын төрөл, түүнийг олгох

2.1. Тухайн сумын улсын байцаагч ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн тодорхойлолтыг олгохдоо тухайн сумын Засаг даргын Тамгын газраас олгосон ахуйн зориулалтаар ан агнах эрхийн бичиг болон үйлдвэрлэлийн зориулалтаар ан агнах гэрээг үндэслэнэ.

2.2. Тодорхойлолт нь агнасан ангийн түүхий эдээс хамаарч гарал үүслийн бичиг, зүүлт гэсэн хоёр төрөлтэй байна.

2.3. Тодорхойлолт нь аймаг, нийслэлийн нэрийг илэрхийлсэн хэвлэмэл сери, он, дугаартай

байна. Сери нь аймаг тус бүрийн нэрийн хоёр үсгийг оролцуулсан байна.

2.4. Гарал үүслийн бичгийг загас болон ангийн мах зэрэг ан амьтны гаралтай түргэн муудах түүхий эдэд олгох бөгөөд хүчинтэй байх дээд хугацаа нь 6 сараас илүүгүй байна.

2.5. Зүүлтийг ангийн арьс, гавлын яс, араг яс, эвэр, соёо, хошуу, чихмэлд олгох бөгөөд хугацаагүй байна.

2.6. Тодорхойлолтыг засварлах, хувилж олшруулахыг хориглоно.

2.7. Тодорхойлолтыг зөвхөн ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнасан ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдэд олгоно.

2.8. Журмын 1 дүгээр зүйлийн 1.3, 1.4, 1.5, 2 дугаар зүйлийн 2.1-д заасан тодорхойлолтгүй ан амьтны гаралтай түүхий эдийн зүйлийг Амьтны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу худалдах, худалдан авахыг хориглоно.

Гурав. Тодорхойлолтыг хэвлүүлж тараах, хяналт тавих

3.1. Тодорхойлолтыг нэгдсэн журмаар хэвлүүлэх, орон нутагт хүргүүлэх, бүртгэх зэрэг ажлыг тус яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар хариуцан зохион байгуулна.

3.2. Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар нь тухайн аймаг, нийслэлийн жилд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнах агнуурын амьтны дээд хязгаарыг үндэслэн аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 1 дүгээр улирлын эхний 10 хоногт багтаан хүргүүлнэ. Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар тодорхойлолтыг хүлээн авснаас хойш 7 хоногт багтаан сумдад хүргэнэ.

3.3. Сум, дүүрэгт хүргүүлсэн тодорхойлолтын тоо хэмжээ нь Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар, орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, гарсан хэрэг зөрчлийг илрүүлэх, арилгуулах, таслан зогсоох зэрэг арга хэмжээ

авах эрх зүйн үндэслэл болно.

3.4. Тодорхойлолтын хүчинтэй эсэхэд байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, цагдаагийн байгууллагын ажилтнууд хяналт тавина.

3.5. Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь өөрийн нутагт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгосон тодорхойлолтыг хянаж бүртгэсэн мэдээ, тайланг тухайн оны 12 дугаар сарын 15-ны дотор тус яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газарт хүргүүлнэ.

3.6. Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн

удирдлагын газар нь тодорхойлолтын тараалтын (борлуулалтын) тайланг дараа оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн дотор гаргаж, санхүүгийн тайлан балансад тусгана.

3.7. Амьтны тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гарсан хууль тогтоомж, бусад актын хэрэгжилт болон тодорхойлолтын хэрэгжилтийг аймаг, нийслэлээс ирсэн тайлангийн нэгдсэн дүнг, газар дээр нь очиж тодотгон хяналт шинжилгээ, үнэлгээ хийж жил бүрийн 2 дугаар улиралд Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулна.



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
2017 А/75 ДУГААР ТУШААЛЫН 2 ДУГААР ХАВСРАЛТ

**АН АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙН
ГАРАЛ ҮҮСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ЗАГВАР**

Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолт нь гарал үүслийн бичиг эсхүл зүүлт хэлбэрээр байна.

ГАРАЛ ҮҮСЛИЙН БИЧИГ

Сери.....

Дугаар

Аймаг.....

Сум.....

Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бэлтгэгчийн нэр, хаяг

Ан амьтны тоо, хэмжээ.....

Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бэлтгэх эрхийн бичиг эсхүл гэрээний дугаар

Түүхий эдийн нэр,

Төрөл:

Олгосон он сар өдөр

Хүчинтэй хугацаа сар

Олгосон (тэмдэг)

(Гарал үүслийн бичиг олгосон улсын байцаагчийн овог нэр, тэмдэг, гарын үсэг)

Зүүлт

Зүүлтийг ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолтын адил үзнэ.

Зүүлт нь цоожлогддог, гадны нөлөөнд тэсвэртэй материалаар хийгдэх ба зарим жил өнгөөр ялгаатай хэвлүүлж болно.

"CONVENTION ON INTERNATIONAL TRADE IN ENDANGERED SPECIES OF WILD FAUNA AND FLORA"-ийн ЗӨВШӨӨРЛИЙН БИЧГИЙН ЗАГВАР



**CONVENTION ON
INTERNATIONAL TRADE IN
ENDANGERED SPECIES OF
WILD FAUNA AND FLORA**


**ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН АЙМГИЙН
ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН
ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦИ**

PERMIT / CERTIFICATE №

EXPORT
 RE-EXPORT
 IMPORT
 OTHER

Original

2. Valid until
Хүчинтэй байх хугацаа

<p>3. Importer (name and address) Импортлогчийн нэр, хаяг</p>		<p>4. Exporter (name and address, country) Экспортлогчийн нэр, хаяг, улсын нэр</p>								
<p>3a. Country of importer Импортлогч улсын нэр</p>		<p>Signature of the applicant Хүсэлт тавигчийн гарын үсэг</p>								
<p>5. Special conditions Тусгай нөхцөл</p> <p><small>For live animals, this permit or certificate is only valid if the transport conditions conform to the Guidelines for Transport of Live Animals or, in the case of air transport, to the IATA Live Animals Regulations. Амьд амьтныг агаараар тээвэрлэхэд олон улсын агаараар амьд амьтан тээвэрлэх журмын дагуу, бусад тохиолдолд амьд амьтныг тээвэрлэх тусгай зааврын нөхцлийг хангасан тохиолдолд зөвшөөрөл олгоно.</small></p>		<p>6. Name, address, national seal/stamp and country of Management Authority</p> <div style="text-align: center;">  <p>MINISTRY OF ENVIRONMENT AND TOURISM Government Building #2 United Nations Street 5/2, Ulaanbaatar-15160, MONGOLIA Tel: 976-51-261726 Fax: 976-11-321401 E-mail: mne@mongol.net</p> </div>								
<p>5a. Purpose of the transaction (see reverse) Худалдааны зорилго</p>		<p>5b. Security stamp № Маркны дугаар</p>								
<p>7/8. SCIENTIFIC NAME (genus and species) AND COMMON NAME OF ANIMAL OR PLANT Шинжлэх ухаан (төрөл зүйл)-ын болон ерөнхий нэр</p>	<p>9. Description of specimens, including identifying marks or numbers (age/sex if live) Зүйлийн биетийн тодорхойлолт, таних шинж, дугаар (хэрэв амьд бол нас/хүйс)</p>	<p>10. Appendix No and source Хавсралтын дугаар, гарал үүсэл</p>	<p>11. Quantity (including unit) Тоо хэмжээ (хэмжих нэгж)</p>	<p>11a. Total exported/ Quota Экспортын тоо/ Зөвшөөрөгдсөн тоо</p>						
A										
B										
C										
<p>12. Country of origin * Эхэлж экспортлосон улсын нэр *</p>	<p>Permit No Зөвшөөрлийн дугаар</p>	<p>Date Он сар өдөр</p>	<p>12a. Country of last re-export Хамгийн сүүлд рэ-экспортлосон улсын нэр</p>	<p>Certificate No Зөвшөөрлийн дугаар</p>	<p>Date Он сар өдөр</p>	<p>12b. Number of the operation ** or date of acquisition *** Үйл ажиллагааны дугаар ** эсвэл олж эзэмшсэн хугацаа ***</p>				
<p>* Country in which the specimens were taken from the wild, bred in captivity or artificially propagated (only in case of re-export) Зүйлийн биет нь ямар орноос гаралтай, зэрлэг эсвэл гаршуулсан, таримал эсэх (зөвхөн рэ-экспортлох тохиолдолд)</p> <p>** Only for specimens of Appendix-I species bred in captivity or artificially propagated for commercial purposes I-хаасралтанд орсон зүйлийн биетийг зөвхөн гаршуулж, тарималжуулан арилжааны зорилгоор худалдаалах тохиолдолд</p> <p>*** For pre-Convention specimens Конвенцид элсэхээс өмнө олж авсан зүйлийн биетүүд</p>										
<p>13. THIS PERMIT IS ISSUED BY: Зөвшөөрлийн бичгийг олгосон:</p> <div style="text-align: center; margin-top: 20px;"> <p>Stamp</p> <hr style="width: 80%; margin: 0 auto;"/> <p>Security stamp, signature and official seal Баталгаат марк, гарын үсэг, тамга</p> </div> <div style="display: flex; justify-content: space-between; margin-top: 10px;"> <div style="width: 30%;"> <p>Place Олгосон газар</p> </div> <div style="width: 30%; text-align: center;"> <p>Date Он сар өдөр</p> </div> </div>										
<p>14. EXPORT ENDORSEMENT: Хил, гаалийн байгууллагын экспортын зөвшөөрөл:</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="width: 50%;">Block Дугаар</th> <th style="width: 50%;">Quantity Тоо хэмжээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td style="text-align: center;">A</td> <td></td> </tr> </tbody> </table>			Block Дугаар	Quantity Тоо хэмжээ	A		<p>15. Bill of Lading/Air Waybill Number Ачааны баримт /Аяллын дугаар</p>			
Block Дугаар	Quantity Тоо хэмжээ									
A										

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн
А/27 тоот тушаалын 1 дүгээр хавсралт



МОНГОЛ УЛС
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ
ТҮҮХИЙ ЭД, ЗҮЙЛИЙГ ГАДААДАД ГАРГАХ
ЗӨВШӨӨРӨЛ

0170021

20__ оны __ дугаар
сарын __-ны өдөр

№

Улаанбаатар хот

1. Иргэн, байгууллагын нэр,
регистрийн дугаар
2. Иргэн, байгууллагын хаяг,
утас /факс/-ны дугаар
3. Мэргэжлийн байгууллагын
гэрчилгээний дугаар
4. Экспортлох улсын нэр
5. Худалдан /хүлээн/
авагчийн нэр
6. Түүхий эдийн нэр
/олон улсын нэршил/
7. Тоо хэмжээ /тоо, үсгээр/
8. Техникийн болон тээвэрлэх
нөхцөл
9. Гарах боомтын нэр
10. Зөвшөөрлийн хүчинтэй
байх хугацаа
11. Зөвшөөрөл олгосон:

Эрх бүхий албан тушаалтан 1.
/нэр, гарын үсэг, тамга/ 2.



МОНГОЛ УЛС
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ
ТҮҮХИЙ ЭД, ЗҮЙЛИЙГ ГАДААДААС ОРУУЛАХ
ЗӨВШӨӨРӨЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн
А/27 тоот тушаалын 2 дугаар хавсралт

0160051

Улаанбаатар хот

20___ оны ___ дугаар
сарын ___ -ны өдөр

№

1. Иргэн, байгууллагын нэр,
регистрийн дугаар
2. Иргэн, байгууллагын хаяг,
утас /факс/-ны дугаар
3. Мэргэжлийн байгууллагын
гэрчилгээний дугаар
4. Импортлох улсын нэр
5. Худалдан /хүлээн/
авагчийн нэр
6. Түүхий эдийн нэр
/олон улсын нэршил/
7. Тоо хэмжээ /тоо, үсгээр/
8. Техникийн болон тээвэрлэх
нөхцөл
9. Орох боомтын нэр
10. Зөвшөөрлийн хүчинтэй
байх хугацаа
11. Зөвшөөрөл олгосон:
Эрх бүхий албан тушаалтан 1.
/нэр, гарын үсэг, тамга/ 2.



МОНГОЛ УЛС
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
MINISTRY OF ENVIRONMENT AND TOURISM

АН АГНАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
SPECIAL HUNTING PERMIT

Дугаар /Permit number/ . 0170527

Аймаг /Province/

Зуучлагч байгууллага /Outfitters/

Сум /Soum/

Анчны нэр /Name of hunter/

Агнуурын бүс нутаг /Hunting area/

Улс /Country/

